



ТЭНГЭРЛИГ МЕДИА ГРУПП ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр

№23/16

Улаанбаатар хот

*Нэгдмэл сонирхолтой этгээдүүдтэй
хамтран хувьцааны хяналтын багц
худалдан авах санал гаргах тухай*

Компанийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1, 56.2, 76 дугаар зүйлийн 76.1.18 Тэнгэрлиг медиа групп ХК (цаашид "Компани" гэх)-ийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.1.4 дэх заалт, 2023 оны 11-р сарын 24-ний өдрийн ТУЗ-ийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

5. Компани нь Өндөрхаан ХК (ОНН)-ийн нийт гаргасан энгийн хувьцаанаас 1,119 ширхэг (нэг хувь) хувьцааг худалдан авах саналыг Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 03 сарын 20-ны 38 тоот тогтоолоор батлагдсан "Хувьцаат компанийн хувьцааг худалдан авах санал гаргах, хувьцааг худалдан авах ажиллагааны журам"-д заасны дагуу сайн дурын үндсэн дээр гаргахыг зөвшөөрсүгэй.
6. Энэхүү тогтоолын 1-д заасан хувьцааг Компани худалдан авснаар компанийн холбогдох этгээдүүдтэй хамт Өндөрхаан ХК-ийн нийт гаргасан энгийн хувьцааны 76.6 хувийн хувьцаа эзэмшигч болно. Иймд сайн дурын үндсэн дээр худалдан авах санал гаргахтай холбоотой мэдэгдэлд санал болгож буй үнэ 10,660 төгрөг, худалдан авах саналын эхлэх хугацааг 2023 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр, дуусах хугацааг 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдөр, хувьцааны худалдан авах төлбөрийн хугацааг 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдөр тус тус байхаар баталсугай.
7. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж холбогдох арга хэмжээг авч ажиллахыг Гүйцэтгэх захирал Г.Бат-Эрдэнэ-д даалгасугай.

ДАРГА



Г.УЯНГА



1	Худалдан авах санал гаргаж буй хуулийн этгээдийн мэдээлэл	<p>Нэр: Тэнгэрлиг медиа групп ХК</p> <p>Хаяг: СБД, 8-р хороо, Ерөнхий сайд Амарын гудамж-2, Ард санхүүгийн нэгдлийн байр, 2 давхар</p> <p>РД: 2054779</p> <p>Бүртгэлийн дугаар: 9007001003</p> <p>Утас: 95432111</p> <p>Цахим хаяг: od@tngr.media, udval@tngr.media</p>
2	Хувьцааг нь худалдан авах хуулийн этгээдийн нэр	Өндөрхаан ХК
3	Худалдан авахаар санал гаргаж буй хувьцааны тоо, ширхэг	1,119
4	Хувьцаа худалдан авахаар санал болгох үнэ	10,660 төгрөг
5	Худалдан авах саналын эхлэх он, сар, өдөр	2023.11.24
6	Худалдан авах саналын дуусах он, сар, өдөр	2023.12.25
7	Худалдах саналыг хүлээн авах эцсийн өдөр	2023.12.25
8	Хувьцааг худалдан авах төлбөрийг гүйцэтгэх өдөр	2023.12.27
9	Санал гаргагчийн компанид эзэмшиж байгаа хувь хэмжээ	1 %
10	Хувьцаа худалдан авах санал гаргасан үндэслэл	Хөрөнгө оруулалтын зорилгоор
11	Санал гаргагчийн өөр компанид эзэмшиж байгаа хувьцааны мэдээлэл	<p>Про медиа нетворк ХХК-80%</p> <p>Анрид ХХК-66%</p> <p>Мперс ХХК-50%</p> <p>Монгол телевиз ХХК-20%</p> <p>Ори студиос ХХК-20%</p> <p>Монгол дифай ХХК-10%</p>
12	Санал гаргагчийн үнэт цаасны компанийн мэдээлэл	<p>Ард Секюритиз УЦК ХХК</p> <p>Хаяг: Улаанбаатар, Сүхбаатар, 8-р хороо, Сүхбаатар талбай-2, Сентрал тауэр, 17 давхар,</p>
13	Худалдан авах санал гаргагчийн худалдах саналыг хүлээн авах шуудангийн хаяг	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 8-р хороо, Сүхбаатарын талбай-2, Сентрал тауэр, 17 давхар,



ТЭНГЭРЛИГ МЕДИА ГРУПП ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр

№23/17

Улаанбаатар хот

Нягтлан бодох бүртгэлийн журам шинэчлэн батлах тухай


Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.3 дах хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 5 сарын 7-ны өдрийн 162 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Компанийн Засаглалын Кодекс”-ын 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

3. “Тэнгэрлиг Медиа Групп” ХК-ийн “Нягтлан бодох бүртгэлийн журам”-ыг Нэгдүгээр хавсралтаар шинэчлэн баталсугай.
4. Энэхүү журмын хэрэгжилтийг хангаж, хяналт тавин ажиллахыг Компанийн нягтлан бодогч, Гүйцэтгэх захирал нарт даалгасугай.

ДАРГА



Г.УЯНГА



**“ТЭНГЭРЛИГ МЕДИА ГРУПП” ХК-ИЙН
НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ**

I. КОМПАНИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

I.1 Компанийн танилцуулга:

<p>➤ Компанийн үүсгэн байгуулалт</p>	<p>Тэнгэрлиг Медиа групп ХК нь анх 1992 онд Тэнгэрлиг Медиа Групп ХК (цаашид “Тэнгэрлиг Медиа Групп” гэх) нь 1992 онд үүсгэн байгуулагдсан, Монголын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй Е-Моние ХК-ийн суурин дээр үүсгэн байгуулагдсан компани юм. Е-Моние ХК (одоогийн Тэнгэрлиг Медиа Групп) нь 2017 оноос хойш үйл ажиллагаа явуулаагүй бөгөөд 2021 онд Ард Менежмент ҮЦК ХХК нь тус компанийн 90.4%-ийг худалдан авснаар үйл ажиллагааг нь өргөжүүлэн ажиллахаар шийдвэрлэсэн билээ. 2021 оны 4 сарын 30-ны өдөр Е-Моние ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал болж, компанийн оноосон нэрийг Тэнгэрлиг Медиа Групп ХК болгон оорчилж, Монгол Улс төдийгүй Олон улсад медиа чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар түүхэн шийдвэр гаргасан. Үүний дагуу Санхүүгийн Зохицуулах Хорооноос 2021 оны 6 сарын 7-ны өдөр 148 тоот тухаалаар компанийн оноосон нэрийг өөрчлөхийг зөвшөөрсөн болно.</p>
<p>➤ Компанийн үйл ажиллагааны чиглэл</p>	<ul style="list-style-type: none"> ➤ Гадаад худалдаа ➤ Менежментийн зөвлөгөө өгөх ➤ Хууль тогтоомжоор хориглоогүй бусад төрлийн үйл ажиллагаа
<p>➤ Түүх</p>	<p>Компани нь 1992 онд үүсгэн байгуулагдаж газар тариалангийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж эхэлсэн. 1993 онд буюу өмч хувьчлалын үед Монголын Хөрөнгийн Биржид бүртгэгдэж, хувьцаат компани болж хэлбэрээ оорчилсон. Хувьцаа эзэмшигч оорчлогдсонтой холбоотойгоор компани нь 2021 онд үйл ажиллагаагаа дахин сэргээж, хэвлэл мэдээллийн салбарт хөл тавьж ажиллахаар шийдэж одоогоор медиа чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй компаниудад хөрөнгө оруулалт хийж ажиллаж байна.</p>
<p>➤ Алсын хараа, эрхэм зорилго</p>	<p>Тэнгэрлиг Медиа Групп нь эерэг медиаг бий болгох, нийгмийг зөв хандлагатай эерэг тал руу залах, сайн сайхан зүйлсийг мэдээлэх, дэвшилтэт технологи арга хэрэгслүүдийг ашиглан салбарын одоогийн нөхцөл байдлыг ахиулах, сайжруулах, хоорондын уялдаа холбоог нэмэгдүүлэх үндсэн зорилготой.</p>
<p>➤ Засаглах удирдлага</p>	<p>Компанийн засаглах эрх дээд удирдлага нь хувьцаа эзэмшигчдийн хурал байх ба тэдгээр нь Төлөөлөн удирдах зөвлөлөөр дамжуулан оролцоогоо хангадаг. Төлөөлөн удирдах</p>

	<p>зөвлөлөөс гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд олгосон эрх мэдлийн хүрээнд компанийн гүйцэтгэх удирдлага, гүйцэтгэх удирдлагаас бусад нэгж хэлтсүүд гэсэн удирдлагын тогтолцоотой юм.</p>
--	--

1.2. Компанийн бүтэц, зохион байгуулалт



1.3. Компанийн бизнесийн орчин

Эрх зүйн орчин	Хувьцаат компани болохын хувьд Санхүүгийн зохицуулах хороонд үйл ажиллагааг тайлагнах, мэдээллэхтэй холбоотой хууль тогтоомж, дүрэм, журмыг дагаж мөрдөх бөгөөд Медиа салбарт үйл ажиллагаа явуулахад шаардлагатай тусгай зөвшөөрөл болон Оюуны өмчийн эрх зүйн зохицуулалтын хүрээнд үйл ажиллагаа явуулна.
Зах зээл ба гол хэрэглэгчид	Медиа, интeртэйментийн зах зээл байх ба гол хэрэглэгчид нь Сошиал медиа, интернет орчны хэрэгчлэгчид бөгөөд хөрөнгийн зах зээл, санхүүгийн зах зээл дээр оролцох сонирхолтой оролцогчид байх ба өрсөлдөөн, чанар, шинэ санал, санаачлагад тулгуурлан зах зээлийн орчноо бүрдүүлдэг.
Өрсөлдөгч	Гол өрсөлдөгчид нь Медиа, интeртэйментийн зах зээл дээр ижил төрлийн үйл ажиллагаа явуулж байгаа хувийн хэвшлийн компаниуд байна.
Нягтлан бодох бүртгэлийн орчин	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартыг заавал мөрдөж санхүүгийн тайлан, тодруулгаа бэлтгэнэ. Санхүүгийн тайлан бэлтгэхэд ямар нэг тусгай шаардлага, зохицуулалт шаарддаггүй бөгөөд нийтлэг зориулалт бүхий шаардлагуудыг баримтална.
Компанийн засаглал ба хяналтын орчин	Компанийн засаглах эрх бүхий дээд удирдлага нь хувьцаа эзэмшигчдийн хурал байх ба тэдгээр нь Төлөөлөн удирдах зөвлөлөөр дамжуулан оролцоогоо хангадаг. Төлөөлөн удирдах зөвлөлийн эрх мэдлийн хүрээнд компанийн гүйцэтгэх удирдлага, гүйцэтгэх удирдлагаас бусад нэгж хэлтсүүд гэсэн удирдлагын тогтолцоотой юм. Төлөөлөн удирдах зөвлөл нь өөрийн чиг үүргийг хэрэгжүүлэх тодорхой чиг үүрэг бүхий (1)Аудитын хороо, (2) Хөрөнгө оруулалтын хороо, (3)Нэр дэвшүүлэх, Цалин урамшууллын хороо, (4) Хараат бус редакцийн зөвлөл гэх хороодыг ажиллуулдаг. Өдөр тутмын үйл ажиллагааг ажил үүргийн хуваарийн дагуу алба хэлтсүүд, мэргэжилтнүүд холбогдох хууль, дүрэм, журам зэрэг зохицуулалтын баримт бичгүүдэд тулгуурлан өөр өөрийн чиг үүргээ хариуцан ажиллах ба үйл ажиллагаагаа гүйцэтгэх удирдлагад тайлагнана.

1.4. Компанийн санхүүгийн үйл ажиллагааны бүтэц зохион байгуулалт:

Санхүү бүртгэлийн хэлтсийн ажлын чиг үүрэг

“Тэнгэрлиг медиа групп” ХК -ийн санхүү бүртгэлийн хэлтэс нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Компанийн хэмжээнд нягтлан бодох бүртгэлийг зохион байгуулах, бүртгэл хөтлөлтийг хянан удирдах, санхүүгийн үйл ажиллагааг тасралтгүй хэвийн явуулах;
2. Компанийн өмч, хөрөнгийн ашиглалт, хамгаалалт, зарцуулалтанд нягтлан бодох бүртгэлээр дамжуулан хяналт тавих;
3. Компанийн хөрөнгө, өр төлбөр, өмч, орлого, зардал, үр дүнгийн талаарх санхүүгийн мэдээллийг цаг тухайд нь цуглуулж, анхан шатны баримт бичгээр баталгаажуулан, боловсруулан нэгтгэж тайлагнах;
4. Нягтлан бодох бүртгэлийг СТОУС болон Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж, заавар журам, аргачлалын дагуу хөтлөн явуулах;
5. Өмч, эд хөрөнгийн тооллого, тооцоог тогтоосон хугацаанд хийж гүйцэтгэх;
6. Удирдлага болон дотоод, гадаад хэрэглэгчдийг шаардлагатай мэдээллээр цаг тухайд нь хангах;
7. Хэлтсийн ажилчид компанийн дотоод журам болон энэхүү НББ-ийн бодлогын баримт бичгийг өдөр тутмын үйл ажиллагаанд мөрдлөг болгон хэрэгжүүлж ажиллана.

Санхүүгийн бүртгэлийн хэлтсийн ажилчдын ажил үүргийн хуваарь

- **Санхүү хариуцсан захирал:** СТОУС-ын дагуу компанийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтыг бэлдүүлэн гаргасан тайлан мэдээг хүлээн авч улирал, жилийн санхүүгийн тайлангаа гаргуулах, харьяа дүүргийн санхүүгийн байгууллага, татварын байгууллагад хугацаанд нь тушаалгах, компанийн эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгөнд хяналт тавих, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг удирдан чиглүүлэх, компанийн ажилтнуудын цалин хөлс, шагнал урамшууллыг боловсронгуй болгох,
- **Ерөнхий нягтлан бодогч:** Компанийн ерөнхий нягтлан бодогчийн ажлын байрны тодорхойлолт дараах байдалтай байна.

АЖЛЫН БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТ

1. Ерөнхий зүйл

Байгууллагын нэр	Нэгжийн нэр
Тэнгэрлиг Медиа Групп ХК	Санхүү, бүртгэлийн хэлтэс
Ажлын байрны нэр: Ерөнхий нягтлан бодогч	
Шууд харьяалагдах албан тушаалтан: Санхүү эрхэлсэн захирал	
Шууд харьяалах ажлын байр: Мөнгөн хөрөнгө, өглөгийн нягтлан бодогч болон тооцооны нягтлан бодогч	
Ажлын байрны зорилго:	Компанийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг зохион байгуулж бүртгэх, санхүүгийн тайлан гаргах.
Ажлын байрны үндсэн зорилт:	<ol style="list-style-type: none">1. Бүртгэл, санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөгдөх хууль тогтоомж, шийдвэрийн биелэлтийг хангаж ажиллах, удирдлагыг санхүүгийн мэдээллээр цаг хугацаанд нь шуурхай хангах;2. Харилцах данс, бэлэн мөнгөний мөнгөн урсгалд хяналт тавих, төлбөр тооцоог шуурхай гүйцэтгэх, нягтлан бодох бүртгэл хөтлөх;

	<ol style="list-style-type: none"> 3. Бараа материалын гүйлгээ, зарцуулалтад хяналт тавих, нягтлан бодох бүртгэл хөтлөх, архивлах; 4. Нээлттэй компанийн хувьцаанд оруулсан хөрөнгө оруулалтын ажил гүйлгээг бүртгэх, дансыг хянах, үнэлэх; 5. Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн болон хуримтлагдсан элэгдлийн данснуудын нягтлан бодох бүртгэлийг хөтлөх; 6. Цалин хөлсний тооцооллыг хийх, олгох; 7. Санхүү, татвар, НДШ-ийн тайлан гаргаж холбогдох байгууллагуудад тушаах; 8. Мөнгөний орлого, зарлагын тайлан.
<p>Ажлын байрны гол үйл ажиллагаа:</p>	<p>Ажлын байрны 1 дүгээр зорилтын хүрээнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Санхүүгийн ажилтнуудыг мэргэжлийн болон арга зүйн өдөр тутмын удирдлагаар хангах; 2. Компанийн бэлэн мөнгөний урсгалд хяналт тавих, орлого зарлагын гүйлгээг шуурхай гүйцэтгэх; 3. Бэлэн мөнгөний төлбөр тооцооны дэмжих баримтууд зохих журмын дагуу бүрдэл болсон эсэхийг шалгах; 4. Харилцах данснуудын хуулгыг харилцагч банкнаас авч нягтлан бодох бүртгэлтэй тулган шалгаж орлого, зарлагыг гүйлгээг хийх; 5. Бэлэн мөнгөний тайланг шалгаж хүлээн авах, үлдэгдлийг баталгаажуулах; 6. Бэлэн мөнгөний орлого, зарлагын баримтыг үндэслэн санхүүгийн программд гүйлгээг оруулах; 7. Бараа материалын тайланг анхан шатны баримттай тулган шалгаж хүлээн авах; 8. Бараа материалын орлого, зарлагын баримтыг үндэслэн холбогдох данснуудын нягтлан бодох бүртгэлийг хөтлөх; 9. Үндсэн хөрөнгийн дамжих баримтуудыг үндэслэн орлого, зардал, шилжилт хөдөлгөөнийг бүртгэх; 10. Цалин хөлстэй холбоотой тушаал шийдвэр, эмнэлгийн магадалгаа, цагийн тооцоог шалгаж хүлээн авах; 11. Эмнэлгийн магадалгаа, цалин хөлсний мэдээллийг үндэслэн ХЧТА-ын тэтгэмж, цалинг бодож гүйлгээ хийх; 12. Компанийн санхүүгийн тайланг СТОУС, Монгол Улсын хэмжээнд мөрдөгдөж байгаа холбогдох хууль тогтоомж, заавар журамд нийцүүлэн гаргаж, баталгаажуулан тушаах; <p>Ажлын байрны 2 дугаар зорилтын хүрээнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Авлага, өглөгийн тооцоо хийж бүртгэл хөтлөх; 2. НӨАТ-ын тайланг бэлтгэх, тушаах; 3. Ажиллагсдад нийгмийн даатгалаас олгох тэтгэмжийн тайланг хийж нэхэмжлэх;

	<p>4. Ажиллагсдын ЭМД, НД-ын дэвтрийн бичилтийг хийж баталгаажуулах;</p> <p>5. Компанийн НДШ, ХХОАТ-ын тайлангуудыг бэлтгэж баталгаажуулах, тушаах, тайлагнах;</p> <p>6. Харилцагч нийгмийн даатгалын хэлтэс, татварын байгууллагатай тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулах;</p> <p>7. Татвар, шимтгэлийн тайлангуудыг тооцооны данснуудын үлдэгдэлтэй тулган шалгаж тохируулах;</p> <p>8. Тайлант хугацааны татвар, шимтгэл, бусад өр авлагыг хугацаанд нь барагдуулах;</p> <p>Ажлын байрны 3 дугаар зорилтын хүрээнд:</p> <p>1. Ашиглалтад байгаа үндсэн хөрөнгө, бараа материал, багаж хэрэгслийн эзэмшигчийн карт хөтлөлтөд хяналт тавих;</p> <p>2. Бэлэн мөнгөний тайлан, дэмжих баримтыг санхүүгийн баримт болон үдэж архивд бэлтгэх;</p> <p>3. Харилцах данснуудын хуулга, дэмжих баримтуудыг санхүүгийн баримт болгон үдэж архивд бэлтгэх;</p> <p>4. Үндсэн хөрөнгийн тайлан, тооллогын материалыг санхүүгийн баримт болгон үдэж архивд бэлтгэх;</p> <p>Ажлын байрны 4 дүгээр зорилтын хүрээнд:</p> <p>1. Үндсэн хөрөнгийн тооллого хийж, үлдэгдлийг баталгаажуулах;</p> <p>2. Бараа материалын тооллого хийж, үлдэгдлийг баталгаажуулах;</p>
--	--

2. Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт буюу key performance indicator

Үндсэн үзүүлэлт	Эзлэх хувь
Сар бүрийн санхүүгийн тайланг дараа сарын 15-ны дотор бэлтгэж 10 удирдлагад танилцуулах	10
Улирал бүр татварын тайланг гаргаж татварын байгууллагад тушаах	15
2 болон 4 дүгээр улирлуудад санхүүгийн тайлан гаргаж санхүү, төрийн 15 сангийн хэлтэст тушаах	15
Сар бүр санхүүгийн анхан шатны баримт бичиг архивлах	10
Сар бүр НДШ, НӨАТ-ын тайлангуудаа гаргаж тушаах	10
Сар бүр харилцагч байгууллагуудтай авлага, өглөгийн тооцоо нийлэх	10
Үндсэн хөрөнгийн тооллого, бүртгэлийг хийх, хянах	10
Дотоод хяналт болон хөндлөнгийн хяналт шалгалтаар оруулах	10
Татвар, НДШ хяналт шалгалтаар оруулж амжилттай шалгуулах	10

3. Тавигдах шаардлага

Ерөнхий шаардлага	Боловсрол	Дээд
	Мэргэшлийн бэлтгэл	Нягтлан бодох бүртгэлийн бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй, мэргэшсэн нягтлан бодогч байх
	Туршлага	Нягтлан бодогч мэргэжлээр ... жил ажилласан
	Ур чадвар	Бүртгэл, санхүүгийн асуудлыг шуурхай шийдвэрлэн холбогдох бичиг баримтыг

		боловсруулах, багаар ажиллах, удирдах арга барил эзэмшсэн
Тусгай шаардлага		Хууль зүйн болон англи хэлний зохих мэдлэгтэй
Ажлын байрны нөөц хэрэгсэл	Санхүү	Батлагдсан төсвийн хүрээнд
	Эд хөрөнгө	Бичгийн ширээ, сандал, компьютер, бусад дагалдах хэрэгсэл, тооны машин бичгийн хэрэгсэл

Ажлын байрны тодорхойлт гаргасан		Зөвшөөрсөн
Үндэслэл		Он, сар, өдөр
Монгол Улсын Үндсэн хуулийн 16.4, Хөдөлмөрийн тухай хуулийн 49.1.1		

4. Ерөнхий нягтлан бодогчийн ажил үүргийн хуваарь

Д/Д	Хийж гүйцэтгэх ажлууд	Хугацаа
1	Санхүүгийн ажилтнуудыг мэргэжлийн болон арга зүйн өдөр тутмын удирдлагаар хангах	Өдөр тутам
2	Компанийн мөнгөн урсгалын болон зардлын төлөвлөгөөнд тусгагдсан зорилго, зорилгод нийцүүлэн мөнгөн ба бусад хөрөнгийг удирдах	Өдөр тутам
3	Үндсэн болон эргэлтийн хөрөнгийн хөдөлгөөн, өөрчлөлт, хадгалалт, хамгаалалтад байнгын хяналт тавих	Жилийн турш
4	Компанийн санхүүгийн үйл ажиллагаанд сахилга бат, шуурхай байдлыг хангаж ажиллах	Өдөр тутам
5	Тайлант хугацааны татвар, шимтгэл, бусад өр авлагыг хугацаанд нь барагдуулах, хугацаа хэтэрсэн өр, авлага үүсгэхгүй байх	Жилийн турш
6	Компанийн ХХОАТ, АТБӨЯХАТ, ҮХЭХАТ, ААНОАТ, НӨАТ, НДШ-ийн тайланг гаргаж хянуулан баталгаажуулах, тушаах	Хуулийн хугацаанд
7	Компанийн улирал, жилийн санхүүгийн тайланг СТОУС, Монгол улсын хэмжээнд мөрдөж байгаа холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гаргах	Дараа улирлын эхний сарын 20- ны дотор, дараа оны 2 дугаар сарын 10-ны дотор
8	Санхүүгийн тайланг онлайн аар тушаах	Улирал, жилээр
9	Компанийн жилийн татварын тайлан, санхүүгийн нэгдсэн тайлан, гүйлгээ баланс, холбогдох журналуудыг үдэж архивд бэлтгэх	Улирал тутам, дараа оны 2 дугаар сарын 20- ны дотор
10	Шатахуун талоны зарцуулалтын тайланг авч нэгтгэх, хяналт тавих	Сар бүрийн 05-ны дотор
11	Бэлтгэн нийлүүлэгчийн зарлагын баримт, нэхэмжлэх, албан томилолтын удирдамж, ажлын гүйцэтгэлийн тайлан, мөнгө олгохыг хүссэн өргөдөл нь зохих журмын дагуу бүрдэл болсон эсэхийг шалгах	Гүйлгээ гарах тухай бүрд
12	Дэмжих баримтууд бүрдэл болсон бэлэн мөнгөний гүйлгээний орлого, зарлагын баримтыг бичиж гүйлгээг хийх	Гүйлгээ гарах тухай бүрд
13	Бэлэн мөнгөний орлого, зарлагын баримтыг үндэслэн гүйлгээг шивэх,	Гүйлгээ гарах тухай бүрд
14	Бэлэн мөнгөний тайлан /кассын тайлан/ гаргах	Дараа сарын 05- ны дотор

15	Бэлэн мөнгөний тайлан, дэмжих баримтыг санхүүгийн баримт болгон үдэж архивд бэлтгэх	Дараа сарын 15- ны дотор
16	Цалин хөлстэй холбоотой тушаал, шийдвэр эмнэлгийнхуудас, цагийн тооцоог шалгаж хүлээн авах	Сар бүрийн 03-нд
17	Урьдчилгаа цалинг бодож олгох	Сар бүрийн 03-нд
18	Ажиллагсдын сарын сүүлийн цалинг бодож олгох	Сар бүрийн 25-нд
19	Ажиллагсдад нийгмийн даатгалаас олгох тэтгэмжийн тайланг хийж нийгмийн даатгалын байгууллагаас нэхэмжлэх	Сар бүрийн 28-ны дотор
20	Ажилгасдын НД, ЭМД-ийн бичилтийг хийж баталгаажуулах	Дараа сарын 15- ны дотор
21	ЭМД, НД, ХХОАТ-ын гүйлгээ шивэх	Сар бүрийн 25-ны дотор
22	Цалингийн өглөг, НДШ-ийн өглөг, ХХОАТ-ын өглөгийн, тайлан дараа гарагч /₮, \$/-ын авлага дансны үлдэгдлийг ерөнхий дансаар баталгаажуулах	Сар бүрийн 25-ны дотор, улирлын эхний сарын 12- ны дотор
23	НДШ-ийн тайланг гаргаж хянуулан холбогдох байгууллагаар баталгаажуулах	Сар бүрийн 30-ны дотор
24	НДШ, ХХОАТ-ын өглөгийг хуулийн хугацаанд төлөх, зохион байгуулах	Тухайн сард
25	Цалин хөлсний холбогдох баримтуудыг санхүүгийн баримт болгон үдэж архивд бэлтгэх	Дараа сарын 03- ны дотор
26	Бэлэн бус төлбөр тооцооны баримт, бэлтгэн нийлүүлэгчийн зарлагын баримт, нэхэмжлэх, компанийн орлогын баримт, журмын дагуу бүрдсэн эсэхийг шалгах	Гүйлгээ гарах тухай бүрд
27	Банкны өдөр тутмын хуулгыг орлогын баримт, төлбөрийн даалгавар, дэмжих баримтуудад тулган шалгаж орлого, зарлагын гүйлгээг шивэх	Өдөр бүр
28	Валютын харилцах данс, бэлэн мөнгөний дансны үлдэгдлийг Монголбанкны ханшаар тэгшитгэл хийх	Дараа сарын 2-ны дотор
29	Харилцах данснуудын банкны хуулгыг авах, нягтлан бодох бүртгэлтэй тулган шалгах	Тухайн сарын 01- нд
30	Харилцах данс бүрээр дансны хуулга бэлтгэх	Дараа сарын 02- ны дотор
31	Харилцах данс бүрээр тайланг бэлтгэх	Дараа сарын 04- ний дотор
32	Тайлант хугацааны харилцах данснуудын хуулга, дэмжих баримтуудыг санхүүгийн баримт болгон үдэж архивд бэлтгэх	Дараа сарын 25- ны дотор
33	Хугацаандаа төлбөр хийгээгүй харилцагч нарт мэдэгдэл хүргүүлэх, гэрээний дагуу хариуцлага тооцох	Сарын турш
34	Орлогыг хугацаанд нь төвлөрүүлэх, авлага үүсгэхгүй байх ажлыг зохион байгуулах	Сарын турш
35	Үндсэн хөрөнгийн анхан шатны баримтуудыг үндэслэн орлого, зарлага, шилжилт хөдөлгөөнийг бүртгэх	Дараа сарын 05- ны дотор
36	Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгийн элэгдэл, хорогдол тооцох	Дараа сарын 10- ны дотор
37	Тайлант хугацаанд шинээр нэмэгдсэн болон хасагдсан үндсэн хөрөнгийн тайлан, товчоог гаргах	Улирлын дараа сарын 10-ны дотор
38	Үндсэн хөрөнгийн үлдэгдлийн тайлан гаргах	Дараа оны 1 дүгээр сарын 25- ны дотор

39	Жилийн эцсийн үндсэн хөрөнгийн тооллогын материалыг хүлээн авч шалгах, тооллогын үр дүнг тайлагнах, тооцоо бодох	12-р сарын 25-аас дараа оны 1-р сарын 15-ны дотор
40	Үндсэн хөрөнгийн тайлан, тооллогын материалыг санхүүгийн баримт болгон үдэх, архивд бэлтгэх	Улирал тутам, дараа оны 3 сарын 15-ны дотор
41	Үндсэн хөрөнгийн эзэмшилт, ашиглалтад хяналт тавих	Жилийн турш

- **Мөнгөн хөрөнгө, өглөгийн нягтлан бодогч:** Компанийн үйл ажиллагааг тасралтгүй явуулахад шаардагдах мөнгөн хөрөнгийн өдөр тутмын орлого, зардлын гүйлгээг хийж бүртгэлд тусгах, анхан шатны баримтанд нь хяналт тавих, авлага өглөгийн бүх тооцоог дэлгэрэнгүй хөтөлж түүнтэй холбоотой ажил гүйлгээг баримтжуулан НББ-д үнэн зөв, тогтоосон хугацаанд тусгах, шаардлагатай мэдээллээр удирдлага, харилцагч, хэрэглэгчдийг хангаж ажиллана. Хариуцан гаргах тайлан мэдээ нь мөнгөн хөрөнгийн орлого зарлагын журнал, өглөг авлагын мэдээ, дэлгэрэнгүй бүртгэл. “Тэнгэрлиг медиа групп” ХК -д энэхүү ажил үүргийг ерөнхий нягтлан бодогч давхар хариуцан ажиллана.
- **Тооцооны нягтлан бодогч нь дараах ажил үүргийг гүйцэтгэнэ:** Сангийн яамнаас баталсан санхүүгийн тайлангийн нэгдсэн маягтын дагуу анхан шатны баримт бүрдүүлэх, тайлангуудыг бэлтгэх, батлагдсан албан хэрэг хөтлөлт, зохих дүрэм журам, зааврыг мөрдлөг болгон компанийн албан бичиг хөтлөх, боловсруулах, эмх цэгцтэй байлгах, компанийн захирлын өдөр тутмын ажилд туслах, албан бичиг хэрэг хөтлөх стандартын дагуу компанийн бичиг хэргийн хөтлөлт хөдөлгөөнийг хянах тушаал шийдвэрийг гаргах, ирсэн явсан бичиг баримтыг бүртгэх, тараах албан баримтыг эмх цэгцтэй хадгалах архивлах, эд хариуцагчийн эрх үүргийн дүрэм, Мөнгөн кассын үйл ажиллагааны дүрэм, компанийн дотоод дүрэм журам, ажлын байрны тодорхойлолтын дагуу ажиллана.
- **Бараа материалын нягтлан бодогч:** Компаний үйл ажиллагааг хэвийн явуулах үндсэн дээр хариуцсан бараа материалын холбогдох бүртгэл, тооцоог анхан шатны баримтыг үндэслэн үнэн зөв, цаг хугацаанд нь бүртгэж, тайлагнаж ажиллана. Хариуцан гаргах тайлан мэдээ нь материалын орлого, зарлагын тайлан.
- **Үндсэн хөрөнгө хариуцсан нягтлан бодогч:** Компаний үйл ажиллагааг хэвийн явуулах үндсэн дээр үндсэн хөрөнгийн бүртгэл, тооцоог цаг хугацаанд нь үнэн зөв шуурхай хийж, бүртгэлд тусган, мэдээ мэдээллээр хангахад оршино. Хариуцан гаргах тайлан мэдээ нь үндсэн хөрөнгийн орлого, зарлагын журнал, дэлгэрэнгүй тайлан, тооллогын бүртгэл.
- **Цалин хөлсний нягтлан бодогч:** Компаний ажиллагсдын цалин, хөдөлмөрийн хөлсний тооцоог цаг хугацаанд нь хийж бүртгэлд үнэн зөв тусгаж, цалин хөлсний ажил гүйлгээтэй холбоотой тайлан мэдээллийг боловсруулж, шаардлагатай мэдээллээр хангаж ажиллана. Хариуцан гаргах тайлан мэдээ нь ажиллагсдын цалин хөлсний дэлгэрэнгүй бүртгэл, НДШ төлөлтийн тайлан, ХХОАТ-ын тайлан.
- **Аж ахуйн нярав:** Харилцагч байгууллагаас бэлэн мөнгийг тоолж хүлээн авч зориулалтын дагуу иж бүрдэл болсон баримтаар зохих зөвшөөрлийн дагуу зарцуулах, компаний өдөр тутмын сэлбэг материалын гүйлгээг холбогдох журмын дагуу түргэн шуурхай, цаг алдалгүй, эрх бүхий хүмүүсийн зөвшөөрөл болон баримтуудыг үндэслэн хийх, бараа материалтай холбогдон гарсан бүх гүйлгээнүүдийн баримтын бүрдүүлэлт, тооцоог бодож сэлбэг материалын гүйлгээний тайланг тогтоосон хугацаанд хариуцсан нягтлан бодогчид гаргаж өгөх, агуулахад байгаа сэлбэг материалын хадгалалт, хамгаалалтанд байнга хяналт тавих.

II. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГЫН ҮНДЭС

Нягтлан бодох бүртгэлийн бодлого гэдэг нь санхүүгийн тайлан гаргах, толилуулахад мөрддөг тухайн аж ахуй нэгж байгууллагын баталсан тусгай зарчим, үндэслэл, дүрэм, журам болон практик үйл ажиллагааг тусган боловсруулсан баримт бичиг юм.

2.1. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг

НББ-ийн бодлогын баримт бичиг нь “Тэнгэрлиг медиа групп” ХК -ийн санхүүгийн тайланг бэлтгэхэд баримтлах НББ-ийн зарчим, бодлогуудыг тодорхойлох, компанийн хэмжээнд зайлшгүй мөрдөгдөх санхүүгийн бүртгэл, хяналтын өдөр тутмын үйл ажиллагааны хэм хэмжээг тогтоон, санхүүгийн сахилга батыг мөрдүүлэх, НББ-ийг хөтөлж, санхүүгийн тайлан бэлтгэн хэрэглэгчдийг мэдээллээр хангах үндсэн зориулалтаар ашиглагдана. НББ-ийн бодлогын баримт бичгийн заалт бүрийн агуулга нь “Тэнгэрлиг медиа групп” ХК -д хамаарна.

НББ-ийн бодлогын баримт бичиг нь “Тэнгэрлиг медиа групп” ХК-ийн гүйцэтгэх захирлын тушаалаар батлагдсан даруйд хүчин төгөлдөр болж мөрдөгдөнө.

НББ-ийн бодлогыг зөвхөн дараах тохиолдлуудад өөрчилнө. Үүнд:

- Хууль тогтоомжоор шаардсан;
- Бүртгэлийн стандарт тогтоогч байгууллагаас шаардсан;
- Өөрчлөлт нь тайлагналыг илүү тохиромжтой болгохоор нөхцөлд өөрчилнө.

Монгол Улсын нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд аж ахуйн нэгж, байгууллагууд дараах гурван төрлийн стандартыг баримтлан нягтлан бодох бүртгэлээ хөтөлж санхүүгийн тайлан, тодруулгаа бэлтгэхээр хуульчилсан.

- Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)
- Жижиг, дунд аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
- Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.2-д Санхүүгийн тайлагналын олон улсын стандартыг зайлшгүй дагаж мөрдөх аж ахуйн нэгжийн ангилалд Тэнгэрлиг медиа групп ХК нь хамаарч байгаа учир тус стандартыг дагаж мөрдөнө.

СТОУС нь 2022 оны байдлаар ширхэг СТОУС, ширхэг НББОУС-аас бүрдэх ба санхүүгийн тайлагнал, нягтлан бодох бүртгэлтэй холбоотой бүхий л зүйлийг багтаасан байдаг. СТОУС-аар зарим сонголтод хувилбартай зүйлс эсхүл тухайн улс орны хуулиар шаардсан зүйлсийг аж ахуйн нэгж, байгууллагууд өөрийн үйл ажиллагааны онцлогтоо тохируулан НББ-ийн бодлогын баримт бичигтээ тусган мөрдөхийг зөвшөөрсөн байдаг.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.2-д “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан мөрдөж ажиллана” гэж заасан учраас компани нь энэ шаардлагыг хангаж, нягтлан бодох бүртгэлийн бодлогыг жил бүр тогтвортой мөрдөж ажиллана.

2.2. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн ач холбогдол:

Компани нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулснаар дараах ач холбогдолтой байна. Үүнд:

- НББ болоод санхүүгийн бодлогуудыг холбогдох дүрэм, журам, стандарт болон бусад бизнесийн процессуудад нийцүүлэх;
- НББ-ын бодлого удирдамжаар санхүүгийн ажилтнуудыг ижил түвшний шаардлага, зохистой удирдлагаар хангах;
- Санхүүгийн тайлагнал болон бизнесийн процессууд илүү нийцтэй бөгөөд аливаа зөрчил дутагдлаас ангид байх;
- Шинэ бодлогуудыг хэрэглэх, сонгох үед тэргүүлэх туршлага болон ижил төрлийн үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн туршлагыг судлах;

- Бодлогыг хэрэгжүүлэхэд дотоод хэрэглэгчид болон оролцогч талууд сонирхлын бүлгүүдийн хэрэгцээг анхаарч үзэх;
- Илүү үр ашигтай санхүүгийн тайлангийн хаалтын процессыг сонгон авах;
- Санхүүгийн мэдээлэл дэх алдаануудыг хязгаарлах;
- НББ-ийн бодлогын тараан байршуулалт болон процессын талаарх сургалтаар дамжуулан ажилчиддаа энэ талаарх боловсрол олгох;
- Компани үйл ажиллагаа, нөөц бололцоогоо илүү стратегийн шинж чанартай, өндөр эрсдэлтэй хэсгүүдэд төвлөрүүлэх боломжийг олгоно.

2.3. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн хэрэглээ:

НББ-ийн бодлогын баримт бичиг нь “Тэнгэрлиг медиа групп” ХК -ийн санхүүгийн тайланг бэлтгэхэд баримтлах НББ-ийн зарчим, бодлогуудыг тодорхойлох, компанийн хэмжээнд зайлшгүй мөрдөгдөх санхүүгийн бүртгэл, хяналтын өдөр тутмын үйл ажиллагааны хэм хэмжээг тогтоон, санхүүгийн сахилга батыг мөрдүүлэх, НББ-ийг хөтөлж, санхүүгийн тайланг бэлтгэн, хэрэглэгчдийг үнэн зөв, бодит мэдээллээр хангах үндсэн зориулалтаар ашиглагдана.

НББ-ийн бодлогын баримт бичгийн заалт бүрийн агуулга нь “Тэнгэрлиг медиа групп” ХК-д хамаарах ба доорх тайлангуудыг бэлтгэхэд ашиглагдана.

- Тусдаа санхүүгийн тайлан
- Нэгтгэсэн санхүүгийн тайлан
- Татварын тайлангууд
- НДШ ногдуулалт төлөлтийн тайлан
- Удирдлагын тайлан

III. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ БОДЛОГУУД

3.1. Санхүүгийн тайлангууд, тэдгээрийг бэлтгэж тайлагнах

“Тэнгэрлиг медиа групп” ХК-ийн санхүүгийн тайлан нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцсэн, хувьцаа эзэмшигчид, харилцагчид, мэдээлэл хэрэглэгчийн нийтлэг эрх ашгаас урган гарсан, тэднийг үнэн зөв, бодит мэдээллээр хангах зорилгоор зохион байгуулагдан бэлтгэгдсэн байвал зохино.

Санхүүгийн тайлангийн хамрах хүрээ

Санхүүгийн тайлан нь тодорхой хугацаанд явагдсан үйлдвэрлэл, бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ, санхүүгийн болон аж ахуйн үйл ажиллагааны явц үр дүнг тоо чанар, үнийн дүнгийн болон бүтцийн үзүүлэлтээр иж бүрэн цогц байдлаар илэрхийлнэ.

Нягтлан бодох бүртгэлийн тогтолцоо, мэдээлэл хэрэглэгчийн эрэлтээс хамааран тайланг дараах үндсэн төрлөөр гаргана.

- Санхүүгийн тайлан
- Татварын тайлангууд
- Зардлын болон удирдлагын тайлан

Санхүүгийн тайлангийн бүрдэл

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8.1 Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна.

- Санхүүгийн байдлын тайлан
- Орлогын тайлан
- Өмчийн өөрчлөлтийн тайлан
- Мөнгөн гүйлгээний тайлан

Санхүүгийн тайлангаа Сангийн сайдын 2017 оны 361 тоот тушаалаар батлагдсан “Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ыг удирдамж болгон бэлтгэн толилуулах ба санхүүгийн тайлангийн бүтэц бүрэлдэхүүн тус зааварт нийцсэн байна.

Санхүүгийн байдлын тайлан: Тухайн бизнесийн үйл ажиллагааны орлогыг олоход ямар хөрөнгийг ашигладаг, тэдгээр хөрөнгүүдийг бий болгохын тулд ямар эх үүсвэр санхүүжилтээр бий болгосон, тэдгээрийн хэмжээ, бүтэц, ерөнхий ангиллыг өмнөх тайлант хугацааны үлдэгдэлтэй зэрэгцүүлсэн байдлаар харуулах ба санхүүгийн тайлангийн мэдээлэл хэрэглэгчдэд компанийн хөрвөх чадвар, төлбөрийн чадвар, тогтвортой байдал, санхүүгийн уян хатан байдал зэрэг хүчин зүйлсэд хариу болохуйц товч мэдээллийг илэрхийлнэ.

Санхүүгийн байдлын тайлан нь хөрөнгө, түүнийг бий болгосон эх үүсвэр гэсэн бүтэцтэй байна. Санхүүгийн байдлын тайлан дахь хөрөнгө нь дараах зүйлсээс бүрдэж байна.

- Эргэлтийн хөрөнгө:
 - Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө
 - Авлага (Тээврийн хөлсний авлага буюу дансны авлага, Татвар НДШ-ийн авлага, бусад авлага)
 - Хөрөнгө оруулалт
 - Урьдчилж төлсөн тооцоо
 - Бараа материал
 - Борлуулах зорилготой эргэлтийн бус хөрөнгө
- Эргэлтийн бус хөрөнгө:
 - Үндсэн хөрөнгө
 - Биет бус хөрөнгө
 - Хөрөнгө оруулалт
 - Хойшлогдсон татварын хөрөнгө
 - Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө
 - Бусад эргэлтийн бус хөрөнгө

Санхүүгийн байдлын тайлан дахь эх үүсвэр нь өр төлбөр болон өөрийн хөрөнгө буюу өмчийн өөрчлөлтийн тайлангийн зүйлсээс бүрдэнэ. Өр төлбөрийг СТОУС-ын дагуу төлөгдөх хугацаагаар нь ангилан богино хугацаат эсвэл урт хугацаат гэж ангилан тайлагнах ба дараах зүйлс багтана.

- Өр төлбөр:
 - Дансны өр төлбөр
 - Цалингийн өр төлбөр
 - Татвар, НДШ-ийн өр төлбөр
 - Хойшлогдсон орлого буюу урьдчилж орсон орлого
 - Бусад өр төлбөр

Орлогын дэлгэрэнгүй тайлан: Тухайн тайлангийн хугацааны туршид компани ямар бүтээгдэхүүн, үйлчилгээ үйлдвэрлэж түүнийгээ худалдан авагч, хэрэглэгчид зарж борлуулснаар хэчнээн хэмжээний орлогыг бий болгосон, мөн уг орлогыг олохын тулд хэчнээн хэмжээний зардал гаргасан, улмаар ямар хэмжээний ашиг олсон эсвэл алдагдал хүлээснийг харуулна. “Тэнгэрлиг медиа групп” ХК-ийн орлогын дэлгэрэнгүй тайлан нь тайлангийн хугацаанд СТОУС-ын дагуу орлого, зардлаар хүлээн зөвшөөрсөн дараах зүйлсээс бүрдэнэ.

- Борлуулалтын орлого

- Борлуулалтын өртөг
- Түрээсийн орлого
- Хүүний орлого
- Ногдол ашгийн орлого
- Эрхийн шимтгэлийн орлого
- Бусад орлого
- Борлуулалт маркетингийн зардал
- Ерөнхий удирдлагын зардал
- Санхүүгийн зардал
- Бусад зардал
- Гадаад валютын ханшийн зөрүүний олз, гарз
- Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз, гарз
- Биет бус хөрөнгө данснаас хассаны олз, гарз
- Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз, гарз
- Бусад ашиг, алдагдал
- Татварын зардал

Өмчийн өөрчлөлтийн тайлан: Хувьцаа эзэмшигчдийн зүгээс оруулсан хөрөнгө оруулалт болон өнгөрсөн үйл явдлаас хуримтлагдсан ашиг, тэдгээрийн үлдэгдэл, өөрчлөлтийг зэрэгцүүлсэн байдлаар харуулна.

“Тэнгэрлиг медиа групп” ХК ХК-ийн хувьд өмчийн өөрчлөлтийн тайлан нь дараах зүйлсээс бүрдэнэ.

- Дүрмийн сан буюу хувьцаа эзэмшигчдийн оруулсан хөрөнгө
- Нэмж төлөгдсөн капитал
- Халаасны хувьцаа
- Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл
- Хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнийн нөөц
- Тусгай зориулалттай сан
- Хуримтлагдсан ашиг

Мөнгөн гүйлгээний тайлан: Тайлангийн хугацааны мөнгөн орлого, зардлын урсгал, санхүүжилтийн хэлбэр, бүтэц, хэмжээг өмнөх тайлант хугацаатай зэрэгцүүлэн харуулах ба санхүүгийн тайлангийн мэдээлэл хэрэглэгчдэд ямар санхүүгийн эх үүсвэрээр үйл ажиллагаагаа санхүүжүүлсэн гэдгийг мэдээлэх зорилготой.

Компани СТОУС-ын дагуу мөнгөн урсгалаа дараах хэсгүүдэд харуулна.

- Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ
- Хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээ
- Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ

Нэгтгэсэн санхүүгийн тайлан: Нэг буюу түүнээс дээш охин компанитай аж ахуйн нэгж, байгууллага нэгтгэсэн санхүүгийн тайлан гаргана. /НББТХ 8.3 дахь заалт/

Нэгтгэсэн санхүүгийн тайлан нь дараах тайлангуудаас бүрдэнэ.

- Нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан
- Нэгтгэсэн орлогын дэлгэрэнгүй тайлан
- Нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан
- Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан
- Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулга

Нэгтгэсэн санхүүгийн тайлангуудын дотоод бүтэц тусдаа санхүүгийн тайлангийн бүтэцтэй ижил байх бөгөөд санхүүгийн тайлангийн үзүүлэлт тус бүрийн хувьд харгалзах үзүүлэлтүүдээр нэгтгэсэн дүнг илэрхийлнэ.

Санхүүгийн тайланг бэлтгэх зарчим

“Тэнгэрлиг медиа групп” ХК нь санхүүгийн тайлангаа бэлтгэхэд “СТОУС-ын үзэл баримтлал”-ын дагуу дараах зарчмуудыг баримтална.

- **“Аккруэл суурь” зарчим:** Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө” гэж заасан ба энэ нь ажил гүйлгээ, үйл явцын үр нөлөөг гарсан тухайд бүрд нь хүлээн зөвшөөрч, төлбөрийг мөнгөөр хүлээн авсан эсвэл төлсөн эсэхээс үл хамааран гарсан тухайн хугацаанд нь хүлээн зөвшөөрч бүртгэх зарчим юм.
- **Тасралтгүй байх зарчим:** Аж ахуйн нэгж нь одоо явуулж байгаа үйл ажиллагаагаа алс ирээдүйд ч хэвийн тасралтгүй үргэлжлүүлнэ гэсэн төсөөлөлд үндэслэн санхүүгийн тайлангаа бэлтгэх явдал. Тасралтгүй ажиллагаанд сөргөөр нөлөөлөхүйц ямар нэгэн шинж тэмдэг илэрсэн тохиолдолд энэ талаар санхүүгийн тайлангийн тодруулга хэсэгт тэмдэглэнэ.

Санхүүгийн тайланд тавигдах шаардлага

“Тэнгэрлиг медиа групп” ХК -ийн санхүүгийн тайлангийн мэдээллүүд нь дараах шаардлагыг хангасан байна.

- **Цаг хугацаатай байх:** Санхүүгийн тайлан нь цаг хугацаандаа бэлтгэгдэж, хэрэглэгчийн шийдвэр гаргах хэрэгцээг аль болох хангаж байх ёстой. Үүний тулд жилийн санхүүгийн тайланг хууль заасан хугацаанд гаргаж, холбогдох байгууллагуудад тайлагнана.
- **Үр дүн, зардлын хоорондын тэнцвэрийг хангасан байх:** Тайлан мэдээллийг боловсруулахад гарсан зардал нь түүнээс олж болох үр дүнгээс бага байхаар зохион байгуулагдсан байна.
- **Чанартай байх:** Санхүүгийн тайлан нь нягтлан бодох бүртгэлийн зорилго, зорилгод нийцсэн, мэдээлэл нь хэрэглэгчдийн эрэлтийг хангасан байвал зохино.
- **Үнэнч шударга байдал:** Санхүүгийн байдал, үр дүн, түүнд гарсан өөрчлөлтийг шударгаар илэрхийлнэ.

Санхүүгийн тайлангийн элементүүд:

- **Хөрөнгө:** Ирээдүйд эдийн засгийн үр өгөөж авч ирэх, аж ахуйн нэгжийн эзэмшилд байгаа нөөцийг хэлнэ. Санхүүгийн тайланд тусгагдсан хөрөнгө нь “Тэнгэрлиг медиа групп” ХК -ийн удирдлагын төвд бодитой оршин байгаа хөрөнгийг илэрхийлнэ.
- **Өр төлбөр:** Өнгөрсөн үеийн үйл ажиллагааны үр нөлөөгөөр үүссэн, хүлээгдэж буй төлбөр тооцоо бөгөөд бусдын өмнө хүлээх хариуцлага юм. Аливаа өр төлбөрийг тайлагнахгүй орхигдуулах, нэг байгууллагад төлөх өрийг өөр байгууллагаас авах авлагаар хааж, цэвэрлэн харуулахыг хориглоно.
- **Өмч, капитал:** Компанид анх оруулсан хөрөнгө, хуримтлагдсан ашиг, түүнээс байгуулсан сан, нөөц, бусад эх үүсвэр зэргээс бүрдэнэ.
- **Орлого:** Хөрөнгийг бий болгох, нэмэгдүүлэх хэлбэрээр тайлангийн үед бий болсон үр дүн өртгийн өсөлтийг хэлнэ.
- **Зардал:** Хөрөнгийг зарлагадах хэлбэрээр тайлант үед гарсан эдийн засгийн үр дүнгийн өртгийн бууралтыг хэлнэ.
- **Үйл ажиллагааны үр дүн:** Орлого зардлын харьцуулалтын үр дүн буюу ашиг алдагдлаар тодорхойлогдоно.

Санхүүгийн жил

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 10.1 дэх хэсэгт Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлангийн жилийг заасан бөгөөд уг зохицуулалтын дагуу “Тэнгэрлиг медиа групп” ХК-ийн санхүүгийн жил нь тухайн оны 1 дүгээр сарын 1-нээс 12 дугаар сарын 31-нийг дуустал хугацааг хамаарна.

Татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан:

Компанийн татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн тайлангууд нь татварын ерөнхий хууль болон холбогдох татварын хуулиуд, нийгмийн даатгалын тухай хууль, дүрэм, журам зэрэг зохицуулалтын эрхзүйд нийцсэн, нээлттэй, ил тод, шударгаар бэлтгэгдсэн байна.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар:

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 4.1.1, 5.1-д “Тэнгэрлиг медиа групп” ХК хувьд ААНОАТ төлөгч болох үндэслэл болно.

Нэмэгдсэн өртгийн албан татвар:

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн тухай хуулийн 4.1.5, 5.2-д заасны үйл ажиллагааны борлуулалтын орлогын хэмжээ нь 50 сая ба түүнээс дээш төгрөгт хүрч, албан татвар ногдуулан суутган авч, төсөвт төвлөрүүлэх үүрэг бүхий этгээд албан татвар суутган төлөгч байна гэж тодорхойлсон. Эдгээр нь “Тэнгэрлиг медиа групп” ХК-ийн хувьд НӨАТ ногдох ажил үйлчилгээ явуулсан тохиолдолд НӨАТ-ын тайлан бэлтгэх үндэслэл болно.

Хувь хүний орлогын албан татварын тайлан:

Татварын ерөнхий хуулийн 6.1.19-д “суутган төлөгч” гэж тухайн төрлийн татварын хуулийн дагуу татвар төлөгчийн төлөх татварыг суутгаж, төсөвт шилжүүлэх, тайлагнах үүрэг бүхий этгээдийг тодорхойлсон. Энэ нь “Тэнгэрлиг медиа групп” ХК -ийн хувьд ажиллагсад болон хувь хүмүүст олгож буй зарим орлогууд (хуулийн дагуу ХХОАТ суутгах ёстой орлогууд)-аас татвар суутган тооцож холбогдох тайланг бэлтгэн тайлагнах үндэслэл болно.

Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тайлан:

Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн 4.1.1-д өмчийн бүх төрөлд хамаарагдах компани, ... албан татвар төлөгч байхаар тодорхойлсон. Энэ нь “Тэнгэрлиг медиа групп” ХК-ийн хувьд үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар төлөгчийн үүрэг хүлээх үндэслэл болох ба үл хөдлөх эд хөрөнгө эзэмшиж байх хугацаанд бэлтгэнэ.

Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тайлан:

Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1-д “Улсын бүртгэлд байгаа автотээврийн болон өөрөө явагч хэрэгсэлд тэдгээрийг ашиглаж байгаа эсэхийг үл харгалзан албан татвар ногдуулна, 2-д Автотээврийн болон өөрөө явагч хэрэгсэл ашиглалтаас хасагдсан тохиолдолд улсын бүртгэлээс хассан тухай албан ёсны баримт бичгийг үндэслэн түүнд ногдох албан татварыг дараа улирлаас эхлэн зогсооно. Албан татвар төлөгч автотээврийн болон өөрөө явагч хэрэгсэл өмчлөх эрхээ бусдад шилжүүлсэн тохиолдолд түүний албан татвар төлөх үүрэг дараа улирлаас эхлэн дуусгавар болно гэж тус тус заасан. Энэ нь “Тэнгэрлиг медиа групп” ХК-ийн хувьд автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар төлөх үндэслэл болох ба автомашин эзэмшиж байх хугацаанд бэлтгэнэ.

Нийгмийн даатгалын шимтгэл ногдуулалт, төлөлтийн тайлан:

Нийгмийн даатгалын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 7-д “шимтгэл төлөгч” гэж хууль тогтоомжийн дагуу нийгмийн даатгалын шимтгэл төлөх үүрэг хүлээсэн хуулийн этгээдийг хэлнэ гэж тодорхойлсон. Энэ нь компани нийгмийн даатгалын шимтгэл ногдуулалт, төлөлтийн тайланг бэлтгэх үндэслэл болох бөгөөд тус хуулийн 32 дугаар зүйлд заасан ангилалд хамаарах ажил гүйлгээ гарсан сар бүрийн тайланг бэлтгэн тайлагнана.

Санхүүгийн тайлан бэлтгэх хугацаа

Эрх зүйн үндэслэл: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9.1. Аж ахуйн нэгж, байгууллага санхүүгийн тайлангаа энэ хуулиар тогтоосон хугацаанд харилцагч санхүүгийн байгууллагад цахим хэлбэрээр хүргүүлэх үүрэгтэй, мөн хуулийн 10.3-д энэ хуулийн 4.1.1-д заасан стандартыг мөрдөх үүрэгтэй аж ахуйн нэгж, байгууллага нь эхний хагас жилийн санхүүгийн тайланг 7 дугаар сарын 20-ны өдрийн дотор, жилийн санхүүгийн тайланг дараа оны 2 дугаар сарын 10-ны өдрийн дотор харилцагч санхүүгийн байгууллагад цахим хэлбэрээр хүргүүлнэ гэж тус тус заасан.

Нэгтгэсэн санхүүгийн тайланг группийн нэгтгэлд хамрагдаж буй компаниудын санхүүгийн тайланд үндэслэн бэлтгэх ба дараа оны 3 дугаар сарын 01-ний өдрийн дотор бэлтгэн харилцагч санхүүгийн байгууллагад цахим хэлбэрээр хүргүүлнэ.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 26 дугаар зүйлд аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайланг тайлагнах хугацааг тодорхойлж өгсөн бөгөөд өмнөх жилийн татвар ногдуулах орлогын дүнгээс хамааруулан тайлагнахаар байна. Үүнд:

- Хуулийн 26.1-д “Өмнөх татварын жилийн албан татвар ногдуулах орлого нь 6 тэрбум төгрөг ба түүнээс дээш бол уг албан татвар төлөгч тухайн татварын жилийн улирлын татварын тайланг дараа улирлын эхний сарын 20-ны дотор, жилийн эцсийн татварын тайланг дараа оны 2 дугаар сарын 10-ны дотор харьяалах татварын албанд хүргүүлнэ”
- 26.2. Татварын өмнөх жилийн албан татвар ногдуулах орлого нь 6 тэрбум төгрөг хүртэл энэ хуулийн 29.1-д заасны дагуу татварын албанд бүртгүүлээгүй албан татвар төлөгч тухайн татварын жилийн эхний хагас жилийн татварын тайланг 7 дугаар сарын 20-ны дотор, жилийн эцсийн татварын тайланг дараа оны 2 дугаар сарын 10-ны дотор гаргаж, харьяалах татварын албанд хүргүүлнэ.
- 26.8. Албан татвар төлөгч үйл ажиллагаа эрхлээгүй тухай тайлан гаргасан жилийн дараагийн татварын жилээс эхлэн жилд нэг удаа дараа оны 2 дугаар сарын 10-ны дотор харьяалах татварын албанд хүргүүлнэ. Өөрөөр хэлбэл жилийн турш үйл ажиллагаа явуулаагүй Х тайлан гаргасан тохиолдолд дараагийн тайлангийн хугацаанд жилд нэг удаа тайлангаа илгээнэ.
- 29.13. Энэ хуулийн 29.1-д заасны дагуу гаргасан хүсэлтээ татварын албанд бүртгүүлсэн албан татвар төлөгч жилийн эцсийн татварын тайланг дараа оны 2 дугаар сарын 10-ны дотор харьяалах татварын албанд хүргүүлнэ.
- 29.1.Өмнөх татварын жилийн тайлангаар баталгаажсан борлуулалтын нийт орлогын хэмжээ 50.0 сая төгрөгөөс бага бол тухайн албан татвар төлөгч тухайн татварын жилийн 3 дугаар улиралд багтаан хүсэлт гаргасныг харьяалах татварын алба бүртгэж авсан тохиолдолд дараагийн татварын жилээс эхлэн тухайн албан татвар төлөгчийн үйл ажиллагааны орлогын нийт дүнгээр албан татвар ногдуулах орлогыг тодорхойлж болно.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 16.1-д “албан татвар суутган төлөгч нь борлуулсан бараа, ажил, үйлчилгээнд ногдох албан татварыг дараа сарын 10-ны өдрийн 23 дотор төрийн сангийн нэгдсэн дансанд шилжүүлж, баталсан маягтын дагуу тайлангаа харьяалах татварын албанд тушаана” гэж заасан.

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 27.1-д “суутган төлөгч энэ хуулийн 14 дүгээр зүйл, 16.1.2, 16.1.3, 16.1.4, 17.1.1, 18 дугаар зүйл, 19.1.1, 19.1.2, 20.1-д заасан буюу хувь хүнд олгосон орлогод ногдуулан суутгасан албан татварын улирлын тайланг дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор, жилийн тайланг дараа оны 2 дугаар сарын 15- ны өдрийн дотор өссөн дүнгээр гаргаж, харьяа татварын албанд хүргүүлэхээр заасан.

Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн 9.1-д “албан татвар төлөгч нь үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тайланг дараа оны 2 дугаар сарын 10-ны дотор харьяалагдах татварын албанд тушаана.

Монгол улсын автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2-д “Аж ахуйн нэгж, байгууллага автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн жилийн албан татварыг тэнцүү хэмжээгээр улирал бүрийн сүүлчийн сарын 25- ны дотор багтаан төсөвт төлж дараа оны 2 дугаар сарын 15-ны дотор тайланг татварын албанд ирүүлнэ.

Нийгмийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 3-д “Ажил олгогч нь тухайн сарын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг дараа сарын 05-ны өдрийн дотор нийгмийн даатгалын байгууллагад ирүүлэх бөгөөд энэ хугацаа долоо хоног бүрийн амралт, нийтээр амрах баярын өдөртэй давхацвал дараагийн ажлын өдөр тайлагнана” гэж тус тус заасан.

“Тэнгэрлиг медиа групп” ХК санхүүгийн болон татвар, нийгмийн даатгалын шимтгэл ногдуулалт, төлөлтийн тайлангуудыг хуулиар тогтоосон хугацааг баримтлан харьяалах татвар, санхүүгийн байгууллагад тайлагнана.

IV. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ТУСГАЙ БОДЛОГУУД

4.1. Мөнгөн хөрөнгийн бүртгэлийн бодлого

Мөнгөн хөрөнгийн бүртгэлийн бодлогын зорилго

Мөнгөн хөрөнгийн бүртгэлийн бодлогын зорилго нь мөнгөн хөрөнгийн бүрэлдэхүүн, түүний бүртгэл, дотоод хяналтын талаарх мэдээллийг гаргах аргыг тодорхойлоход оршино.

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгөд хамаарагдах зүйлс

“Тэнгэрлиг медиа групп” ХК-ий мөнгө, түүнтэй адилтгах зүйлсэд дараах зүйлс хамаарагдана. Үүнд:

- Бэлэн мөнгө: Бизнесийн ердийн үйл ажиллагаанд ашиглах зорилгоор бэлнээр байршуулсан цаасан болон зоосон мөнгө.
- Банкинд байршуулсан мөнгөн хөрөнгө: Бизнесийн үйл ажиллагаанд ашиглах зорилгоор банкны харилцах болон хадгаламжийн дансанд байршуулсан мөнгө.
- Мөнгөн хөрөнгөтэй адилтгах зүйлс: Үнэ цэнийг өөрчлөх өчүүхэн бага эрсдлийг мэдэрдэг, мөнгөний тодорхой дүнд чөлөөтэй хувирдаг, хөрвөх чадвар сайтай богино хугацаат хөрөнгө оруулалтыг хамааруулна.

Бүртгэлд тусгах

“Тэнгэрлиг медиа групп” ХК нь мөнгөн хөрөнгөө касс болон банкны харилцах дансуудад үндэслэн бүртгэнэ. Тэдгээрт гарсан мөнгөн хөрөнгийн гүйлгээг тус тусад нь мөнгөн хөрөнгийн журналд тусгана.

Кассын журналд ажилчдын цалинг тавьж олгох болон зарим төрлийн эд зүйлс, бараа материалыг худалдан авах, үйлчилгээний төлбөрийг төлөх зорилгоор кассанд авчирсан бэлэн төгрөг, валютын орлого, кассаас тавьж олгосон цалингийн урьдчилгаа, бэлэн мөнгөөр худалдан авсан бараа материал, эд зүйлс худалдан авах зэрэг ажил гүйлгээг бүртгэнэ. Бэлэн мөнгө авахыг хүсэгч бараа материал олгохыг хүссэн өргөдөл бичиж, захирал, ерөнхий нябо нараар цохуулсаны дараа кассын няраваас очиж авна. Кассын орлого болон зарлагын гүйлгээг нябо нягтлан бодох бүртгэлд тусгахдаа гарсан гүйлгээ нэг бүртэй танилцаж зохих дансуудад хуваарилан бичнэ.

Харилцахын журналд банкны харилцах дансуудад банкны харилцахын хуулгаар орсон мөнгөн орлого, банкны харилцах дансуудаас гарсан мөнгөний зарцуулалтыг энэ журналд бүртгэж холбогдох дансны бичилтийг хийнэ. Харилцах дансны орлого зарлага нь банкны хуулга дээр тодорхой тусгагдсан байна.

Банкны гүйлгээ хийхийн тулд тухайн байгууллага төлбөрийн даалгавараар бичиж анхан шатны баримтанд тусгана. Борлуулалтын болон хийж гүйцэтгэсэн ажил үйлчилгээний орлого банканд дахь харилцаагаар дамжин орж ирэхдээ мөн төлбөрийн даалгавараар хийгдэнэ. Тухайн дансанд орсон болон гарсан ажил гүйлгээ бүрийн төлбөрийн даалгавар тухайн байгууллагад нэг хувь байх ёстой бөгөөд эдгээр анхан шатны баримтуудад үндэслэн нягтлан бодох бүртгэлд тусгана. Банкны хуулга нь байгууллагын харилцах дансаар орсон болон гарсан мөнгөний хэмжээг илэрхийлэгч баримт юм. “Тэнгэрлиг медиа групп” ХК -ий банкны гүйлгээг зөвхөн тооцооны болон ерөнхий нябо хийнэ.

Компанийн харилцахад байгаа мөнгөний тайланг банкны нягтлан гаргасныг харилцахын хуулга гэж нэрлэнэ. Хэрэв ямар нэгэн алдаа орхигдол гараагүй, бүх дансанд орсон мөнгө (хадгаламж), данснаас гарсан мөнгө (чек) нь банкны тайлан ба компанийн мөнгөн хөрөнгийн журналд тусгагдсан бол банкны тайлан дахь мөнгөний үлдэгдэл нь компанийн НББ дэх мөнгөний үлдэгдэлтэй тэнцүү байна. Компанийн бүртгэл дэх буюу мөнгөн хөрөнгийн дансны ерөнхий дэвтрийн үлдэгдэл болон банкны тайлан дах мөнгөн хөрөнгийн үлдэгдэл дараах тохиолдолд зөрнө. Үүнд:

1. Бүртгэлд тусгагдсан зүйл банкны тайланд тусгагдаагүй байх
2. Банкны тайланд тусгагдсан зүйл бүртгэлд тусгагдаагүй байх

Бүртгэлд тусгагдсан боловч банкны тайланд тусгагдаагүй зүйл нь:

1. Замд яваа хадгаламж
2. Төлбөр хийгдээгүй чек
3. Алдаа

Банкны тайланд тусгагдсан боловч бүртгэлд тусгагдаагүй зүйл:

1. Банкны үйлчилгээний хөлс
2. Хүү ба авлагын цуглуулалт
3. Хүрэлцээгүй сантай чек
4. Алдаа

1. Замд яваа хадгаламж

Компанийн бүртгэлд тусгагдсан боловч тухайн сард банкинд орж ирээгүй мөнгөн орлого. Жишээ: компани өөр банкаар дамжуулан сарын эцсийн өдөр харилцах дансандаа шилжүүлсэн мөнгө нь дараа сарын эхэнд дансанд орж ирж болно. Учир нь банк хоорондын гүйлгээг төв банкаар дамжуулан хийнэ. Замд яваа хадгаламжийг банкны үлдэгдэл дээр нэмж тохируулна.

2. Төлбөр хийгдээгүй чек (гар дээр байгаа чек) буюу төлбөр хийгдээгүй даалгавар

Байгууллага төлбөрийн даалгавар бичээд мөнгө зарцуулсан талаар мөнгөн зарлагын журналд бүртгэсэн боловч банкны нягтлан төлбөрийг данснаас шилжүүлээгүй байж болно. Нэгэнт компани төлбөрийн даалгавар бичсэн бол банк данснаас мөнгө гаргах үүрэгтэй. Төлбөр хийгдээгүй чекийг банкны үлдэгдлээс хасч тохируулна.

3. Банкны үйлчилгээний шимтгэл

Банк үйлчилгээ үзүүлсний төлбөрийг компанид мэдэгдэлгүйгээр шууд данснаас нь суутгадаг. Иймд компани энэ төлбөрийг харилцахын хуулга иртэл мөнгөний зарлагын журналдаа бүртгээгүй байж болно. Банкны үйлчилгээний хөлсийг бүртгэлийн үлдэгдлээс хасна.

4. Банкны кредит

Дансанд мөнгө орсныг компанийн нягтлан харилцахын хуулга хүлээн авах хүртэл мэдээгүй байж болно. Банкны цуглуулсан мөнгийг бүртгэлийн үлдэгдэл дээр нэмж тохируулна.

5. Хүрэлцээгүй сантай чек

Компани харилцагч байгууллагаас мөнгө шилжүүлсэн тухай баримт хүлээн авч мөнгөн орлогын журналд бүртгэсэн боловч харилцахын хуулга ирсэн үед уг мөнгө нь дансанд орж ирээгүй, эсвэл дутуу орж ирсэн байж болно. Хүрэлцээгүй сантай чекийг бүртгэлийн үлдэгдлээс хасч тохируулах ба авлагаар бүртгэнэ.

6. Алдаа

Компанийн нягтлан эсвэл банкны нягтлангийн гаргасан санаатай болон санамсаргүй алдаа. Алдаа гаргасан тал нь алдаагаа залруулах тохируулга хийнэ.

Компани мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг зөв гаргах, банкны ба бүртгэлийн үлдэгдлийн хоорондын зөрүүг арилгахын тулд банкны тохируулгын тайланг бэлтгэнэ. Банкны тохируулгын тайланг бүртгэлийн дүнтэй тулгаж баталгаажуулах үүргийг “Тэнгэрлиг медиа групп” ХК -ий ерөнхий нягтлан бодогч хүлээнэ. Банкны тохируулгын тайланг бэлтгэсний дараа мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг зөв болгохын тулд холбогдох журналын бичилтийг бэлтгэнэ.

Санхүүгийн тайланд тусгах

Мөнгөн хөрөнгө нь хөрвөх чадвар хамгийн сайтай хөрөнгө учраас балансын хөрөнгө хэсэгт хамгийн эхэнд нь тусгана.

4.2. Авлагын бүртгэл

Авлагын бүртгэлийн зорилго

Авлагын бүртгэлийн зорилго нь авлагыг бүртгэх бүртгэлийн аргыг тодорхойлоход оршино.

Авлагын дансанд хамаарагдах зүйлс

Авлагын дансанд бусад аж ахуй нэгж байгууллага, хувь хүмүүсийн “Тэнгэрлиг медиа групп” ХК -д төлвөл зохих дүнг хамааруулан үзнэ.

Хүлээн зөвшөөрөлт ба үнэлгээ

Авлагыг хүлээн зөвшөөрөх дүн нь борлуулагч, худалдан авагч 2 талын хоорондын бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний солилцооны үнэ байна. Авлагыг нэхэмжилсэн дүнгээр тусгана.

“Тэнгэрлиг медиа групп” ХК нь худалдан авагчиддаа борлуулалтын хөнгөлөлт үзүүлэх үед борлуулалтын хөнгөлөлтийг нийт дүнгийн аргаар бүртгэнэ. Энэ нь борлуулалт хийх үедээ авлагыг нийт дүнгээр бүртгэх бөгөөд барааны төлбөрийг хөнгөлөлтийн хугацаанд төлсөн бол борлуулалтын хөнгөлөлтийг хүлээн зөвшөөрч бүртгэх явдал юм.

Авлагыг цэвэр боломжит үнэ цэнээр нь бүртгэлд тусгана. Цэвэр боломжит үнэ цэн гэдэг нь ирээдүйд худалдан авагчаас авах боломжит мөнгөний дүн буюу авлагын данс найдваргүй авлага дансны зөрүүгээр хэмжигдэнэ. Найдваргүй авлага гэдэгт худалдан авагчаас цуглуулагдахгүй гэж үзсэн мөнгөн дүнг хамааруулж үзнэ.

“Тэнгэрлиг медиа групп” ХК нь найдваргүй авлагын нөөцийг Авлагын хувийн жингийн аргаар тооцох ба нөөц байгуулах хувь нь 8% байна.

Авлагын дансны ангилал

“Тэнгэрлиг медиа групп” ХК нь авлагаа дараах үндсэн төрлүүдэд ангилж бүртгэнэ. Үүнд:

- Дансны буюу худалдааны авлага: Зээлийн борлуулалт, зээлээр хийж гүйцэтгэсэн ажил үйлчилгээний үр дүнд үүссэн худалдан авагчийн төлөх дүн.
- Худалдааны бус авлага: Бараа, ажил үйлчилгээтэй холбоогүй хүүгийн авлага, түрээсийн авлага, ажилчдаас авах авлага, ноогдол ашгийн авлага зэрэг хамаарна.
- Авлагын бичиг: Тодорхой хэмжээний мөнгийг тодорхой хугацаанд төлнө гэсэн амлалтын бичиг.

Авлага ба урьдчилгаа төлбөрийн дансны бүртгэлийн горим

Компани хувьцаа болон бусад хөрөнгийг борлуулах, мөнгөөр санхүүжилт олгох зэрэг үйл ажиллагаатай холбоотой авлагыг тухайн ажил гүйлгээ гарсан болохыг анхан шатны баримтаар нотлогдсон үед бүртгэлд тусгах ба ажил үйлчилгээний төрлөөс хамааруулан холбогдох дансны ангилалд валютын төрөл тус бүрээр бүртгэнэ.

Авлагын дансны үндсэн бичилтүүд:

- Бараа материалаа зээлээр борлуулах үед:
 - Дт Авлагын данс
 - Кт Борлуулалтын орлого
- Хөнгөлөлтийн хугацаанд багтан авлагаа цуглуулсан бол:
 - Дт Мөнгөн хөрөнгө
 - Борлуулалтын хөнгөлөлт
 - Кт Авлагын данс
- Хөнгөлөлтийн хугацаа дууссаны дараа авлагаа цуглуулсан үед:

- Дт Мөнгөн хөрөнгө
Кт Авлагын данс
- Авлага найдваргүй болж данснаас хасах үед:
Дт Найдваргүй авлагын зардал
Кт Авлагын данс
- Данснаас хасагдсан авлагыг сэргээх үед:
Дт Дансны авлага
Кт Найдваргүй авлагын зардал
- Авлагыг цуглуулж мөнгийг хүлээн авсан үед:
Дт Мөнгөн хөрөнгө
Кт Авлагын данс
- Барааг зээлээр борлуулж авлагын бичиг үйлдсэн бол:
Дт Авлагын бичиг
Кт Борлуулалтын орлого
- Авлагын бичгийн хүүг тооцох үед:
Дт Хүүгийн авлага
Кт Хүүгийн орлого
- Авлагын бичгийн төлбөрийг хүүгийн хамт хүлээн авах үед:
Дт Мөнгөн хөрөнгө
Кт Авлагын бичиг
Хүүгийн авлага
Хүүгийн орлого
- Авлагын бичгийг борлуулах үед:
Дт Мөнгөн хөрөнгө
Кт Авлагын бичиг
Хүүгийн орлого

Авлагын дансны баримтжуулалт

Нэхэмжлэх: Худалдан авагчдаас авлагыг цуглуулах зорилготой бөгөөд уг баримтанд заасны дагуу худалдан авагч төлбөрийг барагдуулна.

Тооцооны үлдэгдлийн баталгаа: Борлуулагч болон худалдан авагч талууд хоорондын өглөг болон авлагын дүнг тодорхой заасан хугацаанд батгалгаажуулан үйлдэнэ.

Санхүүгийн тайланд тусгах

Авлагыг балансад эргэлтийн хөрөнгө хэсэгт мөнгөн хөрөнгийн дараагийн зүйл болгон цэвэр боломжит үнэ цэнээр тусгана.

4.3. Бараа материалын бүртгэлийн бодлого

Бараа материалын бүртгэлийн бодлогын зорилго

Бараа материалын бүртгэлийн бодлогын зорилго нь бараа материал бүртгэх бүртгэлийн аргыг тодорхойлоход оршино.

“Тэнгэрлиг медиа групп” ХК нь бараа материалын байнгын систем ашиглана. Бараа материалын бүртгэлийн байнгын систем ашиглах гэдэг нь бараа материал авсан тухай бүрд нь “Бараа материал” дансанд орлого авч, бараа материал борлуулах буюу зарлагадах тухай бүрт борлуулсан бараа материалын өртөг тооцож хуримтлуулан бүртгэхийг хэлнэ.

Бараа материалын бүртгэл, хөдөлгөөнийг хариуцсан нягтлан бодогчтой байна. Бараа материал хариуцсан нягтлан бодогч нь бараа материалын худалдан авалт, ашиглалтанд тавьж олгох, түүний үр ашиг, үр бүтээлтэй зарцуулалт, ашиглалтаас хасах зэрэг бараа материалтай холбоотой бүхий л асуудлыг удирдан хариуцна.

Бараа материалд хамаарагдах зүйлс

“Тэнгэрлиг медиа групп” ХК нь өөрийн үндсэн үйл ажиллагаандаа болон компаний хэвийн тасралтгүй үйл ажиллагааг хангахад бараа материалын зүйлсийг ашиглана. Бараа материалын зүйлсд зарж борлуулах бараа материал болон хангамжийн материалыг хамааруулан авч үзнэ. Санхүүгийн тайланд тусгагдсан бараа материал дансны эцсийн үлдэгдэл нь “Тэнгэрлиг медиа групп” ХК -ийн эзэмшилд бодитойгоор байгаа бүх бараа материалын зүйлсийг багтаасан байна.

Бараа материалын үнэлгээ ба хүлээн зөвшөөрөлт

Бараа материалыг өртөг болон цэвэр боломжит үнийн аль багаар нь үнэлнэ. Бараа материалын өртөгт худалдан авалтын өртөг (бараа материалын худалдан авсан үнэ, импортын болон бусад татвар, тээвэрлэлт, ачилт буулгалтын зардал ба бараа материал худалдан авахтай холбогдон гарах бусад зардал), хувиргалтын зардал болон одоогийн байршил ба нөхцөлд бараа материалыг авч ирэхтэй холбогдож гарсан бусад зардлууд орно.

Бараа материалын цэвэр боломжит үнэ цэнэ нь үйл ажиллагааны хэвийн явцад борлуулахаар тооцсон үнээс түүнийг иж бүрдэл болгон тооцсон зардал ба борлуулахад шаардагдах тооцсон зардлыг хассан дүнг хэлнэ.

Бараа материалыг борлуулах үед түүний дансны үнийг тухайн бараа материалын орлогыг хүлээн зөвшөөрсөн тайлант хугацааны зардал гэж хүлээн зөвшөөрч борлуулсан бүтээгдэхүүний өртгөөр тайлагнана.

“Тэнгэрлиг медиа групп” ХК нь бараа материалын зарлагыг дундаж өртгийн аргаар (ДӨА), хангамжийн материалын зарлагыг эхлэж авсанаа эхэлж зарлагдах (ЭАЭЗ) аргаар тооцно.

Бараа материалын бүртгэлд баримтлах бусад заалт

Бараа материалын тооллого: Сар бүрийн эцсийн өдөр бараа материалын нягтлан бодогч, эд хариуцагч нар үлдэгдэлтэй байгаа материалуудыг тоолж тооцоог бодно. Бараа материалын нэгдсэн тооллогыг хагас, бүтэн жилээр гүйцэтгэх захирлын тушаалаар томилогдсон тооллогын комисс хийж гүйцэтгэнэ. Мөн шаардлагатай тохиолдолд гэнэтийн тооллогыг хийнэ. Тооллогыг хийж гүйцэтгэснээс хойш ажлын 5 өдрийн дотор хариуцсан нягтлан бодогч тооцоог бодож, комисс тооллогын үр дүнг удирдлагуудад танилцуулна.

Бараа материал актлах, устгах: Ашиглах болон худалдах боломжгүй болсон, хуучирсан, эвдэрч гэмтсэн бараа материалыг гүйцэтгэх захирлын тушаалаар томилогдсон комисс биетээр тоолж шалгаад шууд устгах, акт тогтоох, эсвэл үнэ хямдруулж худалдах тухай саналыг удирдлагуудад танилцуулан санал оруулна. Удирдлагаас гаргасан шийдвэрийн дагуу зохих арга хэмжээг авч хөрөнгийг устгах, акт тогтоох, эсвэл үнэ хямдруулж худалдана.

Санхүүгийн тайланд тусгах

Бараа материалыг балансад эргэлтийн хөрөнгө хэсэгт мөнгө, авлагын дараагийн зүйл болгон өртөг болон цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар нь тусгана.

Бараа материал орлого болгох журам

Энэ журмын зорилго нь компанийн үндсэн үйлдвэрлэл болон үйл ажиллагаанд шаардлагатай бараа материалыг худалдан авах ажил гүйлгээ гарсанг нотлох, түүнийг хянаж зөвшөөрөх, баримтжуулах, орлогод авах бүртгэлд тусгах, тайлагнах үйл ажиллагааг тодорхойлох, үндэслэлийг зөв бүрдүүлэхэд оршино.

Бараа материалын орлогын гүйлгээнд дараах анхан шатны баримтуудыг ашиглана. Үүнд:

- Бараа материалын захиалгын хуудас
- Бараа материалын хүлээн авалтын баримт НХМаягт БМ-1
- Бараа материалын орлогын баримт НХМаягт БМ-2

Цех, хэлтэс, албадууд тухайн жилд үйл ажиллагаандаа шаардлагатай тоног төхөөрөмж, сэлбэг материалын захиалгыг өмнөх жилийн 10-р сарын 1-ний дотор, нэн шаардлагатай тохиолдолд худалдан авалт хийхээс 3-аас доошгүй хоногийн өмнө “Бараа материалын захиалгын хуудас” маягтаар гаргаж хангамжийн хэлтэст ирүүлнэ.

Эд хариуцагч нь хүчин төгөлдөр баримтаар бараа материалыг орлогод авах ба цаг тухайд нь бүртгэлд тусгах, хадгалалт хамгаалалт бүрэн бүтэн байдлыг хариуцан ажиллана. Бэлтгэн нийлүүлэгч байгууллагаас ирж байгаа бараа материалын үнэ бүхий зүйлс тоо хэмжээ, зэрэг дугаарын хувьд дагалдан ирсэн баримттайгаа тохирч байгаа эсэх, хайрцаг сав, баглаа боодол, лац ломбо гэмтээгүй байгаа эсэхэд шалгалт тулгалт хийж “Бараа материалын хүлээн авалтын баримт”-ыг асуултын дагуу 2 хувь бичнэ.

Эд хариуцагч нь бэлтгэн нийлүүлэгч болон өөрийн үйлдвэрийн цех, тасаг, туслах аж ахуйгаас боловсруулсан зүйлс, үйлдвэрлэлд тавьж олгосон төрөл бүрийн материалын зарцуулагдаагүй үлдэгдэл, үндсэн хөрөнгийн устгалаас ашигласан материал, үнэ бүхий зүйлийг орлого болгохдоо дагалдан ирсэн бичиг баримтыг үндэслэн “Бараа материалын орлогын баримт”-ыг 3 хувь үйлдэнэ.

Бараа материал хариуцсан нягтлан бодогч нь эд хариуцагчийн гаргасан тайлангийн баримтын бүрдэл, хүчин төгөлдөр эсэхийг шалгаж санхүүгийн программд оруулна. Бараа материалын орлогын журнал, тайланг компьютерээс хэвлэн гаргаж холбогдох тайлан, баримтын хамт үдэж хадгална.

Бараа материал зарлага болгох журам

Энэхүү журмын зорилго нь компанийн үндсэн үйлдвэрлэл болон үйл ажиллагаанд шаардлагатай бараа материалын зарцуулалтын ажил гүйлгээ гарсныг нотлох, түүнийг хянаж зөвшөөрөх, баримтжуулах, бүртгэлд тусгах, тайлагнах үндэслэлийг зөв бүрдүүлэхэд оршино.

Бараа материалын зарлагын гүйлгээнд дараах анхан шатны баримтуудыг ашиглана. Үүнд:

- Бараа материалын шаардах хуудас НХМаягт БМ-6
- Бараа материалыг гаргах зөвшөөрөл НХМаягт БМ-4
- Бараа материалын зарлагын баримт НХМаягт БМ-3

Материал үнэ бүхий зүйлсийг байгууллагын үйлдвэрлэл, дотоод хэрэгцээнд зарцуулах шаардлага гарсан үед уг зүйлийг авч зарцуулах ажилтан “Бараа материалын шаардах хуудас”-ыг 1 хувь бичиж эрх бүхий албан тушаалтнаас зөвшөөрөл авна.

Бараа материал үнэ бүхий зүйлийг худалдан авагч гадны байгууллагад илүүдэлтэй байгаа бараа материалыг ачуулах, нэг агуулахаас нөгөө агуулах руу шилжүүлэх тохиолдолд эд хариуцагч зөвшөөрөл шийдвэрийг үндэслэн “Бараа материалын зарлагын баримт”-ыг 2 хувь бичнэ. Эд хариуцагч нь бараа материалын зарлагын баримт, шаардах хуудсын хүчин төгөлдөр эсэхийг хянаж, зөвшөөрсөн хэмжээгээр нь тавьж олгон хүлээн авсан хүнээр гарын үсэг зуруулна.

Бараа материал хариуцсан нягтлан бодогч нь эд хариуцагчийн гаргасан тайлангийн баримтын бүрдэл, хүчин төгөлдөр эсэхийг шалгаж санхүүгийн программд оруулна.

Бараа материал дансны үндсэн бичилтүүд

- Бараа материал худалдан авах үед:
Дт Бараа материал
Кт Мөнгөн хөрөнгө/Дансны өглөг
- Бараа материал борлуулах үед:
Дт Дансны авлага/ Мөнгөн хөрөнгө
Кт Борлуулалтын орлого
Дт ББӨ
Кт Бараа материал
- Бэлтгэн нийлүүлэгчрүү бараа буцаасан үед:
Дт Дансны өглөг/ Мөнгөн хөрөнгө
Кт Бараа материал
- Хугацаандаа барааны төлбөрийг төлсөн үед:
Дт Дансны өглөг
Кт Мөнгөн хөрөнгө

4.4. Борлуулах зорилготой эргэлтийн бус хөрөнгө ба зогсоосон үйл ажиллагааны нягтлан бодох бүртгэлийн бодлого

БЗЭБХ-ийн бүртгэлийн бодлогын зорилго:

БЗЭБХ-ийн бүртгэлийн бодлого нь дараах зорилготой.

- БЗЭБХ-ийг компанийн үйл ажиллагаатай уялдуулан зөв ангилж, бүртгэх, тайлагнах,
- БЗЭБХ-ийн бүртгэл, тайлагналтай холбоотой компанийн хэрэгжүүлж буй хяналтын тогтолцоог хэрэгжүүлэх,
- БЗЭБХ-ийн бодит үнэ цэнийг тодорхойлох,
- БЗЭБХ-тэй холбоотой санхүүгийн удирдлагыг хэрэгжүүлэхэд туслах,
- Санхүүгийн тайлангийн мэдээлэл хэрэглэгчдийг БЗЭБХ-тэй холбоотой үнэн зөв мэдээллээр хангах,
- БЗЭБХ болон зогсоосон үйл ажиллагааны хэмжилт, хэрхэн тайлан толилуулах;
- СТОУС-д нийцсэн бүртгэл хөтлөх,

БЗЭБХ-ийн бүртгэлд хамаарах зүйл:

“Тэнгэрлиг Медиа Групп” ХК эргэлтийн бус хөрөнгийн дансны үнийг үргэлжлүүлэн ашиглах замаар биш борлуулах замаар нөхөн олж авах бол уг хөрөнгийг борлуулах зорилготой эргэлтийн бус хөрөнгө гэж үзнэ. Үүнд дараах хоёр зүйлийг хамруулж ойлгоно:

- Борлуулах зорилготой эргэлтийн бус хөрөнгө
- Зогсоосон үйл ажиллагаа
 - Борлуулах зорилготой эргэлтийн бус хөрөнгө: Эргэлтийн бус хөрөнгө буюу үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгийг үндсэн үйл ажиллагааны дагуу ашиглах биш ойрын хугацаанд борлуулах боломжтой, борлуулалтын идэвхжүүлэлт төлөвлөгөө гарсан, боломжит борлуулах үнийг тогтоож тооцсон хөрөнгө байна.
 - Зогсоосон үйл ажиллагаа: Компанийн бүрэлдэхүүн нэг хэсэг байх бөгөөд данснаас хассан эсвэл борлуулах зорилгоор ангилсан дараах зүйлс байна үүнд (i) тусдаа томоохон үйл ажиллагааны чиглэл эсвэл үйл ажиллагаа явуулах газар зүйн бүс нутгийн төлөөлөл, (ii) тусдаа томоохон бүс нутгийн үйл ажиллагааны чиглэлийг борлуулах, дахин борлуулах зорилгоор худалдан авч эзэмшсэн охин компани байна.

Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт:

Борлуулах зорилготой гэж ангилсан эргэлтийн бус хөрөнгө эсвэл борлуулах бүлэг хөрөнгийг түүний дансны үнэ болон бодит үнэ цэнээс борлуулалтын зардлыг хассан дүн хоёрын аль багаар хэмжинэ. Санхүүгийн тайлан бэлтгэх үед үйл ажиллагаанд ашиглаагүй эргэлтийн бус хөрөнгийг борлуулах зорилготой хөрөнгийн шалгуурыг хангавал БЗЭБХ рүү шилжүүлж болно. Хэрэв дансны үнээс бодит үнэ цэнээс борлуулалтын зардлыг хассан дүн бага байгаа үед шилжүүлэлт хийх үед энэ хоёр дүнгийн зөрүүгээр үнэ цэнийн бууралтын гарзыг хүлээн зөвшөөрч ашиг, алдагдлын тайланд толилуулна.

БЗЭБХ-ийн ангилалд багтсан хөрөнгийг элэгдүүлэхгүй.

Үйл ажиллагааг зогсоосон гэж ангилах хугацааг өөрчлөх, зогсоосон үйл ажиллагаа гэж ангилах хугацааг байгууллага хууль ёсны борлуулалтын гэрээг байгуулсан өдөр эсвэл эрх бүхий субъектийн шийдвэрээр хөрөнгийг борлуулах албан ёсны төлөвлөгөөг баталж, зарласан өдөр хоёрын аль түрүүнийхээр нь сонгодог.

Борлуулах зорилготой эргэлтийн бус хөрөнгийн шалгуур нь дараах байдалтай байна.

1. Одоогийн нөхцөл байдалтайгаар нь нэн даруй борлуулах боломжтой,
2. Борлуулагдах магадлал өндөр (Борлуулалтын төлөвлөгөө гаргах, идэвхтэй байх),
3. Боломжит үнийг тооцоолсон байх,
4. Ангилсан өдрөөс хойш 1 жилийн дотор хэрэгжих боломжтой,

БЗЭБХ-ийн дансны бүртгэлийн горим:

- Борлуулах зорилготой эргэлтийн бус хөрөнгийг эргэлтийн хөрөнгөөр ангилах ба эргэлтийн бус хөрөнгө рүү ангилах үед дараах бичилт хийнэ:
Дт Борлуулах зорилготой эргэлтийн бус хөрөнгө
Дт Хуримтлагдсан элэгдэл, хорогдол
Кт Холбогдох эргэлтийн бус хөрөнгө
- Хэрэв эргэлтийн бус хөрөнгийг борлуулах зорилгоор ангилал шилжүүлэх үед тухайн хөрөнгийн дансны үнэ, бодит үнэ цэнээс борлуулалтын зардлыг хассан дүнгээс илүү үед үнэ цэнийн бууралтын гарзыг хүлээн зөвшөөрөх үеийн бичилт:
Дт Борлуулах зорилготой эргэлтийн бус хөрөнгө
Дт Үнэ цэнийн бууралтын гарз
Кт Хуримтлагдсан элэгдэл, хорогдол
Кт Холбогдох эргэлтийн бус хөрөнгө
- БЗЭБХ-ийг олж бэлтгэх үед доорх байдлаар бүртгэнэ.
Дт Борлуулах зорилготой эргэлтийн бус хөрөнгө
Кт Мөнгөн хөрөнгө эсвэл холбогдох өр төлбөр
- БЗЭБХ-ийг СТОУС-ын дагуу бодит үнэ цэнээр илэрхийлэх ба тайлангийн хугацааны эцэст бодит үнэ цэнэ болон дансны үнийн зөрүүгээр дараах бичилт хийнэ.

Эсвэл:

- Дт БЗЭБХ-ийн үнэлгээний гарз
- Кт БЗЭБХ

- БЗЭБХ-ийн үнэлгээний олз нь өмнө нь хүлээн зөвшөөрсөн үнэлгээний гарзаас илүүгүй байна. БЗЭБХ-ийг худалдан борлуулах үед олзтой эсвэл гарзтай үнээр худалдаж болно. Энэ үед доорх байдлаар бүртгэнэ.

- Дт Мөнгөн хөрөнгө эсвэл авлага
- Дт БЗЭБХ-ийн борлуулалтын гарз
- Кт БЗЭБХ
- Кт НӨАТ-ын өр

Эсвэл:

- Дт Мөнгөн хөрөнгө эсвэл авлага
- Кт БЗЭБХ
- Кт БЗЭБХ борлуулсны олз
- Кт НӨАТ-ын өр

БЗЭБХ-ийг санхүүгийн тайланд тусгах:

БЗЭБХ, түүнтэй адилтгах зүйлсийг Сангийн сайдын 2017 оны 361 тоот тушаалаар батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу дараах байдлаар тусгана.

Толилуулгын нэр	Үнэлгээ
Борлуулах зорилготой эргэлтийн бус хөрөнгө	Санхүүгийн байдлын тайланд эргэлтийн хөрөнгө хэсэгт толилуулж тайлагнана. Тухайн хөрөнгийг дансны үнээр бүртгэх

БЗЭБХ-ийн бүртгэл, тайлагналын хяналт:

Борлуулах зорилготой эргэлтийн бус хөрөнгийн дансны бүртгэл, тайлагналтай холбоотойгоор дараах хяналтын орчныг бүрдүүлж ажиллана.

Хяналтын орчин	Хяналтын горим
Нягтлан бодох бүртгэлийн хяналт:	➢ БЗЭБХ-ийн үндсэн хөрөнгөөс ангилал шилжүүлэх үед зөвхөн гарзыг хүлээн зөвшөөрөх ба энэ үед олз үүсэхээр байвал хүлээн зөвшөөрөхгүй.

	<ul style="list-style-type: none"> ➤ Тайлангийн хугацааны эцэст олз хүлээн зөвшөөрөхөөс бол хүлээн зөвшөөрөх олзын дээд хэмжээ өмнө хүлээн зөвшөөрсөн гарзын дүнгээс ихгүй байна. ➤ БЗЭБХ-ийн үнэ цэнийн бууралтын гарзыг үнэ цэнийн бууралт байдлаар тусад нь данс үүсгэн бүртгэж болно. ➤ БЗЭБХ-ийн санхүүгийн тайлангийн зорилгоор элэгдүүлэхгүй.
Санхүүгийн тайлагналын хяналт:	<p>Санхүүгийн тайлангийн үнэн зөв байдлыг хангах зорилгоор жилийн эцсийн санхүүгийн тайлан бэлтгэх үед БЗЭБХ-ийн бүртгэл, тайлагналтай холбоотой дараах хяналтуудыг хэрэгжүүлнэ.</p> <ul style="list-style-type: none"> ➤ Эргэлтийн бус хөрөнгийг зөв ангилсан эсэх борлуулах зорилготой хөрөнгө байгаа эсэхийг хянана. ➤ БЗЭБХ-ийн дансны үнэ болон бодит үнэ цэнийг хянана. ➤ БЗЭБХ-ийн бодит үнэ цэнээр бүртгэж буурсан үед үнэ цэнийн бууралтын гарзын бүртгэсэн эсэхийг хянана. ➤ БЗЭБХ-ийн эргэлтийн хөрөнгөд тусгасан эсэхийг хянана. ➤ БЗЭБХ-ийн элэгдүүлээгүй гэдгийг эргэн хянана.
Үйл ажиллагааны хяналт:	<ul style="list-style-type: none"> ➤ Ашиглаж байгаа хөрөнгийг худалдан борлуулах шийдвэрийг компанийн засаглах удирдлага эсвэл гүйцэтгэх удирдлагаас шийдвэрлэх ба санхүүгийн бүртгэлийн ажилтан зөвхөн бүртгэлийн асуудлыг хариуцна. ➤ Тайлангийн хугацааны эцэст бодит үнэ цэнийн хэмжилтийг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж болно. ➤ БЗЭБХ-ийн бүрэн бүтэн байдал, хөрөнгийн тооллого эд хариуцагчийг хянана. ➤ Борлуулах зорилгоор авч хэрэгжүүлсэн арга хэмжээг заавал зохион байгуулах ба авч хэрэгжүүлсэн арга хэмжээг баримтжуулна. ➤ Удирдлагаас борлуулах зорилготой гэсэн нотлох баримтад үндэслэн ангилал шилжүүлнэ.
Удирдлагад тайлагнах зүйлс:	<ul style="list-style-type: none"> ➤ БЗЭБХ-ийн бүртгэл, тайлагнал хариуцсан этгээд дараах зүйлсийг ➤ удирдлагад тогтмол мэдээлнэ. ➤ БЗЭБХ-ийн ангилал, товчоо тайлан; ➤ БЗЭБХ-ийн борлуулсан дүн, цаашид хэрхэн ангилал шилжүүлэх талаар мэдээлэл; ➤ Зогсоосон үйл ажиллагааны цэвэр ашиг, алдагдал;

БЗЭБХ-ийн бүртгэл, тайлагналтай холбоотой санхүүгийн тайланд нэмж тодруулах мэдээлэл:

Компани жилийн эцсийн санхүүгийн тайланг бэлтгэж борлуулах зорилготой эргэлтийн бус хөрөнгөтэй холбоотой дараах зүйлсийг нэмж тодруулна.

- БЗЭБХ-ийн данснуудын ерөнхий бодлого;
- БЗЭБХ-ийн данснуудын ерөнхий ангилал;
- Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг, алдагдал;
- Зогсоосон үйл ажиллагаа хөрөнгийн борлуулалтаас хүлээн зөвшөөрсөн татварын дараах олз, гарз;
- БЗЭБХ-ийн дансны үнэ болон бодит үнэ цэнийн тохируулгаас үүссэн олз, гарз;

- Борлуулалт хийгдсэн эсвэл борлуулалтын нөхцөл байдлыг тодорхойлно;
- Борлуулалт хийгдсэн хүлээгдэж буй төлбөрийн хэлбэр;

4.5. Хөрөнгө оруулалтын нягтлан бодох бүртгэлийн бодлого

Хөрөнгө оруулалтын бүртгэлийн бодлогын зорилго:

Хөрөнгө оруулалтын дансны нягтлан бодох бүртгэлийн бодлого нь дараах зорилготой.

- Хөрөнгө оруулалтын данстай холбоотой зүйлсийг компанийн үйл ажиллагаатай уялдуулан зөв ангилж, бүртгэх, тайлагнах;
- Хөрөнгө оруулалтын данстай холбоотой компанийн хэрэгжүүлж буй хяналтын тогтолцоог хэрэгжүүлэх;
- Хөрөнгө оруулалт үйл ажиллагаатай холбоотой санхүүгийн удирдлагыг хэрэгжүүлэхэд туслах;
- Санхүүгийн тайлангийн мэдээлэл хэрэглэгчдийг хөрөнгө оруулалттай холбоотой үнэн зөв мэдээллээр хангах;
- СТОУС-д нийцсэн бүртгэл хөтлөх.

Хөрөнгө оруулалтын бүртгэлд хамаарах зүйлс:

Компани сул чөлөөтэй мөнгөн хөрөнгийг эргэлтэд оруулах, хөрөнгийн зах зээл дээрээс ашиг олох, санхүүжигчийн үйл ажиллагаанаас өгөөж хүртэх зорилгоор өрийн болон өмчийн хэрэгсэл, крипто валютад оруулсан хөрөнгө оруулдаг. Эдгээр үйл ажиллагааг хөрөнгө оруулалтын бүртгэлд хамруулна:

- Хувьцаанд оруулсан хөрөнгө оруулалт
- Охин компанид оруулсан хөрөнгө оруулалт
- Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт
- Бондоорх хөрөнгө оруулалт
- Крипто валютад оруулсан хөрөнгө оруулалт

Хувьцаанд оруулсан хөрөнгө оруулалт: гэдэгт компани үнийн өсөлтөөс ашиг олох зорилгоор хөрөнгийн зах зээл дээр нээлттэй арилжаалагддаг компаниудын хувьцаанд оруулсан хөрөнгө оруулалтыг хамруулна. Эзэмшиж буй хувьцааны тооноос хамааруулан шийдвэр гаргалтад шууд нөлөөлөх боломжтой, хяналтын багцыг эзэмшиж мэдэгдэхүйц нөлөөллийг тогтоох боломжтой байсан ч худалдан борлуулах зорилготойгоор хувьцаа худалдан авсан бол энэхүү ангилалд багтана.

Охин компанид оруулсан хөрөнгө оруулалт: гэдэгт компани үйл ажиллагаанаас нь өгөөж хүртэх зорилгоор нээлттэй болон хаалттай хувьцаат компани, хязгаарлагдмал хариуцлагатай компанийн өмчийн хэрэгсэлд оруулсан хөрөнгө оруулалтыг хамруулна.

Охин компанид оруулсан хөрөнгө оруулалтад энгийн хувьцааны 50 хувь, түүнээс дээш хувь хэмжээгээр эзэмшдэг компанийн хувьцааг ойлгоно. Ингэхийн тулд компани охин компанийн үйл ажиллагаанд хяналттай байх ёстой. Компани хэдийгээр энгийн хувьцааны 50 хувиас бага хувь хэмжээг эзэмшдэг ч үйл ажиллагаанаас өгөөж хүртэхийн тулд өөр аж ахуйн нэгжийн санхүүгийн болон үндсэн үйл ажиллагааны бодлогыг удирдах эрх мэдэлтэй бол түүнийг хяналттай гэж үзэн охин компанид оруулсан хөрөнгө оруулалтаар бүртгэнэ. Харин энгийн хувьцааны 50%-иc дээш хэмжээгээр хувьцааг нь эзэмшиж байгаа боловч хяналт тавьж чадахгүй байгаа тохиолдолд охин компанид оруулсан хөрөнгө оруулалт гэж үзэхгүй бөгөөд санхүүгийн хөрөнгө гэж үзэн СТОУС 9-ийн дагуу бүртгэж тайлагнана.

Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт: гэдэгт компани үйл ажиллагаанаас нь өгөөж хүртэх зорилгоор нээлттэй болон хаалттай хувьцаат компани, хязгаарлагдмал хариуцлагатай компанийн өмчийн хэрэгсэлд оруулсан хөрөнгө оруулалтыг хамруулна.

Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалтад энгийн хувьцааны 20-оос 50 хувь хүртэл хувь хэмжээгээр эзэмшдэг компанийн хувьцаанд оруулсан хөрөнгө оруулалтыг хамруулж ойлгоно. Энэ тохиолдолд компани мэдэгдэхүйц нөлөөлөлтэй гэж үзнэ. Мэдэгдэхүйц нөлөөлөл нь хөрөнгө оруулалтыг хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт гэж үзэх нөхцөл болно. Харин хуулийн дагуу энгийн хувьцааны 20-оос 50 хувийг эзэмшдэг ч мэдэгдэхүйц нөлөөлөлгүй бол түүнийг хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт гэж үзэхгүй.

Бондоорх хөрөнгө оруулалт: Компани өгөөж хүртэх зорилгоор засгийн газрын болоод хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагуудын гаргасан бондоос худалдан авсан болон бусад өрийн хэрэгсэлд оруулсан хөрөнгө оруулалтыг хамруулж ойлгоно.

Крипто валютад оруулсан хөрөнгө оруулалт: Компани үнийн өсөлтөөс нь өгөөж хүртэх зорилготойгоор олон улсын болоод дотоодын зах зээлд нээлттэй арилжаалагдаж буй крипто валютад оруулсан хөрөнгө оруулалтыг хамруулж ойлгоно.

Крипто валют, түүний санхүүгийн хэрэглүүр болох нь:

Крипто валют (Cryptocurrencies) нь цахим зоос бөгөөд виртуал гүйлгээнд хүмүүсийн хооронд дамжуулагдахаар зохион бүтээгдсэн ба зөвхөн дата хэлбэрээр оршиж биет бусаар оршдог. Түүнийг өөрийн гартаа барих эсхүл сейфтээ хадгалах боломжгүй. Крипто валютыг эзэмшинэ гэдэг нь одоогоор өөрийн эзэмшиж буй валютын сүлжээний компьютер бүрийн хамтын гэрээг эзэмшиж байна гэсэн үг бөгөөд хамгийн чухал нь энэ нь олборлогчдоор хууль ёсны бүтээгдсэн байдагт оршино.

Крипто валют болон зарим санхүүгийн болоод санхүүгийн бус хөрөнгийн шинж чанар:

Шинж чанар	Крипто валют	Хувьцаа	Бонд	Бараа материал
Нээлттэй зах зээл дээр арилжаалдаг	Тийм	Тийм	Тийм	
Эрх бүхий байгууллагаас батлагдаж нийтэд арилжаалахыг зөвшөөрсөн		Тийм		
Годорхой эргэн төлөгдөх хугацаагүй	Тийм	Тийм		
Шийдвэр гаргалтад оролцох саналын эрхтэй		Тийм		
Үнийн нэмэгдлээс ашиг олох зорилготой эзэмшиж байгаа	Тийм	Тийм		Тийм
Ногдол ашиг олгодог		Тийм		
Төлбөрийн хэрэгсэл болох эсэх	Боломжтой	Боломжтой	Боломжтой	Боломжтой
Хөрвөх чадвар	Богино хугацаанд	Богино хугацаанд	Богино хугацаанд	Богино хугацаанд

Хөрөнгө оруулалтын дансны ангилал:

Компани дээр дурдсан хөрөнгө оруулалтуудыг доорх байдлаар ангилна.

1. Дараагийн тайлант үе бүрд хорогдуулсан өртгөөр хэмжих санхүүгийн хөрөнгө
2. Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлаар бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө
3. Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогоор бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө

Дараагийн тайлант үе бүрд хорогдуулсан өртгөөр хэмжих санхүүгийн хөрөнгө:

Тус ангилалд бондоорх хөрөнгө оруулалтууд болон авлагыг хамруулж ойлгох ба эдгээр нь идэвхтэй зах зээлд жишиг үнэгүй, тогтмол эсвэл тодорхойлж болох төлбөртэй, үүсмэл биш санхүүгийн хөрөнгүүд юм.

Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлаар бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө:

Тус ангилалд компани үнийн өсөлтөөс нь ашиг олох зорилготой бөгөөд богино хугацаанд эргүүлэн худалдах зориулалттай хувьцаанд оруулсан хөрөнгө оруулалтууд байна.

Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогоор бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө:

Энэхүү ангилалд компани гэрээний мөнгөн гүйлгээг буцаан авах бөгөөд цаашид борлуулах борлуулах зорилготой санхүүгийн хөрөнгийг хамруулна.

Охин компанид оруулсан хөрөнгө оруулалт болон хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт, крипто валютад оруулсан хөрөнгө оруулалт зэрэг нь тус бүртгээ санхүүгийн хөрөнгийн ангилал болно.

Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт:

Анх хүлээн зөвшөөрөх шалгуур нь санхүүгийн хөрөнгө тус бүрийн хувьд харилцан адилгүй байх бөгөөд гагцхүү харилцагчтай гэрээ байгуулж уг гэрээний нөхцөл компанид хамааралтай болсон үед санхүүгийн хөрөнгийг хүлээн зөвшөөрнө. Үүнийг санхүүгийн хөрөнгө тус бүрээр харуулбал дараах байдалтай байна.

Хөрөнгө оруулалтын төрөл	Хүлээн зөвшөөрөх үнэлгээ
Хувьцаанд оруулсан хөрөнгө оруулалт	Зах зээл дээр арилжаалагдаж буй хувьцаанаас худалдан авах захиалга өгч компани хувьцааг бүрэн эзэмшсэнээр санхүүгийн хөрөнгөөр хүлээн зөвшөөрнө. Хүлээн зөвшөөрөх дүнд гэрээний үнэ болоод худалдан авалттай холбоотой шимтгэл хураамжийн зардал багтсан байна.
Охин компанид оруулсан хөрөнгө оруулалт	Охин компанид оруулсан хөрөнгө оруулалтыг анх өртгөөр нь хүлээн зөвшөөрнө. Өртөг нь зөвхөн худалдан авалтын гэрээний үнэ байх бөгөөд худалдан авалттай холбоотой зардлыг тайлант хугацааны зардлаар хүлээн зөвшөөрнө.
Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт	Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалтыг анх өртгөөр нь хүлээн зөвшөөрнө. Өртөг нь зөвхөн худалдан авалтын гэрээний үнэ байх бөгөөд худалдан авалттай холбоотой зардлыг тайлант хугацааны зардлаар хүлээн зөвшөөрнө.
Бондоорх хөрөнгө оруулалт	Бондоорх хөрөнгө оруулалтыг анх өнөөгийн үнэ цэнээр хүлээн зөвшөөрөх ба тайлангийн хугацааны эцэст хорогдуулсан өртгөөр хэмжинэ. Хорогдуулсан өртөг гэдэг нь санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөхөд хэмжсэн дүнгээс эргүүлэн хүлээн авах үндсэн төлбөрийг хасаж анхны дүн ба дуусгавар болгох дүнгийн зөрүүг үр ашигт хүүний аргыг ашиглан хуримтлуулсан хорогдуулалтыг хассан дүн байна.
Крипто валютад оруулсан хөрөнгө оруулалт	Крипто валютад оруулсан хөрөнгө оруулалтыг анх өртгөөр нь хүлээн зөвшөөрөх ба өртөг нь худалдан авсан гэрээний үнэ байна. Крипто валют худалдан авахтай холбоотой гарсан шимтгэл хураамжийн зардлыг тайлант үеийн зардлаар хүлээн зөвшөөрнө.

Үл хүлээн зөвшөөрөлт:

Үл хүлээн зөвшөөрөх гэдэг нь урьд өмнө хүлээн зөвшөөрсөн санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийг аж ахуйн нэгжийн санхүүгийн байдлын тайлангаас хасахыг хэлнэ. Аж ахуйн нэгж, байгууллага санхүүгийн хөрөнгийн мөнгөн гүйлгээнд хамаарах гэрээний эрхийн хүчинтэй хугацаа дууссан, эсвэл санхүүгийн хөрөнгийг шилжүүлсэн тохиолдолд үл хүлээн зөвшөөрөх ёстой.

Компани санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөх шалгуур нь дараах байдалтай байна.

Хөрөнгө оруулалтын төрөл	Хүлээн зөвшөөрөх үнэлгээ
Хувьцаанд оруулсан хөрөнгө оруулалт	Хувьцаанд оруулсан хөрөнгө оруулалтыг худалдан борлуулж эрх бүхий байгууллагын бүртгэлээр хувьцаатай холбоотой эрсдэл өгөөж худалдан авагч талд бүрэн шилжсэн тохиолдолд үл хүлээн зөвшөөрнө.
Охин компанид оруулсан хөрөнгө оруулалт	Охин компанид оруулсан хөрөнгө оруулалтыг бусдад худалдаж шийдвэр гаргалтад нөлөөлөх эрх дуусгавар болсон, түүнээс хүртэх эрсдэл, өгөөж нь худалдан авагчид шилжсэн нь эрх бүхий байгууллагын бүртгэлээр баталгаажсан тохиолдолд үл хүлээн зөвшөөрнө.
Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт	Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалтыг бусдад худалдаж хяналтын эрх, мэдэгдэхүйц нөлөөлөл байхгүй болсон, түүнээс хүртэх эрсдэл, өгөөж нь худалдан авагчид шилжсэн нь эрх бүхий байгууллагын бүртгэлээр баталгаажсан тохиолдолд үл хүлээн зөвшөөрнө.
Бондоорх хөрөнгө оруулалт	Бондоорх хөрөнгө оруулалтыг анх өнөөгийн үнэ цэнээр хүлээн зөвшөөрөх ба тайлангийн хугацааны эцэст хорогдуулсан өртгөөр хэмжинэ. Хорогдуулсан өртөг гэдэг нь санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөхөд хэмжсэн дүнгээс эргүүлэн хүлээн авах үндсэн төлбөрийг хасаж анхны дүн ба дуусгавар болгох дүнгийн зөрүүг үр ашигт хүүний аргыг ашиглан хуримтлуулсан хорогдуулалтыг хассан дүн байна.
Крипто валютад оруулсан хөрөнгө оруулалт	Крипто валютад оруулсан хөрөнгө оруулалтыг анх өртгөөр нь хүлээн зөвшөөрөх ба өртөг нь худалдан авсан гэрээний үнэ байна. Крипто валют худалдан авахтай холбоотой гарсан шимтгэл хураамжийн зардлыг тайлант үеийн зардлаар хүлээн зөвшөөрнө.

Үл хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангасан ба хангаагүй шилжүүлэлт:

Хэрэв компани санхүүгийн хөрөнгийг бүхлээр нь үл хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангасан шилжүүлгээр шилжүүлсэн бөгөөд уг санхүүгийн хөрөнгөд үл хүлээн зөвшөөрөлттэй холбоотой нэмэлт үйлчилгээний гэрээний үнэнд багтааж **үйлчилгээ үзүүлж хураамж авах эрхийг өөртөө үлдээсэн бол** үйлчилгээний хөрөнгө, үйлчилгээний өр төлбөрийн аль нэгийг хүлээн зөвшөөрөх ёстой. Компани санхүүгийн хөрөнгийн үл хүлээн зөвшөөрөлттэй холбоотой үйлчилгээний эрхийг өөртөө үлдээх нөхцөл байхгүй.

Компани шилжүүлсэн санхүүгийн хөрөнгийн эзэмшилд хамаарах бүх эрсдэл, өгөөжийг өөртөө үлдээсний улмаас уг шилжүүлгийн үр дүнд үл хүлээн зөвшөөрөлт үүсэхгүй бөгөөд шилжүүлсэн хөрөнгөө бүхлээр нь үргэлжлүүлэн хүлээн зөвшөөрөх ёстой. Өөрөөр хэлбэл эрх бүхий байгууллагын бүртгэлээр санхүүгийн хөрөнгийн эрсдэл, өгөөж, хяналтын эрхийг хэрэгжүүлэх эрх нь компанид үргэлжилж байгаа тохиолдолд үл хүлээн зөвшөөрөхгүй. Харин гэрээгээр хүлээн авсан хөрөнгийг санхүүгийн өр төлбөрөөр бүртгэх ёстой ба дараа үеүдэд компани шилжүүлсэн хөрөнгөтэй холбоотой аливаа орлого, тухайн санхүүгийн өр төлбөртэй холбоотой зарлага зэргийг хүлээн зөвшөөрөх ёстой.

Хувьцаанд оруулсан хөрөнгө оруулалтын гүйлгээг бүртгэлд тусгах:

Компани нээлттэй бөгөөд олон улсын болоод дотоодын нээлттэй зах зээлээс худалдан борлуулах зорилгоор хувьцаа худалдан авч үнийн зөрүүнээс ашиг олох зорилгоор худалдан авсан тохиолдолд удирдлага борлуулах зорилготой эсэхээ тодорхойлж санхүүд ирүүлнэ.

- Дотоодын зах зээлээс хувьцаа худалдан авсан тохиолдолд доорх байдлаар бүртгэнэ.
Дт Хувьцаанд оруулсан хөрөнгө оруулалт
Дт Шимтгэлийн зардал
Кт Харилцах данс /эскроу/
- Гадаадын зах зээлээс нээлттэй арилжаалагдаж буй хувьцаанаас худалдан авсан тохиолдолд доорх байдлаар бүртгэнэ.
Дт Хувьцаанд оруулсан хөрөнгө оруулалт XXXXX /МБ-ны албан ханшаар/
Кт Замд яваа мөнгө /интерактив эскроу/ XXXXX /МБ-ны албан ханшаар/
- Хувьцаанд оруулсан хөрөнгө оруулалтыг тайлангийн хугацааны эцэст бодит үнэ цэнээр илэрхийлэх бөгөөд бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс үүссэн олз, гарзыг тайлант үеийн ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө. Бодит үнэ цэнэ гэдэг нь холбоогүй талуудын ажил гүйлгээгээр арилжаанд оролцоход бэлэн бөгөөд худалдан авагч, борлуулагчаар зөвшөөрөгдсөн үнийг хэлнэ. Хувьцааны үнийн өсөлтөөс хөрөнгө оруулалт нэмэгдсэн эсвэл хасагдсан тохиолдолд доорх байдлаар бүртгэнэ.
Дт Хувьцаанд оруулсан хөрөнгө оруулалт
Кт Хувьцааны үнэлгээний олз

Эсвэл:

- Дт Хувьцааны үнэлгээний гарз
Кт Хувьцаанд оруулсан хөрөнгө оруулалт
- Гадаадын зах зээлээс худалдан авсан хувьцаанд оруулсан хөрөнгө оруулалтын хувьд (i) хувьцааны зах зээлийн үнэ болон (ii) тухайн гадаад валютын төгрөгтэй харьцах ханшийн нөлөөгөөр бодит үнэ цэнийг илэрхийлнэ. Ийнхүү үнэлсэн хувьцааны бодит үнэ цэнийн өөрчлөлтийг доорх байдлаар бүртгэнэ.
Дт Хувьцаанд оруулсан хөрөнгө оруулалт
Кт Хувьцааны үнэлгээний олз

Эсвэл:

- Дт Хувьцааны үнэлгээний гарз
Кт Хувьцаанд оруулсан хөрөнгө оруулалт
- Хувьцаанд оруулсан хөрөнгө оруулалт худалдан борлуулсан тохиолдолд үл хүлээн зөвшөөрөх бүртгэл хийх бөгөөд хүлээн авсан мөнгө буюу гэрээний үнэ болоод дансны үнийн зөрүүгээр хувьцаа борлуулсны олз эсвэл гарз хүлээн зөвшөөрнө. Хувьцааны борлуулалтаас олз хүлээн зөвшөөрсөн тохиолдолд доорх байдлаар бүртгэнэ.
Дт Мөнгөн хөрөнгө
Дт Шимтгэл, хураамжийн зардал
Кт Хувьцаанд оруулсан хөрөнгө оруулалт
Кт Хувьцаа борлуулсны олз
- Хувьцааны борлуулалтаас гарз хүлээн зөвшөөрсөн тохиолдолд доорх байдлаар бүртгэнэ.
Дт Мөнгөн хөрөнгө
Дт Шимтгэл хураамжийн зардал
Дт Хувьцаа борлуулсны гарз

Кт Хувьцаанд оруулсан хөрөнгө оруулалт

Харин завсар үеийн санхүүгийн тайлангаар хувьцаанд оруулсан хөрөнгө оруулалтаа бодит үнэ цэнийн тохируулга хийж хөрөнгө оруулалтын үнэлгээний бодит бус олз, гарз хүлээн зөвшөөрсөн бөгөөд жилийн эцсийн санхүүгийн тайлан гарахаас өмнө түүнийг худалдан борлуулсан тохиолдолд завсар хугацааны хүлээн зөвшөөрсөн хөрөнгө оруулалтын үнэлгээний олз, гарзаас борлуулсан хэсэгт ногдох хэсгийг хувьцаа борлуулсны олз, эсвэл гарз руу шилжүүлэн бүртгэнэ. Энэ үед зөвхөн хувьцааны үнэлгээний олз, гарзыг хувьцаа борлуулсны олз гарз руу шилжүүлэн бүртгэнэ.

Охин компанид оруулсан хөрөнгө оруулалтын гүйлгээг бүртгэлд тусгах:

Компани бизнесийн үйл ажиллагааны нэгээхэн хэсэг болгон шинээр үүсгэн байгуулах эсвэл нэмэлт хөрөнгө оруулалт хийх, худалдан авах зарчмаар хувьцаат компани болон хязгаарлагдмал хариуцлагатай компанид хөрөнгө оруулалт хийж болно.

Охин компанид анх удаа болон нэмэлтээр хөрөнгө оруулалт хийх үед өртгөөр нь бүртгэх ба доорх байдлаар бүртгэнэ.

- Дотоодын зах зээлээс хувьцаа худалдан авсан тохиолдолд:

Дт Охин компанид оруулсан хөрөнгө оруулалт

Дт Шимтгэлийн зардал

Кт Харилцах данс /эскроу/

Тайлангийн хугацааны эцэст компани охин компанид оруулсан хөрөнгө оруулалтын хяналтыг заавал үнэлэх бөгөөд хяналттай байгаа эсэхээ тодорхойлсон байна.

- Тайлангийн хугацааны эцэст охин компанид оруулсан хөрөнгө оруулалтыг тусдаа санхүүгийн тайланд бодит үнэ цэнээр нь хэмжиж бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрч доорх байдлаар бүртгэнэ.

Дт/Кт Охин компанид оруулсан хөрөнгө оруулалт

Дт/Кт Хөр.ор-ын бодит үнэ цэнийн нөөц

Дт/Кт Хойшлогдсон татварын хөрөнгө/ өр төлбөр

ХХК буюу хувьцаа нь нээлттэй зах зээл дээр хувьцааг нь арилжаалдаггүй охин компанид оруулсан хөрөнгө оруулалтыг бодит үнэ цэнээр илэрхийлэхгүй.

Охин компанид оруулсан хөрөнгө оруулалтыг үл хүлээн зөвшөөрөх болон хяналтаа алдах эсвэл бизнесийн зорилгоосоо хамааруулан ангилал шилжүүлэх зэргээр бууруулж болно.

- Охин компанид оруулсан бөгөөд нээлттэй зах зээл дээр арилжаалагддаг хөрөнгө оруулалтын хувьд түүнийг үл хүлээн зөвшөөрөх үед доорх байдлаар бүртгэнэ.

Дт Мөнгөн хөрөнгө эсвэл холбогдох хөрөнгийн данс

Кт Охин компанид оруулсан хөрөнгө оруулалт

Кт Хөрөнгө оруулалт борлуулсны олз

Эсвэл:

Дт Мөнгөн хөрөнгө эсвэл холбогдох хөрөнгийн данс

Дт Хөрөнгө оруулалт борлуулсны гарз

Кт Охин компанид оруулсан хөрөнгө оруулалт

Хяналтаа алдсан эсвэл бизнесийн зорилгоос хамааран ангилал шилжүүлсэн тохиолдолд шилжүүлсэн үеэс эхлэн дараагийн ангиллаар бүртгэнэ.

- Ангилал шилжүүлсэн тохиолдолд доорх байдлаар бүртгэнэ.

Дт Холбогдох хөрөнгийн данс

Кт Охин компанид оруулсан хөрөнгө оруулалт

Тэнгэрлиг медиа Групп ХК охин компанийн хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнийг өмчийн хэсэгт оруулан тусгах бөгөөд бодит үнэ цэнийн нөөцөөс жил бүр тайлант хугацааны эцэст тодорхой хэсгийг хөрөнгө оруулалтын ашиг байдлаар хэрэгжүүлж ашиг алдагдлын тайланд тусгана.

Хувьцаа нь биржийн 1-р ангилал бол бодит үнэ цэнийн 80% хүртэл, 1-р ангилал бол 50% хүртэл, 3-р ангилал бүртгэлтэй бол 50% хүртэл бодит үнэ цэнийн дүнгээс хөрөнгө оруулалтын ашгийг хэрэгжүүлж болно.

Дт Хөр.ор-ын бодит үнэ цэнийн нөөц
Дт Хойшлогдсон татварын өр
Кт Хөрөнгө оруулалтын ашиг

Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалтын гүйлгээг бүртгэлд тусгах:

Компани бизнесийн үйл ажиллагаанаас нь өгөөж хүртэх зорилгоор хувьцаат компани болон хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцаанаас худалдан авч эсвэл нэмэлт хөрөнгө оруулалт хийж болно.

- Хараат компани хөрөнгө оруулалт хийх үед доорх байдлаар бүртгэнэ.

Дт Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт
Дт Шимтгэлийн зардал
Кт Харилцах данс /эскроу/

Эсвэл

Мөнгөн хөрөнгө, өр төлбөр XXXXX

- Тайлангийн хугацааны эцэст хараат компанид оруулсан хөрөнгө оруулалтыг тусдаа санхүүгийн тайланд бодит үнэ цэнээр нь хэмжиж бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрч доорх байдлаар бүртгэнэ.

Дт Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт
Дт/Кт Хөр.ор-ын бодит үнэ цэнийн нөөц
Дт/Кт Хойшлогдсон татварын хөрөнгө/ өр төлбөр

ХХК буюу хувьцаа нь нээлттэй зах зээл дээр хувьцааг нь арилжаалдаггүй хараат компанид оруулсан хөрөнгө оруулалтыг бодит үнэ цэнээр илэрхийлэхгүй.

- Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалтыг цаашид худалдан борлуулахаар шийдсэн тохиолдолд СТОУС-5 “борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө ба зогсоосон үйл ажиллагаа”-ны дагуу бүртгэнэ. Энэ үед хөрөнгө оруулалтын дансны үнээр шилжүүлэн бүртгэнэ.

Дт Борлуулах зорилготой эргэлтийн бус хөрөнгө
Кт Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт

Тэнгэрлиг Медиа Групп ХК хараат компанийн хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнийг өмчийн хэсэгт оруулан тусгах бөгөөд бодит үнэ цэнийн нөөцөөс жил бүр тайлант хугацааны эцэст тодорхой хэсгийг хөрөнгө оруулалтын ашиг байдлаар хэрэгжүүлж ашиг алдагдлын тайланд тусгана. Хувьцаа нь биржийн 1-р ангилал бол бодит үнэ цэнийн 80% хүртэл, 1-р ангилал бол 50% хүртэл, 3-р ангилал бүртгэлтэй бол 50% хүртэл бодит үнэ цэнийн дүнгээс хөрөнгө оруулалтын ашгийг хэрэгжүүлж болно.

Дт Хөр.ор-ын бодит үнэ цэнийн нөөц
Дт Хойшлогдсон татварын өр
Кт Хөрөнгө оруулалтын ашиг


Бондоорх хөрөнгө оруулалтыг бүртгэлд тусгах:

Бондоорх хөрөнгө оруулалтыг анх өнөөгийн үнэ цэнээр нь хүлээн зөвшөөрч бүртгэх ба дараагийн тайлант үе бүрд хорогдуулсан өртгөөр хэмжинэ. Бондыг нэрлэсэн үнээр нь худалдан авсан бол өнөөгийн үнэ цэнэ болон нэрлэсэн үнэ нь хоорондоо тэнцүү байна. Мөн нэрлэсэн үнээр худалдан авсан тохиолдолд зах зээлийн хүү болон нэрлэсэн хүү тэнцүү байх бөгөөд хөнгөлөлт, урамшуулал үүсэхгүй.

Анх нэрлэсэн үнээс илүү эсвэл бага дүнгээр худалдан авсан тохиолдолд бондоорх хөрөнгө оруулалтын хөнгөлөлт эсвэл урамшуулал үүсэх бөгөөд хөнгөлөлт, урамшууллыг шингээх хорогдуулах үр ашигт хүүний түвшинг тооцох шаардлагатай болно. Үр ашигт

хүүний түвшинг компьютерийн хэрэглээний программ (excel) ашиглан тооцож болох ба доорх байдлаар тооцоолж болно.

Үр ашигт хүүний түвшинг Formulas цэсний Insert Function функцээр тооцоолох аргыг жишээн дээр харуулав:



Дээрх жишээг ашиглан тооцвол бондын хорогдуулалтын хүснэгт дараах байдалтай байна.

№	Нэрлэсэн хүү	ҮАХ-ний хувь	ҮАХ-ний дүн	Хөнгөлөлтийн хорогдуулалт	Хөнгөлөлтийн үлдэгдэл	Дансны үнэ
1	250,000	1.7647%	317,650	67,650	2,000,000	18,000,000
2	250,000	1.7647%	318,844	68,844	1,932,350	18,067,650
3	250,000	1.7647%	320,059	70,059	1,863,505	18,136,495
4	250,000	1.7647%	321,296	71,296	1,793,446	18,206,554
5	250,000	1.7647%	322,554	72,554	1,722,150	18,277,850
6	250,000	1.7647%	323,834	73,834	1,649,597	18,350,403
7	250,000	1.7647%	325,137	75,137	1,575,763	18,424,237
8	250,000	1.7647%	326,463	76,463	1,500,625	18,499,375
9	250,000	1.7647%	327,812	77,812	1,424,162	18,575,838
10	250,000	1.7647%	329,186	79,186	1,346,350	18,653,650
11	250,000	1.7647%	330,583	80,583	1,267,164	18,732,836
12	250,000	1.7647%	332,005	82,005	1,186,581	18,813,419
13	250,000	1.7647%	333,452	83,452	1,104,576	18,895,424
14	250,000	1.7647%	334,925	84,925	1,021,124	18,978,876
15	250,000	1.7647%	336,424	86,424	936,199	19,063,801
16	250,000	1.7647%	337,949	87,949	849,776	19,150,224
17	250,000	1.7647%	339,501	89,501	761,827	19,238,173
18	250,000	1.7647%	341,080	91,080	672,326	19,327,674
19	250,000	1.7647%	342,688	92,688	581,246	19,418,754
20	250,000	1.7647%	344,323	94,323	488,558	19,511,442
21	250,000	1.7647%	345,988	95,988	394,235	19,605,765
22	250,000	1.7647%	347,682	97,682	298,247	19,701,753
23	250,000	1.7647%	349,406	99,406	200,565	19,799,435
24	250,000	1.7647%	351,160	101,160	101,160	19,898,840
					-	20,000,000

- Бондоорх хөрөнгө оруулалтыг анх нэрлэсэн үнээс бага үнээр буюу хямдруулалттай үнээр худалдан авсан учир доорх байдлаар бүртгэнэ.
 Дт Бондоорх хөрөнгө оруулалт XXXXX (НҮ-ээр)Дт
 Бондоорх хөрөнгө оруулалтын хөнгөлөлт (XXXXX) (НҮ болон ЗЗҮ-ийн зөрүүгээр)
 Кт Мөнгөн хөрөнгө Жишээгээр харуулбал: XXXXX (ӨҮЦ-ээр буюу ЗЗҮ-ээр)

Дт	Бондоорх хөрөнгө оруулалт	20,000,000 (НҮ-ээр)
Дт	Бондоорх хөрөнгө оруулалтын хөнгөлөлт ийн зөрүүгээр)	(2,000,000) (НҮ болон ЗЗҮ-ээр)
Кт	Мөнгөн хөрөнгө ЗЗҮ-ээр)	18,000,000 (ӨҮЦ-ээр буюу ЗЗҮ-ээр)

Бондоорх хөрөнгө оруулалтын хөнгөлөлт нь ирээдүйд хүлээн зөвшөөрөх хүүний орлогыг нэмэгдүүлэх бөгөөд хөнгөлөлтийн үлдэгдлийг бондоорх хөрөнгө оруулалтын доор сөрөг утгаар тайлагнана.

- Бондоорх хөрөнгө оруулалтыг анх нэрлэсэн үнээс өндөр үнээр худалдан авсан бол доорх байдлаар бүртгэнэ.

Дт	Бондоорх хөрөнгө оруулалт	XXXXXX (НҮ-ээр)
Дт	Бондоорх хөрөнгө оруулалтын урамшуулал ийн зөрүүгээр)	XXXXXX (НҮ болон ЗЗҮ-ээр)
Кт	Мөнгөн хөрөнгө буюу ЗЗҮ-ээр)	XXXXXX (ӨҮЦ-ээр буюу ЗЗҮ-ээр)

Бондоорх хөрөнгө оруулалтын урамшуулал нь ирээдүйд хүлээн зөвшөөрөх хүүний орлогыг бууруулах бөгөөд урамшууллын үлдэгдлийг бондоорх хөрөнгө оруулалтын доор нэмэх утгаар тайлагнана.

- Бондын нэрлэсэн үнэ болон өнөөгийн үнэ цэнэ тэнцүү үед бондын хүүний орлогыг нэрлэсэн хүүний түвшинд үндэслэн хүлээн зөвшөөрөх бөгөөд нэрлэсэн хүү болон зах зээлийн хүү хоорондоо тэнцүү байна. Энэ үед доорх байдлаар хүүний орлогыг бүртгэнэ.

Дт	Бондын хүүний авлага
Кт	Бондын хүүний орлого

- Бондыг нэрлэсэн үнээс бага үнээр худалдан авч хөнгөлөлт үүссэн үед хүүний орлого хүлээн зөвшөөрөхдөө доорх байдлаар бүртгэнэ.

Дт	Бондын хүүний авлага хүүгээр)	XXXXXX (нэрлэсэн хүүгээр)
Дт	Бондоорх хөрөнгө оруулалтын хөнгөлөлт дүнгээр буюу хорогдуулгын)	XXXXXX (Зөрүү буюу хорогдуулгын)
Кт	Бондын хүүний орлого хувиар)	XXXXXX (үр ашиг хүүний хувиар)

Жишээгээр харуулбал:

Дт	Бондын хүүний авлага хүүгээр)	250,000 (нэрлэсэн хүүгээр)
Дт	Бондоорх хөрөнгө оруулалтын хөнгөлөлт дүнгээр хорогдуулгын)	67,650 (Зөрүү буюу хорогдуулгын)
Кт	Бондын хүүний орлого хүүний хувиар)	317,650 (үр ашиг хүүний хувиар)

- Бондыг нэрлэсэн үнээс өндөр үнээр худалдан авч урамшуулал үүссэн үед хүүний орлого хүлээн зөвшөөрөхдөө доорх байдлаар бүртгэнэ.

Дт	Бондын хүүний авлага	XXXXXX (нэрлэсэн хүүгээр)
Кт	Бондын хүүний орлого хувиар)	XXXXXX (үр ашиг хүүний хувиар)
Кт	Бондоорх хөрөнгө оруулалтын урамшуулал дүнгээр)	XXXXXX (хорогдуулгын дүнгээр)

Бондоорх хөрөнгө оруулалтыг дахин ангилж бусад хөрөнгө оруулалтын дансанд шилжүүлсэн тохиолдолд бондын дансны үнээр шилжүүлэн бүртгэнэ. Бондын дансны үнэ нь хөнгөлөлтийг хассан эсвэл урамшууллыг нэмсэн дүн байна. Энэ үед доорх байдлаар бүртгэх ба дахин ангилалтай холбоотой олз эсвэл гарз хүлээн зөвшөөрнө.

Дт	Холбогдох хөрөнгө оруулалтын данс	XXXXXX (бодит үнэ цэнээр)
----	-----------------------------------	---------------------------

Дт Дахин ангиллын гарз XXXXX (зөрүүгээр)
Кт Бондоорх хөрөнгө оруулалт XXXXX(дансны үнээр)

Эсвэл:

Дт: Холбогдох хөрөнгө оруулалтын данс XXXXX (бодит үнэ цэнээр)
Кт: Бондоорх хөрөнгө оруулалт XXXXX(дансны үнээр)
Кт: Дахин ангиллын олз XXXXX (зөрүүгээр)

Бондоорх хөрөнгө оруулалтын хөнгөлөлт эсвэл урамшуулал нь бондын хугацаанд хүүний орлогын дүнд тохируулагдах бөгөөд хугацааны эцэст гэрээний төлбөрийг хүлээн авснаар дуусгавар болно. Энэ үед доорх байдлаар бүртгэнэ.

Дт: Мөнгөн хөрөнгө XXXXX (нэрлэсэн үнээр)
Кт: Бондоорх хөрөнгө оруулалт XXXXX (нэрлэсэн үнээр)

4.6. Кripto валютaд оруулсан хөрөнгө оруулалтыг бүртгэлд тусгах:

Компани крипто валютaд оруулсан хөрөнгө оруулалтыг бусад санхүүгийн хэрэглүүрүүд, тэдгээрийн шинж чанартай харьцуулсны үндсэн дээр бүртгэлийн аргаа сонгосон бөгөөд дараах байдлаар бүртгэнэ.

- Кripto валютaд хөрөнгө оруулалт хийж худалдан авах үед:
Дт Кripto валютaд оруулсан хөрөнгө оруулалт
Дт Кripto валют арилжааны шимтгэл
Кт Мөнгөн хөрөнгө
- Кripto валютaд оруулсан хөрөнгө оруулалтыг тайлангийн хугацааны эцэст бодит үнэ цэнээр нь илэрхийлэх бөгөөд бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс үүссэн олз, гарзыг доорх байдлаар бүртгэнэ.
Дт Кripto валютaд оруулсан хөрөнгө оруулалт
Кт Кripto валютын үнэлгээний олз

Эсвэл:

- Дт Кripto валютын үнэлгээний гарз
Кт Кripto валютaд оруулсан хөрөнгө оруулалт
- Кripto валютaд оруулсан хөрөнгө оруулалтыг худалдан борлуулсан тохиолдолд үл хүлээн зөвшөөрөх бүртгэл хийх бөгөөд хүлээн авсан мөнгө буюу гэрээний үнэ болоод дансны үнийн зөрүүгээр крипто валют борлуулсны олз эсвэл гарз хүлээн зөвшөөрнө. Кripto валютын борлуулалтаас олз хүлээн зөвшөөрсөн тохиолдолд доорх байдлаар бүртгэнэ.
Дт Мөнгөн хөрөнгө
Дт Шимтгэл, хураамжийн зардал
Кт Кripto валютaд оруулсан хөрөнгө оруулалт
Кт Кripto валют борлуулсны олз
- Кripto валютын борлуулалтаас гарз хүлээн зөвшөөрсөн тохиолдолд доорх байдлаар бүртгэнэ.
Дт Мөнгөн хөрөнгө
Дт Шимтгэл хураамжийн зардал
Дт Кripto валют борлуулсны гарз
Кт Кripto валютaд оруулсан хөрөнгө оруулалт
- Харин завсар үеийн санхүүгийн тайлангаар крипто валютaд оруулсан хөрөнгө оруулалтаа бодит үнэ цэнийн тохируулга хийж крипто валютын үнэлгээний бодит бус олз, гарз хүлээн зөвшөөрсөн бөгөөд жилийн эцсийн санхүүгийн тайлан гарахаас өмнө түүнийг худалдан борлуулсан тохиолдолд завсар хугацаанд хүлээн зөвшөөрсөн үнэлгээний олз, гарзаас борлуулсан хэсэгт ногдох хэсгийг крипто валют борлуулсны олз, эсвэл гарз руу шилжүүлэн бүртгэнэ. Энэ үед зөвхөн крипто валютын үнэлгээний олз, гарзаас крипто валют борлуулсны олз, гарз руу шилжүүлэн бүртгэнэ.

Хөрөнгө оруулалтын дансны дахин ангилал:

Компани бизнесийн зорилго, зорилттойгоо хувьцаанд оруулсан хөрөнгө оруулалт, охин компанид оруулсан хөрөнгө оруулалт, хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт зэргийг дахин ангилж болно.

Компани дахин ангилал хийсэн тохиолдолд дахин ангиллыг гүйцээн мөрдөх горимоор бүртгэнэ. Гүйцээн мөрдөх горимоор тухайн нягтлан бодох бүртгэлийн бодлогыг өөрчилсөн өдрөөс хойших ажил гүйлгээнд мөрдөж нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлтийн үр нөлөөг уг өөрчлөлтөөр нөлөө үзүүлэх тухайн тайлант үед болон ирээдүйн тайлант үеүдэд хүлээн зөвшөөрөхийг шаарддаг.

Санхүүгийн хөрөнгийн дахин ангилал хийх дараах тохиолдлууд байна.

- Хорогдуулсан өртгөөр хэмждэг санхүүгийн хөрөнгөөс → Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөх санхүүгийн хөрөнгө
- Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөх санхүүгийн хөрөнгө → Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөх санхүүгийн хөрөнгө
- Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөх санхүүгийн хөрөнгө → Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нь тайлант үеийн ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөх санхүүгийн хөрөнгө

Компани хорогдуулсан өртгөөр хэмжиж байсан санхүүгийн хөрөнгийг бодит үнэ цэнээр хэмждэг санхүүгийн хөрөнгө рүү ангилсан тохиолдолд дахин ангилал хийсэн өдрийн бодит үнэ цэнийг тодорхойлох бөгөөд хорогдуулсан өртөг ба бодит үнэ цэнийн зөрүүгээр тайлант үеийн олз эсвэл гарз хүлээн зөвшөөрнө.

Хэрэв бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрч байсан санхүүгийн хөрөнгөөс бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөх санхүүгийн хөрөнгө рүү ангилсан тохиолдолд цаашид бодит үнэ цэнээр илэрхийлсэн хэвээр байх бөгөөд дахин ангилал хийсэн өдрөөс хойших бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрнө.

Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрч байсан санхүүгийн хөрөнгөөс бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нь тайлант үеийн ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөх санхүүгийн хөрөнгө рүү ангилсан тохиолдолд бодит үнэ цэнээр хэмжсэн хэвээр байх бөгөөд бусад дэлгэрэнгүй орлогын хэсэгт өмнө нь хүлээн зөвшөөрсөн байна.

Охин компанид оруулсан хөрөнгө оруулалт болон хараат компанид оруулсан хөрөнгө оруулалтыг компани худалдан борлуулахаар шийдсэн бол дахин ангилал гэж үзэхгүй бөгөөд СТОУС 5 “Борлуулах зорилготой эргэлтийн бус хөрөнгө ба зогсоосон үйл ажиллагаа”-ны дагуу бүртгэнэ. Ийнхүү охин компанид оруулсан хөрөнгө оруулалт болон хараат компанид оруулсан хөрөнгө оруулалтыг ангилал шилжүүлсэн тохиолдолд цаашид бодит үнэ цэнээр хэмжих бөгөөд тэдгээртэй холбоотой өмнө нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрсөн бодит үнэ цэнийн нөөцийг ашиг, алдагдалд шилжүүлэхгүй.

Санхүүгийн хөрөнгийн дараа үеийн хэмжилт:

Компани хөрөнгө оруулалтын дансны хувьд дараа үеийн хэмжилтийг дараах байдлаар хийнэ.

- Бондоорх хөрөнгө оруулалтыг хорогдуулсан өртгөөр хэмжих бөгөөд гэрээний нөхцөлд өөрчлөлт орсон бол үр ашигт хүүний арга ашиглан хорогдуулгын хүснэгт бэлтгэж ажиллана.
- Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нь тайлант үеийн ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөх санхүүгийн хөрөнгө буюу хувьцаанд оруулсан хөрөнгө оруулалтыг тайлангийн хугацааны эцэст бодит үнэ цэнээр нь хэмжинэ.
- Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөх санхүүгийн хөрөнгийг тайлангийн хугацааны эцэст бодит үнэ цэнээр нь хэмжинэ. Зах зээлийн бодит үнэ цэнийн мэдээлэл нээлттэй биш хөрөнгө оруулалтын хувьд компани мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллаж болно.
- Охин компанид оруулсан хөрөнгө оруулалтын хувьд хувьцаа нь хөрөнгийн зах зээл дээр нээлттэй арилжаалагддаг бол бодит үнэ цэнээр илэрхийлэх бөгөөд бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрнө. Харин хувьцаа нь идэвхтэй зах зээлийн жишиг үнэ байхгүй, бодит үнэ цэнийг нь хэмжих боломжгүй тохиолдолд өртгөөрөө илэрхийлэгдэж нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэх үед өмчийн аргаар нэгтгэнэ.
- Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалтыг тайлант хугацааны эцэст бодит үнэ цэнээр нь илэрхийлнэ. Харин хувьцаа нь идэвхтэй зах зээлийн жишиг үнэ байхгүй,

бодит үнэ цэнийг нь хэмжих боломжгүй тохиолдолд өртгөөрөө илэрхийлэгдэж нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэх үед өмчийн аргаар нэгтгэнэ.

- Кripto валютад оруулсан хөрөнгө оруулалтыг тайлангийн хугацааны эцэст бодит үнэ цэнээр илэрхийлэх бөгөөд түүний бодит үнэ цэнэ нь түүнийг арилжаалж буй зах зээлийн үнэ ханш байна.

Тайлангийн хугацааны эцэст бодит үнэ цэнээр илэрхийлэх хувьцааны албан ханш нь Монголын Хөрөнгийн Биржийн тухайн хувьцааны хаалтын ханш байна.

Виртуал хөрөнгийг бүртгэх

1. Виртуал хөрөнгийг бүртгэх нягтлан бодох бүртгэлийн дансны код нэр, сегментийн мэдээлэл:

..... санхүүгийн програм хангамж дээр кодлол: Эргэлтийн болон эргэлтийн бусаар ангилахаар бол эргэлтийн хэсгийн койн нь бусад эргэлтийн хөрөнгө хэсэгт ангилна. Энэ нь тухай жилдээ урамшуулалд хаагдаж дуусах хэмжээнд барьж болно.

Дансны сегмент	Дансны код	Дансны нэр
Бусад эргэлтийн бус хөрөнгө		
Бусад эргэлтийн хөрөнгө		
Хөрөнгийн дахин үнэлгээ		
Бусад ашиг (алдагдал)		
Бусад ашиг (алдагдал)		

2. Виртуал хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн журмын бичилт:

- 2.1. Худалдан авалтын журналын бичилт:

Тал	Дансны код	Дансны нэр	Тооцоолол	Дебет дүн	Кредит дүн
Дт		Виртуал хөрөнгө			
Кт		Мөнгөн хөрөнгө			

- 2.2. Сар, улирал, жилийн эцсийн хаалтын ханшаар үнэлгээ хийх үеийн бичилт:

Тал	Дансны код	Дансны нэр	Тооцоолол	Дебет дүн	Кредит дүн
Дт		Виртуал хөрөнгө			
Кт		Хойшлогдсон татварын өр			
		Бодит үнэ цэнийн нөөц			

- 2.3. Арилжаа, зарах үеийн бичилт:

Тал	Дансны код	Дансны нэр	Тооцоолол	Дебет дүн	Кредит дүн
		Мөнгөн хөрөнгө			
		Виртуал хөрөнгө			
		Хойшлогдсон татварын өр			
		Бодит үнэ цэнийн нөөц			
		Хуримтлагдсан ашиг			
		Виртуал хөрөнгө данснаас хассаны олз			

2.4 Урамшуулалын зардлыг бүртгэх тооцоо:

Тал	Дансны код	Дансны нэр	Тооцоолол	Дебет дүн	Кредит дүн
		Идэвхижүүлэлтийн зардал			
		Борлуулалтын урамшуулал			
		Виртуал хөрөнгө			
		Хойшлогдсон татварын өр			
		Бодит үнэ цэнийн нөөц			
		Виртуал хөрөнгө данснаас хассаны олз			

2.4.1. Урамшуулал олгох үеийн койнтой холбоотой дансны үлдэгдэл:

Дансны код	Дансны нэр	Тоо хэмжээ	Тооцоолол/ үнэ ханш, өртөг	Мөнгөн дүн
	Виртуал хөрөнгө			
	Хойшлогдсон татварын өр			
	Бодит үнэ цэнийн нөөц			

2.4.2. Урамшуулал олгосны дараах койнтой холбоотой дансны үлдэгдэл:

Дансны код	Дансны нэр	Тоо хэмжээ	Тооцоолол/ үнэ ханш, өртөг	Мөнгөн дүн
	Виртуал хөрөнгө			
	Хойшлогдсон татварын өр			
	Бодит үнэ цэнийн нөөц			

2.5 Койны дахин үнэлгээг бүртгэх бичилт:

Тал	Дансны код	Дансны нэр	Тооцоолол	Дебет дүн	Кредит дүн
		Виртуал хөрөнгө			
		Хойшлогдсон татварын өр			
		Бодит үнэ цэнийн нөөц			

2.5.1. Дансны үлдэгдэл:

Дансны код	Дансны нэр	Тоо хэмжээ	Тооцоолол/ үнэ ханш, өртөг	Мөнгөн дүн
	Виртуал хөрөнгө			
	Хойшлогдсон татварын өр			
	Бодит үнэ цэнийн нөөц			

2.5.2. Урамшууллын зардлыг бүртгэх бичилт:

Тал	Дансны код	Дансны нэр	Тооцоолол	Тооцоолол/ үнэ ханш, өртөг	Мөнгөн дүн
		Идэвхижүүлэлтийн зардал			
		Борлуулалтын урамшуулал			
		Виртуал хөрөнгө			
		Хойшлогдсон татварын өр			

2.5.3. Койнтой холбоотой дансны үлдэгдэл:

Дансны код	Дансны нэр	Тоо хэмжээ	Тооцоолол/ үнэ ханш, өртөг	Мөнгөн дүн
	Виртуал хөрөнгө			
	Хойшлогдсон татварын өр			
	Бодит үнэ цэнийн нөөц			

4.7. Үндсэн хөрөнгийн бүртгэлийн бодлого

Үндсэн хөрөнгийн бүртгэлийн бодлогын зорилго

Үндсэн хөрөнгийн бүртгэлийн зорилго нь санхүүгийн тайлан хэрэглэгчдэд аж ахуйн нэгжүүдийн үндсэн хөрөнгөнд оруулсан хөрөнгө оруулалт, түүний өөрчлөлт зэрэг мэдээллийг олж харах боломж олгох явдал юм.

Энэхүү бодлого нь үл хөдлөх хөрөнгө, барилга байгууламж болон тоног төхөөрөмжийн бүртгэл, хүлээн зөвшөөрөлт, тэдгээрийн дансны үнийн тодорхойлолт, элэгдлийн өөрчлөлт, үнэ цэнийн бууралтын гарз зэрэгтэй холбоотой бүртгэлийн асуудлыг авч үзнэ.

Тодорхойлолт

Дансны үнэ: Хөрөнгийн хүлээн зөвшөөрөгдсөн дүнгээс дараа үеийн хуримтлагдсан элэгдэл болон үнэ цэнийн бууралтын гарзыг хассан дүн.

Өртөг: Хөрөнгийг худалдан авах, барьж байгуулах өдрийн бодит үнэ цэнэ буюу төлсөн мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн дүн.

Бодит үнэ цэнэ: Холбоогүй талуудын ажил гүйлгээгээр зохих мэдлэгтэй, арилжаанд оролцоход бэлэн байгаа талуудын хооронд хөрөнгийг солилцох, эсвэл өр төлбөрөөр тооцож болох дүн.

Элэгдүүлэх өртөг: Хөрөнгийн өртөг болон түүнтэй адилтгах дүнгээс үлдэх үнэ цэнийг хассан дүн.

Элэгдэл: Хөрөнгийн элэгдүүлэх дүнг түүний ашиглалтын хугацаанд системтэй хуваарилсан хуваарилалт.

Үлдэх өртөг: Хөрөнгийн ашиглалтын хугацааны эцэст түүнийг данснаас хасахтай холбоотой аливаа зардлыг хассаны дараа уг үйл ажиллагаанаас байгууллагад орж ирэх дүн.

Ашиглалтын хугацаа:

- Хөрөнгийн ашиглагдах боломжтой хугацаа;
- Тухайн хөрөнгийг ашиглаад бий болгох бүтээгдэхүүн үйлчилгээний тоо хэмжээ, түүнтэй адилтгах зүйлсийн нэгж байна.

Үндсэн хөрөнгөд хамаарагдах зүйлс

Үндсэн хөрөнгөд дараах шалгууруудыг хангасан биет зүйлсийг хамааруулна. Үүнд:

- Үйлдвэрлэл, борлуулалт, үйлчилгээ, түрээс эсвэл удирдлагын хэрэгцээнд ашиглаж байгаа
- Нэгээс дээш тайлант хугацаанд ашиглагдах
- Өртгөө аажмаар нөхдөг
- Ашиглагдах хугацаанд хэлбэр дүрсээ өөрчилдөггүй.

Хүлээн зөвшөөрөлт ба үнэлгээ

Дараах шалгуурууд нэгэн зэрэг биелэгдсэн үед үндсэн хөрөнгийн өртгийг хүлээн зөвшөөрч бүртгэнэ. Үүнд:

- Аж ахуйн нэгжид ирээдүйн эдийн засгийн үр өгөөж авчрах боломжтой байх;
- Хөрөнгийн өртгийг үнэн зөв хэмжих боломжтой байх

Үндсэн

хөрөнгийг хүлээн зөвшөөрөх дээрх шалгуурыг хангасан хөрөнгүүдийн өртгийг үнэлж бүртгэнэ. Үндсэн хөрөнгийн өртөгт дараах зүйлсийг багтаан авч үзнэ. Үүнд:

- Худалдан авсан үнэ, гаалийн татвар, буцаан олгоогүй худалдааны татварын дүн. Худалдан авалтын үеийн хөнгөлөлтийг хасч тооцно.
- Хөрөнгийг ашиглах байрлалд авчрах ба ашиглахад бэлэн болгохтой холбоотой шууд зардлууд.

- Хөрөнгийг анх олж эзэмших үед тухайн аж ахуйн нэгж нь буулгах, сэргээн засварлах, нүүлгэн шилжүүлэхтэй холбогдон гарсан зардлуудыг өөрөө хариуцахаар тооцоолсон бол эдгээр зардлууд өртөгт орно.

Үндсэн хөрөнгийн өртөг нь түүнийг хүлээн зөвшөөрсөн үеийн мөнгө болон мөнгөтэй адилтгагчийн дүн байна. Хэрэв үндсэн хөрөнгийг зээлээр худалдан авсан бол түүнийг өр төлбөрийн өнөөгийн үнэ цэнээр бүртгэж өнөөгийн үнэ цэнэ болон нийт төлбөрийн зөрүүг өр төлбөрийн хугацаанд хүүний зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэнэ.

Нэг болон хэд хэдэн үндсэн хөрөнгийг мөнгөн, мөнгөн бус хөрөнгөөр эсвэл мөнгөн болон мөнгөн бус хөрөнгө аль аль нь оролцсон солилцоогоор олж эзэмшиж болно. Солилцоогоор олж эзэмшсэн хөрөнгийг дараахаас бусад тохиолдолд бодит үнэ цэнээр нь бүртгэнэ. Үүнд:

- Солилцооны ажил гүйлгээ нь арилжааны зорилгогүй байх эсвэл
- Солилцоонд өгсөн болон авсан хөрөнгийн бодит үнэ цэнийг хэмжих боломжгүй байх.

Солилцоогоор авсан хөрөнгийг хүлээн зөвшөөрсөн даруйд өгсөн хөрөнгийг данснаас хасна.

Хүлээн авсан хөрөнгийн бодит үнэ цэнийг тооцох боломжгүй үед түүнийг өгсөн хөрөнгийн дансны үнээр хэмжиж бүртгэнэ.

Үндсэн хөрөнгөний дансны ангилал

Дараах зүйлсийг “Тэнгэрлиг медиа групп” ХК үндсэн хөрөнгө гэж бүртгэлдээ тусгана. Үүнд:

- Барилга байгууламж
- Машин, механизм, техник, тоног төхөөрөмж
- Компьютер, түүний эд анги, программ хангамж
- Ашиглах хугацаа нь тодорхой биет бус хөрөнгө
- Бусад үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн элэгдэл

Үндсэн хөрөнгийн нийт өртгийн дүнд багтсан чухал ач холбогдол бүхий нэгж хэсэг тус бүрээр элэгдлийг тооцоолно. Элэгдүүлсэн дүнг бусад хөрөнгийн дансны үнэнд багтсанаас бусад тохиолдолд тайлант хугацаа бүрд нь орлого, зардлаар хүлээн зөвшөөрнө.

Элэгдүүлсэн дүн гэдэг нь тайлант хугацаанд байгуулсан элэгдлийн хэмжээ бөгөөд энэ нь тайлант хугацаанд хүлээн зөвшөөрсөн элэгдлийн зардал, бусад хөрөнгийн өртөгт шингэсэн элэгдлийн дүнгийн нийлбэрээс бүрдэнэ. Элэгдүүлсэн дүн нь тайлант хугацааны зардлаар хүлээн зөвшөөрөгдөнө.

Хөрөнгийн элэгдүүлэх өртөг нь ашиглалтын хугацааны туршид системтэйгээр хуваарилагдана. Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үлдэх үнэ цэнийг санхүүгийн жил бүрийн эцэст дахин хянаж үзэх бөгөөд хэрэв эдгээрт өөрчлөлт орсон бол уг өөрчлөлтийг нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлтөөр авч үзнэ.

“Тэнгэрлиг медиа групп” ХК нь үндсэн хөрөнгөө дараах хугацаанд элэгдүүлнэ. Үүнд:

№	Үндсэн хөрөнгийн бүлэг	Ашиглах хугацаа /жилээр/
1	Барилга, багууламж	35
2	Машин, механизм, техник, тоног төхөөрөмж	8
3	Компьютер, түүний эд анги, программ хангамж	2
4	Ашиглах хугацаа нь тодорхой биет бус хөрөнгө	Хүчин төгөлдөр байх хугацаанд
5	Бусад үндсэн хөрөнгө	9

“Тэнгэрлиг медиа групп” ХК нь барилгын элэгдлийг Шулуун шугамын аргаар, тоног төхөөрөмжийн элэгдлийг Жилүүдийн нийлбэрийн аргаар, тавилга эд хогилыг Давхар бууруулах аргаар элэгдүүлнэ.

Үндсэн хөрөнгө данснаас хасах

Дараах тохиолдолд үндсэн хөрөнгийн дансны үнийг санхүүгийн тайлангаас хасна:

- Данснаас хасагдсан;
- Эдийн засгийн ирээдүйн үр өгөөжгүй болсон.

Үндсэн хөрөнгийг санхүүгийн тайлангаас хасах үед үүссэн олз, гарзыг тухайн үеийн олз гарзаар хүлээн зөвшөөрнө. Үндсэн хөрөнгийг ашиглалтаас хассанаас үүсэх олз, гарзыг данснаас хасалтын цэвэр үр дүн болон дансны үнийн зөрүүгээр тодорхойлно.

Үндсэн хөрөнгө дансны үндсэн бичилтүүд

- Үндсэн хөрөнгийг орлогод авах үед:
Дт Үндсэн хөрөнгө
Кт Мөнгөн хөрөнгө
- Үндсэн хөрөнгийг барьж байгуулах үед:
Дт Үндсэн хөрөнгө- дуусаагүй
Кт Зардлууд
- Барьж буй үндсэн хөрөнгийн өртгийг бүртгэх үед:
Дт Үндсэн хөрөнгө
Кт Үндсэн хөрөнгө- дуусаагүй
- Төлбөр хариуцагч ерөндөө үндсэн хөрөнгө өгсөн бол:
Дт Үндсэн хөрөнгө
Кт Авлага
- Элэгдлийн зардлыг бүртгэх үед:
Дт Элэгдлийн зардал
Кт Хуримтлагдсан элэгдэл- үндсэн хөрөнгө
- Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийг актлах үед:
Дт Хуримтлагдсан элэгдэл
Кт Үндсэн хөрөнгө
- Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхөж амжаагүй үндсэн хөрөнгийг актлах үед:
Дт Хуримтлагдсан элэгдэл
Үндсэн хөрөнгө устгалтын гарз
Кт Үндсэн хөрөнгө
- Акталж устгасан үндсэн хөрөнгийг дотооддоо эргүүлэн ашиглах үед:
Дт Хуримтлагдсан элэгдэл
Кт Үндсэн хөрөнгө
- Үндсэн хөрөнгийн солилцоо хийх үед:
Дт Тоног төхөөрөмж- шинэ
Хуримтлагдсан элэгдэл
Мөнгөн хөрөнгө
Солилцооны гарз
Кт Мөнгөн хөрөнгө
Солилцооны олз
Үндсэн хөрөнгө- хуучин

Санхүүгийн тайланд тусгах

Үндсэн хөрөнгийг балансад эргэлтийн бус хөрөнгийн биет хөрөнгийн хэсэгт өртөг болон цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар нь тусгана.

4.8. Биет бус хөрөнгийн бодлого

Биет бус хөрөнгийн бодлогын зорилго

Биет бус хөрөнгийн бодлогын зорилго нь биет бус хөрөнгийн хүлээн зөвшөөрөлт болон хэмжилтийн шалгуурыг тодорхойлоход оршино.

Биет бус хөрөнгөд хамаарагдах зүйлс

Биет бус хөрөнгө гэж биет шинж чанаргүй, тодорхойлогдох мөнгөн бус хөрөнгийг хэлнэ.

Биет бус хөрөнгө нь дараах шалгуурын аль нэгийг хангавал түүнийг тодорхойлогдох хөрөнгө гэж үзнэ. Үүнд:

- Тусад нь авч үзэх боломжтой, өөрөөр хэлбэл, аж ахуйн нэгж уг хөрөнгийг тусад нь эсвэл холбогдох гэрээ, хөрөнгө, өр төлбөрийн хамт түрээсэлж, борлуулж, шилжүүлж, солилцох боломжтой байна;
- Биет бус хөрөнгө нь гэрээний буюу бусад хууль эрхийн актын дагуу тэдгээр эрхийн шилжүүлэгдэх эсвэл тусад нь авч үзэх шинж чанараас үл хамааран үүсч байвал.

Хүлээн зөвшөөрөлт ба үнэлгээ

Биет бус хөрөнгийг анхны өртгөөр нь бүртгэх ба анхны өртөг нь түүний худалдан авсан үнэ, гаалийн болон эргэн төлөгдөхгүй нэмэгдсэн өртгийн татвар ба хөрөнгийг зориулалтаар нь ашиглахад бэлэн болохтой холбоотой бусад шууд зардлууд орно. Худалдан авсан үед худалдан авалтын хөнгөлөлт ба хямдрал эдэлсэн бол хөнгөлөлт хямдралын дүн нь хөрөнгийн өртөгт орохгүй.

Биет бус хөрөнгийн дансны ангилал

“Тэнгэрлиг медиа групп” ХК нь биет бус хөрөнгөө дараах үндсэн төрлүүдэд хуваана. Үүнд:

- Компьютерийн программ хангамж
- Патент
- Зохиогчийн эрх
- Худалдааны тэмдэг
- Лиценз
- Франчайз, борлуулалтын эрх зэрэг орно.

Биет бус хөрөнгийн хорогдуулалт

Тодорхой ашиглалтын хугацаатай биет бус хөрөнгийг түүний ашиглалтын хугацаанд хорогдуулна. Биет бус хөрөнгийн хорогдуулалт нь хөрөнгийг ашиглахад эсвэл хэрэглэхэд бэлэн болсон үеэс эхэлнэ.

“Тэнгэрлиг медиа групп” ХК нь биет бус хөрөнгөө Шулуун шугамын аргаар хорогдуулах ба хорогдуулах хугацаа нь 35 жил байна.

Биет бус хөрөнгөөс аж ахуйн нэгж хэдий хугацаанд өгөөж хүртэх нь тодорхойгүй байх үед ашиглалтын хугацаа тодорхойгүй биет бус хөрөнгө гэж үзнэ. Тодорхойгүй ашиглалтын хугацаатай биет бус хөрөнгийг хорогдуулахгүй.

Биет бус хөрөнгийг данснаас хасах

Биет бус хөрөнгийг борлуулах эсвэл түүнээс ирээдүйн эдийн засгийн өгөөж хүртэх нь тодорхойгүй болох үед түүнийг данснаас хасна. Биет бус хөрөнгийг данснаас хасах үед түүний дансны үнэ ба хасалтаас олсон орлогын зөрүүгээр олз, гарзыг тооцож түүнийг тайлант үеийн ашиг, алдагдлын хэсэгт тусгана.

Биет бус хөрөнгө дансны үндсэн бичилтүүд

- Биет бус хөрөнгийг авсан үед:
 - Дт Биет бус хөрөнгө
 - Кт Мөнгөн хөрөнгө
- Тайлант хугацаанд ногдох хорогдлын зардлыг тооцоолсон үед:
 - Дт Элэгдүүлэлтийн зардал
 - Кт Хуримтлагдсан элэгдүүлэлт

- Элэгдүүлэлтийн хугацаа дуусахаас өмнө үнэ цэнээ алдсан үед:
 - Дт Алдагдал
 - Хуримтлагдсан элэгдүүлэлт
 - Кт Биет бус хөрөнгө
- Гүүдвилийг бүртгэх үед:
 - Дт Хөрөнгө
 - Гүүдвил
 - Кт Өр төлбөр
 - Мөнгөн хөрөнгө
- Байгалийн нөөцийг худалдан авах үед:
 - Дт Байгалийн нөөц
 - Кт Мөнгөн хөрөнгө
- Байгалийн нөөцийг олборлосон үед хорогдуулгын зардлыг бүртгэх үед:
 - Дт Бараа
 - Кт Хуримтлагдсан хорогдуулга
- Барааг борлуулах үед:
 - Дт ББӨ
 - Кт Бараа

Санхүүгийн тайланд тусгах

Биет бус хөрөнгийг балансад эргэлтийн бус хөрөнгийн биет бус хөрөнгийн хэсэгт тусгана. Биет бус хөрөнгийг данснаас хасах үед үүссэн олз, гарзыг Орлогын тайлангийн үйл ажиллагааны бус ашиг, алдагдал хэсэгт тусгана.

4.9. ХОЗҮХХ-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлого

ХОЗҮХХ-ийн бүртгэлийн бодлогын зорилго:

ХОЗҮХХ-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлого нь дараах зорилготой.

- ХОЗҮХХ-ийг компанийн үйл ажиллагаатай уялдуулан зөв ангилж, бүртгэх, тайлагнах;
- ХОЗҮХХ-ийн өртөг, бодит үнэ цэнийг үнэн зөв тодорхойлох;
- ХОЗҮХХ-тэй холбоотой хяналтын тогтолцоог хэрэгжүүлэх;
- Санхүүгийн тайлангийн мэдээлэл хэрэглэгчдийг ХОЗҮХХ-тэй холбоотой үнэн зөв мэдээллээр хангах;
- СТОУС-д нийцсэн бүртгэл хөтлөх;

ХОЗҮХХ-ийн бүртгэлд хамаарах зүйлс:

ХОЗҮХХ гэдэг нь түрээсийн орлогоор эсвэл капиталын үнийн өсөлтөөр эсвэл энэ хоёрын аль алинаар ашиг олохын тулд эзэмшиж байгаа үл хөдлөх хөрөнгө (газар эсвэл барилга, барилгын нэг хэсэг) юм. Компани ХОЗҮХХ-ийн ангилалд өмчилсөн бөгөөд нэг буюу хэд хэдэн үйл ажиллагааны зориулалтаар түрээслүүлсэн, ирээдүйд ХОЗҮХХ-ийн зориулалтаар ашиглахын тулд барьж байгуулж буй эсвэл хөгжүүлж буй үл хөдлөх хөрөнгийг хамруулна.

Зарим тохиолдолд үл хөдлөх хөрөнгийг түрээсийн орлого олох, үнийн өсөлтөөр ашиг олох, үйлдвэрлэл үйлчилгээний болон удирдлагын зориулалтаар ашиглах зорилгоор эзэмшдэг. Хэрэв эдгээр хэсгүүдийг тусад нь борлуулж болохоор байвал компани тэдгээр хэсгүүдийг тусад нь бүртгэж, тайлагнана. Хэрэв тэдгээр хэсгүүдийг тусад борлуулах боломжгүй бөгөөд өчүүхэн бага хэсгийг үйлдвэрлэл үйлчилгээний болон удирдлагын зориулалтаар ашиглаж байвал бүхэлд нь ХОЗҮХХ гэж үзнэ.

ХОЗҮХХ-ийн салшгүй хэсэг болж буй хөрөнгүүдийг тухайн ХОЗҮХХ гэж үзэх бөгөөд тусад нь хөрөнгө гэж бүртгэхгүй. Тухайлбал түрээсэлж буй үл хөдлөх хөрөнгөтэй хамт түүний дотор байршуулсан тоноглол, тавилга зэрэг нь адилхан ХОЗҮХХ болж түүний бодит үнэ цэнийг тодорхойлоход багтана.

Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт:

ХОЗҮХХ-ийн анх өртгөөр нь хүлээн зөвшөөрөх бөгөөд (i) эдийн засгийн үр өгөөжийг нь компани хүртэж магадлалтай, (ii) өртгийг нь найдвартай хэмжих боломжтой үед хүлээн зөвшөөрнө.

ХОЗҮХХ-ийг анх өртгөөр нь хэмжинэ. Хүлээн зөвшөөрөлтийн өртөг нь худалдан авсан үнэ болон зориулалтын дагуу ашиглахад бэлэн болгохтой холбоотой нэмэлт зардал, сольж орлуулах зардлуудаас бүрдэнэ.

Хүлээн зөвшөөрөлтийн дараа үеийн хэмжилт:

ХОЗҮХХ-ийг хүлээн зөвшөөрөлтийн дараа бодит үнэ цэнийн загвараар хэмжинэ. Бодит үнэ цэнийн загварын бүх ХОЗҮХХ-ийн бүртгэлд тууштай мөрдөж ажиллах ба тайлангийн хугацаанд бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс үүссэн зөрүүг тайлант үеийн ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.

ХОЗҮХХ-ийг бодит үнэ цэнийн загвараар бүртгэж байгаа үед санхүүгийн зорилгоор элэгдэл байгуулахгүй бөгөөд татварын зорилгоор элэгдэл байгуулна.

ХОЗҮХХ-ийн шилжүүлэлт:

Компани хөрөнгийн ашиглалтад өөрчлөлт орсон зөвхөн ийм тохиолдолд үл хөдлөх хөрөнгийг ХОЗҮХХ-д эсвэл ХОЗҮХХ-өөс үл хөдлөх хөрөнгөд шилжүүлнэ. Үл хөдлөх хөрөнгө нь ХОЗҮХХ-ийн тодорхойлолтын хангасан эсвэл хангаахаа болсон гэдэг нотолгоо байгаа тохиолдолд хөрөнгийн ашиглалт өөрчлөгдсөн гэж үзнэ. Удирдлагын санал,

компанийн бизнесийн төлөвлөгөө зэрэг нь ашиглалтын өөрчлөлтийн нотолгоо болж чадахгүй.

Компани үл хөдлөх хөрөнгийн ашиглалт өөрчлөгдөх хүртэл өмнө бүртгэлийн загварыг мөрдөх бөгөөд үндсэн хөрөнгөөс ХОЗҮХХ гэж ангилах өдөр хүртэл элэгдэл байгуулсан хэвээр байна. Харин үл хөдлөх хөрөнгийн ашиглалт тодорхой болж ХОЗҮХХ-ийг бодит үнэ цэнийн загвараар бүртгэх үед үүссэн дансны үнэ болоод бодит үнэ цэнийн зөрүүг үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэлтэй ижил байдлаар бүртгэнэ. Өөрөөр хэлбэл шилжүүлэлт хийх үед дансны үнэ буурсан бол тайлант хугацааны зардал эсвэл өмнө нь хүлээн зөвшөөрсөн захин үнэлгээний нэмэгдлийн бууралтаар бүртгэнэ.

Үл хөдлөх хөрөнгийн ХОЗҮХХ рүү шилжүүлэх үед хөрөнгийн бодит үнэ цэнэ нэмэгдвэл бусад дэлгэрэнгүй орлогын хэсэгт дахин үнэлгээний нэмэгдэл байдлаар хүлээн зөвшөөрч түүнийг үл хүлээн зөвшөөрөх үед хуримтлагдсан ашигт шилжүүлнэ.

ХОЗҮХХ-ийн ашиглалт өөрчлөгдөж үндсэн хөрөнгө рүү шилжүүлэх үед буцаан мөрдөх горимоор нөлөөллийг бүртгэнэ.

ХОЗҮХХ-ийн үл хүлээн зөвшөөрөлт:

ХОЗҮХХ-ийг данснаас хассан эсвэл ашиглалтаас бүрэн гаргасан ба түүнээс эдийн засгийн үр өгөөж хүртэхээргүй болсон тохиолдолд үл хүлээн зөвшөөрнө. Үл хүлээн зөвшөөрөлттэй холбоотой үүссэн олз, гарзыг тайлант үеийн ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.

ХОЗҮХХ-ийг бүртгэлд тусгах:

- ХОЗҮХХ-ийг анх худалдан авахдаа өртгөөр нь хүлээн зөвшөөрөх ба өртөгт нь бусад бэлтгэл ажиллагааны зардал багтана. Бүртгэлд тусгах үед доорх байдлаар бүртгэнэ.
Дт ХОЗҮХХ
Кт Мөнгөн хөрөнгө эсвэл холбогдох өр төлбөр
- ХОЗҮХХ-ийг үндсэн хөрөнгөөс шилжүүлэх бөгөөд бодит үнэ цэнийн бууралт үүссэн үед доорх байдлаар бүртгэнэ.
Дт ХОЗҮХХ XXXXX (бодит үнэ цэнээр)
Дт ХОЗҮХХ-ийн шилжүүлгийн гарз XXXXX (БҮЦ болон дансны үнийн зөрүүгээр)
Кт: Үл хөдлөх хөрөнгө XXXXX (дансны үнээр)

Эсвэл:

- Дт ХОЗҮХХ XXXXX (бодит үнэ цэнээр)
- Дт Дахин үнэлгээний нэмэгдэл XXXXX (БҮЦ болон дансны үнийн зөрүүгээр)
Кт Үл хөдлөх хөрөнгө XXXXX (дансны үнээр)
- ХОЗҮХХ-ийг үндсэн хөрөнгөөс шилжүүлэх бөгөөд бодит үнэ цэнийн өсөлт үүссэн үед доорх байдлаар бүртгэнэ.
Дт ХОЗҮХХ XXXXX (бодит үнэ цэнээр)
Кт Үл хөдлөх хөрөнгө XXXXX (дансны үнээр)
- Дт Дахин үнэлгээний нэмэгдэл зөрүүгээр) XXXXX (БҮЦ болон дансны үнийн)
- ХОЗҮХХ-ийг тайлангийн хугацааны эцэст бодит үнэ цэнээр илэрхийлэх бөгөөд доорх байдлаар бүртгэнэ.
Дт ХОЗҮХХ
Кт ХОЗҮХХ-ийн үнэлгээний олз

Эсвэл:

Дт ХОЗҮХХ-ийн үнэлгээний гарз
Кт ХОЗҮХХ

- ХОЗҮХХ-ийг үл хүлээн зөвшөөрөх буюу борлуулсан үед доорх байдлаар бүртгэнэ.

Дт Мөнгөн хөрөнгө авлага авлага
Кт ХОЗҮХХ
Кт ХОЗҮХХ борлуулсны олз

Эсвэл:

Дт Мөнгөн хөрөнгө авлага авлага
Дт ХОЗҮХХ борлуулсны гарз
Кт ХОЗҮХХ

ХОЗҮХХ-ийг худалдан борлуулахаар шийдсэн тохиолдолд СТОУС 5 “борлуулах зорилготой эргэлтийн бус хөрөнгө ба зогсоосон үйл ажиллагаа”-ны дагуу бүртгэх бөгөөд бодит үнэ цэнээр бүртгэсэн хэвээр байна.

Санхүүгийн тайланд тусгах:

Тайлангийн хугацааны эцэст ХОЗҮХХ-ийг Сангийн сайдын 2017 оны 361 тоот тушаалаар батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу санхүүгийн байдлын тайлангийн эргэлтийн бус хөрөнгийн хэсэгт ХОЗҮХХ-ийн хэсэгт бодит үнэ цэнээр тайлагнана.

ХОЗҮХХ-ийн бүртгэл, тайлагналын хяналт:

ХОЗҮХХ-ийн бүртгэл, тайлагнал, үйл ажиллагаатай холбоотойгоор дараах хяналтын орчныг бүрдүүлж ажиллана.

Хяналтын орчин	Хяналтын горим
Нягтлан бодох бүртгэлийн хяналт:	<ul style="list-style-type: none"> ➢ ХОЗҮХХ-ийг 26 толгойтой дансанд бүртгэх бөгөөд ХОЗҮХХ тус бүрээр бүртгэл хөтөлнө. ➢ ХОЗҮХХ-ийн дотор зайлшгүй шаардлагатай хөрөнгүүдийг тусад нь бүртгэх боловч БҮЦ-д оруулж тооцно. ➢ ХОЗҮХХ-ийг бүртгэх БҮЦ-ийн загвараар бүртгэх үед санхүүгийн зорилгоор элэгдэл байгуулахгүй.
Санхүүгийн тайлагналын хяналт:	<p>Санхүүгийн тайлангийн үнэн зөв байдлыг хангах зорилгоор жилийн эцсийн санхүүгийн тайлан бэлтгэх үед ХОЗҮХХ-ийн бүртгэл, тайлагналтай холбоотой дараах хяналтуудыг хэрэгжүүлнэ.</p> <ul style="list-style-type: none"> ➢ ХОЗҮХХ-ийн бодит үнэ цэнийн хэмжилт хийсэн эсэхээ эргэн хянана. ➢ ХОЗҮХХ-ийг түрээслүүлж байгаа эсэхийг эргэн хянана. ➢ ХОЗҮХХ-д элэгдэл байгуулаагүй эсэхээ эргэн хянана.
Үйл ажиллагааны хяналт:	<p>ХОЗҮХХ-ийг тайлангийн хугацааны эцэст үндсэн хөрөнгийн тооллогод хамруулна.</p> <p>ХОЗҮХХ-ийг бүртгэлд тусгахдаа хөрөнгийн ашиглалт өөрчлөгдсөн эсэхийг баримтжуулж нотлох баримтыг үндэслэнгүйлгээг бүртгэх ба баримтаар нотлогдоогүй тохиолдолд бүртгэлд тусгахгүй.</p> <p>ХОЗҮХХ-ийн ажил гүйлгээг дараах санхүүгийн баримтыг үндэслэн бүртгэлд тусгана.</p> <ul style="list-style-type: none"> ➢ Бэлтгэн нийлүүлэлтийн гэрээ, нэхэмжлэх; ➢ Бэлтгэн нийлүүлэгчийн цахим төлбөрийн баримт;

	<ul style="list-style-type: none"> ➤ Худалдан авалттай холбоотой бэлтгэл ажиллагааны зардлыг нотлох бусад баримт;
Удирдлагад тайлагнах зүйлс:	<p>ХОЗҮХХ-ийн бүртгэл, тайлагнал хариуцсан этгээд дараах зүйлсийг компанийн удирдлагад тайлагнана.</p> <ul style="list-style-type: none"> ➤ Хөрөнгийн ашиглалтын байдал; ➤ ХОЗҮХХ-ийн бодит үнэ цэнийн мэдээлэл; ➤ ХОЗҮХХ-ийн ашиглалтын байдал;

ХОЗҮХХ-ийн бүртгэл, тайлагналтай холбоотой санхүүгийн тайланд нэмж тодруулах мэдээлэл:

- ХОЗҮХХ-ийг бүртгэж буй бүртгэл тайлагналын ерөнхий бодлого;
- ХОЗҮХХ-ийн бүртгэлийн арга;
- ХОЗҮХХ-ийн өөрчлөлт, хөдөлгөөн;
- ХОЗҮХХ-ийн бодит үнэ цэнийн мэдээлэл, түүний хараат бус үнэлгээчний үнэлсэн үндэслэл;
- ХОЗҮХХ-өөс олсон түрээсийн орлого;
- ХОЗҮХХ-ийн түрээсийн орлого олохтой холбоотой шууд холбогдон гарсан зардал;
- ХОЗҮХХ-ийн борлуулалт, түүнээс хүлээн зөвшөөрсөн олз, гарз;
- ХОЗҮХХ-ийн шилжилт, түүнтэй холбоотой тоон мэдээлэл, шилжилт хийсэн өдөр;
- ХОЗҮХХ-ийг түрээслүүлэхтэй холбоотой гэрээний болоод бусад нэмэлт үүрэг;
- Бодит үнэ цэнийн тохируулгаас үүссэн цэвэр олз, гарз;

4.10. Өр төлбөрийн бүртгэлийн бодлого

Өр төлбөрийн бүртгэлийн бодлогын зорилго

Өр төлбөрийн бүртгэлийн бодлогын зорилго нь өр төлбөр, түүнийг хэрхэн тооцоолох, бүртгэх аргыг тодорхойлоход оршино.

Өр төлбөрт хамаарагдах зүйлс

“Тэнгэрлиг медиа групп” ХК -ий өнгөрсөн цаг хугацаанд гарсан ажил гүйлгээ болон үйл явдлын үр дүнд бусдад хөрөнгө, үйлчилгээ шилжүүлэх өнөөгийн үүрэг хариуцлагаас үүсэлтэй эдийн засгийн үр өгөөжийн ирээдүйн мөнгөн зарлагуудыг өр төлбөр хэмээн авч үзнэ.

Хүлээн зөвшөөрөлт ба үнэлгээ

Дараах нөхцөлийг хангасан өр төлбөрийн зүйлсийг өр төлбөр гэж үзэн хүлээн зөвшөөрнө. Үүнд:

- Өнгөрсөн хугацаанд гарсан ажил гүйлгээ болон үйл явдал
- Өнөөгийн үүрэг хариуцлага
- Хөрөнгө, үйлчилгээний ирээдүйн төлбөр.

Бараа болон үйлчилгээний төлбөрийг ирээдүйд төлөхөөр бол уг бараа болон үйлчилгээний өнөөгийн үнэ цэнээр өр төлбөрийг бүртгэнэ.

“Тэнгэрлиг медиа групп” ХК нь бондын хөнгөлөлтийг үр ашигт хүүгийн аргаар элэгдүүлнэ.

Өр төлбөрийн дансны ангилал

Өр төлбөрийн төлөгдөх хугацаа харилцан адилгүй байдаг энэ шинж чанараас хамааруулан өр төлбөрийг 2 ангилна.

- Богино хугацаат өр төлбөр: Энэ нь эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэхэд зориулагдсан байх ба төлөгдөх хугацааны хувьд 1 жилийн дотор төлөгдөх өрүүд байна.
- Урт хугацаат өр төлбөр: Энэ нь эргэлтийн бус хөрөнгийг санхүүжүүлэхэд зориулагдсан байх ба төлөгдөх хугацааны хувьд 1 жилээс дээш хугацаатай байдаг.

“Тэнгэрлиг медиа групп” ХК нь өр төлбөрөө балансад дараах үндсэн төрлүүдэд ангилж бүртгэнэ. Үүнд:

- Дансны өр
- Богино хугацаат өрийн бичиг
- Урьдчилж олсон орлого
- Татварын өр
- Түрээсийн өр
- Хүүгийн өр
- Цалингийн өр
- Банкны зээлийн өглөг
- Бондын өглөг
- Санхүүгийн түрээсийн өглөг
- Бусад өр.

Өр төлбөр дансны үндсэн бичилтүүд

- Бараа материалыг зээлээр худалдан авах үед:
Дт Бараа материал
 Кт Дансны өр
- Дансны өрийг хөнгөлөлтийн хугацаанд төлж барагдуулах үед:

- Дт Дансны өр
- Кт Бараа материал
- Мөнгөн хөрөнгө
- Дансны өрийг хөнгөлөлтийн хугацааны дараа төлж барагдуулах үед:
 - Дт Дансны өр
 - Кт Мөнгөн хөрөнгө
- Өрийн бичиг гаргах үед:
 - Дт Мөнгөн хөрөнгө
 - Кт Өрийн бичиг
- Өрийн бичгийн хүүг тооцож бүртгэх үед:
 - Дт Хүүгийн зардал
 - Кт Хүүгийн өр
- Хугацаа дуусах үед өрийн бичгийг хуримтлагдсан хүүгийн хамт төлөх үед:
 - Дт Өрийн бичиг
 - Дансны өр
 - Кт Мөнгөн хөрөнгө
- Банкнаас зээл авах үед:
 - Дт Мөнгөн хөрөнгө
 - Кт Банкны зээл
- Дансны өрийг өрийн бичиг рүү шилжүүлэн бүртгэх үед:
 - Дт Дансны өр
 - Кт Өрийн бичиг

Санхүүгийн тайланд тусгах

Өр төлбөрийг балансад эх үүсвэр талд хамгийн эхэнд тусгаж харуулна.

4.11. Эзэмшигчдийн өмчийн бүртгэлийн бодлого

Эзэмшигчдийн өмчид хамаарагдах зүйлс

“Тэнгэрлиг медиа групп” ХК -ийн эзэмшигчээс олж авсан санхүүжилт буюу эзэмшигчийн компанид оруулсан хөрөнгө оруулалтыг эзэмшигчдийн өмчид хамааруулан үзнэ.

Эзэмшигчдийн өмч дансны ангилал

“Тэнгэрлиг медиа групп” ХК -ийн эзэмшигчийн өмч нь дараах зүйлсээс бүрдэнэ. Үүнд:

- Хувьцаат капитал: Хувьцаа эзэмшигчийн хувьцаа худалдан авах замаар компанид оруулсан хөрөнгө.
- Энгийн хувьцаа: Энгийн хувьцааг нэрлэсэн үнээр тайлагнах ба санхүүгийн байдлын тайланд эзэмшигчдийн өмчийн хэсэгт хувийн өмчийн дүнд тайлагнана. Мөн давуу эрхтэй хувьцаа гаргасан бол мөн хэсэгт тайлагнана.
- НТК-ЭХ
- Давуу эрхтэй хувьцаа
- НТК-ДЭХ
- Халаасны хувьцаа
- Хуримтлагдсан ашиг: Бизнесийн үйл ажиллагааны үр дүнд бий болно. Бизнесийн үйл ажиллагааны хуримтлагдсан цэвэр ашгаас хувьцаа эзэмшигчдэд төлсөн ногдол ашгийг хассан дүн.

Үнэлгээ ба хүлээн зөвшөөрөлт

Хувьцаа гэдэг нь тухайн компанид хувь нийлүүлж хөрөнгө оруулсныг, ноогдол ашиг авах эрхийг гэрчлэх үнэт цаас юм. “Тэнгэрлиг медиа групп” ХК нь үнэт цаасны хорооноос зохих зөвшөөрөл авсанаар саналын эрхгүй буюу давуу эрхтэй хувьцаа, саналын эрхтэй буюу энгийн хувьцааг тодорхой нэрлэсэн үнэтэйгээр гаргаж болно.

Хувьцаа гаргалт: Компаний үйл ажиллагаатай холбоотой асуудалд санал оруулах эрхийг саналын эрх гэх бөгөөд саналын эрхтэй хувьцаа нь энгийн хувьцаа. Энгийн хувьцаа нь дараах онцлогтой байна.

- Саналын эрхтэй
- Компани ноогдол ашиг зарлах үед ноогдол ашиг авна
- Ноогдол ашгийн хэмжээ нь компанийн ашгийн хэмжээтэй шууд хамааралтай байдаг бөгөөд алдагдалтай ажиллах, ноогдол ашиг зарлаагүй үед ноогдол ашиг авахгүй байх эрсдэлтэй.

Нэрлэсэн үнийн тодорхой хувиар эсвэл тогтмол дүнгээр урьдчилан ноогдол ашиг зарлаж гаргасан хувьцааг давуу эрхтэй хувьцаа гэх бөгөөд дараах онцлогтой байна.

- Саналын эрхгүй
- Ногдол ашгийг хамгийн түрүүнд авах эрхтэй.
- Компани ашигтай, алдагдалтай ажилласан ч ногдол ашгийн хэмжээ тогтмол байна.

Хувьцааны борлуулалтаас хүлээн авсан дүн болон нэрлэсэн үнийн зөрүүгээр Нэмэгдэж төлөгдсөн капитал данс үүснэ.

“Тэнгэрлиг медиа групп” ХК нь хувьцааг үнэт цаасны зах зээл дээр чөлөөтэй борлуулахаас гадна захиалгын үндсэн дээр борлуулж болно. Хувьцааны төлбөр бүрэн эсвэл дийлэнх хэсэг нь төлөгдөх хүртэл хувьцааг эзэмшигчдэд шилжүүлэхгүй байна.

Халаасны хувьцаа: “Тэнгэрлиг медиа групп” ХК өөрийн гаргасан хувьцаагаа эргүүлэн худалдан авсныг халаасны хувьцаа гэж үзнэ.

Халаасны хувьцааг дараах хэд хэдэн зорилгоор бий болгоно. Үүнд:

1. Эргэлтэн дэх энгийн хувьцааны тоог багасгаснаар нэгж энгийн хувьцаанд ноогдох ашгийн нэмэгдүүлэх
2. Хяналтын багцыг алдахаас сэргийлэх

3. Хувьцааны эрэлт бий болох
4. Халаасласан хувьцаагаар төрөл бүрийн шагнал урамшуулал олгох
5. Хувьцаа эзэмшигчдийн тоог цөөрүүлэх замаар ноогдол ашгийг бууруулах.

“Тэнгэрлиг медиа групп” ХК нь Халаасны хувьцааны худалдан авалтыг бүртгэх өртгийн аргыг ашиглана.

Халаасны хувьцааны худалдан авалтыг худалдан авсан өдрийн өртөг дээр суурилан бүртгэнэ.

Ногдол ашиг: Ашгаас хувьцаа эзэмшигч буюу хөрөнгө оруулагчдад хуваарилагдах хэсгийг ногдол ашиг гэж үзнэ. Хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах шийдвэрийг “Тэнгэрлиг медиа групп” ХК -ийн төлөөлөн удирдах зөвлөл гаргана. Компани нь ногдол ашгийг мөнгөөр, хувьцаагаар, эд хөрөнгөөр хуваарилаж болно.

“Тэнгэрлиг медиа групп” ХК нь энгийн хувьцааны ногдол ашгийг компаний ашгийн түвшинд үндэслэн, давуу эрхтэй хувьцааны ногдол ашгийг нэрлэсэн үнийн тодорхой хувиар хуримтлалтай байдлаар хувьцаа эзэмшигчдэд хуваарилна.

Эзэмшигчийн өмч дансны үндсэн бичилтүүд

- Хувьцааг нэрлэсэн үнээр нь борлуулах үед:
 - Дт Мөнгөн хөрөнгө
 - Кт Энгийн хувьцаа/ ДЭХ
- Хувьцааг нэрлэсэн үнээс нь өндөр үнээр борлуулах үед:
 - Дт Мөнгөн хөрөнгө
 - Кт Энгийн хувьцаа/ ДЭХ
 - НТК-ЭХ/ ДЭХ
- Хувьцааны захиалга хүлээн авсан үед:
 - Дт Захиалгат хувьцааны авлага
 - Кт Захиалгат энгийн хувьцаа
 - НТК
- Захиалгат хувьцааны төлбөр хүлээн авсан бол:
 - Дт Мөнгөн хөрөнгө
 - Кт Захиалгат хувьцааны авлага
- Хувьцаа гаргасан үед:
 - Дт Захиалгат энгийн хувьцаа
 - Кт Энгийн хувьцаа
- Хувьцаагаа буцаан худалдан авсан үед:
 - Дт Халаасны хувьцаа
 - Кт Мөнгөн хөрөнгө
- Халаасны хувьцаагаа буцаан гаргасан үед:
 - Дт Мөнгөн хөрөнгө
 - Кт Халаасны хувьцаа
 - НТК-ХХ
- Халаасны хувьцаагаа хүчингүй болгосон үед:
 - Дт Энгийн хувьцаа
 - НТК
 - Хуримтлагдсан ашиг
 - Кт Халаасны хувьцаа
 - Эргэлтээс гаргасны НТК
- Ногдол ашиг зарласан үед:
 - Дт Зарласан ногдол ашиг
 - Кт Ногдол ашгийн өглөг
- Ногдол ашгийг олгосон үед:

Дт Ногдол ашгийн өглөг
Кт Мөнгөн хөрөнгө

Санхүүгийн тайланд тусгах

Эзэмшигчийн өмчийг балансын эх үүсвэр талд өр төлбөрийн дараа тусгана.

4.12. Орлогын бүртгэлийн бодлого

Байгууллагын ердийн үйл ажиллагааны явцад тайлант хугацаанд бий болсон бөгөөд эзэмшигчдээс оруулсан хөрөнгөнөөс бусад шалтгаанаар өмчийн өсөлт хэлбэрээр илэрсэн эдийн засгийн өгөөжийн дотогш урсгалыг орлого гэж үзнэ. Орлого нь өөртөө үйл ажиллагааны орлого болон бусад орлогыг багтаана.

Энэхүү бүртгэлийн бодлогын зорилго нь тодорхой ажил гүйлгээ болон үйл явцаас үүссэн орлогыг нягтлан бодох бүртгэлд бүртгэх журмыг тодорхойлоход оршино.

Орлогод хамаарах зүйлс

“Тэнгэрлиг медиа групп” ХК нь өөрийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг борлуулж орлого олно. Түүнчлэн хүү, эрхийн төлбөр, ногдол ашиг болон бусад төрлийн орлого олж болно.

Орлогын дансны ангилал

Компани борлуулалтын орлогоо дараах үндсэн төрлүүдэд ангилж бүртгэнэ. Үүнд:

1. Үндсэн үйл ажиллагааны орлого
2. Үндсэн бус үйл ажиллагааны орлого
3. Үйл ажиллагааны бус орлого

Үндсэн үйл ажиллагааны орлого: Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ борлуулсанаас орж ирэх борлуулалтын орлого.

Үндсэн бус үйл ажиллагааны орлого: Худалдан авагчаас нэхэмжилсэн хүү, торгуулийн болон бусад төрлийн орлого.

Үйл ажиллагааны бус орлого: Дээрхи хүү, торгуулийн орлогоос бусад төрлийн хүү, торгуулийн орлого, ногдол ашгийн, хөрөнгө борлуулсан болон дээрхээс бусад бүх төрлийн орлогууд хамаарна.

Хүлээн зөвшөөрөлт ба үнэлгээ

Орлогыг нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурийн дагуу хүлээн зөвшөөрнө. Дараах нөхцөл бүрдсэн үед борлуулалтын орлогыг хүлээн зөвшөөрнө. Үүнд:

- Орлогыг найдвартай хэмжин тодорхойлж болохуйц
- Тухайн ажил гүйлгээнд хамаарах эдийн засгийн өгөөжийг “Тэнгэрлиг медиа групп” ХК хүртэх магадлалтай
- Баланс гарах үед тухайн ажил гүйлгээний бүрдэлтийн үе шатыг бодитойгоор тооцож болохоор байвал
- Тухайн ажил гүйлгээтэй холбогдон гарсан зардлыг болон уг ажил гүйлгээний бүрдэлтийн өртгийг үнэн магадтайгаар тодорхойлж болохоор байх ёстой.

Орлогод зөвхөн “Тэнгэрлиг медиа групп” ХК -ийн үйл ажиллагаанаас хүлээн авсан, мөн ирээдүйд хүлээн авах эдийн засгийн өгөөжийн нийт хэмжээ хамаарна.

Орлого нь хүлээн авсан болон авахаар хүлээгдэж буй нөхөлтийн бодит үнэ цэнээр бүртгэнэ. Бодит үнэ цэн гэдэг нь холбоогүй талуудын ажил гүйлгээгээр арилжаанд ороход бэлэн байгаа талуудын хооронд хөрөншгийг солилцох, эсвэл өр төлбөрөөр тооцож болох дүнг хэлнэ.

Орлогын дансны үндсэн бичилтүүд

- Үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнээ борлуулсан хэмжээгээр:
Дт Дансны авлага/ Мөнгөн хөрөнгө
Кт Борлуулалтын орлого
- Худалдан авагч нь борлуулалтын нэхэмжлэхийн төлбөрийг гэрээнд заасан хөнгөлөлттэй хугацаанд хийвэл:
Дт Мөнгөн хөрөнгө

Кт Борлуулалтын хөнгөлөлт

Кт Дансны авлага

- Банкнаас харилцах дансны тогтвортой үлдэгдэлд хүү төлөх, түрээсийн орлого гэх мэт орлого олохоос гадна үндсэн бус үйл ажиллагаанаас орлого олсон бол:

Дт Мөнгөн хөрөнгө/ Худалдааны бус авлага

Кт Үйл ажиллагааны бус орлого

Санхүүгийн тайланд тусгах

Үндсэн үйл ажиллагааны борлуулалтын орлогыг Орлогын тайланд нийт борлуулалтын хэсэгт, борлуулалтын хөнгөлөлт, борлуулалтын буцаалт, үнийн бууралтыг нийт борлуулалтын дор сөрөг утгатайгаар, харин үлдсэн үйл ажиллагаанаас гадуур олсон орлогыг Үйл ажиллагааны бус орлого хэсэгт тайлагнаж харуулна.

4.13. Өртөг, зардлын бүртгэлийн бодлого

Үндсэн үйл ажиллагаа явуулахтай холбоотойгоор гарсан үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны зардал, удирдлага ба борлуулалтын зардлууд, борлуулсан барааны өртөг гэх мэт өртөг зардлын зүйлс, түүнчлэн тайлангийн хугацаанд хувь нийлүүлэгчид олгосон хуваарилалттай холбогдон цэвэр өмч буурахаас бусад замаар хөрөнгийг багасгасан болон өр төлбөрийг нэмэгдүүлсэн эдийн засгийн үр өгөөжийн бууралтыг зардал гэж үзнэ.

Өртөг зардлын бүртгэлийн зорилго

Энэхүү бүртгэлийн бодлогоор өртөг зардлыг хүлээн зөвшөөрөх, түүнийг нягтлан бодох бүртгэлд бүртгэх журмыг тодорхойлоход оршино.

Өртөг, зардлын дансны ангилал

Зардлыг бүтээгдэхүүнд шингэх байдалтай уялдуулан дараах байдлаар ангилна. Үүнд:

- Борлуулсан бүтээгдэхүүний өртөг
- Ерөнхий удирдлагын зардал (Төлөөлөн удирдах зөвлөл, хянан шалгах хороо, байгууллагын удирдлагатай холбоотой зардал)
- Борлуулалтын зардал (Борлуулалтын хэсгийн зардал)
- Үндсэн бус үйл ажиллагааны зардал (Хүү торгууль хөнгөлөлтийн зардал, гадаад валютын ханшийн зөрүүнээс гарсан алдагдал, үндсэн хөрөнгө худалдсаны алдагдал гэх мэт)

Хүлээн зөвшөөрөлт ба үнэлгээ

Зардлыг гарсан тухайн үед нь мөнгөөр төлөгдсөн эсэхээс үл хамааран зардал хэмээн хүлээн зөвшөөрч, тайлант жилийн орлогын тайланд тайлагнана.

Хөрөнгө багасах буюу өр төлбөр нэмэгдсэний улмаас эдийн засгийн үр өгөөж буурч, энэхүү бууралтыг найдвартай хэмжих боломжтой байвал зардал гэж үзнэ.

Бүтээгдэхүүн үйлчилгээний өртгийг түүнтэй холбоотой орох орлогод нь шууд хамааруулан орлого зардлыг уялдуулан хүлээн зөвшөөрнө. Эдийн засгийн үр ашиг нь тайлангийн хэд хэдэн үед гарахаар хүлээгдэж байвал уг зардлыг орлогын үе шаттай нь уялдуулан хуваарилж хүлээн зөвшөөрнө. Энэ нь үл хөдлөх хөрөнгө, машин, тоног төхөөрөмж, биет бус хөрөнгийн ашиглахтай холбогдон гарсан зардлыг хүлээн зөвшөөрөхөд илүү тохиромжтой. Ийм төрлийн зардлын түгээмэл жишээ нь үндсэн хөрөнгийн элэгдэл юм.

Санхүүгийн тайланд тусгах

Борлуулсан үтээгдэхүүний өртгийг орлогын тайланд борлуулсан барааны өртөг хэсэгт тайлагнана.

Удирдлага, борлуулалтын зардлыг орлогын тайлангийн үйл ажиллагааны зардал хэсэгт, үндсэн бус үйл ажиллагааны зардлыг үндсэн бус үйл ажиллагааны ашиг алдагдал хэсэгт зардлын төрлөөр нь ангилан харуулна.

4.14. Гадаад валютын ханшийн зөрүүний нягтлан бодох бүртгэлийн бодлого

Гадаад валютын ханшийн зөрүүний олз, гарзын бүртгэлийн бодлогын зорилго:

Гадаад валютын ханшийн зөрүүний олз, газрын бүртгэлийн бодлого нь компанийн гадаад валюттай холбоотой ажил гүйлгээнээс үүсэх олз, газрыг үнэн зөв тодорхойлж тайлангийн хугацааны болон хойшлогдсон татварын нөлөөг үнэн зөв бүртгэх, тайлагнах зорилготой юм. Өөрөөр хэлбэл:

- Ханшийн зөрүүнээс үүдэлтэй олз, гарзыг СТОУС, компанийн үйл ажиллагаатай уялдуулан үнэн зөв тодорхойлох;
- Монгол улсын татварын хууль тогтоомжид нийцүүлэн ханшийн зөрүүний бодит болон бодит бус олз, гарзыг үнэн зөв тодорхойлох;

- Тайлангийн хугацааны хойшлогдсон татварын нөлөөг үнэн зөв тодорхойлох;
- Хойшлогдсон татварын үлдэгдлийг үнэн зөв тодорхойлж аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг хуулийн дагуу үнэн зөв тооцох;
- Хойшлогдсон татвараас үүдэлтэй хуулийн хүрээнд татварыг бага төлөх;
- Санхүүгийн тайлангийн мэдээлэл хэрэглэгчдийг гадаад валютын ханшийн өөрчлөлтөөс үүссэн ашиг, алдагдалтай холбоотой үнэн зөв мэдээллээр хангах;
- СТУОС-д нийцсэн бүртгэл хөтлөх;

Гадаад валютын ханшийн зөрүүний олз, гарзын бүртгэлд хамаарах зүйлс:

Компани Монгол улсын нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу бүртгэлээ Монгол төгрөгөөр бүртгэдэг бөгөөд үүнээс бусад валют нь гадаад валют байна. Гадаад валютаар илэрхийлэгдсэн ажил гүйлгээ, санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн үлдэгдэлд тооцогдсон валютын ханшийн зөрүүнээс үүдэлтэй дараах олз, гарзыг ойлгоно. Үүнд:

- Ханшийн зөрүүний бодит олз
- Ханшийн зөрүүний бодит гарз
- Ханшийн зөрүүний бодит бус олз
- Ханшийн зөрүүний бодит бус гарз
 - Ханшийн зөрүүний бодит олз, гарз: нь гадаад валютаар гарсан ажил гүйлгээний үр дүнд хүлээн зөвшөөрч буй санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн өөрчлөлт юм. Бодит олз, гарз нь валют солиулах буюу арилжаанд оролцох, авлага цугларах, өр төлбөрийг төлж барагдуулах үед үүснэ.
 - Ханшийн зөрүүний бодит бус олз, гарз: нь гадаад валютаар илэрхийлэгдсэн санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн үлдэгдлийн түүхэн ханш болон Монголбанкны хаалтын ханшаар тэгшитгэн тооцсон дүнгийн зөрүү юм. Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн хувьд ханшийн зөрүүний бодит бус олз, гарз гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн хөрөнгө, авлага, дансны өр болон банк санхүүгийн байгууллагаас авсан зээл зэрэг санхүүгийн хөрөнгө, өр төлбөртэй холбоотойгоор үүснэ.

Тайлангийн хугацааны эцэст гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн зүйлсийн үлдэгдлийг Монголбанкны хаалтын ханшаар тэгшитгэн тооцох ба мөнгөн бус зүйлсийн хувьд гадаад валютаарх ажил гүйлгээний түүхэн ханшаар илэрхийлэгдэнэ.

Мөнгөн зүйлсэд дараахыг хамруулж ойлгоно.

- Мөнгөн хөрөнгө
- Мөнгөөр барагдуулах нөхцөлтэй авлага
- Гадаад валютаарх хөрөнгө оруулалтууд
- Мөнгөөр төлж барагдуулах өр төлбөр, зээл, бусад өр

Мөнгөн бус зүйлсэд дараах зүйлс хамаарна.

- Ажиллагсдын дараа тайлангийн авлага
- Урьдчилж төлсөн зардал, тооцоо
- Бараа материал
- Борлуулах зорилготой эргэлтийн бус хөрөнгө
- Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө
- Үндсэн хөрөнгө
- Биет бус хөрөнгө
- Хойшлогдсон татварын хөрөнгө
- Урьдчилж орсон орлого
- Эзэмшигчдийн өмчийн данснууд

Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт:

Гадаад валютын ханшийн зөрүүний бодит олз, гарзыг тухайн ажил гүйлгээ гарах бүрд хүлээн зөвшөөрөх ба бодит бус олз, гарзыг санхүүгийн тайлан тасалбар холгох хугацааны эцэст хүлээн зөвшөөрнө.

Гадаад валютын ханшийн зөрүү нь тухайн ажил гүйлгээний түүхэн ханш болон ажил гүйлгээг гарах үеийн Монголбанкны зарласан ханш хоёрын зөрүүгээр илэрхийлэгдэнэ.

Гадаад валютын ханшийн зөрүүг бүртгэлд тусгах:

Гадаад валютын ханшийн зөрүүний бодит олз, гарзыг ажил гүйлгээ гарсан тухай бүрд бүртгэлд тусгах ба бодит олз, гарз үүсэх дараах тохиолдлууд байна.

- Гадаад валютын арилжаа буюу худалдан авах үед дараах бичилт хийнэ.

	Дт Мөнгөн хөрөнгө /валютын данс/	XXXXXX /МБ-ны ханшаар/
	Дт Ханшийн зөрүүний бодит гарз	XXXXXX /МБ, АБ-ны ханшийн зөрүүгээр/
	Кт Мөнгөн хөрөнгө /төгрөгийн данс/	XXXXXX /АБ-ны ханшаар/

- Гадаад валютын арилжаа буюу худалдан борлуулах үед дараах бичилт хийнэ.

	Дт Мөнгөн хөрөнгө /төгрөгийн данс/	XXXXXX /АБ-ны ханшаар/
	Дт Ханшийн зөрүүний бодит гарз	XXXXXX /МБ, АБ-ны ханшийн зөрүүгээр/
	Кт Мөнгөн хөрөнгө /валютын данс/	XXXXXX /МБ-ны ханшаар/

- Гадаад валютаар үүссэн авлага барагдуулах үед: /ханшийн өсөлттэй/

	Дт Мөнгөн хөрөнгө /валютын данс/	XXXXXX /МБ-ны ханшаар/
	Кт Авлага /валютын данс/	XXXXXX /түүхэн ханшаар/
	Кт Ханшийн зөрүүний бодит олз зөрүү/	XXXXXX /МБ, түүхэн ханшийн зөрүү/

- Гадаад валютаар үүссэн авлага барагдуулах үед: /ханшийн бууралттай/

	Дт Мөнгөн хөрөнгө /валютын данс/	XXXXXX /МБ-ны ханшаар/
	Дт Ханшийн зөрүүний бодит гарз	XXXXXX /МБ, түүхэн ханшийн зөрүү/
	Кт Авлага /валютын данс/	XXXXXX /түүхэн ханшаар/

- Гадаад валютаар гарсан төлбөрийн бараа, ажил, үйлчилгээг орлогод авах, зардалд тооцох үед төлбөр төлөгдсөн тухайн үеийн ханшаар төгрөгт хөрвүүлсэн дүнгээр тохируулах бичилт хийнэ.

	Дт Бараа эсвэл зардал	XXXXXX /түүхэн ханшаар/
	Кт УТЗ, тооцоо /валютын данс/	XXXXXX /түүхэн ханшаар/

- Гадаад валютаар илэрхийлэгдсэн өр төлбөр, түүнтэй адилтгах санхүүгийн хариуцлагыг төлж барагдуулах үед: /ханшийн өсөлттэй/

	Дт Өр төлбөр /валютын данс/	XXXXXX /түүхэн ханшаар/
	Дт Ханшийн зөрүүний бодит гарз	XXXXXX /МБ, түүхэн ханшийн зөрүү/
	Кт Мөнгөн хөрөнгө /валютын данс/	XXXXXX /МБ-ны ханшаар/

- Гадаад валютаар илэрхийлэгдсэн өр төлбөр, түүнтэй адилтгах санхүүгийн хариуцлагыг төлж барагдуулах үед: /ханшийн бууралттай/

	Дт Өр төлбөр /валютын данс/	XXXXXX /түүхэн ханшаар/
	Кт Мөнгөн хөрөнгө /валютын данс/	XXXXXX /МБ-ны ханшаар/
	Кт: Ханшийн зөрүүний бодит олз	XXXXXX /МБ, түүхэн ханшийн зөрүү/

- Гадаад валютаарх үйлчилгээний төлбөрийг орлогод тооцох үед төлбөр хүлээн авсан түүхэн ханшаар орлого тохируулан бүртгэнэ.

	Дт УОО /валютын данс/	XXXXXX /түүхэн ханшаар/
	Кт Борлуулалтын орлого/валютын данс/	XXXXXX /түүхэн ханшаар/

Гадаад валютын ханшийн зөрүүний бодит бус олз, гарзыг санхүүгийн тайлан бэлтгэх хугацаа бүрийн эцэст хийж гүйцэтгэх ба бодит бус олз, гарз үүсэх дараах тохиолдлууд байна.

- Мөнгөн хөрөнгө, авлага зэрэг санхүүгийн хөрөнгийн үлдэгдэл өсгөх үед дараах бичилт хийнэ.
Дт Мөнгөн хөрөнгө эсвэл авлага
Кт Ханшийн зөрүүний бодит бус олз
- Мөнгөн хөрөнгө, авлага зэрэг санхүүгийн хөрөнгийн үлдэгдэл буурах үед дараах бичилт хийнэ.
Дт Ханшийн зөрүүний бодит бус гарз
Кт Мөнгөн хөрөнгө эсвэл авлага
- Өр төлбөр, түүнтэй адилтгах санхүүгийн өр төлбөрийн үлдэгдэл буурах үед дараах бичилт хийнэ.
Дт Ханшийн зөрүүний бодит бус гарз
Кт Өр төлбөр, түүнтэй адилтгах зүйл
- Өр төлбөр, түүнтэй адилтгах санхүүгийн өр төлбөрийн үлдэгдэл буурах үед дараах бичилт хийнэ
Дт Өр төлбөр, түүнтэй адилтгах зүйл
Кт Ханшийн зөрүүний бодит бус олз
- Гадаад валют, түүнтэй тэнцэх төгрөгийг шилжүүлэх замаар бараа, ажил, үйлчилгээ худалдан авч болох ба энэ үед гадаад валют худалдан авч шилжүүлсэн байдлаар бүртгэнэ.
Дт Холбогдох хөрөнгө эсвэл зардлын данс ханш XXXXX (тооцоолсон валют*МБ-ны)
Дт Ханшийн зөрүүний бодит гарз XXXXX (зөрүүгээр)
Кт Мөнгөн хөрөнгө /төгрөг/ XXXXX (зарцуулсан мөнгө)

Ханшийн зөрүүний бодит бус олз, гарзыг тодорхойлох:

- Гадаад валютын ханшийн зөрүүний бодит бус олз, гарз нь санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн үлдэгдэлд ногдох ханшийн үнэлгээний зөрүүг илэрхийлж байх ёстой бөгөөд тайлангийн Хугацааны эцэст тэдгээрийг дахин тооцоолж зөрүүг ханшийн зөрүүний бодит олз, гарз руу шилжүүлэн бүртгэнэ. Энэ үед дараах бичилтийг хийнэ.
Дт Ханшийн зөрүүний бодит бус олз
Кт Ханшийн зөрүүний бодит олз
Дт Ханшийн зөрүүний бодит гарз
Кт Ханшийн зөрүүний бодит бус гарз

Гадаад валютын ханшийн зөрүүний данснуудын хаалт:

Гадаад валютын ханшийн зөрүүний олз нь тайлант үеийн ашгийг нэмэгдүүлэх, гарз нь бууруулах утгыг илэрхийлэх ба ОЗНД-аар дамжуулан орлого, үр дүнгийн тайланд хаах ба дараах бичилт хийнэ.

1. Дт Ханшийн зөрүүний бодит олз
Кт Орлого, зарлагын нэгдсэн данс
Дт Ханшийн зөрүүний бодит бус олз
Кт Орлого, зарлагын нэгдсэн данс
2. Дт Орлого, зарлагын нэгдсэн данс
Кт Ханшийн зөрүүний бодит гарз
Дт Орлого, зарлагын нэгдсэн данс
Кт Ханшийн зөрүүний бодит бус гарз

Ханшийн зөрүүний олз, гарзыг санхүүгийн тайланд тусгах:

Ханшийн зөрүүний олз, гарзыг Сангийн сайдын 2017 оны 361 тоот тушаалаар батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу нийт ханшийн зөрүүний бодит болон бодит бус олз, гарзын ОЗНД-д хаагдсан цэвэр дүнгийн нийлбэрээр Орлого үр дүнгийн тайланд толилуулна.

Ханшийн зөрүүний олз, гарзын дансны бүртгэл, тайлагналын хяналт:

Ханшийн зөрүүний бүртгэл, тайлагналтай холбоотойгоор дараах хяналтын орчныг бүрдүүлж ажиллана.

Хяналтын орчин	Хяналтын горим
Нягтлан бодох бүртгэлийн хяналт:	<ul style="list-style-type: none"> ➤ Гадаад валютын ханшийн зөрүүний бодит болон бодит бус олз, гарзыг тус бүрээр нь НББ-ийн данс үүсгэн бүртгэх ба бодит бус олз, гарзыг мөнгөн хөрөнгийн, авлагын, дансны өр төлбөрийн, зээлийн, бусад өр төлбөрийн үлдэгдэлд тооцогдсон гэх зэрэг үүссэн дансны ерөнхий ангиллаар нь тусад нь бүртгэнэ. ➤ Гадаад валютын ханшийн зөрүүний бодит олз, гарзыг ажил гүйлгээ гарсан тухай бүрд нь Монголбанкны албан ханш ашиглан тооцно. ➤ Гадаад валютаар гарсан ажил гүйлгээнд Монголбанкны албан ханшийн ашиглахдаа гүйлгээ гарсан өдрийн өмнөх өдрийн ханшийг ашиглана. ➤ Гадаад валютаарх санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн үлдэгдэлд ханшийн тэгшитгэл тооцоходоо 12 дугаар сарын 30- ны өдрийн албан ханшийг ашиглан тэгшитгэнэ.
Санхүүгийн тайлагналын хяналт:	<p>Санхүүгийн тайлангийн үнэн зөв байдлыг хангах зорилгоор жилийн эцсийн санхүүгийн тайлан бэлтгэх үед гадаад валютын ханшийн зөрүүний бүртгэл, тайлагналтай холбоотой дараах хяналтуудыг хэрэгжүүлнэ.</p> <ul style="list-style-type: none"> ➤ Тайлангийн хугацаанд ханшийн зөрүүний бодит бус олз, гарзыг дахин тооцоолсон эсэхээ хянана. ➤ Тайлангийн хугацааны эцэст ханшийн зөрүүний бодит бус олз, гарз тооцоход ашигласан санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн бодит үлдэгдэл зөв эсэхийг шалгана.
Үйл ажиллагааны хяналт:	<ul style="list-style-type: none"> ➤ Тайлангийн хугацааны гадаад валютын ханшийн зөрүүнээс алдагдал хүлээж болзошгүй эсэхээ үнэлнэ. ➤ Ханшийн эрсдэлд өртөж болзошгүй гэж үзвэл эсрэг арга хэмжээг төлөвлөнө.
Удирдлагад тайлагнах зүйлс:	<p>Гадаад валютын ханшийн зөрүүний бүртгэл, тайлагналтай холбоотой дараах зүйлсийг удирдлагад тайлагнана.</p> <ul style="list-style-type: none"> ➤ Гадаад валютын ханшийн зөрүүний өөрчлөлтөөс хүлээж байгаа ашиг, алдагдал; ➤ Ханшийн зөрүү үүсээд байгаа санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн үлдэгдэл; ➤ Тайлангийн хугацаанд хүлээн зөвшөөрсөн ханшийн зөрүүний татварын нөлөөлөл; ➤ Цаашид хойшлогдсон татварын бүртгэлд нөлөөлөх нөлөөлөл ▪Ханшийн зөрүү, ханшийн эрсдэлээс сэргийлэх арга хэмжээ;

Гадаад валютын ханшийн зөрүүний бүртгэл, тайлагналтай холбоотой санхүүгийн тайланд нэмж тодруулах мэдээлэл:

Гадаад валютын ханшийн зөрүүтэй холбоотой дараах зүйлсийг санхүүгийн тайланд нэмж тодруулна.

- Гадаад валютаар илэрхийлэгдсэн санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн үлдэгдлийг өмнөх онтой зэрэгцүүлсэн үлдэгдэл;
- Гадаад валютын ханшийн зөрүүнээс сэргийлэх компанийн ерөнхий бодлого, зарчим, ажиллагаа;
- Гадаад валютын ханшийн зөрүүнээс үүссэн бодит болон бодит бус олз, гарзыг тус бүрээр нь өмнөх онтой зэрэгцүүлэн тодруулна;

4.15. Бусад олз, гарзын нягтлан бодох бүртгэлийн бодлого

Бусад олз, гарзын бүртгэлийн бодлогын зорилго:

Бусад олз, гарзын бүртгэлийн бодлого нь дараах зорилготой.

- Бусад олз, гарзыг СТОУС, компанийн үйл ажиллагаатай уялдуулан үнэн зөв ангилж, бүртгэх, тайлагнах;
- Бусад олзыг байгаа шинж чанараас хамааруулан хөрөнгөд суурилсан ангиллаар, бусад гарзыг хөрөнгийн бодит үнэ цэнэ буурах байдлыг тодорхойлох;
- Бусад олз, гарзтай холбоотой компанийн хэрэгжүүлж буй хяналтын тогтолцоог хэрэгжүүлэх;
- СТОУС-д нийцсэн бүртгэл хөтлөх;

Бусад олз, гарзын бүртгэлд хамаарах зүйлс:

Компанийн үндсэн үйл ажиллагаа бусад олзыг олох, бусад гарзыг үүсгэхэд чиглэхгүй бөгөөд тодорхой нэг хөрөнгө, өр төлбөр ажил гүйлгээний үр дүнд үүсэж байдаг. Бусад олз үүссэн үед хөрөнгийн өсөлт, өр төлбөрийн бууралт байдлаар өмчийг нэмэгдүүлэх нөлөөтэй эдийн засгийн үр өгөөжийн өсөлтийг ойлгоно. Бусад гарзын үр дүнд хөрөнгийн бууралт, өр төлбөрийн өсөлт, өмчийг бууруулах нөлөөтэй, эдийн засгийн үр өгөөжийн бууралтыг хэлнэ.

Бусад олз, гарз, бусад ашиг, алдагдал дараах байдлаар ангилна. Үүнд:

- Бараа материалын үнэ цэнийн бууралтын гарз
- БЗЭБХ-ийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийн олз, гарз
- Үндсэн хөрөнгө борлуулсны олз, гарз
- Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз, гарз
- Үндсэн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарз
- Биет бус хөрөнгө борлуулсны олз, гарз
- Биет бус хөрөнгө данснаас хассаны олз, гарз
- Биет бус хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарз
- Хөрөнгө оруулалтын үнэлгээний олз, гарз
- ХОЗҮХХ-ийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийн олз, гарз
- Дахин үнэлгээний гарз
- Бонд эргэлтээс гаргасны олз, гарз
- Болзошгүй өр төлбөрөөс үүссэн гарз

Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт:

Бусад олз, гарзыг хүлээн зөвшөөрөх шалгуур нь санхүүгийн тайлангийн данснуудтай холбоотой стандартуудаар зохицуулагдах ба тухайн стандартаар тайлант үеийн ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөх шалгуураар хангасан тохиолдолд хүлээн зөвшөөрнө. Өөрөөр хэлбэл бусад олз, гарзыг (i) ажил гүйлгээ нь бодитойгоор тохиолдсон бөгөөд (ii) олз, гарзын хэмжээг тодорхойлох боломжтой үед хүлээн зөвшөөрнө.

Бусад олз, гарзыг хүлээн зөвшөөрөх шалгуурыг олз, гарз тус бүрээр дараах байдалтай байна.

- Бараа материалын үнэ цэнийн бууралтын гарз: НББОУС 2 Бараа материал-ын дагуу бараа материалын цэвэр боломжит үнэ цэнэ хүртэл бууруулсан тохиолдолд энэхүү зардлыг хүлээн зөвшөөрнө.
- БЗЭБХ-ийн үнэлгээний олз, гарз: СТОУС 5 Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө-ийн дагуу үйл ажиллагааны зарим хэсгийг худалдан борлуулах зорилгоор үйл ажиллагааг нь зогсоосон тохиолдолд тус ангилалд шилжүүлэн бодит үнэ цэнээр илэрхийлэх бөгөөд бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс үүссэн олз, эсвэл гарзыг тайлан үеийн ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.
- Үндсэн хөрөнгө борлуулсан болон данснаас хассаны олз гарз: НББОУС-16 Үндсэн хөрөнгийн дагуу үндсэн хөрөнгийн үл хүлээн зөвшөөрөлтийн үед буюу данснаас

хасагдсан, эдийн засгийн ирээдүйн үр өгөөжгүй болсон үед хасалт хийгддэг. Үүнтэй холбоотой үндсэн хөрөнгө борлуулсны олз гарз, үндсэн хөрөнгө данснаас хассаны олз, гарзыг ашиг, алдагдлын тайланд хүлээн зөвшөөрнө.

- Үндсэн хөрөнгийн бодит үнэ цэнийн бууралтын гарз: СТОУС 13 бодит үнэ цэнийн дагуу дахин үнэлүүлсэн хөрөнгийн дансны үнэд үнэ цэнийн бууралт оршин байгаа эсэхийг тодорхойлох шаардлагатай бөгөөд үнэ цэнийн бууралт байна гэж үзвэл түүнийг тооцож тайлант үеийн алдагдлаар хүлээн зөвшөөрнө.
- Биет бус хөрөнгө борлуулсан болон данснаас хассаны олз гарз: НББОУС-38 Биет бус хөрөнгийн дагуу биет бус хөрөнгийг актлах, борлуулах, хандивлах, шилжүүлэх, эдийн засгийн үр өгөөжгүй болсон үед данснаас хасалт хийгдэнэ дансны үнэ хасалтын үеийн дүнгийн зөрүүгээр олз, гарзыг ашиг, алдагдлын тайланд хүлээн зөвшөөрч бичнэ.
- Биет бус хөрөнгийн бодит үнэ цэнийн бууралтын гарз: СТОУС 13 бодит үнэ цэнийн дагуу дахин үнэлүүлсэн хөрөнгийн дансны үнэд үнэ цэнийн бууралт оршин байгаа эсэхийг тодорхойлох шаардлагатай бөгөөд үнэ цэнийн бууралт байна гэж үзвэл түүнийг тооцож тайлант үеийн алдагдлаар хүлээн зөвшөөрнө.
- Дахин үнэлгээний олз, гарз: НББОУС-16, 38 дагуу биет болон биет бус хөрөнгийн дахин үнэлгээ хийх үед дансны үнэ дахин үнэлсэн дүнгээс их үед дахин үнэлгээний гарз бүртгэх бөгөөд эргээд тухайн хөрөнгийн үнэ өссөн үед өмнө үүссэн дахин үнэлгээний гарзын хэмжээгээр дахин үнэлгээний олзыг хүлээн зөвшөөрч ашиг, алдагдлын тайланд тусгана.
- СТОУС-9 санхүүгийн хэрэглүүрийн дагуу хөрөнгө оруулалтаар бүртгэсэн компанийн үнэ цэнэ хувьцааны үнэлгээ өсөж буурсан үед тодорхой үе тутамд үнэлгээ хийж, хөрөнгө оруулалтын үнэлгээ болон дансны үнийн зөрүүгээр хөрөнгө оруулалтын үнэлгээний олз, гарз үүсэх бөгөөд үүнийг ашиг, алдагдлын тайлант тусгана. Бусад дэлгэрэнгүй орлогоор бүртгэх хөрөнгө оруулалтын үнэлгээний олз, гарзыг ашиг, алдагдлын тайланд тусгахгүй болно.
- Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний олз, гарз: НББОУС-40 дагуу ХОЗҮХХ хөрөнгийг тайлант хугацааны бодит үнэ цэнийн загварын дагуу эцэст үнэлгээ хийх, ангилал шилжүүлэх, данснаас хасалт хийх үед олз гарзыг хүлээн зөвшөөрнө.
- Бонд эргэлтээс гаргасны олз гарз: Компани санхүүжилт татах зорилготой бонд гаргаж санхүүжилт татсан. Дараагийн үед тухайн гаргасан бондын тодорхой хэсгийг болон бүрэн төлөлт хийх байдлаар эргэлтээс гаргасан үүнтэй холбоотой бондын өрийн дансны үнэ цэнэ бондыг буцаан эргэлтээс авах үнийн зөрүүгээр олз, гарзыг бүртгэнэ.
- Болзошгүй өр төлбөрөөс үүссэн гарз: Ирээдүйд тохиолдох эсвэл үл тохиолдох зүйлс тодорхой тооцоолол бий болсон үед шүүхийн зарга маргаанаас үүсэх болзошгүй өр төлбөрөөс үүсэх гарз бүртгэнэ.

Бусад олз, гарзын данснуудын бүртгэлийн горим:

1. Үндсэн хөрөнгийн данснаас хасалтын олз, гарзын бүртгэл

Дт	Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз	
Дт	Хуримтлагдсан элэгдэл	
Дт	Холбогдох	хөрөнгө
	Кт	Үндсэн хөрөнгө
Дт	Хуримтлагдсан элэгдэл	
Дт	Холбогдох хөрөнгө	
	Кт	Үндсэн
	Кт	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз
		хөрөнгө

2. Биет бус хөрөнгө данснаас хасалтын олз, гарзын бүртгэл

Дт	Биет бус хөрөнгө данснаас хассаны гарз
----	--

Дт	Хуримтлагдсан	хорогдол
Дт	Холбогдох хөрөнгө	
	Кт Биет бус хөрөнгө	
Дт	Хуримтлагдсан хорогдол	
Дт	Холбогдох хөрөнгө	
	Кт Биет	бус
	Кт Биет бус хөрөнгө данснаас хассаны олз	хөрөнгө

3. Биет болон биет бус хөрөнгийн дахин үнэлгээний олз, гарзын бүртгэл

Дт	Дахин үнэлгээний гарз
Дт	Хуримтлагдсан хорогдол
	Кт Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө
Дт	Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө
	Кт Дахин үнэлгээний олз
	Кт Дахин үнэлгээний нэмэгдэл

4. Биет болон биет бус хөрөнгийн солилцооны олз, гарзын бүртгэл

Дт	Хөрөнгийн солилцооны гарз
Дт	Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө- хүлээн авсан
Дт	Хуримтлагдсан хорогдол
	Кт Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө-өгсөн
Дт	Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө- хүлээн авсан
Дт	Хуримтлагдсан хорогдол
	Кт Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө-өгсөн
	Кт Хөрөнгийн солилцооны олз

5. Хөрөнгө оруулалтын үнэлгээний олз, гарзын бүртгэл

Дт	Хөрөнгө оруулалтын үнэлгээний гарз-ангилал
	Кт Хөрөнгө оруулалтын данс-ангилал
Дт	Хөрөнгө оруулалтын данс-ангилал
	Кт Хөрөнгө оруулалтын үнэлгээний олз

Хөрөнгө оруулалтын ангиллаас үүдэн ашиг, алдагдлын тайлан эсвэл өмчийн хэсэгт тусгана.

6. Гадаад валютын ханшийн зөрүүний олз, гарзын бүртгэл

Дт	Гадаад валютын ханшийн хэрэгжсэн гарз
Дт	Холбогдох өр төлбөр
	Кт Холбогдох хөрөнгө
Дт	Холбогдох өр төлбөр
	Кт Холбогдох хөрөнгө
	Кт Гадаад валютын ханшийн хэрэгжсэн олз
Дт	Гадаад валютын ханшийн хэрэгжээгүй гарз
	Кт Холбогдох өр төлбөр
	Кт Холбогдох хөрөнгө

Дт	Холбогдох өр төлбөр
Дт	Холбогдох хөрөнгө
	Кт Гадаад валютын ханшийн хэрэгжээгүй олз

7. Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний олз, гарзын бүртгэл

Дт	ХОЗҮХХ-ийн үнэлгээний гарз
	Кт ХОЗҮХХ
Дт	ХОЗҮХХ
	Кт ХОЗҮХХ-ийн үнэлгээний олз

8. Бонд эргэлтээс гаргалтын олз, гарзын бүртгэл

Дт Бонд эргэлтээс гаргалтын гарз
 Дт Бондын өр төлбөр
 Кт Мөнгөн хөрөнгө

Дт Бондын өр төлбөр
 Кт Мөнгөн хөрөнгө
 Кт Бонд эргэлтээс гаргалтын олз

9. Үнэ цэнийн бууралтын гарзын бүртгэл

Дт Үнэ цэнийн бууралтын гарз
 Кт Хуримтлагдсан үнэ цэнийн бууралт

Бусад олз, гарз дансны бүртгэл, тайлагналын хяналт:

Бусад олз, гарз дансны бүртгэл, тайлагналтай холбоотойгоор дараах хяналтын орчныг бүрдүүлж ажиллана.

Хяналтын орчин	Хяналтын горим
Нягтлан бодох бүртгэлийн хяналт:	<ul style="list-style-type: none"> > Бусад олз, гарз данснуудыг тэдгээрийн ерөнхий ангилал, зардлын төрлөөс нь хамааруулан ялгаатай байдлаар НББ-ийн данс үүсгэн бүртгэнэ. 80-00-00-00-001 Гадаад валютын ханшийн зөрүүний олз 82-00-00-00-001 Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз 85-99-00-00-001 Биет бус хөрөнгө данснаас хассаны гарз > Гадаад валютаар гарсан олз, гарзыг хүлээн зөвшөөрөх өдрийн Монголбанкны албан ханшаар төгрөгт хөрвүүлэн бүртгэнэ. > Нийт олз, гарзын дүнд материаллаг хэмжээний дүн бүрдүүлнэ гэж үзсэн олз, гарзын данснуудыг ажил гүйлгээний тохирох нэршлээр нягтлан бодох бүртгэлийн данс үүсгэн бүртгэнэ. > Бусад олз, гарзыг хүлээн зөвшөөрөхдөө дараах зүйлсийг харгалзан үзнэ. <ul style="list-style-type: none"> ● Тайлант хугацаанд хамааралтай байх; ● Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримттай байх; ● Өмчлөл, ашиглалттай холбоотой мэдэгдэхүйц эрсдэл, өгөөжийг компани хүртэх эрхтэй байх; ● Олз, гарзын үнийн дүн хэмжигдэхүйц байх; ● Зарим тохиолдолд баримт нь татварын дахин давтагдашгүй дугаартай татварын төлбөрийн баримтаар баталгаажсан;
Санхүүгийн тайлагналын хяналт	<p>Санхүүгийн тайлангийн үнэн зөв байдлыг хангах зорилгоор жилийн эцсийн санхүүгийн тайлан бэлтгэх үед бусад олз, гарзын бүртгэл, тайлагналтай холбоотой дараах хяналтуудыг хэрэгжүүлнэ</p> <ul style="list-style-type: none"> > Тайлангийн хугацаанд хүлээн зөвшөөрсөн олз, гарзууд нь уг тайлангийн хугацаанд хамаарах эсэхийг хянана; > Гадаад валютаар илэрхийлэгдсэн өртөг, зардлыг Монголбанкны албан ханшаар бүртгэсэн эсэх; > Бусад олз, гарзыг тохирох дансны ангиллаар зөв ангилсан эсэх;

	<ul style="list-style-type: none"> > Гүйлгээ балансаарх олз, гарзын ангилал зөв эсэхийг эргэн хянана. Орлогын тайлангийн нөлөөлөл тайлагнал зөв эсэх; > Бусад олз, гарзын үүссэн шалтгаан, хүлээн зөвшөөрөлт;
Үйл ажиллагааны хяналт:	<ul style="list-style-type: none"> > Тайлангийн хугацааны эхэнд бусад олз, гарзын үүсэх нөхцөл, төрөл тус бүрээр төлөвлөнө. > Тайлангийн хугацааны эцэст олз, гарзыг гүйцэтгэлийг төлөвлөгөөтэй харьцуулан шалгана. > Бусад олз, гарзыг гэрээ, нэхэмжлэх, зарлагын баримт, төлбөрийн баримт, тооцоолол тайлан зэрэгтэй НББ-ийн анхан шатны баримт бүрдүүлж түүнд үндэслэн бүртгэлд тусгана.
Удирдлагад тайлагнах зүйлс:	<p>Бусад олз, гарзын бүртгэл, тайлагналтай холбоотой дараах зүйлсийг удирдлагад тайлагнана.</p> <ul style="list-style-type: none"> > Бусад олз, гарзын төлөвлөгөө гүйцэтгэл; > Бусад олз, гарз үүссэн байдал; > Бусад олз, гарз үүсэх эрсдэл;

Бусад олз, гарзын бүртгэл, тайлагналтай холбоотой санхүүгийн тайланд нэмж тодруулах мэдээлэл:

Компани жилийн эцсийн санхүүгийн тайланг бэлтгэж бусад олз, гарзын холбоотой дараах зүйлсийг нэмж тодруулна.

- Бусад олз, гарзыг хүлээн зөвшөөрөлтийн ерөнхий бодлого;
- Бусад олз, гарзын дансны ерөнхий ангилал;
- Бусад олз, гарзын үүссэн шалтгаан, түүний үр нөлөө;
- Бусад олз, гарзын ангилал;
- Холбоотой талуудын бусад олз, гарзын дүн;

4.16. Татварын нягтлан бодох бүртгэлийн бодлого

Татварын бүртгэлийн бодлогын зорилго:

Татварын бүртгэлийн бодлого нь СТОУС-д нийцсэн татварын бүртгэл хөтөлж тайлант үеийн болоод хойшлогдсон татварыг үнэн зөв тодорхойлох, ААНОАТ-ын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хуулийн хүрээнд ААНОАТ-ын хамгийн бага төлөх, бүртгэх, тайлагнах зорилготой юм. Өөрөөр хэлбэл:

- СТОУС-ын дагуу ханшийн зөрүүнээс үүдэлтэй хойшлогдсон татварыг үнэн зөв тодорхойлох;
- Хойшлогдсон татвараас бодит болж хэрэгжсэн хэсгийг хуулийн дагуу үнэн зөв тооцоолох;
- Тайлант жилийн татварын зардлыг үнэн зөв тодорхойлох;
- Компанийн хуулийн хүрээнд татварын эрсдэлээс сэргийлэх;
- Хуулийн хүрээнд ААНОАТ-ын хамгийн багаар төлөх;
- Санхүүгийн тайлангийн мэдээлэл хэрэглэгчдийг татвар ногдуулалттай холбоотой үнэн зөв мэдээллээр хангах;
- СТОУС-д нийцсэн бүртгэл хөтөлөх;

Татварын бүртгэлд хамаарах зүйлс:

Татварын бүртгэлд СТОУС-ын дагуу дараах зүйлсийг хамруулж ойлгоно.

- Тайлант жилийн татварын бүртгэл
- Хойшлогдсон татварын бүртгэл
- ХХОАТ, НДШ ногдуулалтын бүртгэл
- Хөрөнгийн татвар
- Үнэ шилжүүлэлтийн бүртгэл

ААНОАТ-ын бүртгэл, тайлагнал:

Татварын зардал: гэдэг нь тайлант үеийн болон хойшлогдсон татварт холбогдох тухайн тайлант үеийн цэвэр ашиг, эсвэл алдагдлыг тодорхойлоход багтсан нийт дүн юм. Өөрөөр хэлбэл татварын зардал (татварын орлого) нь тайлант үеийн татварын зардал (тайлант үеийн татварын орлого) болон хойшлогдсон татварын зардал (хойшлогдсон татварын орлого)-аас бүрдэнэ.

Тайлант үеийн татвар: гэдэг нь тайлант үеийн татвар ногдуулах ашиг (алдагдал)-аас орлогын албан татварын (нөхөлт) өглөгийн дүн юм.

Хойшлогдсон татварын өр төлбөр: гэдэг нь татвар ногдох түр зөрүүтэй холбоотойгоор ирээдүйн тайлант үед төлөх орлогын албан татварын өглөгийн дүн юм.

Хойшлогдсон татварын хөрөнгө: гэж дараах зүйлстэй холбоотойгоор ирээдүйн тайлант үед нөхөгдөх орлогын татварын дүнг хэлнэ:

- Хасагдах түр зөрүү
- Ашиглагдаагүй татварын алдагдлыг дараагийн үе рүү шилжүүлэх
- Ашиглагдаагүй татварын дискаунтыг дараагийн үе рүү шилжүүлэх

Түр зөрүү гэдэг нь санхүүгийн байдлын тайлан дахь хөрөнгө, эсвэл өр төлбөрийн дансны үнэ ба татварын суурь хоёрын хоорондох зөрүү юм. Түр зөрүү нь татвар ногдох түр зөрүү, хасагдах түр зөрүү гэсэн хоёр хэлбэртэй байна.

Татвар ногдох түр зөрүү гэдэг нь хөрөнгө, эсвэл өр төлбөрийн дансны үнийг нөхөх эсвэл барагдуулах үед ирээдүйн тайлант үеийн татвар ногдуулах ашиг (татварын алдагдал)-ыг тодорхойлоход татвар ногдох орлогод үүсэх түр зөрүү юм. Харин хасагдах түр зөрүү гэдэг нь хөрөнгө, эсвэл өр төлбөрийн дансны үнийг нөхөх эсвэл барагдуулах үед ирээдүйн үеийн татвар ногдуулах ашиг (татварын алдагдал)-ыг тодорхойлоход татвар ногдох орлогоос хасагдах дүнгээс үүсэх түр зөрүү юм.

“Тэнгэрлиг Медиа Групп” ХК-ийн хувьд хойшлогдсон татварын **түр зөрүү** үүсгэх дараах орлого, зардлууд байна.

- Гадаад валютын ханшийн зөрүүний бодит бус олз, гарз
 - Алдагдлыг ирээдүйд шилжүүлэн тооцох
- Татвар ногдуулалтын байнгын зөрүү үүсэх дараах орлого, зардлууд байна.
- Найдваргүй авлагын нөөцийн бууралтаас үүссэн олз
 - БЗЭБХ-ийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийн олз
 - Хөрөнгө оруулалтын үнэлгээний бодит бус олз
 - Крипто валютад оруулсан хөрөнгө оруулалтын үнэлгээний олз
 - ХОЗҮХХ-ийн үнэлгээний олз
 - Тусгайлсан хувь хэмжээгээр татвар ногдуулдаг орлогууд (бүх төрлийн хүүний орлого, ногдол ашгийн орлого, үл хөтлөх хөрөнгө борлуулсны орлого)
 - Найдваргүй авлагын зардал
 - Хандив тусламжийн зардал
 - Хүлээн авалт, баяр ёслолын зардал
 - Үндсэн хөрөнгө, бараа материал актлалын гарз
 - Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээнд ногдох элэгдлийн зардал
 - ХХОАТ суутган тооцоогүй цалингийн зардал
 - Баримтаар нотлогдохгүй зардал
 - Цахим төлбөрийн баримтгүй зардал
 - Ахмадын сангийн зардал
 - Бараа материалын үнэ цэнийн бууралтын гарз
 - Хөрөнгө оруулалтын үнэлгээний гарз
 - Крипто валютад оруулсан хөрөнгө оруулалтын үнэлгээний гарз
 - БЗЭБХ-ийн үнэлгээний гарз
 - ХОЗҮХХ-ийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийн гарз
 - Хөрөнгө оруулалтын дахин ангилалтай холбоотой гарз
 - Бодит үнэ цэнээр илэрхийлэгддэг хөрөнгүүдийн дансны үнэ болон өртгийн зөрүү

Тайлбар-1:

БЗЭБХ, ХОЗҮХХ, хөрөнгө оруулалт, крипто валют зэрэг СТОУС-ын дагуу бодит үнэ цэнээр илэрхийлэх шаардлагатай хөрөнгүүдийн бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс үүссэн олз, гарзыг татвар ногдуулалтын байнгын зөрүүгээр тохируулах бөгөөд тухайн хөрөнгийг худалдан борлуулах буюу орлого бодитоор тодорхойлогдог учир байнгын зөрүү үүсгэн тохируулна. Харин орлого бодитоор тодорхойлогдох үед эдгээрийн хөрөнгийн дансны үнийг өртөг хүртэл бууруулна.

Тайлбар-2:

ХОЗҮХХ-ийн ангилалд хамаарах хөрөнгүүдэд татварын хуулийн дагуу тусгайлсан хувь хэмжээгээр татвар ногдуулдаг. Мөн ХОЗҮХХ-ийг санхүүгийн тайлангийн зорилгоор элэгдэл байгуулахгүй бөгөөд татварын зорилгоор элэгдэл байгуулж татвар ногдох орлогыг бууруулах боломжтой байна. Тиймээс ААНОАТ тооцохдоо татварын зорилгоор байгуулсан элэгдлээр татвар ногдох орлогоос хасагдах зардлыг нэмэгдүүлж тооцно.

Тайлбар-3:

Компанид бүртгэлтэй ахмадуудад олгосон тэтгэмж нь хуулийн дагуу татвар ногдох орлогоос хасагдах зардал болох бөгөөд тайлангийн хугацаанд нэмж байгуулсан сангаар татвар ногдох орлогыг нэмэгдүүлж сангийн зарцуулалтаар татвар ногдох орлогыг бууруулж тохируулна.

Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт:

Тайлант үеийн болон өмнөх үеийн төлөгдөөгүй татварыг тухайн тайлант хугацаанд тэр дүнгээр нь хойшлогдсон татварын өр төлбөр гэж хүлээн зөвшөөрөх ёстой. Харин тайлант үе болон өмнөх үед аль хэдийн төлсөн дүн нь тэдгээр үеүдэд төлөх ёстой байсан дүнгээс давсан байвал илүү төлсөн дүнг хойшлогдсон татварын хөрөнгө гэж хүлээн зөвшөөрнө.

Компани тайлант үеийн эцсээр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа татварын хувь хэмжээ (татварын хууль)-г ашиглан татварын эрх бүхий байгууллагад төлөхөөр хүлээгдэж буй дүнгээр тайлант үе ба өмнөх тайлант үеийн тайлант үед төлөх татварын өр төлбөр (хөрөнгө)-ийг хэмжих ёстой.

Хойшлогдсон татвар, тайлант үеийн татварыг бүртгэлд тусгах:

Компани хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийг үндсэн хөрөнгийн элэгдэл, гадаад валютын ханшийн зөрүүний бодит бус олз, гарз, ахмадын сангийн зардлаас тус тусад нь НББ-ийн данс үүсгэж бүртгэнэ.

Үндсэн хөрөнгийн элэгдлийг санхүүгийн болон татварын зорилгоор өөрөөр байгуулах эсэхээ компанийн удирдлага шийдвэрлэнэ. Санхүүгийн болон татварын зорилгоор өөрөөр элэгдүүлсэн тохиолдолд тайлангийн хугацаанд үүссэн хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийг дараах байдлаар бүртгэлд тусгана.

- Тайлангийн хугацаанд “Санхүүгийн зорилгоор тооцсон элэгдэл > Татварын зорилгоор тооцсон элэгдэл” үед хойшлогдсон татварын хөрөнгө үүсэх ба энэ үед дараах бичилт хийнэ.

Дт Татварын зардал

Дт Хойшлогдсон татварын хөрөнгө

Кт ААНОАТ-ын өр

- Тайлангийн хугацаанд “Санхүүгийн зорилгоор тооцсон элэгдэл < Татварын зорилгоор тооцсон элэгдэл” үед хойшлогдсон татварын өр төлбөр үүсэх ба энэ үед дараах бичилт хийнэ.

Дт Татварын зардал

Кт ААНОАТ-ын өр

Кт Хойшлогдсон татварын өр

- Дараагийн тайлант хугацаанд үндсэн хөрөнгийн худалдан борлуулах, актлах зэрэг данснаас хассанаас бусад тохиолдолд дээрх бүртгэлийг үргэлжлүүлэн бүртгэнэ. Харин хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөр үүсгэхэд нөлөөлсөн хөрөнгийг данснаас хасах үед дараах бичилт хийнэ.

Хойшлогдсон татварын хөрөнгө үүсгэсэн хөрөнгө данснаас хасах үед:

Дт Татварын зардал

Кт Хойшлогдсон татварын хөрөнгө

Хойшлогдсон татварын өр төлбөр үүсгэсэн хөрөнгө данснаас хасах үед:

Дт Хойшлогдсон татварын өр

Кт Татварын өгөөж буюу татварын зардал

- Тайлангийн хугацаанд “Ханшийн зөрүүний бодит бус гарз < Ханшийн зөрүүний бодит бус олз” үед хойшлогдсон татварын өр төлбөр үүсэх ба энэ үед дараах бичилт хийнэ.

Дт Татварын зардал

Кт ААНОАТ-ын өр

Кт Хойшлогдсон татварын өр

- Тайлангийн хугацаанд “Ханшийн зөрүүний бодит бус гарз > Ханшийн зөрүүний бодит бус олз” үед хойшлогдсон татварын өр төлбөр үүсэх ба энэ үед дараах бичилт хийнэ.

Дт Татварын зардал

Дт Хойшлогдсон татварын хөрөнгө

Кт ААНОАТ-ын өр

- Дараагийн тайлант хугацаануудад ханшийн зөрүүнээс үүссэн бодит бус олз, гарзаас бодит олз, гарз болон хэрэгжих хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрөөс ААНОАТ-ын өр рүү шилжүүлэн бүртгэх ба энэ үед дараах бичилт хийнэ.

Ханшийн зөрүүний бодит бус олзоос бодит олз болж хэрэгжих үед:

Дт Хойшлогдсон татварын өр

Кт ААНОАТ-ын өр

Ханшийн зөрүүний бодит бус гарзаас бодит болж хэрэгжих үед:

Дт ААНОАТ-ын өр

Кт Хойшлогдсон татварын хөрөнгө

- Дараагийн тайлант хугацаануудад ханшийн зөрүү үүсгэж хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөр үүсгэхэд нөлөөлсөн санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг найдваргүйд тооцож данснаас хасах замаар үл хүлээн зөвшөөрөх үед тэдгээртэй холбоотой хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийг ч үл хүлээн зөвшөөрнө.
- Энэ үед дараах бичилт хийнэ.

Ханшийн зөрүүний бодит бус олз үүсгэсэн санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг үл хүлээн зөвшөөрөх үед:

Дт Хойшлогдсон татварын өр

Кт Татварын өгөөж буюу татварын зардал

Ханшийн зөрүүний бодит бус гарз үүсгэсэн санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг үл хүлээн зөвшөөрөх үед:

Дт ААНОАТ-ын зардал

Кт Хойшлогдсон татварын хөрөнгө

“Ахмад настны тухай хууль”-ийн дагуу компаниас өндөр настны чөлөөндөө суусан ахмадуудад тэдгээрийн амьжиргааг дэмжих, тэдэнд хүндэтгэл үзүүлэх зорилгоор ахмадын сан байгуулж, зарцуулах бөгөөд байгуулсан санг зарцуулах хүртэл хойшлогдсон татварын хөрөнгө үүсгэн бүртгэнэ.

- Ахмадын сан нэмж байгуулах үед доорх бичилт хийнэ.

Дт Татварын зардал

Дт Хойшлогдсон татварын хөрөнгө

Кт ААНОАТ-ын өр

Ахмадын сангаас зарцуулж гүйцэтгэлээр зардал гарах үед:

Дт ААНОАТ-ын өр

Кт Хойшлогдсон татварын хөрөнгө

Хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийн үлдэгдлийг тодорхойлох:

Үндсэн хөрөнгийн элэгдэл, ахмадын сангийн зардал, алдагдлыг ирээдүйд шилжүүлэх зэргээс үүссэн хойшлогдсон татварын үлдэгдлийг тэдгээрийн нэмэгдэх, хасагдах өөрчлөлтийг тусгах байдлаар тодорхойлно.

Харин гадаад валютын ханшийн зөрүүний бодит бус олз, гарзаас үүдэлтэй хойшлогдсон татварын үлдэгдлийг балансын аргаар тодорхойлно.

Ханшийн зөрүүний бодит бус олз, гарзаас үүдэлтэй хойшлогдсон татварын үлдэгдлийг санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн үлдэгдэлд ногдох бодит бус олз, газрын (Тайлангийн хугацааны үлдэгдэл болон тус үлдэгдлийн түүхэн ханшийн зөрүүгээр) өссөн дүнгээс тодорхойлох ба дараах байдлаар тооцоолно.

Хойшлогдсон татварын хөрөнгө

1.	XXXXXX		
2.	XXXXXX	XXXXXX	3.
		XXXXXX	5.
4.	XXXXXX		

1-р алхам: Эхний үлдэгдлийг санхүүгийн тайлангаарх үлдэгдэл

2-р алхам: Тайлангийн хугацаанд нэмж үүссэн хойшлогдсон татварын хөрөнгө бөгөөд тайлант жилийн тооцооллоос үүсгэн бүртгэнэ.

3-р алхам: Тайлангийн хугацаанд найдваргүйд тооцож данснаас хассан санхүүгийн хэрэглүүрт ногдох хойшлогдсон татварын хөрөнгийг тодорхойлж бүртгэнэ.

4-р алхам: Санхүүгийн тайлангаарх санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн үлдэгдэлд ногдох хойшлогдсон татварын үлдэгдлийг тодорхойлно.

5-р алхам: Хойшлогдсон татварын үлдэгдэлд тохируулан тайлант жилд хэрэгжих дүнг тохируулна.

ААНОАТ-ын зардал, өр төлбөрийн бүртгэлийн горим:

Орлогын албан татварын зардал нь тусгайлсан хувь хэмжээгээр ногдуулсан татвар, нийтлэг хувь хэмжээгээр ногдуулсан татвар, бусдад суутгуулсан татвар, хойшлогдсон татварын зардлаас бүрдэнэ.

- Эрхийн шимтгэлийн орлого,
- Ногдол ашгийн орлого,
- Хүүгийн орлого,
- Үл хөдлөх эд хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлого,
- Даатгалын нөхөн төлбөр,
- Компани дээрх орлогуудыг хүлээн зөвшөөрсөн тохиолдолд ААНОАТ-ын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.1-20.2.4-д заасан хувь хэмжээг баримтлан албан татвар ногдуулах ба тооцсон дүнгээр дараах бичилт хийнэ.

Дт	Татварын	зардал
	Кт	ААНОАТ-ын өр
- ААНОАТ-ын тухай хуулийн дагуу тусгайлсан хувь хэмжээгээр татвар ногдуулж буй орлогуудаас бусдад суутгуулан тооцох үед дараах бичилт хийнэ.

Дт	Авлага эсвэл мөнгөн хөрөнгө	
	Дт	Татварын зардал
	Кт	Холбогдох орлого
- Нийтлэг хувь хэмжээгээр татвар ногдуулахдаа татварын өмнөх ашгаас тусгайлсан хувь хэмжээгээр татвар ногдуулах орлого, татвараас хасагдахгүй зардлуудыг тохируулсны дараах дүнгээс ААНОАТ-ын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д заасан хувь хэмжээгээр ногдуулах ба энэ үед дараах бичилт хийнэ.

Дт	Татварын зардал	
	Кт	ААНОАТ-ын өр

Нийтлэг хувь хэмжээгээр ногдуулсан татварын зардал, өр төлбөрийг тодорхойлох:

Аж ахуйн нэгжийн орлогын албан татвараа ААНОАТ-ын тухай хууль, түүнийг хэрэгжүүлэх арга, аргачлалыг баримтлан тооцох бөгөөд тооцох аргачлалыг жишээгээр харуулбал дараах байдлаар тооцно.

Тооцооллын үзүүлэлт	Мөрийн дугаар	Тайлант жил	Тохируулга	Татварын тайлан тусгах дүн
Татварын өмнөх ашиг	1	500,000,000		500,000,000
Байнгын зөрүү	2	80,000,000		80,000,000
Албан татвараас ногдох орлогоос хасагдахгүй зардал	3	25,000,000		25,000,000
Хязгаарлалтаас хэтэрсэн зардал	4	(50,000,000)		(50,000,000)
ААНОАТ-аас чөлөөлөгдөх орлого	5	(15,000,000)		(15,000,000)
Тусгайлсан хувь хэмжээгээр	6	(7,000,000)		(7,000,000)
Татвар нь суутгагдсан орлого	7	533,000,000		533,000,000
Байнгын зөрүүгээр тохируулагдсан дүн				
Түр зөрүү				
Ханшийн зөрүүнээс хэрэгжсэн хойшлогдсон татвар олз, (гарз)	8		1,500,000	1,500,000
Ахмадын сангийн зарцуулалт	9		(4,500,000)	(4,500,000)
Санхүүгийн зорилгоор байгуулсан элэгдэл	10	35,800,000		35,800,000
Татварын зорилгоор байгуулсан элэгдэл	11	(28,300,000)		(28,300,000)
Ханшийн зөрүүний бодит бус гарз	12	17,250,000		17,250,000
Ханшийн зөрүүний бодит бус олз	13	(19,380,000)		(19,380,000)
Ахмадын сангийн зардал	14	6,300,000		6,300,000
Түр зөрүүгээр тохируулагдсан дүн	15	544,670,000		544,670,000
Сайн дурын даатгалын хэтрэлт	16	12,000,000		12,000,000
Татвар ногдуулах орлого	17	556,670,000		556,670,000
Нийт татварын зардал	18	56,700,000		56,700,000
Төлбөл зохих татварын өр	19	57,167,000		57,167,000
Хойшлогдсон татварын хөрөнгө	20	1,167,000		1,167,000
Журналын бичилт:				
Дт: Татварын зардал	21	56,000,000		
Дт: Хойшлогдсон татварын хөрөнгө	22	1,167,000		
Кт: ААНОАТ-ын өр	23		57,167,000	
Дт: ААНОАТ-ын өр	24	300,000		
Кт: Хойшлогдсон татварын өр	25		300,000	

Тооцооллын тайлбар:

Мөр 7=1+2+3+4+5+6

Мөр 15=7+8+9+10+11+12+13+14

Мөр 16=Сайн дурын даатгалын зардал-15*15%

Мөр 17=15+16
 Мөр 18=(7*татварын хувь)-(6*татварын хувь)-(5*татварын хувь)+(16*татварын хувь)
 Мөр 19=(17*татварын хувь)-(5*татварын хувь)
 Мөр 20=(10+11+12+13+14)*татварын хувь
 Мөр 21=19+(6*татварын хувь)
 Мөр 22=20
 Мөр 23=19

Татвар ногдуулах орлогыг тодорхойлох:

Татвар ногдох орлогоос хасагдах зардлыг тодорхойлох зорилгоор санхүүгийн тайлангаарх зардлыг үйл ажиллагааны болон үйл ажиллагааны бус гэж ангилна. Татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо тус орлогыг олохтой холбогдон гарсан зардлыг хасаж тооцно. Татвар ногдох орлогоос хасагдах зардалд дараах шаардлага тавигдана.

- Тухайн татварын тайлант хугацаанд хамаарсан байх;
- Албан татвар төлөгчийн албан татвар ногдох орлого олох үйл ажиллагаатай шууд холбогдон гарсан байх;
- Зардал бодитой гарсан бөгөөд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан баримт болон холбогдох бүртгэлээр баталгаажсан байх;
- Татварын ерөнхий хуулийн 28.5-д заасан дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримт, импортын бараанд татвар ногдуулж, гаалийн байгууллагад төлсөн тухай баримтаар баталгаажсан байх;
- Албан татвар, төлбөр, хураамж нь төсөвт төлөхөөр тайлагнасан байх;
- Албан томилолтын зардал нь төрийн албан хаагчдын албан томилолтын зардлыг хоёр дахин нэмэгдүүлснээс хэтрэхгүй байх;
- Гамшгаас хамгаалах тухай хуульд заасны дагуу гамшгийн улмаас учирсан хохирлыг арилгахад гарсан зардал нь холбогдох байгууллагын дүгнэлтээр баталгаажсан байх;
- Ёслол хүндэтгэлийн арга хэмжээний зардал нь тухайн татварын жилд Хөдөлмөрийн тухай хуульд заасан хөдөлмөрийн гэрээ болон контракт байгуулан ажиллаж байгаа ажиллагчдад олгосон цалингийн зардлын нийт дүнгийн 5 хувиас хэтрэхгүй байх;
- Даатгалын тухай хуулийн 4.1.2-т заасан даатгагчаас бусад этгээдийн сайн дурын даатгалын хураамжийн дүн нь тухайн татварын жилийн албан татвар ногдуулах орлогын 15 хувиас хэтрэхгүй байх;
- Даатгалын тухай хуулийн 4.1.2-т заасан даатгагчийн харилцан хамааралтай этгээдүүдтэй хийсэн сайн дурын даатгалын хураамжийн дүн нь тухайн татварын жилийн албан татвар ногдуулах орлогын 15 хувиас хэтрэхгүй байх;
- Урсгал засварын зардал нь сэлбэг хэрэгслийн зардлыг багтаасан байх бөгөөд тухайн үл хөдлөх эд хөрөнгийн хувьд үлдэгдэл өртгийн 2 хувь, бусад хөрөнгийн хувьд үлдэгдэл өртгийн 5 хувиас хэтрэхгүй бөгөөд үүнээс хэтэрсэн урсгал засварын зардлыг их засварын зардалд тооцох;
- Цалин, хөдөлмөрийн хөлс, нэмэгдэл, түүнтэй адилтгах орлогод нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татвар ногдуулж, суутгасан байх;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасан шууд бус орлогод хувь хүний орлогын албан татвар ногдуулж, суутгасан байх;
- Албан татвар суутгах орлого олгосон тохиолдолд холбогдох албан татварыг суутган тайлагнасан байх;
- Хүүний зардалд дараах хязгаарлалтыг баримтална.
 - ААНОАТ-ын тухай хуулийн 9.1.4-т заасан буюу бусдад хүүний орлого олгосон бол албан татвар ногдох орлогоос хасаж тооцно.

- Харин харилцан хамааралтай этгээдэд хүүний орлого олгосон бол тайлант хугацааны нийт борлуулалтын орлогоос хүү, элэгдэл, хорогдлоос бусад ААНОАТ-ын тухай хуульд заасан нөхцөл шаардлагыг хангасан зардлыг хассан дүнгийн 30 хувиар хүүний зардлыг хязгаарлана.
- Мөн хөрөнгө оруулагчаас албан татвар төлөгчид өмнө нь оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээг гурав дахин нэмэгдүүлснээс илүү хэмжээний тухайн хөрөнгө оруулагчийн зээлд төлсөн хүүний төлбөрийг албан татвар ногдох орлогоос хасаж тооцохгүй бөгөөд түүнийг тухайн хөрөнгө оруулагчийн ногдол ашигт тооцож албан татвар ногдуулна.
- “Өмнө нь оруулсан хөрөнгө оруулалт” гэдэгт хөрөнгө оруулагч этгээдээс энгийн хувьцаа, давуу эрхийн хувьцаа худалдан авах, хувь нийлүүлэх замаар оруулсан хөрөнгө оруулалтыг хамааруулна.
- Албан татвартөлөгчийн хувьцаа эзэмшдэг Монгол Улсад байнга оршинсуугч хувь хүнээс авсан зээлийн хүүний зардлыг тухайн албан татвар төлөгчийн албан татвар ногдох орлогоос хасаж тооцохгүй.

Хойшлогдсон татвар, ААНОАТ-ыг санхүүгийн тайлан, татварын тайланд тусгах:

ААНОАТ-ын зардал, өр төлбөр, хойшлогдсон татварын үлдэгдлийг Сангийн сайдын 2017 оны 361 тоот тушаалаар батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу санхүүгийн тайланд, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайлангийн маягтын дагуу тус тус тайлагнана.

Толилуулгын нэр	Үнэлгээ
ААНОАТ-ын зардал	Орлого, үр дүнгийн тайлангийн татварын зардал хэсэгт Мөр 18-ийн дүнгээр буюу нийтлэг, тусгайлсан ногдуулсан болон бусад суутгуулсан татварын дүнгийн нийлбэрээр толилуулна.
ААНОАТ-ын өр	Санхүүгийн тайланд татварын өр төлбөрийн хэсэгт бусад татваруудын хамтаар нэгтгэгдэн тайлагнах ба тооцсон татварын өр төлбөр нь тайлант хугацааны бүртгэлд тусгах дүн болно.
Хойшлогдсон татварын хөрөнгө	Хойшлогдсон татварын хөрөнгийг санхүүгийн байдлын тайлангийн эргэлтийн бус хөрөнгийн хэсэгт “Хойшлогдсон татварын хөрөнгө” нэртэйгээр толилуулна.
Хойшлогдсон татварын хөрөнгө	Хойшлогдсон татварын өр төлбөрийг санхүүгийн байдлын тайланд урт хугацаат өр төлбөрийн хэсэгт “Хойшлогдсон татварын өр төлбөр” нэртэйгээр бусад өр төлбөрөөс тусад нь толилуулна.

Хойшлогдсон татвар, ААНОАТ-ын бүртгэл, тайлагналын хяналт:

ААНОАТ, түүнтэй холбоотой зардал, өр төлбөр, хойшлогдсон татварын бүртгэл, тайлагналтай холбоотойгоор дараах хяналтын орчныг бүрдүүлж ажиллана.

Хяналтын орчин	Хяналтын горим
Нягтлан бодох бүртгэлийн хяналт:	<ul style="list-style-type: none"> ➢ ААНОАТ-ын бүртгэлийн хялбаршуулах зорилгоор хуулийн дагуу татвар ногдуулах орлогоос хасагдах боломжгүй зардлуудыг үйл ажиллагааны бус зардлаар бүртгэж санхүүгийн тайланд бусад зардлаар тайлагнана. ➢ Татвараас хасагдах боломжгүй зардлуудыг дангаараа санхүүгийн тайлан болоод бусад зардлын дүнд материаллаг хувь хэмжээ эзэлж байна гэж үзвэл тусад нь данс үүсгэн бүртгэнэ. ➢ Хойшлогдсон татвар үүсгэж буй ажил гүйлгээ тус бүрээр НББ-ийн данс үүсгэж бүртгэнэ.

	<ul style="list-style-type: none"> ➤ Татварын зардлыг тайлант хугацааны болон хойшлогдсон татварын зардлын данс үүсгэж нийлбэр дүнгээр тайлагнана.
Санхүүгийн тайлагналын хяналт:	<p>Санхүүгийн тайлан, татварын тайлангийн үнэн зөвийг хянах зорилгоор жилийн эцсийн санхүүгийн тайлан бэлтгэх үед татвар ногдуулалттай холбоотой дараах хяналтуудыг хэрэгжүүлнэ.</p> <ul style="list-style-type: none"> ➤ Тайлангийн хугацааны эцэст хойшлогдсон татварын үлдэгдлийг үнэн зөв тодорхойлсон эсэхээ шалгана. ➤ Татвар ногдох орлогоос хасагдсан зардлуудыг дээр дурдсан шалгуурт нийцэж байгаа эсэхийг шалгана. ➤ Хойшлогдсон татвараас тайлангийн хугацаанд хэрэгжсэн хэсгийн үнэн зөвийг шалгана. ➤ Татвар ногдуулалттай холбоотой эргэлзээтэй орлого, зардал байсан эсэхээ эргэн нягтална. ➤ Бүртгэлээрх ААНОАТ-ын өглөг, татварын үлдэгдэлтэй тохирч байгаа эсэхийг шалгана.
Үйл ажиллагааны хяналт:	<p>Компани ААНОАТ-ын тооцоолол хийхдээ дараах хууль, дүрэм, журам, заавар, аргачлалыг баримтална.</p> <ul style="list-style-type: none"> ➤ Тайлан бэлтгэх хугацаанд хамааралтай ААНОАТ-ын тухай хууль; ➤ ААНОАТ-ын тайлангаар гарсан алдагдлыг ирээдүйд шилжүүлэн тооцох, баталгаажуулах журам; ➤ Санхүүгийн болон орлогын албан татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг тайлагнах журам; ➤ Татварын ногдлыг жишиг үнийн аргаар тодорхойлох журам;
Удирдлагад тайлагнах зүйлс:	<p>Тайлангийн хугацааны татвар ногдуулалттай холбоотой дараах зүйлсийг удирдлагад тайлагнана.</p> <ul style="list-style-type: none"> ➤ Хуулийн дагуу тайлангийн хугацаанд төлөх татвар; ➤ Дараагийн тайлангийн хугацаанд төлөхөөр тооцсон хойшлогдсон татвар; ➤ Дараагийн тайлангийн хугацаанд буцаан авахаар тооцсон татвар; ➤ Тайлангийн хугацаанд төлөхөөр тооцсон татварын өсөлт, бууралт, түүний гол нөлөөлөл; ➤ Татвараас хасагдахгүй байгаа зардлууд, түүний агуулга, голлох зардлууд;

Хойшлогдсон татвар, ААНОАТ-ын бүртгэл, тайлагналтай холбоотой санхүүгийн тайланд нэмж тодруулах мэдээлэл:

ААНОАТ, хойшлогдсон татварын тооцоололтой холбоотой дараах зүйлсийг санхүүгийн тайланд нэмж тодруулна.

Тайлант үеийн татварын зардал;

- Өмнөх тайлант үеийн татварыг тайлант үеийн татварт хүлээн зөвшөөрсөн аливаа тохируулга бичилт;
- Үүссэн түр зөрүү болон түүнийг буцаахтай холбоотой хойшлогдсон татварын зардал (орлого)-ын дүн;
- Татварын хувь хэмжээнд орсон өөрчлөлт буюу шинэ татвар ногдуулалттай холбогдох хойшлогдсон татварын зардал (орлого)-ын дүн;

- Тайлант үеийн татварын зардлыг бууруулахад хэрэглэдэг өмнөх тайлант үед хүлээн зөвшөөрөөгүй өмнөх татварын алдагдал, татварын дискаунт буюу түр зөрүүнээс үүссэн өгөөжийн дүн;
- Хойшлогдсон татварын зардлыг бууруулахад ашигладаг өмнөх тайлант үед хүлээн зөвшөөрөөгүй өмнөх татварын алдагдал, татварын дискаунт буюу түр зөрүүнээс үүссэн өгөөжийн дүн;
- Татварын зардал (орлого) ба нягтлан бодох бүртгэлийн ашгийг хэрэглэх боломжтой татварын хувь хэмжээгээр үржүүлсэн дүн хоёрын хоорондох тоон тохируулга, мөн түүнчлэн хэрэглэх боломжтой татварын хувь хэмжээгээр тооцоолсон суурь;

4.17. ХХОАТ, НДШ тооцох нь:

Компани ажилчид, гэрээт ажилтанд олгож буй цалин, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого олгох, хувь хүмүүсээс худалдан авалт хийж тэдгээрт орлого олгохдоо Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, түүнийг хэрэгжүүлэх арга, аргачлалуудыг баримтална. /2020 оны 1 дүгээр сарын 1-ээс мөрдөхөөр УИХ-аас баталсан Хувь хүний орлогын албан татварын тухай хууль/

Компани ХХОАТ-ын тухай хуулийн дагуу дараах хувь хүний орлогуудаас ХХОАТ суутган тооцож төсөвт шилжүүлнэ.

- Ажилтантай байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу олгож байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого;
- Ажилтан, түүний гэр бүлийн гишүүнд олгосон тэтгэмж болон түүнтэй адилтгах орлого;
- Ажилтан, түүний гэр бүлийн гишүүнд өгсөн бэлэг;
- Төлөөлөн удирдах зөвлөл, хяналтын зөвлөл, орон тооны бус зөвлөл болон бусад зөвлөл, хороо, ажлын хэсгийн гишүүний цалин хөлс, шагнал, урамшуулал, тэдгээртэй адилтгах орлого;
- Ажилтанд гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, иргэн болон бусад этгээдээс өгсөн бүх төрлийн шагнал, урамшуулал, тэдгээртэй адилтгах орлого;
- Үндсэн ажлын газраас бусад хуулийн этгээд болон хувь хүнтэй байгуулсан гэрээний үндсэн дээр ажил, үүрэг гүйцэтгэж авсан хөдөлмөрийн хөлс, шагнал, нэмэгдэл, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого;
- Хоол, унааны нэмэгдэл;
- Хувь хүнд олгосон эрхийн шимтгэлийн орлого;
- Эрхийн шимтгэлийн орлого;
- Ногдол ашгийн орлого;
- Хувь хүнд олгосон хүүний орлого;
- Хувь хүнд олгосон үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны орлого;
- ХХОАТ-ын тухай хуулийн 11.1-д заасан дараах шууд бус орлогууд;
 - Үнэ төлбөргүй, эсхүл хөнгөлөлттэй үнээр тээврийн хэрэгслээр үйлчилсэн;
 - Орон сууцны ашиглалтын болон түрээсийн зардлын төлбөр, байрын хөлс, түлшний зардлын төлбөр;
 - Үзвэр үйлчилгээний олговор;
 - Ахуйн үйлчлэгч, жолооч, цэцэрлэгч болон бусад үйлчилгээ үзүүлсний зардлын төлбөр;
 - Ажил олгогч, эсхүл бусад этгээдэд төлөх өр барагдуулсны төлбөр;
 - Арилжааны зээлийн хүүгээс доогуур хүүтэй олгосон зээлийн хүүний зөрүү;
 - Ажил олгогчийн төлсөн энэ хуулийн 11.2.7-д зааснаас бусад сайн дурын даатгалын хураамж;
 - Гэр бүлийн гишүүний сургалтын төлбөр;
 - Монгол Улсад нүүж ирэх болон буцахтай холбогдон гарах зардлын төлбөр;
 - Эрс тэс уур амьсгалд ажиллаж амьдарсны нэмэгдэл;
 - Дээрх орлогуудтай адилтгах бусад орлого;

ХХОАТ-ын тухай хуулийн дагуу 12 дугаар зүйл заасан бусад орлогууд

- Урлаг, спортын тэмцээний шагнал, наадмын бай шагнал, тэдгээртэй адилтгах бусад орлого;
- Төлбөрт таавар, бооцоот тоглоом, эд мөнгөний хонжворт сугалааны хонжворын орлого;

Дараах орлогуудаас татвар төлөгч өөрөө татвараа тодорхойлон төлөх учир компани ХХОАТ суутгахгүй.

1. ХХОАТ-ын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан дараах орлогууд:
 - Бие даан эрхэлсэн мэргэжлийн ажил, үйлчилгээний орлого;
 - хувиараа бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх, зуучлалын үйл ажиллагаа эрхэлж олсон орлого;
 - Шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээл туурвих, шинэ бүтээл, бүтээгдэхүүний болон ашигтай загвар зохион бүтээх, спортын тэмцээн, урлагийн тоглолт зохион байгуулах, тэдгээрт оролцох замаар олсон орлого, тэдгээртэй адилтгах бусад орлого;
 - Эрхэлж байгаа үйл ажиллагаатай холбоотойгоор үнэ төлбөргүй бусдаас авсан бараа, ажил, үйлчилгээ;
 - Тогтмол бус үйл ажиллагаа эрхэлж олсон орлого;
2. Хөрөнгө ашиглуулсан болон түрээслүүлсний орлого;
3. Газар эзэмших, ашиглах эрх болон бусад биет бус хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлого;
4. Хөдлөх эд хөрөнгө борлуулсны орлого;
5. Хувьцаа, үнэт цаас болон санхүүгийн бусад хэрэгсэл борлуулсны орлого;
6. Бичил худалдаа, ажил, үйлчилгээний орлого;

ХХОАТ ногдуулах орлогыг тодорхойлох:

Ажилчид, хувь хүмүүс ХХОАТ-ын тухай хуулийн дагуу татвар ногдуулахад нягтлан боох бүртгэлийн аккурэль суурийн зарчмыг баримтлах бөгөөд тэдгээрт олгосон орлого буюу худалдан авалтыг компани ямар нэг хөрөнгө эсвэл зардлаар хүлээн зөвшөөрсөн үед татвар тооцох үндэслэл болно. Дараа тайлангийн хэлбэрээр олгосон болон урьдчилж төлсөн зардалд ХХОАТ тооцохгүй. Харин аливаа бүтээн байгуулалттай холбоотой зардлыг хуримтлуулан бүртгэж байгаа үед энэ хамаарахгүй.

Компани ХХОАТ ногдуулах орлогыг доорх байдлаар тодорхойлно.

Орлогын төрөл	Татвар ногдуулах орлого тодорхойлох
Ажилтантай байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу олгож байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого	НДШ хассан дүнгээс
Ажилтан, түүний гэр бүлийн гишүүнд олгосон тэтгэмж болон түүнтэй адилтгах орлого	НДШ хассан дүнгээс
Ажилтан, түүний гэр бүлийн гишүүнд өгсөн бэлэг	НДШ хассан дүнгээс
Төлөөлөн удирдах зөвлөл, хяналтын зөвлөл, орон тооны бус зөвлөл болон бусад зөвлөл, хороо, ажлын хэсгийн гишүүний цалин хөлс, шагнал, урамшуулал, тэдгээртэй адилтгах орлого	НДШ хассан дүнгээс
Ажилтанд гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, иргэн болон бусад этгээдээс өгсөн бүх төрлийн шагнал, урамшуулал, тэдгээртэй адилтгах орлого	НДШ хассан дүнгээс
Үндсэн ажлын газраас бусад хуулийн этгээд болон хувь хүнтэй байгуулсан гэрээний үндсэн дээр ажил, үүрэг гүйцэтгэж авсан хөдөлмөрийн хөлс, шагнал, нэмэгдэл, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого	НДШ хассан дүнгээс
Хоол, унааны нэмэгдэл	НДШ хассан дүнгээс
Эрхийн шимтгэлийн орлого	Нийт дүнгээс

Ногдол ашгийн орлого	Нийт дүнгээс
Хувь хүнд олгосон хүүний орлого	Нийт дүнгээс
Хувь хүнд олгосон үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны орлого	Нийт дүнгээс
Үнэ төлбөргүй, эсхүл хөнгөлөлттэй үнээр тээврийн хэрэгслээр үйлчилсэн	Нийт дүнгээс
Орон сууцны ашиглалтын болон түрээсийн зардлын төлбөр, байрын хөлс, түлшний зардлын төлбөр;	Нийт дүнгээс
Үзвэр үйлчилгээний олговор;	Нийт дүнгээс
Ахуйн үйлчлэгч, жолооч, цэцэрлэгч болон бусад үйлчилгээ үзүүлсний зардлын төлбөр;	Нийт дүнгээс
Ажил олгогч, эсхүл бусад этгээдэд төлөх өр барагдуулсны төлбөр;	Нийт дүнгээс
Арилжааны зээлийн хүүгээс доогуур хүүтэй олгосон зээлийн хүүний зөрүү	Нийт дүнгээс
Ажил олгогчийн төлсөн энэ хуулийн 11.2.7-д зааснаас бусад сайн дурын даатгалын хураамж	Нийт дүнгээс
Гэр бүлийн гишүүний сургалтын төлбөр	Нийт дүнгээс
Монгол Улсад нүүж ирэх болон буцахтай холбогдон гарах зардлын төлбөр	Нийт дүнгээс
Эрс тэс уур амьсгалд ажиллаж амьдарсны нэмэгдэл	Нийт дүнгээс
Дээрх орлогуудтай адилтгах бусад орлого	Нийт дүнгээс
Урлаг, спортын тэмцээний шагнал, наадмын бай шагнал, тэдгээртэй адилтгах бусад орлого	Нийт дүнгээс
Төлбөрт таавар, бооцоот тоглоом, эд мөнгөний хонжворт сугалааны хонжворын орлого	Нийт дүнгээс

ХХОАТ-ын хөнгөлөлт, чөлөөлөлт:

Компани хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23 дугаар зүйлд заасны дагуу ажилтан, хувь хүмүүст олгосон дараах орлогуудад ХХОАТ-ын хөнгөлөлт эдлүүлж татвар ногдуулна.

- Ажилтантай байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу олгож байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого;
- Ажилтан, түүний гэр бүлийн гишүүнд олгосон тэтгэмж болон түүнтэй адилтгах орлого;
- Ажилтан, түүний гэр бүлийн гишүүнд өгсөн бэлэг;
- Төлөөлөн удирдах зөвлөл, хяналтын зөвлөл, орон тооны бус зөвлөл болон бусад зөвлөл, хороо, ажлын хэсгийн гишүүний цалин хөлс, шагнал, урамшуулал, тэдгээртэй адилтгах орлого;
- Ажилтанд гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, иргэн болон бусад этгээдээс өгсөн бүх төрлийн шагнал, урамшуулал, тэдгээртэй адилтгах орлого;
- Хоол, унааны нэмэгдэл;

Компани Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн дагуу ажилтанд олгож буй цалингаас ХХОАТ суутган тооцох бөгөөд энэ үед ХХОАТ-ын хөнгөлөлтийг дараах байдлаар эдлүүлнэ. тайлагнана.

№	Татвар ногдуулах орлогын хэмжээ /төгрөгөөр/	Хөнгөлөлт /төгрөгөөр/
1.	0-500,000 хүртэл	20,000
2.	500,000-1,000,000 хүртэл	18,000
3.	1,000,000-1,500,000 хүртэл	16,000
4.	1,500,000-2,000,000 хүртэл	14,000
5.	2,000,000-2,500,000 хүртэл	12,000
6.	2,500,000-3,000,000 хүртэл	10,000
7.	3,000,000-аас дээш	Хөнгөлөхгүй

Компани ХХОАТ-ын тухай хуулийн дагуу хууль тогтоомжид тусгайлан зааснаас бусад тохиолдолд ХХОАТ ногдуулна.

Компани нийгмийн даатгалын тухай хуулийн дагуу ажилтан, хувь хүмүүст олгож буй дараах орлогуудаас НДШ тооцно.

- Ажилтанд хөдөлмөрийн гэрээний дагуу олгосон үндсэн цалин, нэмэгдэл хөлс, шагнал урамшуулал, бусад нэмэгдэл;
- Ажилтны ээлжийн амралтын олговор;
- Сул зогсолтын үеийн олговор;
- Ажилтныг өөр ажилд шилжүүлсэн үед гүйцэтгэсэн ажилд нь ногдох цалин хөлс, бусад нэмэгдэл;
- Ажил хүлээлцэх хугацааны олговор;
- Ажил, албан тушаал нь хэвээр хадгалагдажбайгаа ажилтанд олгох тэтгэмж, олговор;
- Хүндэтгэн үзэх шалтгаанаар ажилдаа ирээгүй үеийн олговор;
- Буруу халсан буюу шилжүүлсэн үеийн олговор;
- Иргэний хуулийн 343 дугаар зүйлд заасны дагуу Ажил гүйцэтгэх гэрээний дагуу олгосон төлбөр;
- Иргэний хуулийн 359 дүгээр зүйлд заасны дагуу Хөлсөөр ажиллах гэрээний дагуу олгосон төлбөр;

4.18. Хөрөнгийн татвар:

Хөрөнгийн татварын бүртгэлийн бодлогын зорилго:

- Хөрөнгийн татвартай холбоотой хууль тогтоомж, дүрэм журмыг мөрдөх
- Хуулийн дагуу хөрөнгийн татварыг хамгийн багаар ногдуулж төлөх
- Компанийг татварын эрсдэлээс сэргийлэх
- Хөрөнгийн татварын суурийг үнэн зөв тодорхойлох
- Хөрөнгийн татварын бүртгэлийг үнэн зөв хөтлөх

Хамрах хүрээ:

Хөрөнгийн татвартай холбоотой хууль тогтоомжийн дагуу компани өөрийн өмчлөлийн үл хөдлөх хөрөнгө, тээврийн хэрэгслүүдийн татварыг хамруулах ба компанийн өмчлөлд байдаггүй хөрөнгүүдийн хувьд хамааралгүй болно.

Хөрөнгийн татвар ногдуулах үнэлгээ:

Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварыг доор дарааллын дагуу үнэлэгдсэн дүнгээс татвар ногдуулна.

3. Уг хөрөнгийн үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлд бүртгэгдсэн үнийн дүнгээс, үгүй бол
4. Хөрөнгийн даатгалд даатгуулсан үнийн дүнгээс, үгүй бол
5. Хөрөнгийн даатгалд даатгуулаагүй бол данс бүртгэлд бүртгэгдсэн үнийн дүнгээс

СТОУС-ын дагуу үл аливаа хөрөнгийн үнэлгээг зах зээлийн тогтвортой байдалтай уялдуулан дахин үнэлэхийг шаарддаг. Харин хөрөнгийн үнэ цэнэ тогтвортой байгаа гэж үзвэл багадаа 3-аас 5 жилийн дотор үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлүүлэх нь зохистой гэж үздэг. Үл хөдлөх эд хөрөнгийг дахин үнэлүүлсэн тохиолдолд татвар ногдуулах данс бүртгэлд бүртгэгдсэн үнийн дүн нь дахин үнэлүүлсэн дүн болно.

Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварыг энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан үнэлгээнээс аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн хөрөнгийн байршил, зориулалт, хэмжээ, зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн байдлыг харгалзан 0.6-1.0 хувиар тооцож ногдуулна.

Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварыг тухайн тээврийн хэрэгслийн дугуйны тоо, зорчигчийн суудлын тоо, хөдөлгүүрийн багтааж, ачааны даацад үндэслэн харьяа нутаг дэвсгэрийн иргэдийн хурлаас тогтоосон үнэлгээгээр ногдуулна.

Компани өөрийн үйл ажиллагаанд ашиглагдаж буй тээврийн хэрэгслийн төрлөөс хамааруулан нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаас тогтоосон үнийн дүнгээр авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвараа ногдуулна. Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварыг тээврийн хэрэгслийн ашиглалтаас үл хамааруулан төлнө.

- Хөрөнгийн татварыг санхүүгийн жилд улирал бүр хувь тэнцүүлэн нягтлан бодох бүртгэлд тусгах ба доорх байдлаар бүртгэнэ.

Дт ҮХЭХАТ-ын зардал
Кт ҮХЭХАТ-ын өр

Дт АТБӨЯХАТ-ын зардал
Кт АТБӨЯХАТ-ын өр

- Хөрөнгийн татвараа төлөх үед доорх байдлаар бүртгэнэ.

Дт ҮХЭХАТ-ын өр
Кт Мөнгөн хөрөнгө
Дт АТБӨЯХАТ-ын өр
Кт Мөнгөн хөрөнгө

Компани хөрөнгийн татварын илүү төлөлтийг бусад татварт суутгуулах, бусад татварын илүү төлөлтийг хөрөнгийн татвар шилжүүлэх байдлаар суутган тооцоолол хийж болно.

Хөрөнгийн татварын зардал нь компанийн удирдлагын зардлын бүрэлдэхүүнд хамаарах ба аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн дагуу татвар ногдуулах орлогоос хасагдах зардал болно.

4.19. Үнэ шилжүүлэлтийн бодлого:

Үнэ шилжүүлэлтийн бодлогын зорилго:

Татварын ерөнхий хууль болон Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, үнэ шилжүүлэлттэй холбоотой журам зааврын хүрээнд үнэ шилжүүлэлтийн тайлан бэлтгэх, татварын эрсдэлээс сэргийлэх зорилготой байна. Энэхүү бодлого нь үнэ шилжүүлэлттэй холбоотой татварын суурийг нэмэгдүүлэхэд ашиглагдах бөгөөд татварын суурийг бууруулах чиглэлээр ашиглахгүй. Өөрөөр хэлбэл:

- Үнэ шилжүүлэлттэй холбоотой харилцан хамаарал бүхий этгээдүүдийг тодорхойлох,
- ✓ Харилцан хамаарал бүхий этгээдүүдтэй холбоотой гарсан ажил гүйлгээг тодорхойлох,
- ✓ Үнэ шилжүүлэлттэй холбоотой татварын суурийг үнэн зөв тодорхойлох,
- ✓ Харилцан хамаарал бүхий этгээдүүдийн талаар татварын албыг үнэн зөв мэдээллээр хангах.

Хамрах хүрээ:

Харилцан хамаарал бүхий этгээд гэдэг нь компанийн зүгээс эдийн засгийн шийдвэр гаргалтад нь шууд болон шууд бус нөлөөлөх боломжтой хувь хүн болон хуулийн этгээдийг хамруулж ойлгоно. Үүнийг доорх этгээдүүд хамаарна:

1. Татвар төлөгчийн эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, өвөг эцэг, эмэг эх, ач, зээ болон эхнэр (нөхөр), хамтран амьдрагч, тэдгээрийн эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү;
2. нэг группт хамаарах этгээд (“групп” гэж санхүүгийн тайлагналын зорилгоор нэгтгэсэн санхүүгийн тайлан гаргадаг, эсхүл аль нэг аж ахуйн нэгжийн хувьцаа хөрөнгийн биржид нээлттэй арилжаалагдах үед нэгтгэсэн санхүүгийн тайлан гаргадаг, өмчлөл болон удирдлагын хувьд хамааралтай аж ахуйн нэгжүүдийг хэлнэ);
3. хувьцаа, хувь оролцоо, эсхүл саналын эрхийг 20% ба түүнээс доошгүй хувийг шууд болон шууд бусаар эзэмшдэг этгээд;
4. ашиг, эсхүл татан буугдсаны дараах үлдэгдэл хөрөнгөөс 20% ба түүнээс доошгүй хувийг шууд болон шууд бусаар хүртэх эрхтэй этгээд;
5. хувьцаа, хувь оролцоо, эсхүл саналын эрхийн 20% ба түүнээс доошгүй хувийг шууд болон шууд бусаар эзэмшдэг 3-дагч этгээдэд хянагддаг этгээдүүд;
6. ашиг, эсхүл татан буугдсаны дараах үлдэгдэл хөрөнгөөс 20% ба түүнээс доошгүй хувийг шууд болон шууд бусаар хүртэх 3-дагч этгээдэд хянагддаг этгээдүүд;
7. (1)-д заасан этгээдийн шууд болон шууд бусаар эзэмшдэг (3), (4), (5), (6)-д заасан этгээдүүд;
8. (1)-д заасан этгээд, тэдгээрийг томилох эрхтэй этгээд, тэдгээрийн эрх, үүргийг шилжүүлэн хүлээн авсан этгээд, эсхүл тэдгээрийг төлөөлөхөөр сонгогдсон этгээд;
9. (1)-д заасан этгээд болон харилцан хамаарал бүхий аж ахуйн нэгжийн салбар, төлөөний газар;
10. Монгол улсад оршин суугч татвар төлөгчийн татвар ногдуулах орлогыг бууруулах, алдагдлыг өсгөх үндсэн зорилгоор харилцаа тогтоосон этгээд;
11. Ерөнхий тодорхойлолтод нийцэх бусад этгээдүүд.

Компани тайлангийн хугацааны эцэст дээрх шаардлагуудыг баримтлан харилцан хамаарал бүхий этгээдүүдээ тодорхойлох ба тайлангийн хугацаанд харилцан хамаарал бүхий этгээдүүдтэй холбоотой гарсан ажил гүйлгээг тодорхойлно.

Татварын ерөнхий хууль болон аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулиар үнэ шилжүүлэлтээс чөлөөлөгдөх аж ахуйн нэгж, байгууллага, ажил гүйлгээ, босго үнийг тодорхойлоогүй бөгөөд хуулийн дагуу харилцан хамаарал бүхий этгээдтэй холбоотой гадаад, дотоодын бүхий л ажил гүйлгээг тайлагнана.

Үнэ шилжүүлэх арга:

Компани үнэ шилжүүлэлтийн тайлан бэлтгэхдээ доорх аргуудаас хамгийн тохиромжтой аргыг сонгон тайлагнана.

- Харьцуулагдах бие даасан үнийн арга
- Дамжуулан борлуулах үнийн арга
- Өртөг дээр нэмэх арга
- Ажил гүйлгээний цэвэр ашгийн арга
- Ажил гүйлгээний ашиг хуваах арга

Компани дээрх аргуудаас дангаар нь болон хослуулан хэрэглэх боломжтой бөгөөд хэрэглэсэн арга болон мэдээллийн эх үүсвэрийг заавал баримтжуулна.

Харьцуулагдах бие даасан үнийн арга нь хяналтад байгаа ажил гүйлгээний үнийг харьцуулж болохуйц адилхан нөхцөлд хийгдсэн бие даасан ажил гүйлгээний үнэ, түүнд нөлөөлөгч хүчин зүйлстэй харьцуулан тодорхойлох арга юм.

Дамжуулан борлуулах үнийн арга-ыг татвар төлөгч харилцан хамааралтай этгээдээс бараа бүтээгдэхүүн худалдан авч, харилцан хамааралгүй этгээдэд дамжуулан борлуулсан үед хэрэглэнэ. Уг аргаар бодит үнийг тодорхойлохдоо дамжуулан борлуулсан үнээс дамжуулан борлуулагч гүйцэтгэсэн ажил үүргийнхээ хүрээнд ашигласан хөрөнгө болон хүлээсэн эрсдэлээ харгалзан борлуулалтын болон бусад холбогдох зардлаа нөхөж, олохоор төлөвлөсөн нийт ашгийг хасаж тодорхойлно.

Өртөг дээр нэмэх арга-аар хяналтад байгаа ажил гүйлгээний бодит үнийг тодорхойлохдоо нийлүүлэгчийн нийлүүлсэн бараа, ажил үйлчилгээний өртөг дээр гүйцэтгэсэн ажил болон зах зээлийн нөхцөл байдлыг харгалзан олохоор тооцсон нийт нэмэгдэл ашгийг нэмж тодорхойлно.

Ажил гүйлгээний цэвэр ашгийн арга нь хяналтад байгаа ажил гүйлгээний цэвэр ашгийн түвшинг харьцуулагдах бие даасан гүйлгээний цэвэр ашгийн түвшинтэй харьцуулж тодорхойлно.

Ажил гүйлгээний ашиг хуваах арга нь харилцан хамааралтай талуудын хяналтад байгаа ажил гүйлгээнээс олсон нэгдсэн ашгийг харьцуулагдах бие даасан ажил гүйлгээний нөхцөл, зарчимд үндэслэн тодорхойлно. Үүний дараа нэгдсэн ашгийг харилцан хамааралтай этгээдийн гүйцэтгэсэн ажил үүрэг, хүлээсэн эрсдэлийг харгалзан эдийн засгийн үндэслэлтэйгээр харилцан хамааралгүй этгээдүүд энэ ашгийг хэрхэн хуваах байсантай нийцүүлэн хуваарилна.

Үнэ шилжүүлэлтийн тайлан:

Татварын ерөнхий хууль болон аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн дагуу компани үнэ шилжүүлэлттэй холбоотой доорх дөрвөн төрлийн тайлангаас өөрийн үйл ажиллагаатай холбоотой тайланг бэлтгэх ёстой.

Тайлангийн төрөл	Тайлангийн агуулга	Хэрхэн тайлагнах
Үнэ шилжүүлэлтийн жилийн тайлан	Харилцан хамааралтай этгээдүүдтэй хийсэн ажил гүйлгээний мэдээлэл	Харилцан хамааралтай этгээдтэй ажил гүйлгээ хийсэн бүх татвар төлөгч
Дотоод үнэ шилжүүлэлтийн тайлан	Монголд дахь аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны талаарх дэлгэрэнгүй мэдээлэл	Өмнөх татварын жилд 6 тэрбум төгрөг болон түүнээс дээш борлуулалтын орлого олсон бол;
Ерөнхий үнэ шилжүүлэлтийн тайлан	Группийн бизнес болон үйл ажиллагааны талаарх товч мэдээлэл	
Улс бүрээр бэлтгэх тайлан	Улс бүрээрх санхүүгийн болон татварын мэдээлэл	Өөр улс оронд салбар, охин компани байгуулж нэгтгэсэн санхүүгийн тайлангаар 1.7 их наяд төгрөг болон түүнээс дээш борлуулалтын орлого олсон бол;

Үнэ шилжилтийн тайлангуудыг татварын ерөнхий газрын даргын 2020 оны 9 дүгээр сарын 3-ны өдрийн А/133 дугаар тушаалаар батлагдсан доорх тайлангийн маягтаар тайлагнана.

№	Тайлангийн төрөл	Маягтын дугаар	Тайлан бэлтгэх хугацаа
1	Үнэ шилжүүлэлтийн жилийн тайлан	Маягт ҮШТ-01	Дараа жилийн 2 сарын 10-ны дотор
2	Дотоод үнэ шилжүүлэлтийн тайлан	Маягт ҮШТ-02	Дараа жилийн 2 сарын 10-ны дотор
3	Ерөнхий үнэ шилжүүлэлтийн тайлан	Маягт ҮШТ-03	
4	Улс бүрээр бэлтгэх тайлан	Маягт ҮШТ-04	Группийн санхүүгийн жилийн сүүлийн өдрөөс хойш 12 сарын дотор

Компани үнэ шилжүүлэлтийн жилийн тайланг үйл ажиллагааны төрөл, чиглэл, үнийн дүнгээс үл хамааран бэлтгэх бөгөөд бэлтгэхдээ Татварын ерөнхий газрын даргын 2020 оны 9 дүгээр сарын 3-ны өдрийн А/133 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан үнэ шилжилтийн тайлангийн тогтмол мэдээллийг ашиглана.

- Үнэ шилжүүлэлтийн тохируулгаар компани татвар нөхөн төлөхөөр гарсан тохиолдолд ААНОАТ-ын зардлыг шууд нэмэгдүүлэн бүртгэх бөгөөд энэ нь татвар ногдуулалтын байнгын зөрүү үүсгэнэ.

Дт ААНОАТ-ын зардал

Кт ААНОАТ-ын өр

4.20. Нэмэгдсэн өртгийн албан татварын нягтлан бодох бүртгэлийн бодлого

Нэмэгдсэн өртгийн албан татварын бүртгэлийн бодлогын зорилго:

НӨАТ-ын бүртгэлийн бодлого нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, түүний хэрэгжүүлэхээр эрх бүхий байгууллагаас баталсан журам зааврыг хэрэгжүүлэх, СТОУС-д нийцсэн татварын бүртгэл хөтөлж, хуулийн хүрээнд НӨАТ-ыг хамгийн багаар төлөх, бүртгэх, тайлагнах зорилготой юм. Өөрөөр хэлбэл:

- Борлуулалт, худалдан авалттай холбоотой үүссэн НӨАТ-ыг үнэн зөв тодорхойлох
- Сар бүрийн НӨАТ-ын ногдлыг үнэн зөв тодорхойлох
- Хуулийн хүрээнд татварын эрсдэлээс сэргийлэх
- Хуулийн хүрээнд НӨАТ-ыг хамгийн багаар төлөх
- Санхүүгийн тайлангийн мэдээлэл хэрэглэгчдийг НӨАТ ногдуулалттай холбоотой үнэн зөв мэдээллээр хангах

НӨАТ-ын бүртгэлд хамаарах зүйлс:

Монгол улсын Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн дагуу дараах зүйлсийг хамруулж ойлгоно.

- Нэмэгдсэн өртгийн албан татварын өр
- Нэмэгдсэн өртгийн албан татварын тооцоо
- Хойшлогдсон НӨАТ-ын тооцоо
- Нэмэгдсэн өртгийн албан татварын авлага

НӨАТ-ын өр төлбөр: нь тухайн сард компани борлуулалтаараа дамжуулан нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчдөөс /эцсийн хэрэглэгчээс/ бараа ажил үйлчилгээний төлбөр дээр нэмж авч төсөвт шилжүүлэхээр тооцсон өр төлбөр юм.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тооцоо: нь компани нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгч байгууллагаас НӨАТ шингэсэн үнээр бараа ажил үйлчилгээ худалдан авсан бөгөөд хараахан НӨАТ-ын тайлангаар буцаан авах эрх үүсээгүй авлагын тооцоо байна.

Хойшлогдсон НӨАТ-ын тооцоо: нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн дагуу компани барилга, байгууламж, тоног төхөөрөмжийн худалдан авалтад төлсөн НӨАТ-ыг хуулийн дагуу хувь тэнцүүлэн буцаан авах хүртэл бүртгэж ирээдүйд хасалт хийх НӨАТ-ын авлага юм.

НӨАТ-ын авлага: нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн дагуу тухайн сард буцаан авалт хийхээр хүлээн зөвшөөрөгдөж сар бүрийн НӨАТ-ын тайлангаар тайлагнасан НӨАТ-ын авлага байна.

Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт:

Компани НӨАТ-ын өр төлбөрийг борлуулалт хийсэн тухай бүр НӨАТ-ын дахин давтагдашгүй дугаар бүхий цахим баримтыг үндэслэн НӨАТ төлөгчөөс бараа, ажил үйлчилгээний төлбөр дээр нэмж нэхэмжилсэн дүнгээр хүлээн зөвшөөрнө. Компани бараа, ажил үйлчилгээний орлогоос ногдуулсан НӨАТ-ын өр төлбөрийг бүртгэхдээ НББ-ийн аккурэль суурийн зарчмыг баримтлах бөгөөд урьдчилж орсон орлогод НӨАТ-ын цахим баримт үйлдэхгүй.

Бараа, ажил, үйлчилгээний төлбөрт НӨАТ ногдуулах гурван хэлбэр байна.

- Үнийн дүн дээр 10% нэмж ногдуулах
- Үнийн дүн дээр 0% нэмж ногдуулах
- НӨАТ-аас чөлөөлөгдөх орлого

НӨАТ ногдуулах, чөлөөлөхдөө НӨАТ-ын тухай хуулийг баримтлах бөгөөд компани бүтээгдэхүүний үйлчилгээний орлогуудаас дараах байдлаар НӨАТ тооцож төсөвт шилжүүлнэ.

- Хувьцаа борлуулсны орлого
- Зээл болон бондын хүүний орлого

- Менежментийн үйлчилгээний орлого
- Түрээсийн орлого
- Ногдол ашгийн орлого
- Хүүний орлого
- Хувьцаа болон хөрөнгө оруулалтын үнэлгээний олз

Дараах тохиолдолд бараа, ажил, үйлчилгээ борлуулсанд тооцож орлогоос НӨАТ тооцох үндэслэл болно.

- Бараа, ажил, үйлчилгээг бусдад борлуулсан
- Бараа, ажил, үйлчилгээг бусадтай харилцан солилцсон
- Өр төлбөрийг бараа нийлүүлэх, ажил, үйлчилгээ үзүүлэх замаар хассан

НӨАТ ногдуулах үнэлгээ:

- Бараа, ажил үйлчилгээг бусдад борлуулсан гэрээний үнээс
- Бараа, ажил үйлчилгээг харилцан солилцсон тохиолдолд харилцан тохиролцсон зах зээлийн жишиг үнээс
- Өр төлбөрийг бараа шилжүүлэх, ажил үйлчилгээ үзүүлэх замаар хаасан тохиолдолд өр төлбөрийн хасагдах дүнгээс
- Гадаад валютаар илэрхийлэгдсэн орлогын хувьд орлого хүлээн зөвшөөрөх өдрийн

Монгол банкны албан ханшаар төгрөгт шилжүүлэн тооцсон үнэлгээнээс тус тус тооцно. Нэмэгдсэн өртгийн албан татварын тооцоог компани НӨАТ суутган төлөгч байгууллагаас худалдан авалт хийсэн боловч хараахан худалдан авалтын цахим төлбөрийн баримт, дахин давтагдашгүй дугаар бүхий НӨАТ-ын падаан үйлдээгүй тохиолдолд худалдан авалтад нэмж төлсөн дүнгээр авлага үүсгэн бүртгэнэ.

Хойшлогдсон НӨАТ-ын тооцоо дансанд компани өөрийн үйл ажиллагаандаа ашиглах зорилгоор барилга байгууламж, тоног төхөөрөмж худалдан авсан, зардал хуримтлуулсан (дотоодын зах зээл дээрээс болон импортоор худалдан авсан) бий болгоход хуримтлуулж түүнтэй холбоотой төлсөн НӨАТ-ыг бүртгэнэ.

НӨАТ-ын авлагаар тухайн сарын НӨАТ-ын тайлангаар буцаан авалт хийх эрх нь үүссэн худалдан авалт, нэмэгдсэн өртгийн албан татварын тооцоо болон хойшлогдсон НӨАТ-ын тооцооноос шилжүүлэн бүртгэсэн авлагуудыг бүртгэнэ.

Буцаан авалттай холбоотой НӨАТ-ын тооцоо, авлагыг бүртгэхдээ дараах суурь үнэлгээнд үндэслэнэ.

- Дотоодын зах зээлээс худалдан авсан бараа, ажил үйлчилгээний үнэд нэмж төлсөн дүнгээр
- Импортоор авсан барааны хувьд гаалийн үнэлгээнд үндэслэнэ.

НӨАТ-ын өр төлбөрийг бүртгэлд тусгах:

- НӨАТ ногдуулсан үед дараах бичилт хийнэ.

Дт	Авлага эсвэл мөнгөн хөрөнгө
Кт	Холбогдох орлогын данс
Кт	НӨАТ-ын өр

Гадаад валютаар илэрхийлэгдсэн урьдчилж орсон орлогоос борлуулалтын орлого тохируулах үед гадаад валютын түүхэн ханшаар орлого хүлээн зөвшөөрч НӨАТ тооцох үед:

Дт	Авлага эсвэл мөнгөн хөрөнгө
Кт	Борлуулалтын орлого
Кт	НӨАТ-ын өр

НӨАТ-ын авлагыг бүртгэлд тусгах:

Компани бараа, ажил үйлчилгээний худалдан авалтад нэмж төлсөн НӨАТ-ыг Нэмэгдсэн өртгийн албан татварын тооцоо, Хойшлогдсон НӨАТ-ын тооцоо, НӨАТ-ын авлага данснуудын тохирох хэсэгт бүртгэнэ.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тооцоо дансанд компани НӨАТ суутган төлөгч байгууллагаас худалдан авалт хийсэн ч хараахан НӨАТ-ын төлбөрийн баримт бичигдээгүй худалдан авалттай холбоотой тооцоог бүртгэнэ. Энэ үед доорх бичилтийг хийнэ.

Дт Зардал эсвэл холбогдох хөрөнгийн данс
Дт НӨАТ-ын тооцоо
Кт Өр төлбөр эсвэл мөнгөн хөрөнгө

Бэлтгэн нийлүүлэгч НӨАТ-ын дахин давтагдашгүй дугаар бүхий цахим баримтыг бичсэнээр НӨАТ-ын тооцоо данснаас НӨАТ-ын авлага дансанд шилжүүлэн бүртгэж буцаан авалтаар тооцно. Энэ үед дараах бичилт хийнэ.

Дт НӨАТ-ын авлага
Кт НӨАТ-ын тооцоо

Хойшлогдсон НӨАТ-ын тооцоо дансанд “барилга байгууламж, тоног төхөөрөмж” худалдан авах, өөртөө бий болгохтой холбоотой төлсөн НӨАТ-ыг хойшлогдсон НӨАТ-ын тооцоо дансанд бүртгэх ба барилга байгууламж худалдан авахад төлсөн НӨАТ-ыг 10 жилийн хугацаанд, тоног төхөөрөмж худалдан авахад төлсөн НӨАТ-ыг 5 жилийн хугацаанд тэнцүү хэмжээгээр буцаан авалтаар тохируулна.

Барилга байгууламж, тоног төхөөрөмжтэй холбоотой худалдан авалт хийх үед доорх байдлаар бүртгэнэ.

Дт Барилга эсвэл тоног төхөөрөмж
Дт Хойшлогдсон НӨАТ-ын тооцоо
Кт Өр төлбөр эсвэл мөнгөн хөрөнгө

Өөртөө бий болгосон барилга байгууламж, тоног төхөөрөмжийг ашиглалтад оруулснаас эхлэн Хойшлогдсон НӨАТ-ын тооцоо данснаас НӨАТ-ын авлага дансанд шилжүүлэн бүртгэж буцаан авалтаар тооцно. Энэ үед дараах бичилт хийнэ.

Дт НӨАТ-ын авлага
Кт Хойшлогдсон НӨАТ-ын тооцоо

Нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгч байгууллагаас бараа, ажил үйлчилгээ худалдан авч НӨАТ-ын дахин давтагдашгүй дугаар бүхий НӨАТ-ын худалдан авалтын цахим баримт бичигдсэн үед худалдан авалтад төлсөн НӨАТ-ыг шууд НӨАТ-ын авлага дансанд бүртгэх ба доорх байдлаар бүртгэнэ.

Дт Зардал эсвэл холбогдох хөрөнгийн данс
Дт НӨАТ-ын авлага
Кт Өр төлбөр эсвэл мөнгөн хөрөнгө

Нэмэгдсэн өртгийн албан татвараас хасалт хийх:

Компани хүлээн зөвшөөрсөн орлогуудаас 10 % болон “тэг” %-иар НӨАТ ногдуулсан орлогыг олохтой холбогдуулан худалдан авалтад төлсөн НӨАТ-ыг төсөв төлөх НӨАТ-аас хасаж тооцох бөгөөд чөлөөлөгдөх орлого олохтой холбогдуулан худалдан авалтад төлсөн НӨАТ-ыг төсөвт төлөх НӨАТ-аас хасаж тооцохгүй.

Нэмэгдсэн өртгийн албан татвараас хасалт хийхэд тавигдах хязгаарлалт:

Дараах тохиолдолд компани НӨАТ-аас хасалт хийхгүй бөгөөд тухайн бараа, ажил үйлчилгээний өртөгт шингээнэ.

- Суудлын автомашин, түүнтэй холбоотой сэлбэг хэрэгсэл худалдан авахад төлсөн НӨАТ,
- Ажиллагсдын хувийн хэрэгцээнд зориулан худалдан авахад төлсөн НӨАТ,
- НӨАТ-аас чөлөөлөгдөх орлого олохтой холбоотойгоор худалдан авсан бараа, ажил үйлчилгээнд төлсөн НӨАТ.

НӨАТ-ын авлага, өр төлбөрийг санхүүгийн тайланд тусгах:

НӨАТ-ын авлага болон өр төлбөрийн үлдэгдлийг Сангийн сайдын 2017 оны 361 тоот тушаалаар батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу санхүүгийн тайланд дараах байдлаар тусгана.

Толилуулгын нэр	Үнэлгээ
НӨАТ-ын өр төлбөр	Төсөвт төлөхөөр тооцсон НӨАТ-ын өр болон хасалт хийхээр тооцсон НӨАТ-ын авлагын цэвэр дүнгээр санхүүгийн байдлын тайланд татварын өр төлбөрийн хэсэгт толилуулна.
НӨАТ-ын тооцоо	Санхүүгийн байдлын тайлангийн татвар, шимтгэлийн авлага хэсэгт ирээдүйд НӨАТ-ын авлага руу шилжүүлэн тооцох дүнгээр толилуулна.
Хойшлогдсон НӨАТ-ын тооцоо	Санхүүгийн байдлын тайлангийн татвар, шимтгэлийн авлага хэсэгт ирээдүйд НӨАТ-ын авлага руу шилжүүлэн тооцох дүнгээр толилуулна.
НӨАТ-ын авлага	Нийт НӨАТ-ын авлагаас төсөвт төлөхөөр тооцсон НӨАТ-ын өр төлбөрийг хассан цэвэр дүнгээр санхүүгийн байдлын тайланд татвар, шимтгэлийн авлага хэсэгт толилуулна.

НӨАТ-ын бүртгэл, тайлагналын хяналт:

НӨАТ ногдуулалт, бүртгэл, тайлагналтай холбоотойгоор дараах хяналтын орчныг бүрдүүлж ажиллана.

Хяналтын орчин	Хяналтын горим
Нягтлан бодох бүртгэлийн хяналт:	<ul style="list-style-type: none"> ➢ НӨАТ-ын тооцоо, Хойшлогдсон НӨАТ-ын тооцоо, НӨАТ-ын авлага зэргийг тус тусад нь нягтлан бодох бүртгэлийн данс үүсгэн бүртгэнэ. ➢ Ирээдүйд хасалт хийх тооцоо тодорхой байлгах зорилгоор НӨАТ-ын тооцоо болон Хойшлогдсон НӨАТ-ын тооцоо дансны хувьд дэлгэрэнгүй бүртгэл хөтөлж болно.
Санхүүгийн тайлагналын хяналт:	<ul style="list-style-type: none"> ➢ Санхүүгийн тайлагналын үнэн зөвийг хянах зорилгоор жилийн эцсийн санхүүгийн тайлан бэлтгэх үед НӨАТ ногдуулалт, төлөлттэй холбоотой дараах хяналтуудыг хэрэгжүүлнэ. ➢ Тайлангийн хугацааны эцэст сар бүрийн НӨАТ-ын тайлангаарх орлогыг нэгтгэн санхүүгийн тайлан, ААНОАТ-ын тайлантай тохирч байгаа эсэхийг шалгана. ➢ Бүртгэлээрх НӨАТ-ын авлага, өр төлбөрийн цэвэр үлдэгдэл татварын байгууллагын тооцооны үлдэгдэлтэй тохирч байгаа эсэхийг шалгана. ➢ НӨАТ-аас чөлөөлөгдөх орлого болон “Тэг” %-иар НӨАТ ногдуулах орлогоо үнэн зөв ангилсан эсэхээ эргэн хянана. ➢ НӨАТ-ын хасалт хийсэн дүн, буцаан тохируулсан тохируулгын хуулийн нийцлийг эргэн хянана.
Үйл ажиллагааны хяналт:	<p>Компани НӨАТ-ын тооцоолол хийхдээ дараах хууль, дүрэм, журам, заавар, аргачлалыг баримтална.</p> <ul style="list-style-type: none"> ➢ Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, ➢ Сангийн сайдын 2015 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 333 тоот тушаалаар батлагдсан “Нэмэгдсэн өртгийн албан татварын хасалт хийх, буцаан олгох, тэдгээрийг нягтлан бодох бүртгэлд тусгах журам”

Удирдлагад тайлагнах зүйлс:	<p>НӨАТ-ын ногдуулалт, бүртгэл, тайлагнал хариуцсан этгээд дараах зүйлсийг удирдлагад тайлагнана.</p> <ul style="list-style-type: none"> ➤ Хуулийн дагуу тухайн сард тайлагнасан орлого, ногдуулсан татвар, ➤ Тухайн сард төлөх татварын өрийн үлдэгдэл эсвэл авлагын үлдэгдэл, ➤ Тухайн сард ногдуулсан татвараас хасалт хийхгүйгээр буцаан тохируулсан НӨАТ-ын тооцоо,
-----------------------------	---

НӨАТ-ын бүртгэл, тайлагналтай холбоотой санхүүгийн тайланд нэмж тодруулах мэдээлэл:

НӨАТ-ын авлага, өр төлбөрийн үлдэгдлийг санхүүгийн байдлын тайлангийн татварын авлага, эсвэл өр төлбөрийн хэсэгт тайлагнах бөгөөд санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулга бэлтгэхэд НӨАТ-ын тооцоо, Хойшлогдсон НӨАТ-ын тооцоо, НӨАТ-ын авлага, НӨАТ-ын өр төлбөрийн үлдэгдэл дүнг өмнөх оны үлдэгдэлтэй зэрэгцүүлэн толилуулна.

4.21. Балансын дараах үйл явдлыг тодорхойлох

Балансын дараах үйл явдлыг тодорхойлохын зорилго:

Тусгай бүртгэлийн бодлого нь дараах зорилготой.

- Аж ахуй нэгж тайлагналын үеийн дараах үйл явдлын хувьд өөрийн санхүүгийн тайланг хэзээ залруулах
- Тайлагналын үеийн дараах залруулах үйл явдал эсвэл үл залруулах үйл явдал
- Санхүүгийн тайланг гаргахыг зөвшөөрсөн огноо ба тайлагналын үеийн дараах үйл явдлын талаар аж ахуй нэгжийн хийвэл зохих тодруулга
- Санхүүгийн тайлангийн мэдээлэл хэрэглэгчдийг тайлагналын дараах үйл явдалтай холбоотой үнэн зөв мэдээллээр хангах,
- СТОУС-д нийцсэн бүртгэл хөтлөх.

Балансын дараах үйл явдалд хамаарах зүйл:

Ард Санхүүгийн Нэгдэл ХК бодлогоор тайлагналын дараах үйл явдал гэдэг нь тайлагналын үеийн эцэст санхүүгийн тайланг гаргахыг зөвшөөрсөн өдрийн хооронд гарч тохиолдсон тааламжтай болон тааламжгүй үйл явдлууд юм. Үүнд:

- Тайлагналын үеийн эцэст оршин байх нөхцөл байдлуудыг (тайлагналын дараах залруулагдах үйл явдал)
- Тайлагналын үеийн дараа үүссэн нөхцөл байдлуудыг (тайлагналын дараах үл залруулагдах үйл явдал)
- Тайлагналын дараах залруулагдах үйл явдал: Санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрсөн дүнгээ залруулах эсвэл өмнө хүлээн зөвшөөрөөгүй зүйлсээ хүлээн зөвшөөрөхийг аж ахуй нэгжээс шаарддаг үйл явдал.
- Тайлагналын дараах үл залруулагдах үйл явдал: Санхүүгийн тайланг тайлагналын үеийн дараах үл залруулагдах үйл явдлыг тусгахын тулд компани санхүүгийн тайлан хүлээн зөвшөөрсөн дүнгээ залруулахгүй байх үйл явдал

Тайлагналын үеийн дараах залруулагдах үйл явдал:

1. Тайлагналын үеийн эцсээр тухайн аж ахуй нэгж ийм одоогийн үүрэгтэй байсан гэдгийг нотлох баталгаажуулах шүүхийн зарга маргаан тайлагналын дараа үед шийдэгдэх, шүүхийн зарга маргааныг НББОУС-37 нөөцийн дагуу шинээр нөөц үүсгэж хүлээн зөвшөөрнө. Нэмэлт нотолгоо хангалттай байх учир компани болзошгүй өр төлбөрийн талаар зөвхөн тодруулга хийгээд орхихгүй юм.
2. Тайлагналын үеийн эцсээр хөрөнгийн үнэ цэнэ буурсан эсвэл тухайн хөрөнгийн хувьд өмнө хүлээн зөвшөөрсөн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарзын дүнг залруулах шаардлагатай гэдгийг илэрхийлэх мэдээллийг тайлагналын үеийн дараа хүлээн авсан. Жишээ нь худалдан авагчийн дампуурал нь тайлагналын үеийн эцсээр уг худалдан авагчийн зээлийн чадвар батлан даалт муудсан, бараа материалын цэвэр боломжит үнэ цэнийн талаарх нотолгоог илэрхийлж болох юм.
3. Тайлагналын үеийн эцсээр худалдан авсан хөрөнгийг өртөг эсвэл борлуулсан хөрөнгийн орлогыг уг тайлагналын үеийн дараа тодорхойлох
4. Тайлагналын үеийн өмнөх аливаа гэрээ хэлцлийг тайлагналын дараах үйл явдлын дотор хугацаанд
5. Санхүүгийн тайлагналын буруу илэрхийллээр харуулах залилан эсвэл алдаатай байдлыг илрүүлэх

Тайлагналын үеийн дараах үл залруулагдах үйл явдал:

- Тайлагналын үеийн дараах үл залруулагдах үйл явдалд тайлагналын үеийн эцэст болон санхүүгийн тайланг гаргахыг зөвшөөрсөн өдрийн хоорондох хугацаанд хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнэд үүссэн бууралт гарз.
- Аж ахуй нэгж өөрийн хувьцаа эзэмшигч, өөрийн өмчийн хэрэглүүр эзэмшигч нартаа тайлагналын үеийн дараа ногдол ашиг олгохоор зарласан бол компани тухайн

тайлагналын үеийн эцсээр тухайн ногдол ашгийг өр төлбөрөөр хүлээн зөвшөөрч бүртгэхгүй.

- Тайлангийн үеийн эцсийн огноо гэдэг нь 12 сарын 31-ний өдөр гэж ойлгоно. Тайланг зөвшөөрсөн огноо мөн тодорхойлж өгнө. Тайланг бэлтгэж дуусах хугацаа болон ТУЗ-өөр тайланг гаргахыг зөвшөөрсөн огноо.

Балансын дараах үйл явдлыг санхүүгийн тайланд тусгах:

Тайлагналын үеийн дараах үйл явдлыг тусгах бичилт хийгдэнэ.

Шүүх зарга маргааны улмаас шүүхээр төлөхөөр баталгаажсан үед дараах бичилт хийнэ:

1. Дт: Холбогдох торгууль, зардал

Кт: Нөөц (Урт хугацаат эсвэл богино хугацаат)

Тайлагналын үеийн эцсээс тайлагналын дараах үйл явдалд хөрөнгийн үнэ цэнийн бууралт үүсэх үеийн бичилт:

2. Дт: Үнэ цэнийн бууралтын гарз

Кт: Холбогдох эргэлтийн бус хөрөнгө

Тайлагналын үеийн дараах үйл явдлын хяналт:

Тайлагналын үеийн дараах үйл явдлын бүртгэл, тайлагналтай холбоотойгоор дараах хяналтын орчныг бүрдүүлж ажиллана.

Хяналтын орчин	Хяналтын горим
Санхүүгийн тайлагналын хяналт:	<ul style="list-style-type: none"> ➤ Тайлагналын үеийн дараах үйл явдлын залруулсан бичилт нь санхүүгийн тайланд хэрхэн нөлөөлсөн нөлөөллийг хянана. ➤ Тайлагналын үеийн дараах үл залруулагдах санхүүгийн ажил гүйлгээ байгаа эсэхийг хянана.
Үйл ажиллагааны хяналт:	<ul style="list-style-type: none"> ➤ Тайлагналын үеийн дараах үйл явдлыг үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлж байгаа, татан буугдах, тасралтгүй байдлыг хянах
Удирдлагад тайлагнах зүйлс:	<ul style="list-style-type: none"> ➤ Балансын дараах үйл явдалтай холбоотой дараах зүйлсийг удирдлагад тайлагнана. ➤ Тайлагналын үеийн дараах үйл явдал байгаа эсэх; ➤ Тайлагналын үеийн дараах үйл явдлаас үндэслэж тухайн санхүүгийн тайлан хэрхэн өөрчлөгдсөн талаар; ➤ Тайлагналын үеийн дараах үл залруулагдах үйл явдал үүссэн эсэх; ➤ Тайлангийн эцсийн хугацаа болон тайлагналын үеийн дараах тайланг бэлтгэх, зөвшөөрөх огноо;

Балансын дараах үйл явдлын талаар санхүүгийн тайланд нэмж тодруулах мэдээлэл:

Компани жилийн эцсийн санхүүгийн тайланг бэлтгэж тайлагналын үеийн дараах үйл явдалтай холбоотой дараах зүйлсийг нэмж тодруулна. данс

- Компани санхүүгийн тайланг гаргахыг зөвшөөрсөн огноо болон уг зөвшөөрлийг хэн өгсөн талаар тодруулга хийнэ;
- Хэрэв санхүүгийн тайланг гаргасны дараа өөрчлөлт оруулах бүрэн эрхтэй бол компани энэ тухай тодруулга хийнэ;
- Тайлагналын үеийн дараах үл залруулагдах үйл явдлын материаллаг анги тус бүрээр тодруулга хийгдэнэ;
- Тайлагналын үеийн дараах бизнесийн томоохон нэгдэл, томоохон охин компанийг худалдан борлуулах, данснаас хасах;
- Үйл ажиллагааг зогсоох тухай төлөвлөгөө;

- Хөрөнгийн томоохон худалдан авалт, борлуулах зорилготой эргэлтийн бус хөрөнгийн ангилал өөрчлөлт;
- Тайлагналын үеийн дараах энгийн хувьцаанд гарсан томоохон өөрчлөлт, ажил гүйлгээ буюу хувьцааг хуваах, урамшуулалт гаргалт, нэгж хувьцаанд ногдох ашиг өөрчлөлт;
- Тайлагналын үеийн дараах хөрөнгийн үнэд өөрчлөлт гарах, гадаад валютын ханшид орсон хэвийн бус томоохон өөрчлөлтүүд;
- Тайлагналын үеийн дараах хойшлуулсан татварын хөрөнгө болон өр төлбөр дансанд мэдэгдэхүйц нөлөө үүсэх;
- Томоохон хариуцлага хүлээх эсвэл болзошгүй өр төлбөр үүсгэх гэрээ хэлцэл байгуулах, томоохон баталгаа;
- Зөвхөн тайлагналын үеийн дараах үед үүссэн томоохон хэмжээний зарга маргаан.

4.22. Тасралтгүй үйл ажиллагаа

Тасралтгүй байх зарчмын зорилго:

Компанийн тасралтгүй үйл ажиллагааны талаар санхүүгийн тайлангийн мэдээлэл хэрэглэгчдийг хангах зорилготой.

№	Гол шалгуур	Нөхцөл тийм эсвэл үгүй
Татан буулгах буюу түүний үйл ажиллагааг зогсоохоор төлөвлөж байгаа:		
1	Компанийн үйл ажиллагаа эрхлэх хугацаа дууссан эсэх	
2	Компанийн үйл ажиллагааг эрх бүхий байгууллагаас зогсоохоор шаардлага ирүүлсэн эсэх	
3	Компанийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл хүчинтэй үргэлжилж байгаа эсэх	
4	Компанийг өөрчлөн зохион байгуулалтад оруулахаар төлөвлөж байгаа эсэх	
5	Компанийн үйл ажиллагааг өөр компанид шилжүүлэхээр төлөвлөж байгаа эсэх	
6	Компанийн үйл ажиллагаанаас зарим хэсгийг өөр компанид шилжүүлэхээр төлөвлөж байгаа эсэх	
Санхүүгийн үйл ажиллагааны хувьд:		
1	Үйл ажиллагааны дахин давтагдсан алдагдал байгаа эсэх	
2	Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний хувьд дахин давтагдсан алдагдал байгаа эсэх	
3	Ажлын капиталын хүрэлцээ хангалттай байгаа эсэх	
4	Төлөх хугацаа хэтэрсэн материаллаг хэмжээний өр төлбөр байгаа эсэх	
5	Шаардлагатай мөнгөн зарлагын гүйлгээг санхүүжүүлэх санхүүгийн эх үүсвэрээ тодорхойлсон эсэх	
6	Үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах хүний нөөцийн хүрэлцээ хангалттай эсэх	

Тасралтгүй үйл ажиллагаатай холбоотой нэмэлт тодруулга:

Компанийн удирдлага тасралтгүй байдлаа үнэлсний үндсэн дээр дараах зүйлсийг санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулгын хэсэгт нэмж тодруулна.

- Тайлангийн хугацаанаас хойш 12 сарын хугацаанд татан буулгах эсвэл үйл ажиллагааг нь зогсоох болон өөрчлөн зохион байгуулахтай холбоотой төлөвлөгөө;
- Ажлын капиталын хүрэлцээ;
- Төлөгдөх хугацаа хэтэрсэн өр төлбөр;
- Санхүүгийн хөрөнгийн төлбөр гүйцэтгэхэд бэлэн байдал;
- Санхүүгийн болоод бусад өр төлбөрийн төлбөр гүйцэтгэх хугацаа;
- Ирээдүйн 12 сарын хугацаанд орох, гарах мөнгөн урсгалын төлөвлөгөө.

4.23. Холбоотой талуудын ажил гүйлгээ

Холбоотой талуудын ажил гүйлгээний зорилго:

Тусгай бүртгэлийн бодлого нь дараах зорилготой.

- Холбоотой талуудын харилцаа ба ажил гүйлгээг тодорхойлох;
- Компанитай холбоотой талуудын ажил гүйлгээ борлуулалт, зардлыг тодорхойлох;
- Холбоотой талуудын хоорондын төлөгдөөгүй тооцоо үлдэгдэл;
- Холбоотой талуудын төлөгдөөгүй үлдэгдлээс үүсэх үүрэг хариуцлагын улмаас компанийн санхүүгийн байдал болон ашиг, алдагдалд нөлөөлж болох боломжит байдал;
- Холбоотой талуудын тодруулга хийхийг шаардах нөхцөл байдлыг тодорхойлох;
- СТОУС-д нийцсэн бүртгэлийн байдал.

Холбоотой талуудад хамаарах зүйл:

Компани группийн бизнесийн үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах, зарим тохиолдолд холбоотой талуудтайгаа харилцан үйлчилгээ үзүүлж ажилладаг бөгөөд холбоотой талуудын ажил гүйлгээ өдөр тутам гарч байдаг. Тухайлбал үйл ажиллагаа явуулж байгаа барилга байгууламжийг түрээсээр ашиглах, охин компани болон бусад холбоотой талуудад түрээслүүлэх, өөр хоорондоо хувьцаа худалдан борлуулах гэх мэт. Энэ тохиолдолд тухайн аж ахуй нэгжид бүрэн хяналт эсвэл хамтарсан хяналт эсвэл мэдэгдэхүйц нөлөөгөөр дамжуулан тухайн санхүүжигчийн санхүүгийн ба үйл ажиллагааны бодлогод нөлөө үзүүлэх чадвартай байдаг.

Холбоотой талуудын ажил гүйлгээний үр дүнд компанийн ашиг, алдагдал болон санхүүгийн байдалд нөлөө үзүүлж болно. Мөн холбоотой талуудын хоорондох ажил гүйлгээг хийхгүй байж болох ба дараах байдлаар холбогдоно.

- Холбоотой талуудын хоорондын орлого зардал, олз гарз: Холбоотой компаниудын болох толгой компани, хараат компани, хамтарсан компани, охин компанийн хоорондын орлого зардал, худалдан авалт борлуулалт багтана.
- Холбоотой талуудын төлөгдөөгүй авлага, өглөг : Холбоотой компаниудын болох толгой компани, хараат компани, хамтарсан компани, охин компанийн хоорондын ажил гүйлгээний үр дүнд үүссэн хоорондын тооцоо хараахан төлөгдөөгүй авлага өглөг багтана.

Хүлээн зөвшөөрөлт ба Тодорхойлолт:

Холбоотой талууд: Холбоотой тал гэдэг нь санхүүгийн тайлан бэлтгэж буй аж ахуй нэгжийн холбоотой тал гэж үзсэн хүн ба аж ахуй нэгж байна.

- Хувь хүн эсвэл түүний гэр бүхий ойрын гишүүнийг дараах тохиолдолд уг компанитай холбоотой гэж үзнэ.
 1. Тайлагнагч аж ахуй нэгжийг хянадаг эсвэл хамтран хянадаг;
 2. Тайлагнагч аж ахуй нэгжид мэдэгдэхүйц үлэмж нөлөөтэй;
 3. Тайлагнагч аж ахуй нэгжийн эсвэл түүний толгой компанийн эрх бүхий албан тушаалтан байх;
- Аж ахуй нэгжтэй холбоотой:
 1. Групп компанийн гишүүн байх, толгой компани, охин компани;
 2. Хараат компани эсвэл хамтарсан үйлдвэр группийн гишүүн компани;
 3. Хоёр компанийн аль аль нь нэг ижил гуравдагч компанид хамтарсан үйлдвэрүүд байх;
 4. Нэг компани нь гуравдагч аж ахуй нэгжийн хамтарсан үйлдвэр, нөгөө аж ахуй нэгж нь уг гуравдагч аж ахуй нэгжийн хараат компани байх;
 5. Компани нь тайлагнагч байгууллага эсвэл тайлагнагч байгууллагатай холбоотой аль алины ажилтнуудын тэтгэмжийн хөтөлбөртэй байвал хэрэв уг

тайлагнагч аж ахуй нэгж өөрөө ийм хөтөлбөр бол санхүүжүүлэгч ажил олгогч нь тухайн тайлагнагч аж ахуй нэгжтэй мөн холбоотой байх;

6. Дээрх а-д тодорхойлсон хувь хүн нь тухайн аж ахуй нэгжийг хянадаг эсвэл хамтран хянадаг байх;
7. Дээрх а-гийн 1-т тодорхойлсон хувь хүн тухайн аж ахуй нэгжид мэдэгдэхүйц нөлөөтэй эсвэл тухайн компанийн болон толгой компанийн эрх бүхий албан тушаалтан байх;

Холбоотой талуудын ажил гүйлгээг үнийг нэхэмжилсэн эсэхээс үл хамааран тайлагнагч компани ба холбоотой талын хоорондох нөөц, үйлчилгээ, үүргийн шилжүүлэлтийг хамруулна.

Холбоотой талуудын боломжит харилцаа бүрийг авч үзэхдээ, зөвхөн хуулийн хэлбэр төдийгүй уг харилцааны мөн чанарт анхаарал хандуулдаг

НББОУС-24 дагуу дараах аж ахуй нэгжийг холбоотой талууд гэж үзэхгүй:

- Захирал буюу эрх бүхий албан тушаалтны хувьд хоёр аж ахуй нэгжийн хоёуланд нэг хүн байх, эсвэл аж ахуй нэгжийн эрх бүхий албан тушаалтан нь нөгөө аж ахуй нэгжид мэдэгдэхүйц нөлөөтэй байх тийм хоёр аж ахуй нэгж;
- Хамтарсан үйлдвэрт хамтын хяналт тавьдаг уг хамтарсан үйлдвэрийн хоёр хувь нийлүүлэгч;
- Аж ахуй нэгжтэй өөрсдийн хэвийн ажил хэргээр зөвхөн холбогдох дараах этгээдүүд:
 - Санхүүжилт өгдөг аж ахуй нэгж, нийтийн аж ахуй алба, тайлагнагч аж ахуй нэгжийг хянадаггүй, хамтран хянадаггүй, мэдэгдэхүйц нөлөө үзүүлдэггүй засгийн газрын байгууллага агентлагууд;
 - Аж ахуй нэгжийн мэдэгдэхүйц их тоо хэмжээний бизнесийн ажил гүйлгээ хийсний үр дүнд аяндаа эдийн засгийн хамааралтай болсон худалдан авагч, бэлтгэн нийлүүлэгч, франчайз олгогч, дистрибьютор, төлөөлөгчийн газар;

Холбоотой талуудын ажил, гүйлгээний бүртгэл, тайлагналын хяналт:

Холбоотой талуудын тодруулгыг тайлагнахтай холбоотойгоор дараах хяналтын орчныг бүрдүүлж ажиллана.

Хяналтын орчин	Хяналтын горим
Нягтлан бодох бүртгэлийн хяналт:	<ul style="list-style-type: none"> ➢ Холбоотой талуудаас авах авлага, өглөгийн тооцоог нягтлан бодох бүртгэлийн тусдаа данс үүсгэн бүртгэнэ. ➢ Тайлангийн хугацааны эцэст холбоотой талуудын ажил гүйлгээ, тооцооны үлдэгдлийг нэмж тодруулна.
Үйл ажиллагааны хяналт:	<ul style="list-style-type: none"> ➢ Холбоотой талуудын бүрэлдэхүүнийг тайлангийн хугацааны эхэнд эрх бүхий албан тушаалтан тодорхойлно. ➢ Тайлангийн хугацааны эцэст холбоотой талуудын бүрэлдэхүүнд багтаж байгаа этгээдийн холбоо хамаарлын эргэн хянаана. ➢ Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээг бусад харилцагч нарын ажил гүйлгээтэй адилтган тооцох ба шаардлагатай баримт материалыг тухай бүр нь бүрдүүлж ажиллана. ➢ Холбоотой талуудын төлөгдөөгүй өр авлага, өглөгийн тооцоог сар бүрийн эцэст тооцоо нийлж баталгаажуулна. ➢ Холбоотой талуудын бүрэлдэхүүнд багтсан этгээдүүдтэй хийгдсэн худалдан авалт, борлуулалтын ажил гүйлгээг үнэ шилжүүлэлтийн тайланд тусгах үнэ шилжилтийн тайланд тодорхойлсон холбоотой талуудтай ижил байна. ➢ Тайлангийн хугацааны эхэнд холбоотой талын бүрэлдэхүүнд байсан ч тайлангийн хугацааны

	эцэстбүрэлдэхүүнээс хасагдсан эсвэл тайлангийн хугацааны дундуур бүрэлдэхүүнд багтсан харилцагч нарын ажил гүйлгээг тухайн хугацаанд ногдох хэсгээр тодорхойлно.
Удирдлагад тайлагнах зүйлс:	Холбоотой талуудын ажил, гүйлгээний талаар дараах зүйлсийг удирдлагад тайлагнана. <ul style="list-style-type: none"> ➤ Холбоотой талуудын бүрэлдэхүүн, холбоо хамаарал; ➤ Холбоотой талуудын хоорондын гарсан худалдан авалт, борлуулалт; ➤ Холбоотой талуудын төлөгдөөгүй хоорондын тооцооны тайлан үлдэгдэл; ➤ Холбоогүй талаас холбоотой талд нэмэгдсэн, хасагдсан харилцагч;

Холбоотой талуудын ажил гүйлгээний талаар санхүүгийн тайланд нэмж тодруулах мэдээлэл:

Компани жилийн эцсийн санхүүгийн тайланг бэлтгэж холбоотой талуудын талаарх дараах зүйлсийг нэмж тодруулна.

- Толгой компани болон түүний охин компаниудын хооронд ажил гүйлгээ гарсан эсэхээс үл хамааран тэдгээрийн хооронд харилцан хамаарал;
- Аж ахуй нэгж нь өөрийн толгой компанийн нэрийг, хэрэв хамгийн дээд хяналт тавигч тал нь уг толгой компаниас өөр бол түүний нэр;
- Эрх бүхий албан тушаалтны богино хугацааны тэтгэмж, ажил эрхлэлтийн дараах тэтгэмж, урт хугацааны тэтгэмж, ажлаас халагдсаны тэтгэмж, хувьцаанд суурилсан төлбөр;
- Санхүүгийн тайланг хамаарах тайлант хугацаанд холбоотой талуудын ажил гүйлгээ хийсэн тэрхүү үр нөлөөг ажил гүйлгээний дүн, төлөгдөөгүй үлдэгдлийн, үүний дотор хүлээсэн хариуцлага;
- Тодруулгыг дараах ангиллын дагуу тодруулна. Толгой компани, хамтын хяналттай эсвэл мэдэгдэхүйц нөлөөтэй, охин компаниуд, хамтын хувь оруулагч, хамтарсан үйлдвэр, тухайн аж ахуй нэгж болон толгой компанийн эрх бүхий албан тушаалтан, бусад холбоотой талууд;
- Холбоотой талуудын хоорондын авах авлага, төлөх өглөгийн дүн;
- Холбоотой талуудын хооронд хийгдсэн ажил гүйлгээний дүн: Барааны худалдан авалт, борлуулалт, үл хөдлөх хөрөнгө ба бусад хөрөнгийн худалдан авалт буюу борлуулалт, үйлчилгээ үзүүлсэн, үйлчилгээ хүлээн авсан, түрээс, судалгаа хөгжүүлэлтийн шилжүүлэлт, лицензийн гэрээний дагуу хийгдэх санхүүжилт, санхүүгийн хэлцэл арга хэмжээний дагуу хийгдэх, баталгаа барьцаа, холбоотой талын өмнөөс төлсөн өр төлбөрийн барагдуулалт;

4.24. Болзошгүй өр төлбөрийн нягтлан бодох бүртгэлийн бодлого

Болзошгүй өр төлбөрийн бүртгэлийн зорилго:

Болзошгүй өр төлбөрийн шинж чанар, цаг хугацаа ба дүнгийн талаар санхүүгийн тайлангийн мэдээлэл хэрэглэгчдийг хангах, түүнтэй холбоотой бүртгэх болох, тодруулагдах мэдээллийг тодорхойлох, удидамжаархангахад оршино.

Болзошгүй өр төлбөрийг үнэлж, бүртгэх:

Болзошгүй өр төлбөр гэдэг нь одоо өр төлбөр болоогүй боловч ирээдүйд өр төлбөр болох эсвэл болохгүй ч байж болох өр юм. Ирээдүйд гарч болзошгүй өр төлбөрийг урьдчилан тодорхойлж болох боловч, болзошгүй байдал нь тодорхой болсон үед л бүртгэлд тусгана. 1 буюу хэд хэдэн ирээдүйн үйл явдал гарах эс гарахаас аж ахуйн нэгж, байгууллагад учрах боломжит олз (болзошгүй олз) буюу гарзын (болзошгүй гарз) эцсийн шийдвэрлэлтийн тодорхойгүй байдал бүхий одоогийн нөхцөл, байдал буюу иж бүрэн нөхцөл байдлыг болзошгүй гэнэ.

Дараах нөхцөл биелсэн үед болзошгүй өр төлбөрийг бүртгэнэ.

- Өнгөрсөн үйл явдлаас үүссэн өнөөгийн боломжит үүрэг хариуцлага хүлээсэн бол;
- Тодорхой үүрэг хариуцлага хүлээж, түүнийг төлөх нөөцийн гадагш урсгал гарах болон төлөх магадлалтай бол;
- Найдвартай тооцоолол хийх боломжтой бол;

Дээрх нөхцөл бүрдээгүй бол компани өр төлбөрийг бүртгэхгүй.

Болзошгүй өр төлбөрийг санхүүгийн тайланд тусгах:

Компани болзошгүй өр төлбөрийг дараах тохиолдлыг ул үндэслэлтэй тодорхойлсны үндсэн дээр санхүүгийн тайланд тусгах, эс тусгах эсэхийг шийдвэрлэнэ.

Тохиолдлын үзүүлэлт	Магадлалын хувь	Санхүүгийн тайланд тусгах
Үүсэх магадлалтай бараг тодорхой	90 хүртэл	Өр төлбөрийг тайлагнана /нөөц/
Үүсэх магадлалтай	51-89 хүртэл	Өр төлбөрийг тайлагнана /нөөц/
Боломжтой гэхдээ магадгүй	10-50 хүртэл	Тодруулга хийнэ
Ялимгүй	10 хүртэл	Тодруулга хийх шаардлагагүй

Болзошгүй өр төлбөрийг хүлээн зөвшөөрч бүртгэх үед доорх бичилт хийж бүртгэлд тусгана.

Дт Болзошгүй өр төлбөрөөс үүссэн гарз


Кт Болзошгүй өр төлбөр

Болзошгүй өр төлбөрийн бүртгэл, тайлагналтай холбоотой санхүүгийн тайланд нэмж тодруулах мэдээлэл:

Компани жилийн эцсийн санхүүгийн тайланг бэлтгэж болзошгүй өр төлбөртэй холбоотой дараах зүйлсийг нэмж тодруулна.

- Болзошгүй өр төлбөрийн хэлбэр, хугацаа
- Болзошгүй үүрэг хариуцлага, түүний төрөл, ангилал, хугацаа
- Болзошгүй өр төлбөрийг төлөх хугацаа

Дараах диаграммын дагуу болзошгүй өр төлбөрт хамаарах стандартын хүлээн зөвшөөрөлтийн гол шалгууруудыг нэгтгэн дүгнэнэ.



4.25. Эрсдэлийн удирдлагын тайлагнал

Эрсдэлийн удирдлагын тайлагналын зорилго:

Эрсдэлийн удирдлагын тайлагнал нь компанийн эрсдэлийн удирдлагын тогтолцоо, санхүүгийн хэрэглүүрийн талаар санхүүгийн тайлангийн мэдээлэл хэрэглэгчдийг үнэн зөв мэдээллээр хангах зорилготой байна.

Компани санхүүгийн тайлангаар дамжуулан мэдээлэл хэрэглэгчдийг дараах мэдээллээр хангана:

- Компани үйл ажиллагааныхаа эрсдэлийг удирдах тогтолцоо
- Санхүүгийн хэрэглүүртэй холбоотой бусад мэдээлэл
 - Зээлийн эрсдэл ба түүний удирдлагын тогтолцоо
 - Зах зээлийн эрсдэл ба түүний удирдлагын тогтолцоо
 - Төлбөрийн чадварын эрсдэл ба түүний удирдлагын тогтолцоо

Үйл ажиллагааны эрсдэл-ийн удирдлагын тогтолцооны талаар санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулгын хэсэгт хүүрнэсэн эсвэл тоо мэдээлэл зэрэг хэрэглэгчдэд ойлгуулах энгийн аргаар тайлбарлах ба үүнд санхүүгийн шинжилгээний үр дүн байж болно.

Зээлийн эрсдэл ба түүний удирдлагын тогтолцоо:

Зээлийн эрсдэл гэдэг нь харилцагч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байх эрсдэл бөгөөд дараах зүйлсийг нэмэлт тодруулгаар тайлагнана.

- Тайлангийн хугацааны эцэс дэх зээлийн эрсдэлд өртөж болзошгүй санхүүгийн хөрөнгийн дээд хэмжээ (авлагын үлдэгдэл, бондоорх хөрөнгө оруулалт зэрэг харилцагч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд учрах эрсдэлтэй хөрөнгийн дээд хэмжээ)
- Зээлийн эрсдэлд өртөж болзошгүй хөрөнгүүдийн төвлөрөл (авлагын үлдэгдэл, бондоорх хөрөнгө оруулалт зэрэг харилцагч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд учрах эрсдэлтэй хөрөнгийн төвлөрлийг харуулах ба эдгээрээс найдваргүй гэж үзсэн хэсэг, холбоотой талаас авах авлага гэх мэт)
- Зээлийн эрсдэлд өртөж болзошгүй хөрөнгүүдийн баталгаа (гэрээний үүргийн баталгаа буюу барьцаа, батлан даалт, эдгээрийн үнэлгээ)
- Зээлийн эрсдэлээс сэргийлэх удирдлагын тогтолцоо

Зах зээлийн эрсдэл ба түүний удирдлагын тогтолцоо:

Зах зээлийн эрсдэл гэдэг нь гадаад хүчин зүйл буюу зах зээлийн нөхцөл байдлаар үүсэн учирч болохыг эрсдэл юм. СТОУС-ын дагуу компани зах зээлийн эрсдэлтэй холбоотой дараах зүйлсийг санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулгаар тайлагнана.

- Гадаад валютын ханшийн эрсдэл буюу санхүүгийн тайлангаарх гадаад валютаар илэрхийлэгдсэн санхүүгийн хэрэглүүрийн тоо хэмжээ, цэвэр үлдэгдэл;
- Хүүгийн түвшний эрсдэл буюу зах зээл дээрх бодлогын хүү, инфляци зэрэг эдийн засгийн орчинтой уялдуулан тооцох хөвөгч хүүтэй санхүүгийн хэрэглүүр, тэдгээрийн өртөх магадлал;
- Бодит үнэ цэнийн эрсдэл буюу бодит үнэ цэнээр илэрхийлэгдэх санхүүгийн хэрэглүүр, бусад хөрөнгө, өр төлбөрүүдийн бодит үнэ цэнийн үнэлгээний зах зээлийн түвшний мэдээлэл;
- Зах зээлийн эрсдэлээс сэргийлэх удирдлагын тогтолцоо;

Төлбөрийн чадварын эрсдэл ба түүний удирдлагын тогтолцоо:

Төлбөрийн чадварын эрсдэл гэдэг нь өрийн хэрэглүүрийн эргэн төлөлтөөс үүсдэг эрсдэл юм. СТОУС-ын дагуу компани төлбөрийн чадварын эрсдэлтэй холбоотой дараах зүйлсийг санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулгаар тайлагнана.

- Санхүүгийн тайлангаарх санхүүгийн хөрөнгийн төлбөр гүйцэтгэхэд бэлэн байх хугацаа, өр төлбөрийн төлбөр гүйцэтгэх хугацаа;
- Төлбөрийн чадварын эрсдэлээс сэргийлэх удирдлагын тогтолцоо;

4.26. Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн бодлого

1. Нэгтгэлийн ерөнхий бодлого:

Нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэхэд дараах бодлогыг баримтална.

- Нягтлан бодох бүртгэлийн бодлого: Санхүүгийн тайланг бэлтгэхэд болон толилуулахад мөрддөг аж ахуй нэгжийн гаргасан тусгай дүрэм, журам, практик үйл ажиллагаа: (НББОУС-8 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, тооцооллын өөрчлөлт, алдаа)
- Нэгтгэл тайланг бэлтгэхдээ нэгтгэлд оролцогч компани бүрийг тодорхойлно. Нэгтгэл тайланд оролцогч компанийн Санхүүгийн тайлагнал үнэн зөв, зэрэгцүүлэгдэх боломжтой тайлагнасан байна.
- Нэгтгэл тайланг бэлтгэхдээ “Тэнгэрлиг Медиа Групп” ХК нэгтгэсэн тайланг бэлтгэх бодлого, нэмэлтээр 2015 оны 06 сарын 29-ний өдөр гаргасан 170 дугаар Сангийн сайдын тушаалтай Нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэх заавар аргачлал, СТОУС-3 Бизнесийн нэгдэл, НББОУС-28 Хараат компани дахь хөрөнгө оруулалт, СТОУС-10 Нэгтгэсэн санхүүгийн тайлан дараах Олон Улсын Стандартыг баримтлах
- “Тэнгэрлиг Медиа Групп” ХК нь нэгтгэсэн тайланг улирал бүр гаргана. 1-р улирлын тайланг тухайн жилийн 05 сарын 01-ний дотор, 2-р улирлын тайланг 08 сарын 01-ний дотор, 3-р улирлын тайланг 11 сарын 01-ний дотор, жилийн эцсийн тайланг 2 сарын 28-ны дотор бэлтгэнэ.

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн зорилго:

Энэхүү бодлогын зорилго нь нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэх шаардлагыг хангасан толгой компани нь өөрийн охин компаниудын тус тусдаа бэлтгэсэн санхүүгийн тайлангуудыг нэгтгэх, хараат компани болон хамтарсан үйлдвэрт оруулсан хөрөнгө оруулалтаа тохируулж нэгтгэх замаар нэгтгэсэн санхүүгийн бэлтгэх удирдамжаар хангана.

Өөрөө нэг ба түүнээс дээш охин компанитай, эдгээр охин компаниуд нь нэг ба түүнээс дээш охин компанитай гэх мэтээр үргэлжилсэн зохион байгуулалттай компанийн хамгийн сүүлчийн толгой компанийг **эцсийн толгой компани**, дээрээ толгой компанитай боловч өөрөөсөө салбарласан охин компанитай компанийг **завсрын толгой компани** гэнэ. Эцсийн толгой компани нь гадаад улсад байрладаг бол Монгол улсад бүртгэгдсэн хамгийн сүүлчийн толгой компанийг эцсийн толгой компани гэж үзнэ.

Дараах нөхцөлийн хангасан толгой компани нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэхгүй:

Доорх бүх нөхцөлийг зэрэг хангаж байгаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8.3 заасан Монгол улсад бүртгэлтэй охин компаниудын доторх дээд шатны толгой компаниас бусад толгой компани;

- Өөр аж ахуй нэгжийн охин компани болох засварын толгой компанийн саналын эрхтэй ба саналын эрхгүй бүх хувьцаа эзэмшигчид нэгтгэсэн санхүүгийн тайланг гаргахгүй гэж мэдэгдсэн бол
- Толгой компани өөрийн гаргасан өрийн болон өмчийн хэрэглүүрээ нээлттэй зах зээлд байршуулсан арилжаалдаггүй бол
- Толгой компани нь нээлттэй зах зээлд санхүүгийн хэрэглүүр гаргах зорилгоор үнэт цаасны хороо эсвэл бусад зохицуулагч байгууллагад бүрдүүлж өгөөгүй бол

2. Нэгтгэл тайлангийн оролцогчид:

Нэгтгэлд оролцогчдыг тодорхойлохдоо Толгой компани оролцооны шинж чанар үл хамааран хяналтын загвар байдлаар нэгдэгчийг тодорхойлно.

- Санхүүжигч дэх эрх мэдэл
- Санхүүжигч дэх хувь оролцооноосоо хувьсах өгөөж хүртэх эрх эсвэл боломжтой байх


- Тухайн санхүүжигч дэх эрх мэдлээ ашиглан хөрөнгө оруулагчийн үр өгөөжид нөлөөлөх чадвар

Эрх мэдэл	Өгөөж	Эрх мэдэл болон өгөөжийн хамаарал
Тодохойлолт:		
Санхүүжигчийн өгөөжид мэдэгдэхүйц нөлөө үзүүлдэг үйл ажиллагааг удирдан чиглүүлэх одоогийн чадвар	Хувьсах өгөөж хүртэх эрхтэй эсвэл боломжтой байх	Эрх мэдлээ ашиглан санхүүжигчийн өгөөжид нөлөөлөх чадвар
Илрэх хэлбэр:		
<ul style="list-style-type: none"> > Саналын эрх > Боломжит саналын эрх > Удирдлагыг томилох эрх > Шийдвэр гаргах эрх > Үйлажиллагаанаас гаргах эрх > Хамгаалалтын эрх биш 	<ul style="list-style-type: none"> > Ногдол ашиг > Урамшуулал > Хэмжээнээс хамаарах эдийн засаг, өртөг хэмнэлт > Бусад хувь оролцоог эзэмшигчдэд хуваарилагдахгүй өгөөж 	<ul style="list-style-type: none"> > Шилжүүлсэн эрх > Эрх мэдлийн хамрах хүрээ > Бусад талуудын эзэмшиж буй эрхүүд > Урамшуулал > Бусад ашиг сонирхолд өртөх
Асуудал	Тайлбар, хэмжигдэхүүн	
Санхүүжигчийн хэв шинж, зорилго	Санхүүжигчийн хэв шинж, зорилгыг үндсэндээ дараах 2 төрөлд ангилж болно. Үүнд: <ul style="list-style-type: none"> > Шийдвэр гаргалтад нөлөөлдөг гэрээ хэлэлцээр, хувь тэнцүү байдлаар санхүүгийн болон үйл ажиллагаанд бодлого тогтоох > Шийдвэр гаргалтад нөлөөлдөг гэрээ хэлэлцээр, болзошгүй эрсдэл болон эдгээр эрсдэлээс хөрөнгө оруулагчдын үүрэг хариуцлагыг тооцох 	
Холбогдох үйл ажиллагааны шийдвэр гаргалт	Ихэнх санхүүжигчийн хувьд үндсэн болон санхүүжилтийн үйл ажиллагаа нь тэдний өгөөжид мэдэгдэхүйц нөлөөлөх үйл ажиллагаа байдаг. Санхүүжигчийн өгөөжид мэдэгдэхүйц нөлөөлдөг үйл ажиллагааг холбогдох үйл ажиллагаа гэж ойлгоно.	
Хөрөнгө оруулагчийн эрх, удирдан чиглүүлэх	Хөрөнгө оруулагчдад эрх мэдэл өгдөг тусгайлсан эсвэл нийт дундын эрх байж болно.	
Санхүүжигч дэх оролцооноосоо хувьсах үр өгөөж хүртэх эрх эсвэл боломж байгаа эсэх	Хувьсах өгөөж гэдэг нь тогтмол бус, санхүүжигчийн үр дүнгээс хамаараад өөрчлөгдөж болох өгөөж юм. Тэгэхээр уг өгөөж нь эерэг, сөргийн аль аль нь байж болно.	
Хөрөнгө оруулагч нь тухайн санхүүжигч дэх эрх мэдлээ ашиглан хөрөнгө оруулагчийн үр өгөөжийн дүнд нөлөөлөх чадвартай эсэх	Шийдвэр гаргагч нь санхүүжигчид хяналттай эсэхээ тогтоохдоо өөрийгөө хэлэлцээрт оролцогч эсвэл агентын аль нь болохоо тодорхойлох нь чухал. Учир нь агент нь шийдвэр гаргах эрх мэдлээ ашиглах үедээ санхүүжигчид хяналтгүй байдаг. Агент нь эрх мэдлээ ашиглан санхүүжигчийн үр өгөөжид нөлөөлөх боломжгүй, харин үндсэн оролцогч тал нь тийм боломжоор хангагддаг.	
Санхүүжигчийн бусад талуудтай байгуулсан харилцааны мөн чанарыг нь авч үзэх	Хяналтыг үнэлэхдээ хөрөнгө оруулгч нь бусад талтай байгуулсан харилцаа холбооны мөн чанар, тэдгээр тал нь уг хөрөнгө оруулагчийн нэрийн өмнөөс ажиллаж байгаа эсэх (өөрөөр хэлбэл жинхэнэ агент эсэх)-ийг авч үзнэ.	

3. Нэр томъёоны тайлбар

- **Толгой компани:** Цаашид “Тэнгэрлиг Медиа Групп” ХК гэж ойлгох нэг ба түүнээс дээш түүнээс дээш аж ахуй нэгжид хяналт тавьдаг аж ахуй нэгж
- **Охин компани:** Цаашид Толгой компанийн хяналтад байгаа аж ахуйн нэгж,
- **Хяналтын бүс хувь оролцоо:** Толгой компанийн шууд эсвэл шууд бусаар хамаарахгүй, охин компанийн өмч (цөөнх жижиг хувьцаа эзэмшигч нарын толгой компани эзэмшээгүй өмч)
- **Хараат компани:** Цаашид хараат компани буюу мэдэгдэхүйц нөлөөлөл ойлгоно. Тайлагнагч аж ахуйн нэгжийн мэдэгдэхүйц нөлөөтэй аж ахуй нэгж
- **Хөрөнгө оруулалтын аж ахуйн нэгж:**
 - (i) хөрөнгө оруулалтын удирдлагын үйлчилгээ үзүүлэх зорилгоор нэг эсвэл хэд хэдэн хөрөнгө оруулагчаас сан бүрдүүлж хүлээн авсан;
 - (ii) капиталын үнэ цэнийн өсөлт, хөрөнгө оруулалтын ашгаас өгөөж хүртэх зорилгоор сангаар хөрөнгө оруулалт хийхийг бизнесийн зорилгоо болгохыг хөрөнгө оруулагчдаа даалгадаг;
 - (iii) үндсэндээ бүх хөрөнгө оруулалтынхаа гүйцэтгэлийг бодит үнэ цэнийн сууриар хэмжиж үнэлдэг аж ахуйн нэгж.
- **Групп:** Толгой компани болон түүний охин компаниуд
- **Хяналт:** Хөрөнгө оруулагч тал санхүүжигч дэх оролцооноосоо хувьсах өгөөж хүртэх эрхтэй эсвэл боломжтой бол, мөн санхүүжигч дэх өөрийн эрх мэдлээрээ дамжуулан тухайн өгөөжид нөлөөлөх чадвартай бол санхүүжигчид хяналттай байна.
- **Хамтын хяналт:** Гэрээний дагуу зөвшөөрсөн хэлэлцээрийн хяналтыг хамтран эзэмших явдал бөгөөд энэ нь зөвхөн холбогдох үйл ажиллагааны талаар гаргах шийдвэрийн дагуу хяналтыг хамтран эзэмшихээр оролцогч талууд санал нэгтгэй зөвшөөрсөн тохиролцоо байхыг шаардсан тохиолдолд л оршин байна.
- **Мэдэгдэхүйц нөлөөлөл:** Санхүүжигчийн санхүүгийн болон үйл ажиллагааны бодлогын талаар шийдвэр гаргахад оролцох эрхтэй тэдгээр бодлогыг дангаараа эсвэл хамтран хянах эрхгүй байхыг хэлнэ.
- **Нэгтгэх арга:** Толгой компанийн хөрөнгө, өр төлбөр, эздийн өмч, орлого, зардал, мөнгөн гүйлгээг түүний охин компани тус бүрийн тэдгээр үзүүлэлтүүдтэй мөрийн дагуу нэмэх замаар эдийн засгийн нэг нэгж мэтээр үзэж нэгтгэх арга.
- **Өмчийн арга:** Өмчийн арга гэдгийг хөрөнгө оруулалтыг анхлан зөвшөөрөхөд өртгөөр нь, санхүүжигчийн цэвэр хөрөнгийн хөрөнгө оруулагчийн хувийн өөрчлөлт өмнөх эзэмшлийн дараа залруулга хийх бүртгэлийн аргыг өмчийн арга гэж тодорхойлсон. Хөрөнгө оруулагчийн ашиг, алдагдалд санхүүжигчийн ашиг, алдагдал багтана. Мөн хөрөнгө оруулагчийн бусад дэлгэрэнгүй орлогод санхүүжигчийн бусад дэлгэрэнгүй орлогын хувь багтана.
- **Нэгтгэсэн санхүүгийн тайлан:** Толгой компани ба түүний охин компаниудын хөрөнгө, өр төлбөр, эздийн өмч, орлого, зардал, мөнгөн гүйлгээг нэг эдийн засгийн нэгж мэтээр үзэж, хэрвээ толгой компани нь худалдан авах хэлбэрээр охин компанийг өөрийн хяналтандаа оруулсан бол, худалдан авалтын аргын дагуу санхүүгийн тайлангийн холбогдох үзүүлэлтүүдийг тохируулж нэгтгэн толилуулсан группийн санхүүгийн тайланд хараат компани болон хамтарсан үйлдвэрт оруулсан хөрөнгө оруулалтаа өмчийн аргаар тохируулж Нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэнэ.

4. Нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэх дараалал:



Групп доторх аж ахуй нэгжүүд хоорондын ажил гүйлгээг устгах бичилт:

- Компани хоорондын орлого зардал (хураамжийн орлого, түрээсийн орлого, менежмент орлого, хүүний орлого, цалингийн зардал, түрээс зардал, менежментийн зардал, элэгдлийн зардал, бусад зардал устгах)

Дт Компани хоорондын борлуулалтын орлого, хүүний орлого

Кт Компани хоорондын үйл ажиллагааны зардал

Кт Компани хоорондын борлуулалтын өртөг

- Компани хоорондын эргэлтийн бус хөрөнгө үндсэн хөрөнгийн ажил гүйлгээ, хоорондоо борлуулсан, худалдан авалтыг устгах бичилт:

Дт Үндсэн хөрөнгө борлуулсны олз

Дт Үндсэн хөрөнгө (борлуулсан тал буцаан хөрөнгөө авна)

Кт Үндсэн хөрөнгө (Худалдан авсан хөрөнгөө буцаан өгнө)

Кт Үндсэн хөрөнгө борлуулсны гарз

Кт Хуримтлагдсан элэгдэл (Борлуулагч тал буцаан авсан хөрөнгийн элэгдэл)

- Компани хоорондын өр, авлага, зээл, бондын өрийн үлдэгдлийг устгах бичилт:

Дт Компани хоорондын өр төлбөр

Дт Компани хоорондын зээл (зээл авсан, төлөгч)

Кт Компани хоорондын авлага

Кт Компани хоорондын зээлийн авлага (зээл олгосон хүлээн авагч)

Хувь нийлүүлсэн хөрөнгө гэдэгт охин компани тус бүрийн тайлант үеийн эцэст дэх хувийн өмч, нэмж төлөгдсөн капитал, бусад дэлгэрэнгүй орлого, нэмэгдэл нөөц сан, хуримтлагдсан ашгийг хамруулна.

- Охин компанид оруулсан хөрөнгө оруулалт нь толгой компанийн өмнөх тайлант үеийн эцсийн үлдэгдлээрх нийтлэг зориулалттай тусдаа санхүүгийн тайланд тусгасан дүн юм. Охин компанид оруулсан хөрөнгө оруулалтыг устгах бичилт:

Дт Энгийн хувьцаа (охин компани)

Дт Нэмж төлөгдсөн капитал (охин компани)

- Дт Бусад эздийн өмчийн хэсэг (охин компани)
- Дт Хуримтлагдсан ашиг
- Дт Гүүдвил (эерэг гүүдвил үүссэн)
 - Кт Охин компани оруулсан хөрөнгө оруулалт (Толгой компани)
 - Кт Хяналтын бус хувь оролцоо (охин компанид ногдох жижиг хувьцаа эзэмшигчдийн дүн)
 - Кт Худалдан авалтын олз (сөрөг гүүдвил)
- Охин компанийн тайлант жилийн ашиг, алдагдал, өмчийн бусад дүн өөрчлөлт орсон үед- хяналтын бус хувь оролцоонд ногдох хэсэг хамаарна.
 - Дт Цэвэр ашиг
 - Дт Нөөц, нэмэгдэл, бодит үнэ цэнийн нөөц
 - Дт Хяналтын бус хувь оролцоо (ашиггүй, өмчийн дүн бууралттай үед)
 - Кт Цэвэр алдагдал
 - Кт Хяналтын бус хувь оролцоо (ашигтай, өмчийн дүн өсөлттэй үед)
- Толгой компани нь охин компанийн хөрөнгө оруулалтыг бодит үнэ цэнээр хэмжиж, бодит үнэ цэнийн нөөц үүсгэсэн үед:
 - Дт Охин компани дахь хөрөнгө оруулалт
 - Кт Хөрөнгө оруулалтын үнэ цэнийн нөөц (гарзтай үед)
 - Дт Хөрөнгө оруулалтын үнэ цэнийн нөөц (олзтой үед)
 - Кт Охин компани дахь хөрөнгө оруулалт
 - Дт Хойшлогдсон татварын өр
 - Кт Охин компани дахь хөрөнгө оруулалт
- Охин компани толгой компанийн хувьцааг эзэмшиж байгаа үед (Хэрвээ охин компани Ард Санхүүгийн нэгдэл ХК хувьцааг эзэмшсэн бол тайлант үеийн эцсийн үлдэгдэл хувьцааг)
 - Дт Халаасны хувьцаа (Ард Санхүүгийн нэгдэл хувьцааны нэрлэсэн үнэ*халаасны хувьцаа тоо)
 - Дт Нэмж төлөгдсөн капитал- нэрлэсэн үнээс илүү давсан дүнгээр
 - Кт Хөрөнгө оруулалт (охин компани данс)
- Хараат компани дахь хөрөнгө оруулалтыг тохируулах, хараат компани дахь өмчийн өөрчлөлтийн нөлөөг эзэмшлийн хувь оролцоогоор дансыг тохируулах, Хараат компани дахь хөрөнгө оруулалт 20%-иас дээш компани ойлгоно.
 - Дт Хараат компани дахь хөрөнгө оруулалт
 - Кт Хөрөнгө оруулалтын орлого
 - Дт Хөрөнгө оруулалтын алдагдал
 - Кт Хараат компани дахь хөрөнгө оруулалт
- Хараат компани ногдол ашиг олгосон бол:
 - Дт Мөнгөн хөрөнгө, Ногдол ашгийн авлага (ногдол ашиг хүлээн авсан үед авлагыг хаах)
 - Кт Хараат компани дахь хөрөнгө оруулалт
- Хараат компани дахь нөөц сан, нэмэгдэл, бусад өмчийн дүн өөрчлөгдсөн үед:
 - Дт Хараат компани дахь хөрөнгө оруулалт
 - Кт Эздийн өмчийн бусад хэсэг
 - Дт Эздийн өмчийн бусад хэсэг
 - Кт Хараат компани дахь хөрөнгө оруулалт
- Хэрэв НББОУС-12 Орлогын Албан Татварын дагуу Хөрөнгө оруулалтын үнэлгээ болон бусад нөлөөллөөс хойшлогдсон татварын өр төлбөр, хөрөнгө үүсгэж болох гүйлгээ гарсан үед хойшлогдсон татварын өр төлбөр, хөрөнгийг устгах бичилт:
 - Дт Хойшлогдсон татварын өр
 - Кт Хөрөнгө оруулалт
 - Дт Хөрөнгө оруулалт
 - Кт Хойшлогдсон татварын хөрөнгө

Бизнесийн нэгдлийн үр дүнд бий болсон группийн нэгжийг нэгтгэх:

Хэрвээ бизнесийн нэгдлийн үр дүнд толгой ба охин компанийн харилцаанд орсон бол бизнесийн нэгдлийн өдөр болон бизнесийн нэгдлээс хойших тайлант үеүдэд нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэх шаардлагатай. Ийм хэлбэрээр бий болсон толгой ба охин компанийн санхүүгийн үзүүлэлтүүдийг нэгтгэхдээ худалдан авалтын аргыг ашиглана. Бизнесийн нэгдлийн өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэхдээ толгой компанийн нийтлэг зориулалттай тусдаа санхүүгийн тайлан -ийн үзүүлэлтүүдийг охин компанийн нийтлэг зориулалттай тусдаа санхүүгийн тайлан гийн үзүүлэлтүүдтэй мөр мөрийн дагуу нэмэх байдлаар нэгтгэхдээ худалдан авалтын аргыг дараах байдлаар ашиглана:

- Нэгтгэгч талыг тодорхойлох: нэг ба түүнээс дээш аж ахуйн нэгжийг өөртөө нэгтгэсэн буюу хяналтандаа оруулж байгаа аж ахуйн нэгж, өөрөөр хэлбэл тухайн бизнесийн нэгдэлд давуу эрхтэй оролцож байгаа тал. Харин тухайн бизнесийн нэгдэлд оролцож байгаа нэгтгэгчээс бусад талыг нэгдэгч гэж үзнэ.
- Худалдан авалтын огноог тодорхойлох: нэгтгэгч тал нь нэгдэгч талд хяналтаа тогтоосон өдөр
- Худалдан авч эзэмшсэн тодорхойлогдох хөрөнгө, тооцоолсон өр төлбөр болон нэгдэгч тал дахь хяналтын эрхгүй хувь оролцоог хүлээн зөвшөөрөх ба хэмжих: өөр аж ахуйн нэгжийн хяналтанд орсон аж ахуйн нэгжийн буюу нэгдэгчийн цэвэр хөрөнгийн зах зээлийн үнийг бизнесийн нэгдлийн өдрөөр үнэлэх ба бизнесийн нэгдэлд нэгдэгч талыг цэвэр хөрөнгийн зах зээлийн үнээр нэгдэхийг шаарддаг. Ийнхүү нэгдэгчийг нэгдлийн өдрөөр цэвэр хөрөнгийн зах зээлийн үнээр нэгтгэсэн гэдгийг илэрхийлэх хэлбэр нь нэгдлийн өдрөөр бэлтгэгдэж байгаа нэгтгэсэн санхүүгийн тайланд устгах бичилтээр нэгдэгчийн цэвэр хөрөнгийн зах зээлийн болон дансны үнийн зөрүүг тохируулж өгдөг.
- Мөн бизнесийн нэгдлийн өдрөөр нэгдэгч тал дахь аливаа хяналтын эрхгүй хувь оролцоо эзэмшигчид байгаа бол тэр өдрөөрх хяналтын эрхгүй хувь оролцоог эзэмшигчдийн хувь оролцоо (100% - толгой компанийн хувь эзэмшил %)-г тодорхойлж, цэвэр хөрөнгө дэх хяналтын эрхгүй хувь оролцоо (нэгдлийн өдрөөрх нэгдэгчийн цэвэр хөрөнгийн зах зээлийн үнэ*хяналтын эрхгүй хувь оролцоог эзэмшигчдийн хувь эзэмшил %)-г нэгдлийн өдрийн Нэгтгэсэн санхүүгийн тайланд устгах бичилтээр хүлээн зөвшөөрнө.
- Тохиролцоот худалдан авалтаас үүсэх олз буюу гүүдвилийг хүлээн зөвшөөрөх ба хэмжих: бизнесийн нэгдлийн өдрийн толгой компанийн охин компанид оруулсан хөрөнгө оруулалтын дүнгээс охин компанийн тодорхойлогдох цэвэр хөрөнгийн бодит үнэ цэнээс толгой компанийн эзэмшлийн хувиар үржүүлсэн дүнг хассан зөрүүгээр гүүдвилийн анхны хүлээн зөвшөөрөх дүнг тодорхойлно. Хэрвээ энэ зөрүү нь эерэг утгатай бол нэгдлийн өдрийн нэгтгэсэн санхүүгийн тайланд “Гүүдвил” буюу биет бус хөрөнгөөр устгах бичилтийн горимоор хүлээн зөвшөөрнө. Харин үүссэн зөрүү нь сөрөг утгатай гарсан бол нэгдлийн өдрийн толгой компанийн нийтлэг зориулалттай тусдаа санхүүгийн тайланд “Худалдан авалтын олз”-р хүлээн зөвшөөрч, охин компанид оруулсан хөрөнгө оруулалт дансаа сөрөг гүүдвилийн дүнгээр хасаж тохируулна. СТОУС 3 “Бизнесийн нэгдэл”-д аливаа холбогдох гүүдвилийг хэрхэн тайлагнахыг тайлбарласан.)

6. Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн дансны төлөвлөгөө

Нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэх дансны кодлол нь 4 оронтой байх бөгөөд энэ кодлол нь зөвхөн группийн нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэх кодлол болно.

Кодлолын ангилал:

- Эргэлтийн хөрөнгө
- Эргэлтийн бус хөрөнгө
- Богино болон урт хугацаат өр төлбөр

Кодлол:

1000-1999
2000-2999
3000-3999

• Өөрийн хөрөнгө буюу эздийн өмчийн хэсэг	4000-4999
• Борлуулалтын орлого ба бусад нэмэлт орлого	5000-5999
• Үйлчилгээ болон хөрөнгийн өртөг	6000
• Үйл ажиллагаа болон нэмэлт зардлууд	7000-7999
• Гадаад валютын ханшийн зөрүүгийн олз, (гарз)	8000
• Хөрөнгө оруулалт данснаас хассаны олз, (гарз)	8100
• Биет хөрөнгө данснаас хассаны олз, (гарз)	8200
• Болзошгүй эрсдэлийн сангийн зардал	8300
• Орлогын албан татварын зардал	9000
• Цөөнхийн хувь оролцооны зардал	9100

“Тэнгэрлиг Медиа Групп” ХК охин компани хоорондын ажил гүйлгээг хянах, мэдээлэх чадварыг сайжруулах зорилгоор:

1. Охин компанийн авлага, өглөг
2. Охин компанийн олгосон зээл
3. Охин компаниас авсан зээл
4. Охин компанид хийсэн борлуулалт жишээ нь түрээс, менежмент, бусад орлого
5. Охин компаниас авсан үйлчилгээ зардал гэсэн данснуудаар дансны төлөвлөгөөг бэлтгэн ашиглана.

4.27. Цалин хөлсний бүртгэлийн бодлого

Хүлээн зөвшөөрөлт ба үнэлгээ

“Тэнгэрлиг медиа групп” ХК нь цалингийн бүртгэлийг аккруэл зарчмаар хөтөлдөг байна. Өөрөөр хэлбэл тайлант хугацаа бүрийн эцэст ажиллагсдад олговол зохих цалин хөлсийг зардалд шингээж өглөгөөр хүлээн зөвшөөрдөг.

Цалин хөлсний хэмжээг Монгол улсын Хөдөлмөрийн хууль болон ажил олгогч, ажилтан хоёрын тохиролцон байгуулсан Хөдөлмөрийн гэрээн дээр үндэслэн тогтоож, гүйцэтгэх захирлын тушаалаар баталж мөрддөг.

Цалин хөлсний бүрэлдэхүүн

Компаний ажилчдад олгох цалин хөлс нь үндсэн болон нэмэгдэл цалингаас бүрдэнэ. Үндсэн цалин нь тухайн ажилтны гүйцэтгэсэн ажил, ажилласан цагт суурилан тооцоолсон цалин, харин нэмэгдэл цалин нь илүү цаг, амралт баяр ёслолын өдөр ажилласны хөлс, удаан жил ажилласны нэмэгдэл, үр дүнгийн гэх мэт шагнал урамшууллаас бүрддэг.

Цалин хөлсний суутгал

Ажилчдын цалингаас хувь хүний орлогын албан татвар болон эрүүл мэнд нийгмийн даатгалын шимтгэлийг хуульд заасан хувиар тооцож суутгана. Мөн байгууллага өөрөө төлөх эрүүл мэнд нийгмийн даатгалын шимтгэлийг 12%-аар тооцож хуримтлуулан бүртгэнэ.

Эрүүл мэнд нийгмийн даатгалын шимтгэл:

Нийгмийн даатгалын тухай хуулийн дагуу байгууллага хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа ажилчин албан хаагчид нийгмийн даатгалд заавал даатгуулах ёстой. Байгууллага нь албан хаагчдын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогыг зөв тодорхойлж, түүнд ногдох шимтгэлийг хуульд заасан хувь хэмжээгээр тооцож, нийгмийн даатгалын санд сар бүр төлж, тайланг дараа сарын 5-ны дотор харъяа нийгмийн даатгалын байгууллагад өгнө.

Хувь хүний орлогын албан татвар:

Хуьт хүний орлогын албан татварын хуулийн дагуу байгууллага нь ажилчдад олгосон дор тодорхойлсон орлогын жилийн дүнд 10 хувиар тооцож албан татвар ноогдуулан суутгаж авна.

Татварт ногдох орлогыг тодорхойлохдоо тооцоолсон нийт цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын дүнгээс нийгмийн даатгалын шимтгэлийг хасч тооцно. Албан татварын хэмжээг тооцсоны дараа Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 24.1-д заасны дагуу жилд 84,000 төгрөг, сар бүр 7,000 төгрөгийн татварыг чөлөөлнө.

Энэхүү суутган авсан албан татварыг дараа сарын 10-ны дотор харъяа татварын байгууллагын дансанд шилжүүлнэ. Албан татварын улирлын тайланг дараа улирлын эхний сарын 20-ны дотор өссөн дүнгээр гаргаж тушаана.

Ажилчидтай хийх тооцоо:

Энэ нь ажилчдын байгууллагаас авсан урьдчилгаа, хөрөнгийн дутагдал болон бусад авлагыг тооцож суутгал хийнэ.

Бусад нэмэгдэл, шангал, олговор, тэтгэмж

Компани нь ажиллагсадын ажлын үр дүнд тооцон олгох шангал, урамшуулал болон ажилласан жилийн нэмэгдлийг компанийн дотоод журам, хөдөлмөрийн гэрээндээ заасны дагуу олгоно.

Ээлжийн амралтын олговор:

Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу байгууллага нь ээлжийн амралтын хуваарийг тухайн жилийн эхний улиралд багтаан байгууллагын даргын тушаалаар батлуулах бөгөөд

ажилчдад ээлжийн амралтыг жилд багтаан заавал биеэр эдлүүлнэ. Ээлжийн амралтын хуваарийг гаргахдаа ажилтны саналыг үндэслэн байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүйгээр зохицуулна.

Ажилтны ээлжийн амралтын үндсэн хугацаа нь 15 хоног байх бөгөөд ажилласан жил, ажлын нөхцөлийг харгалзан амралтын нэмэгдэл хоногийг тооцож олгоно. Үүнд:

№	Ажилласан жил	Нэмэгдэл амралтын хоног	
		Хэвийн нөхцөл	Хэвийн бус нөхцөл
1	5 жил хүртэл	0	0
2	6-10 жил	3	5
3	11-15 жил	5	7
4	16-20 жил	7	9
5	21-25 жил	9	12
6	26-31 жил	11	15
7	32 түүнээс дээш жил	14	18

Ээлжийн амралтын олговрыг тооцохдоо амралт олгохоос өмнөх 12 сарын цалинд үндэслэн нэг өдрийн дундаж цалинг тодорхойлоод түүнийг ээлжийн амралтын өдрөөр үржүүлж тооцоолно. Ээлжийн амралтын үргэлжлэх хугацаанд жирэмсний болон амаржсаны амралт, хөдөлмөрийн чадвар түр алдсан, ажил олгогчоос олгосон албан ёсны чөлөөтэй хугацааг оруулахгүй.

Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж:

Ажилтан нь ердийн өвчин болон ахуйн ослын улмаас хөдөлмөрийн чадвараа түр алдсан бөгөөд хөдөлмөрийн чадвар түр алдахаас өмнөх 3 ба иүүнээс дээш сар тэтгэмжийн даатгалын шимтгэл төлж ажилласан тохиолдолд энэхүү тэтгэмж авах эрх үүснэ.

Хөдөлмөрийн чадвар түр алдсан эхний 5 хоногийн тэтгэмжийг байгууллагаас, 6 дахь өдрөөс хойших тэтгэмжийг нийгмийн даатгалын сангаас олгоно. Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэмж олгох нэг удаагийн дээд хязгаар нь хорт хавдар, сүрьеэгээр анх өвчилсөн тохиолдолд 132 хоног, бусад тохиолдолд 66 хоногоос хэтрэхгүй байна. Жилд удаа дараа өвдсөн тохиолдолд жилд 132 хоногоос илүүгүй хугацаагаар тэтгэмж олгох бөгөөд тэтгэмж авсны дараа 3 сараас доошгүй хугацаагаар шимтгэл төлж ажилласан тохиолдолд дахин тэтгэмж авах эрх үүснэ.

Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг даатгуулагчийн шимтгэл төлж ажилласан хугацааг харгалзан түүний сүүлийн бүтэн ажилласан 3 сарын цалингийн дунджаас доорх хэмжээгээр бодож олгоно.

Шимтгэл төлж ажилласан хугацаа	Тэтгэмж бодох хувь
5 хүртэл жил	45
5-14 жил	55
15 түүнээс дээш жил	75

Жирэмсний болон амаржсаны тэтгэмж:

Жирэмсний чөлөө авахаас өмнө 12 сараас доошгүй хугацаанд, үүнээс сүүлийн 6 сард нь уг шимтгэлийг тасралтгүй төлсөн даатгуулагч эх жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах эрхтэй. Ажилтан эхэд жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг тэтгэмжийн даатгалын шимтгэл төлсөн сүүлийн 12 сарын хөдөлмөрийн хөлсний сарын дунджаас 100 хувиар тооцож 4 сарын хугацаанд нийгмийн даатгалын сангаас олгоно. Тэтгэмжийг ажлын өдрөөр тооцож олгоно.

Цалин хөлстэй холбогдох дансны бичилтүүд

- Цалингийн урьдчилгаа тавьж олгосон үед:
- Дт Цалингийн урьдчилгаа
- Кт Мөнгөн хөрөнгө

- Цалинг тооцоолох үед:
Дт Цалингийн зардал
Кт Цалингийн тооцоо
- Цалингаас татвар болон урьдчилгааг суутгах үед:
Дт Цалингийн тооцоо
Кт НДШ-ийн өр
ХХОАТ-ын өр
Цалингийн урьдчилгаа
- Ажил олгогчийн НДШ-ийн зардлыг тооцож бүртгэх үед:
Дт НДШ-ийн зардал
Кт НДШ-ийн өр
- Тооцоолсон цалингаас татваруудыг суутгаж гарт олгох цалингийн хэмжээгээр ажиллагчдад өгөх цалингийн бичилтийн үед:
Дт Цалингийн тооцоо
Кт Цалингийн өр
- Цалин олгох үед:
Дт Цалингийн өр
Кт Мөнгөн хөрөнгө
- Цалингийн татваруудыг төлөх үед:
Дт НДШ-ийн өр
ХХОАТ-ын өр
Кт Мөнгөн хөрөнгө

V. Нягтлан Бодох Бүртгэлийн Анхан Шатны Баримтын Маягт, Түүнийг Хэрэглэх Заавар

Монгол улсын “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулийн 7.2 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Санхүү, эдийн засгийн сайд, Үндэсний статистикийн газрын даргын 2002 оны 171/111 тоот хамтарсан тушаалаар батлагдсан “Өмчийн бүр хэбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягт, түүнийг хэрэглэх заавар”-т нийцүүлэн “Тэнгэрлиг медиа групп” ХК нь дотооддоо хэрэглэгдэх анхан шатны баримт, маягыг баталж мөрдөнө.

Анхан шатны баримт гэж ажил гүйлгээ гарсныг нотолж, бичгээр бүрдүүлсэн болон бусад нотолгоог хэлэх бөгөөд нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно.

Анхан шатны баримтын бүрдэлт, үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.

Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл, тайланд тусгахыг хориглоно.

1. Мөнгөн хөрөнгийн маягыг нөхөх заавар

- **Бэлэн мөнгөний орлого, зарлагын баримт- НХМаягт МХ-1,2**

Бэлэн мөнгөний гүйлгээ, түүний хадгалалт хамгаалалт, бүрэн бүтэн байдлыг хангах зорилгоор бэлэн мөнгөний орлого, зарлагын баримтыг хөтөлнө. Байгууллагын удирдлагын шийдвэрийн дагуу хариуцсан нягтлан бодогч бэлэн мөнгөний орлого, зарлагын баримтыг бичиж нэг, хоёрдугаар гарын үсэг зурагдсаны дараа мөнгөний нярав зохих гүйлгээг хийнэ. “Бэлэн мөнгөний орлогын баримт”-аар бэлэн мөнгийг тоолж хүлээн авч, зарлагын баримтыг үндэслэн бэлэн мөнгийг хүлээлгэж өгнө. Эдгээр баримтуудыг 2 хувь үйлдэж, мөнгө тушаагч эсвэл хүлээн авагч нарт 1 хувийг өгч, холбогдох баримт бичгийн хамт 1 хувийг нярав хадгалан “Бэлэн мөнгөний тайлан”-д бичилт хийх үндэслэл болгоно. Бэлэн мөнгөний орлого, зарлагын баримтуудыг дагалдах баримт бичгийн хамт Бэлэн мөнгөний тайлангийн 1 хувьтай хавсарган, холбогдох нягтлан бодогчид тушаана. Бэлэн мөнгөний нярав тайлангийн 1 хувийг өөртөө хадгална.

- **Бэлэн мөнгө олгохыг хүссэн өргөдөл- НХМаягт МХ-3**

Бэлэн мөнгө авах хүмүүс бэлэн мөнгө олгохыг хүссэн өргөдлийг асуултын дагуу 1 хувь нөхөн бичиж, гарын үсгээ зурсны дараа дарга, ерөнхий нягтлан бодогчоор цохуулж, гарын үсэг зуруулан, бэлэн мөнгөний зарлагын баримт хавсаргахаар хариуцсан нягтлан бодогчид өгч, няраваас мөнгөө авч, баримтын 1 хувийг няравт үлдээнэ.

- **Бэлэн мөнгөн гүйлгээний тайлан- НХМаягт МХ-4**

Мөнгөний нярав орлого, зарлагын баримтууд, мөнгө олгохыг хүссэн өргөдөл зэргийг үндэслэн баримт тус бүрээр өдөр бүр бэлэн мөнгөн гүйлгээний тайланг 2 хувь үйлдэн, 1 хувийг холбогдох баримтуудын хамт нягтлан бодогчид тушааж, үлдэх хувийг өөртөө үлдээнэ. Нягтлан бодогч бэлэн мөнгөн гүйлгээний тайлангийн хуудсыг нь хосоор ижил дугаарлаж няравт өгөх бөгөөд тэрхүү дугаарын тоо санхүүгийн жилд тасралтгүй мөрдөгдөж байвал зохино.

- **Бэлэн мөнгөний тооллогын баталгаа- НХМаягт МХ-5**

Мөнгөн хөрөнгийн нярав ажил хүлээлцэхэд, тайлант хугацаа /улирал, жил/-ны эцэст болон гэнэтийн тооллого хийхэд бэлэн мөнгөний үлдэгдлийг дэвсгэрт буюу валютын төрөл бүрээр тоолж, бэлэн мөнгөний тооллогын баталгааг 2 хувь үйлдэнэ. Хариуцсан нягтлан бодогч нь тооллогын комиссоос үйлдсэн “Бэлэн мөнгөний тооллогын баталгаа”-ны 1 хувийг үндэслэн мөнгөн хөрөнгийн няравын тооцоог бодно.

2. Бараа материалын үнэт зүйлийн маягтыг нөхөх заавар

- **Бараа, материал хүлээн авалтын баримт- НХМаягт БМ-1**

Бэлтгэн нийлүүлэгч байгууллагаас ирж байгаа бараа, материалын үнэ бүхий зүйлс, тоо хэмжээ, зэрэг дугаарын хувьд дагалдан ирсэн баримттайгаа тохирохгүй байх, хайрцаг, сав, баглаа боодол, лоц, ломбо задарч гэмтсэн үед эд хариуцагч санхүүгийн албанд мэдэгдэж байгууллагаас мэргэжлийн хүмүүсийн бүрэлдэхүүнтэй комисс томилуулж "Бараа, материал хүлээн авалтын баримт"-аар хүлээн авна. Комисс "Бараа, материал хүлээн авалтын баримт"-ыг асуултын дагуу 2 хувь нөхөн бичиж 1 хувийг дагалдан ирсэн баримтын хамт эд хариуцагчид, үлдэх хувийг тээвэрлэгчид өгнө.

Эд хариуцагч "Бараа, материал хүлээн авалтын баримт"-аар агуулахын бүртгэлийг хөтөлж тайлангийн хамт тайлант хугацаанд санхүүгийн албанд ирүүлнэ. Хариуцсан нягтлан бодогч хураангуй дансанд бичилт хийж баримтыг хадгална.

- **Орлогын баримт- НХМаягт БМ-2**

Бэлтгэн нийлүүлэгч байгууллагаас ирсэн болон өөрийн үйлдвэрийн цех, тасаг, туслах аж ахуйгаас боловсруулсан зүйл, үйлдвэрт тавьж олгосон төрөл бүрийн материалын зарцуулагдаагүй үлдэгдэл, үйлдвэрлэлийн гологдлоос гарсан өөдөс хаягдал, үндсэн хөрөнгийн устгалтаас ашигласан материал, үнэ бүхий зүйлийг орлого болгоход эд хариуцагч нар дагалдан ирсэн бичиг баримтыг үндэслэн орлогын баримтыг 2 хувь бичиж, 1 хувийг өөртөө авч агуулахын бүртгэлд бичилт хийсний дараа тайлангийн хугацаанд санхүүгийн албанд, үлдэх хувийг тээвэрлэгч болон материалыг тушаагчид өгнө.

- **Зарлагын баримт- НХМаягт БМ-3**

Бараа, материалын үнэт зүйлсийг худалдан авагч байгууллагад ачуулах, нэг агуулах,

эд

хариуцагч, няраваас нөгөөд шилжүүлэх, өөрийн хэрэгцээнээс илүү буюу хэрэгцээнд тохирохгүй зүйлийг худалдан борлуулах, нэгжийн орц норм тогтоогдоогүй материал үнэт зүйлийг үйлдвэрт тавьж олгох, зохих шийдвэрийн дагуу өөр газар шилжүүлэхэд зарлагын баримтыг эд хариуцагч зөвшөөрөл шийдвэрийг үндэслэн 2 хувь бичиж, 1 хувийг өөртөө авч тайлангийн хугацаанд санхүүгийн албанд, үлдэх хувийг хүлээн авагчид "Материал үнэ бүхий зүйлийг гаргах зөвшөөрөл"-ийн хамт олгоно.

- **Бараа материалыг гаргах зөвшөөрөл- НХМаягт БМ-4**

Бараа материалын хөдөлгөөнийг эмх цэгцтэй байлгах, өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалтыг сайжруулж, бүрэн бүтэн байдлыг хангах зорилгоор зөвшөөрлийн хуудсыг аж ахуйн эрхлэгч, нярав нар 1 хувь бичиж үнэ бүхий зүйлийг хүлээн авагчид олгоно. "Бараа материалыг гаргах зөвшөөрөл"-ийг харуул, манааны хүмүүс ачсан зүйлтэй тулган шалгаж хураан авч дараагийн ажлын өдөрт санхүүгийн албанд хүлээлгэн өгнө. Зөвшөөрөл нь санхүүгээс тусгай номерлогчоор дугаарлагдсан байна.

- **Агуулахын бүртгэл- НХМаягт БМ-5**

Бараа, материалын хөдөлгөөн, үлдэгдлийн тоо хэмжээг тухай бүрд мэдэх, түүний бүрэн бүтэн байдлыг хангах зорилгоор агуулахын бүртгэлийг эд хариуцагч материалын нэр төрөл, зэрэг, дугаар бүр дээр нээж хөтөлнө. Агуулахын бүртгэлийг дэвтэр маягтаар хөтөлнө. Түүний хуудас нэг бүрийг дугаарлан, хуудасны тоог тавьж хариуцагч нягтлан бодогч нь эд хариуцагчид жилийн эхэнд хүлээлгэн өгнө.

Материал, үнэ бүхий зүйлийн хөдөлгөөнийг эд хариуцагчид "Бараа, материалын үнэ бүхий зүйлийн орлого, зарлагын баримт"-ийг үндэслэн агуулахын бүртгэлийг биет нэгжээр хөтөлж өдөр тутмын үлдэгдлийг тодорхойлохын хамт тайлант хугацаанд хариуцагч нягтлан бодогчоор тайлангаа хянуулж үлдэгдлийг батлуулан гарын үсэг зуруулна. Агуулахын бүртгэлийн хуудас бүрийг дугаарлаж, эцсийн хуудсанд нягтлан бодогч нийт дугаарын тоог тавьж, санхүүгийн тэмдэг дарна.

- **Шаардах хуудас- НХМаягт БМ-6**

Материалын үнэ бүхий зүйлсийг байгууллагын үйлдвэрлэл, дотоод хэрэгцээнд зарцуулах шаардлага гарсан үед уг зүйлийг авч зарцуулах хүн "Шаардах хуудас"-ыг 1 хувь үйлдэж зөвшөөрөл авна. Эд хариуцагч шаардах хуудсыг үндэслэн материал, үнэ бүхий зүйлийг тавьж олгосны дараа агуулахын бүртгэлд бичилт хийж, тайлант хугацаанд нягтлан бодогчид хүргүүлнэ.

- **Тооцоо бодсон баримт- НХМаягт БМ-7**

Эд хөрөнгийн тооллогыг жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө, эд хөрөнгийн хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед, эд хөрөнгө дутагдсан, эд хөрөнгийг хууль бусаар зарцуулсан байж болзошгүй гэж үзсэн үед, байгалийн гамшиг, гал түймэр зэрэг гэнэтийн аюулын дараа, аж ахуйн нэгж, байгууллагыг өөрчлөн байгуулсан, татан буулгасан, дампуурсан гэж зарласан зэрэг тохиолдолд хийнэ.

Тооллогын дараа эд хариуцагч нарын тооцоог бодож илүүдлийг орлого болгох ба дутагдлыг төлүүлэх, эсвэл зарлага болгож шийдвэрлэнэ.

Эд хариуцагчийн тооцоо бодсон баримтыг холбогдох нягтлан бодогч 2 хувь нөхөн бичиж тооллогын комиссын гишүүд гарын үсэг зурж баталгаажуулна. Баримтын нэг хувь нягтлан бодогчид, үлдэх хувь эд хариуцагчид хадгалагдана.

- **Эд хөрөнгийн тооллогын бүртгэл- НХМаягт БМ-8**

Аж ахуйн нэгж, байгууллагын бүртгэлийн бодлогын баримт бичигт заасны дагуу тооллогыг явуулна. Тооллогын комисс эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд зааврын дагуу үнэн зөв, чанартай явуулж тооллогын явц үр дүнг комиссын хурлаар хэлэлцэж, тооллогын бүртгэлийг 2 хувь үйлдэж байгууллагын удирдлагад танилцуулан батлуулж, санхүүгийн албанд хүргүүлэх үүрэгтэй.

Эд хөрөнгийн тооллогын бүртгэлд байгууллагын нэр, эд хөрөнгийн нэр төрөл, хаана ашиглагдаж байгаа, хөрөнгийн чанар байдал зэргийг тэмдэглэхийн хамт тооллогын бүртгэлийн хуудас бүрийн ард тооллогын комиссын дарга, гишүүд, эд хариуцагч гарын үсэг зурна.

- **Бараа материалын тайлан- НХМаягт БМ-9**

Бараа материалын тайланг агуулахын нярав, эд хариуцагч нь аж ахуйн нэгж, байгууллагын бүртгэлийн бодлогын баримт бичигт заасан хугацаанд агуулахын бүртгэлд үндэслэн материалын нэр төрөл тус бүрийн тоо хэмжээгээр нэгтгэн гаргана. Бараа материалын тайланг нярав, эд хариуцагч нар дээр хөтлөгдөж буй агуулахын бүртгэлтэй тулган шалгаж хүлээж авна.

- **Ажилчин, албан хаагчдын хэрэглэж байгаа эд хөрөнгийн ашиглалтын бүртгэл- НХМаягт БМ-10**

Аж ахуйн нэгж, байгууллагын ажилчин, албан хаагчдын албан хэрэгцээнд эзэмшиж байгаа эд хөрөнгийг нэр төрлөөр ангилан бүртгэж, уг бүртгэлийг тооллогын комисс 3 хувь үйлдэж, 1 дүгээр хувийг санхүүгийн албанд, 2 дугаар хувийг аж ахуйн эрхлэгч (нярав)-д, үлдэх хувийг эд хариуцагчид өгнө.

Ажилчин, албан хаагчдын хэрэгцээнд ашиглагдаж байгаа эд хөрөнгийн бэлэн байгаа үлдэгдлийг тооллогын комисс үзэж биечлэн тоолоод тооллого явуулсан хугацааг тодорхой заан тооллогын бүртгэлд гарын үсэг зурна.

3. Хөдөлмөр цалин хөлсний маягтыг нөхөх заавар

- **Ажлын цаг ашиглалтын бүртгэл- НХМаягт ЦХ-1**

Аж ахуйн нэгж, байгууллагын ажилчин албан хаагчдын ажлын цаг ашиглалтанд байнгын хяналт тавих, үйлдвэрлэлд зарцуулсан хөдөлмөр, цалин хөлсний хэмжээг зөв тодорхойлох, хөдөлмөрийн сахилга бат, ажлын цаг ашиглалтыг сайжруулах зорилгоор ажлын цаг ашиглалтын бүртгэлийг хөтөлнө.

Ажлын цаг ашиглалтын бүртгэлийг сарын эхэнд хариуцсан нягтлан бодогч ажилчин, албан хаагч нэг бүрийн нэрээр нээж, цаг бүртгэгчид хүлээлгэн өгнө. Үйлдвэрийн газруудад цех, тасаг, ээлж, хэсгийн дарга, мастер, тоо бүртгэгч зэрэг хүмүүс бүртгэнэ. Ажлын цаг бүртгэгчид сард (сарын эхний, эцсийн цалин бодох үед) 2 удаа хариуцсан нягтлан бодогчоор ажлын цагийн бүртгэлийг шалгуулна. Ажлын цагийг бүртгэхдээ хүн нэг бүрийн өглөө, өдөр ажилдаа ирсэн цагийг 1, 3 мөрөнд, өдөр, орой тарсныг 2, 4 дүгээр мөрөнд, тухайн өдрийн нийт ажилласан цагийг 5 дугаар мөрөнд, илүү ажилласан цагийг ажилласан цагт оруулахгүйгээр зохих шифрээр ажилласан цагийн ард 5 дугаар мөрөнд тус тус бүртгэнэ. Сарын эцэст ажиллаагүй цагаас шалтгаантайг нь зохих шифрээр 11 дүгээр баганад нөхөж бичнэ.

Цаг ашиглалтыг хавсралт 1 –д заагдсан тоон болон үсгийн шифрээр цагийн бүртгэлд тэмдэглэлээ хийж бүртгэж болно. Цаг бүртгэгчид сарын эцэст хүн нэг бүрийн цаг ашиглалтын тооцоог гаргаж нягтлан бодогчид ирүүлнэ.

- **Ажлын цагийн тооцоо- НХМаягт ЦХ-2**

Сарын эцэст цаг бүртгэгч ажлын цагийн тооцоог хүн нэг бүрээр болон, цех, тасаг, ээлж, хэсгийн хэмжээнд гаргаж хариуцсан нягтлан бодогчоор шалгуулж хүлээлгэн өгнө. Ажлын цагийн тооцоог үндэслэн цалин хөлсний тооцоог хийх тул цаг бүртгэгчид тоог цэвэр нямбай, засваргүйгээр нөхөн бичсэн байх шаардлагатай.

Хариуцсан нягтлан бодогч ажлын цагийн тооцоог ажлын цаг ашиглалтын бүртгэлтэй хүн нэг бүрээр тулган шалгаж хүлээн авсаны эцэст, дараагийн шатны цаг ашиглалтын бүртгэлийг олгоно.

- **Ажлын даалгавар- НХМаягт ЦХ-3а,3б**

Хийснээр болон цагаар цалинждаг хүмүүсийн гүйцэтгэсэн ажлыг тодорхойлж, цалин хөлсийг тооцоолохын тулд ажлын даалгаврыг хэрэглэнэ. Ажлын даалгаврыг ажил эхлэхийн өмнө цех, тасаг, ээлж, хэсгийн дарга, мастер, тоо бүртгэгч нар ажилчин нэг бүрээр буюу хэсэг, тасгаар нэг хувь бичиж төвлөрсөн журмаар олгоно. Ажилчид ажил эхлэхийн өмнө ажлын даалгаварт бичигдсэн ажилтай танилцаж, тодруулах зүйлийг лавлаж ажилдаа орно.

Тухайн ажлыг дуустал ажлын даалгаврыг ажилчид өөртөө хадгалж ажил дууссаны эцэст эд шалгагчаар нөхөн бичилт хийлгэж, ажлын гүйцэтгэлийг хүлээн авахад мастерт өгнө. Ажилчин нэг бүрээр бичих ажлын даалгаврыг ЦХ-3а маягтаар, хэсэг тасгаар гүйцэтгэх ажлын даалгаврыг ЦХ-3б маягтаар бүртгэх бөгөөд ажилчин нэг бүрийн зэрэг, цалинг хуваарилах коэффициент, цалинг олгох хэлбэрийг хүн бүрээр нөхсөн байх шаардлагатай.

- **Цалингийн тооцооны карт- НХМаягт ЦХ-4**

Цалингийн тооцооны картыг ажлын цагийн тооцоо, ажлын даалгаврыг үндэслэн, цалин хөлс хариуцсан нягтлан бодогч сард нэг удаа нөхөн бичиж дарга, ерөнхий нягтлан бодогчоор батлуулж тамга тэмдэг дарсан байна.

Цалингийн тооцооны картыг ажилчин, албан хаагчид нэг бүрийн үндсэн нэмэгдэл цалин, суутгалуудыг зөв тооцоолоход зориулан хэрэглэнэ. Цалингийн тооцооны картаар ажиллагсадын цалинг олгож болно.

- **Цалин олгох хүснэгт- НХМаягт ЦХ-5а, 5б**

Цалин олгох хүснэгтийг хэрэглэснээр ажилчин албан хаагч нэг бүрийн цалингийн олголтонд байнгын хяналт тавих зорилготой юм. Цалин олгох хүснэгтийг, харицсан нягтлан бодогч цалингийн тооцооны бичилтийг үндэслэн ЦХ-5б маягтаар хийж, дарга, ерөнхий нягтлан бодогчоор батлуулан, мөнгөн зарлагын баримт бичиж хавсаргаж мөнгөний няравт хүлээлгэн өгнө.

Мөнгөний нярав хүн нэг бүрт цалинг олгож гарын үсэг зуруулж дууссаны эцэст бэлэн мөнгөний тайланд бичилт хийж, нягтлан бодогчид хугацаанд нь ирүүлнэ. Ажилчин албан хаагчдад олгосон сарын эхний урьдчилгаа цалин, хөлсийг ЦХ-5а маягтаар олгож, цалин, хөлсний сарын эцсийн тооцоог цалингийн тооцооны карт ЦХ-4 маягтаар хийнэ.

4. Үндсэн хөрөнгийн маягтыг нөхөх заавар

- **Үндсэн хөрөнгө хүлээн авах, шилжүүлэх баримт- НХМаягт ҮХ-1**

Аж ахуйн нэгж, байгууллага үндсэн хөрөнгийг шинээр хүлээн авах буюу зохих шийдвэрээр шилжүүлэхэд байгууллагын дарга, захирлын тушаал болон холбогдох шийдвэрээр томилогдсон комисс хөрөнгийн нэр төрөл бүр дээр хүлээн авахад нэг хувь, шилжүүлэхэд 2 хувь нөхөж бичнэ. Үндсэн хөрөнгийг шинээр хүлээн авахад томилогдсон

комисс дагалдан ирсэн баримт бичгийг үндэслэн ҮХ-1 маягтыг асуултын дагуу нөхөн бичиж, аж ахуйн нэгж, байгууллагын дарга, захирлаар батлуулан, дагалдах баримтыг хавсарган ажлын 3 хоногийн дотор нягтлан бодогчид ирүүлнэ. Үндсэн хөрөнгө хариуцсан нягтлан бодогч, баримт, дагалдан ирсэн бичиг баримтыг тулган шалгасны эцэст үндсэн хөрөнгийн дансанд бичилт хийж, НХМаягт БМ-10-ийг асуултын дагуу нөхөн хөтөлнө. ҮХ-1 баримт нь орлого болгох, шилжүүлэхтэй холбогдсон үндсэн баримт болж санхүүгийн баримтанд хадгалагдана.

- **Үндсэн хөрөнгийн өргөтгөл, сайжруулалт, их засварыг хүлээн авах баримт-НХМаягт ҮХ-2**

Үндсэн хөрөнгийн өргөтгөл, сайжруулалт, их засвар хийсэн зэрэгт гарч байгаа зардлын хэмжээг тухай бүрд нь үнэн зөв тодорхойлох, засварын ажлын чанарт үнэлэлт өгөх зорилгоор ажил гүйцэтгэгчийн төлөөлөгчийг байлцуулан ерөнхий (ахлах), нягтлан бодогч баримтыг 2 хувь үйлдэж, байгууллагын дарга, захирал болон холбогдох эрх бүхий албан тушаалтнаар батлуулж, нэгдүгээр хувийг өөртөө авч, үлдэх хувийг засварын ажил гүйцэтгэгчид өгнө. Үндсэн хөрөнгө хариуцсан нягтлан бодогч ҮХ-2 баримтыг үндэслэн дансны бичилтийг хийж, НХМаягт БМ-10-ын холбогдох үзүүлэлүүдийг нөхөн хөтөлнө. Санхүүгийн баримт болгон хадгална.

- **Үндсэн хөрөнгө ашиглалтаас хасах баримт- НХМаягт ҮХ-3**

Төрөл бүрийн үндсэн хөрөнгийг ашиглалтаас хасах шалтгааныг тогтоох зорилгоор үндсэн хөрөнгийн нэр төрөл тус бүр дээр ҮХ-3 баримтыг томилогдсон комисс 2 хувь бичиж, аж ахуйн нэгж, байгууллагын дарга, захирлаар батлуулсаны эцэст нэгдүгээр хувийг нягтлан бодогчид, хоёрдугаар хувийг материал хүлээн авагчид ирүүлнэ. Хариуцсан нягтлан бодогч ҮХ-3 баримтыг үндэслэн дансанд бичилт хийж НХМаягт БМ-10-ийг асуултын дагуу нөхөн хөтөлж баримтыг хадгална.

- **Үндсэн хөрөнгийг дотоодод шилжүүлэх дагалдах хуудас- НХМаягт ҮХ-4**

Аж ахуйн нэгж, байгууллагын дотоодод нэг цех, тасаг, хэсэг, бригад хэлтсээс нөгөө цех, тасаг, хэсэг, бригад хэлтэст үндсэн хөрөнгийг шилжүүлэх агуулах, складаас ашиглалтанд өгөхөд зохих шийдвэрийг үндэслэн цех, тасаг, бригадын дарга, мастер, агуулахын нярав нар 2 хувь бичиж, нэгдүгээр хувийг нягтлан бодогчид, үлдэх хувийг хөрөнгө хүлээн авагчид ирүүлнэ. Хариуцсан нягтлан бодогч дагалдах хуудсыг хүлээн авч, НХМаягт БМ-10-д бичилт хийж баримтанд хавсарган хадгална.

5. Тооцооны маягтыг нөхөх заавар

- **Нэхэмжлэх- НХМаягт ТМ-1**

Нэхэмжлэх нь ачуулсан бараа, үзүүлсэн үйлчилгээний хөлсийг нэхэмжлэх үндсэн баримт болох бөгөөд бүх төрлийн тооцооны дансдыг хөтлөх анхан шатны баримт болно. Нэхэмжлэхийг тоон дэс дарааллаар дугаарлана. НӨАТ гэсэн мөрөнд нийлүүлсэн бараа, үзүүлсэн ажил үйлчилгээнд ногдох Нэмэгдсэн өртгийн албан татварыг бичнэ. Хэсгийн дүнг тухайн үед мөрдөж буй НӨАТийн хувиар үржүүлж НӨАТ-ийн дүнг тооцоолно. Нэхэмжлэгч байгууллагын дарга, нягтлан бодогч гарын үсэг зурж, тамга дарна.

- **Мөнгөн урьдчилгааны тайлан- НХМаягт ТМ-2**

Мөнгөн урьдчилгааны тайлан нь гадаад, дотоод албан томилолт, хангамжийн урьдчилгаа гэх мэт бүх төрлийн мөнгөн урьдчилгааны гүйцэтгэлийг тайлагнах үндсэн баримт юм. Урьдчилгаа авагчын гаргасан гүйцэтгэл ба олгосон урьдчилгаа, холбогдох анхан шатны баримттай харьцуулан нягтлан бодогч урьдчилгаа тайланг хянах ба илүү/дутуу зарцуулалтыг урьдчилгааны зориулалт тус бүрээр гаргана. Хянасан дүн гэсэн баганад нягтлан бодогч баримтаар нотлогдож, тооцсон дүнг бичих ба илүү эсвэл дутуу зарцуулалтыг урьдчилгааны зориулалт бүрээр холбогдох мөрөнд бичнэ. Үлдэгдэл буюу илүү зарцуулсан дүнгийн талаар мөнгөн орлого зарлагын хэддүгээр баримтаар орлого эсвэл зардал болгосон шийдвэрийг тэмдэглэнэ. Энэ тэмдэглэлийг хянасан нягтлан бодогч үйлдэнэ.

- **Тооцооны үлдэгдлийн баталгаа- НХМаягт ТМ-3**

Харилцагч талуудын хооронд гарсан ажил гүйлгээг тодруулан тайлант үеийн эцэс дэх

хоорондын тооцооны үлдэгдлийг баталгаажуулахдаа улирал, жилийн эцэст харилцагч талууд тооцооны үлдэгдлийн баталгааг үйлдэнэ. Шаардлагатай бол санхүүгийн тайлангийн дундуур хийж болно. Тооцооны үлдэгдлийн баталгааг тооцоо үүссэн данс тус бүрээр хөтлөнө. байгууллагын тооцооны баримтыг тооцооны үлдэгдлийн баталгааны хавсралтад нэгтгэж гаргана.

- **Жолоочийн тооцооны хуудас- НХМаягт ТМ-4**

Тухайн байгууллагын хөнгөн тэрэг нь ямар албан тушаалтны хэрэгцээнд үйлчилсэн талаархи гүйцэтгэлийг гаргахдаа жолоочийн тооцооны хуудасыг хэрэглэнэ. Хөнгөн тэрэг хэрэглэсэн албан тушаалтан хэдэн км явснаа хянаад гарын үсэг зурна. Тооцоог нягтлан бодогч хийж, нийт дүнгээр түлш, шатахууны хэмнэлт, хэтрэлтийг гаргана.



ТЭНГЭРЛИГ
МЕДИА ГРУПП

**ТЭНГЭРЛИГ МЕДИА ГРУПП ХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2023 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр

№23/19

Улаанбаатар хот

Г ТУЗ-ийн гишүүнийг түр томилох тухай Г

Компанийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.5 дах заалт, 2023 оны 11-р сарын 24-ний өдрийн ТУЗ-ийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. ТУЗ-ийн хараат бус гишүүн Нацаг овогтой Цогтыг өөрийн хүсэлтийн дагуу ТУЗ-ийн гишүүнээс чөлөөлсүгэй.
2. ТУЗ-ийн хараат бус гишүүнээр Булган овогтой Гантулгыг түр томилсугай

ДАРГА



Г.УЯНГА